



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2014 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1."Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3."Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм" батлагдсантай холбогдуулан Дэд бүтцийн сайдын 2003 оны 257 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Баярбаатар/-т даалгасугай.

САЙД



М.СОНОМПИЛ

008000224

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Дүрмийн зорилго, хамрах хүрээ, шаардлага

1. Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм (цаашид дүрэм гэх)-ийн зорилго нь цахилгаан байгууламж ба түүний хамгаалалтын бүсэд ажил, үүрэг гүйцэтгэх иргэн, ажилтны аюулгүй байдлыг хангах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ, үзлэгийг зохион байгуулах үеийн дэг, горим, ажиллах журмыг тогтооход оршино.

2. Энэхүү дүрмийг Монгол улсын нутаг дэвсгэр дээр цахилгаан байгууламжийн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгж, байгууллагад өмчийн хэлбэрээс үл хамааран дагаж мөрдөнө.

3. Цахилгаан байгууламжийн ашиглалтийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн байгууллагынхаа ажлын онцлог нөхцөлд тохируулан энэ дүрэмд нийцүүлэн аюулгүй ажиллагааны талаар журам гарган мөрдөж болно.

4. Дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

“Шуурхай ажиллагаа” гэж эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үйл ажиллагааг стандартын шаардлага, техникийн найдвартай ажиллагаа, хамгийн бага өртгийн шаардлагад нийцүүлэн хоногийн 24 цагийн турш шуурхай зохицуулж диспетчерийн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг;

“Бригад” гэж хариуцлагатай ажил гүйцэтгэгчийг оролцуулаад хоёр ба түүнээс дээш хүнтэй багийг;

“Нөлөөллийн хүчдэлтэй агаарын шугам” гэж цахилгаан дамжуулах агаарын шугамын хүчдэлийг нь таслан газардуулсан байхад түүний утсан дээр зэргэлдээ орших цахилгаан дамжуулах агаарын шугамын нөлөөллөөр 24 В ба түүнээс дээш хүчдэл үүсэхийг;

“Цахилгаан орны нөлөөллийн орчин” гэж цахилгаан орон дотор байгаа барилга байгууламж, мөн түүнчлэн газардуулагдсан металл хийц, тоног төхөөрөмжийн суурь зэргийн орчны цахилгаан орны хүчлэг нь 5 кВ/м-ээс дээш байх орон зайг;

“Өөрчлөгдөөгүй цахилгаан ба соронзон орны хүчлэг” гэж дотор нь хүн орж өөрчлөөгүй ба хойшид ажлын үед дотор нь хүн орохоор завдаж байгаа орон зайд (орчинд) тодорхойлсон цахилгаан ба соронзон орны хүчлэгийг;

“Аюулгүй ажиллагааны наряд” (цаашид наряд гэх) гэж цахилгаан байгууламжид ажил гүйцэтгэх үед ажлын агуулга, байр, эхлэх дуусах хугацаа, аюулгүй нөхцөлийг хангах арга хэмжээ, бригадын бүрэлдэхүүн, ажлын аюулгүй байдлыг хариуцагч нарыг тодорхойлж тусгай зориулалтын маягт дээр бичсэн ажлын даалгаврыг;

“Шийдвэр” гэж ажлын агуулга, байр, хугацаа, түүнийг аюулгүй гүйцэтгэх арга хэмжээ (хэрэв шаардлагатай бол) ба гүйцэтгэх ажилтныг тодорхойлж, ажлыг аюулгүй гүйцэтгүүлэхээр амаар өгч журналд бүртгэсэн даалгаврыг;

“Захиргаа техникийн ажилтан” гэж цахилгаан тоног төхөөрөмжийн засвар, угсралт, тохируулгын ажил болон шуурхай ажиллагааны техникийн зохион байгуулалтын үүрэг хариуцлага хүлээсэн удирдах ажилтан болон мэргэжилтнийг;

“Шуурхай ажиллагааны ажилтан” гэж ээлжийн хугацаанд эрчим хүчний тоног төхөөрөмжийн ажиллагаа, үйлчилгээг хариуцан, сэлгэн залгалтыг шуурхай зохион байгуулахаар тусгайлан бэлтгэгдсэн ажилтныг;

“Шуурхай үйлчилгээ-засварын ажилтан” гэж технологийн тоног төхөөрөмжийг сэлгэн залгах эрх бүхий засварын ажилтныг;

“Засварын ажилтан” гэж эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, угсралт, тохируулга, туршилтийн ажил гүйцэтгэх ажилтныг;

“Холболт” гэж генератор, щит, цуглуулга, ХБ-ийн шинд холбоостой нэг зориулалтын, нэг нэртэй, нэг хүчдэлийн цахилгаан хэлхээ (тоног төхөөрөмж ба шин)-г; Нэг трансформаторын (ороомгийн тооноос хамаарахгүй) янз бүрийн хүчдэлтэй цахилгаан хэлхээ, олон хурдат нэг хөдөлгүүрийн цахилгаан хэлхээнүүд болон олон талын холболттой схемд шугам, трансформаторын нэг холболтод уг шугам буюу трансформаторыг ХБ-д холбоход хэрэглэдэг түүний бүх таслах залгах аппарат ба шинийг нэг холболтод тооцно.

“Хүчдэлтэй нөхцөлд гүйцэтгэх ажил” гэж хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсэгт хамгаалах хэрэгсэлтэйгээр хүрч буюу гүйдэл дамжуулах хэсгийн ойролцоо зөвшөөрөгдсөн зайнаас дотогш гүйцэтгэх ажлыг;

“Өндөрт авирч гүйцэтгэх ажил” гэж газрын гадаргуу, шалнаас болон хаалт хашилтгүй өндөрлөг хэсгийн ирмэгээс 2 м-ээс бага зайд ажил гүйцэтгэж байгаа хүний хөлний ул хүртэл 1,2 метрээс дээш өндөрт авирч ажиллахыг;

“Өндөрт ажил гүйцэтгэх” гэж газрын гадаргуу, шалнаас болон хаалт хашилтгүй өндөрлөг хэсгийн ирмэгээс 2 м-ээс бага зайд ажил гүйцэтгэж байгаа хүний хөлний ул хүртэл 1,2 метрээс дээш өндөрт ажиллахыг;

“Ашиглалтын явцад жагсаалтаар гүйцэтгэх ажил” гэж тухайн ажилтны хариуцдаг 1000 В хүртэлх хүчдэлийн цахилгаан байгууламжид цаашид ямар нэгэн нэмэлт удирдамж, шийдвэр, тухайлсан зааварчилгаа шаардагдахгүй байнга хийгдэх ажлыг;

“Цахилгаан байгууламж” гэж цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх, хувиргах, хувьсгах, дамжуулах, хуваарилах, түгээх зориулалттай машин, тоног төхөөрөмж, шугам сүлжээ, тэдгээрийг суурилуулсан барилга, байгууламжийн цогцыг;

“Гүйдэл үл дамжуулах хэсэг” гэж хэвийн ажиллагаатай үед хүчдэлгүй байдаг цахилгаан байгууламжийн хэсгийг;

“Гүйдэл дамжуулах хэсэг” гэж хэвийн ажиллагаатай үед хүчдэлтэй байдаг цахилгаан байгууламжийн хэсгийг;

“Ашиглалтад байгаа цахилгаан байгууламж” гэж хүчдэлтэй байгаа буюу таслах залгах аппаратыг залгаснаар эсвэл цахилгаан соронзон индукцын нөлөөгөөр хүчдэлтэй болж болох цахилгаан байгууламж буюу түүний хэсгийг;

“Ажиллагаатай байгаа цахилгаан байгууламж” гэж хүчдэлтэй байгаа цахилгаан байгууламж буюу түүний хэсгийг;

“Энгийн тодорхой схемтэй цахилгаан байгууламж” гэж тойруу систем шингүй, секцлэгдсэн болон секцлээгүй нэг систем шинтэй 1000 В-оос дээш хүчдэлийн хуваарилах байгууламж, бүх төрлийн цахилгаан дамжуулах агаарын шугам ба кабель шугам, 1000 В хүртэл хүчдэлийн бүх цахилгаан байгууламжийг;

5. Цахилгаан байгууламж ашиглагч болон шинэ техник технологи нэвтрүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь энэ дүрэм болон түүнд нийцүүлэн гаргасан аюулгүй ажиллагааны эрх зүйн баримт бичгийн талаарх сургалт явуулж шалгалт авсан байна.

6. Сургалт, шалгалтанд хамрагдаагүй буюу тогтоосон шаардлагад тэнцээгүй, зааварчилгаа аваагүй, эрүүл мэндийн үзлэгт хамруулаагүй, эрүүл мэндийн хувьд тэнцээгүй иргэн, ажилтнаар ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

7. Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжийг аюулгүй ажиллагааны зааваргүйгээр ашиглалтад оруулахыг хориглоно.

8. Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмж нь аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангахаар бүрэн бүтэн байх ёстой.

9. Цахилгаан байгууламж нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, дүрмийн дагуу туршигдсан хамгаалах хэрэгслээр хангагдсан байх ёстой.

10. Байнгын жижүүртэй цахилгаан байгууламж нь анхны тусламжийн хэрэгслээр хангагдсан байх ёстой.

11. Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжийн хаалгыг цоож, түгжээтэй байлгана.

12. Ажилтны мэргэжлийн бэлтгэл, түүний мэргэжлийг дээшлүүлэх, мэдлэгийг шалгах, зааварчилгаа өгөх ажлыг улсын болон салбарын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, аюулгүй ажиллагааны эрх зүй, нормативын баримт бичгийн хүрээнд гүйцэтгэнэ.

13. Энэхүү дүрмийн биелэлтэнд тухайн байгууллагын дотоод хяналтын нэгж, албан тушаалтан, эрчим хүчний хяналтын эрх бүхий байгууллагууд хяналт тавьж ажиллах бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын хариуцлагыг ажил олгогч хүлээнэ.

14. Энэ дүрэмд харш тушаал, шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэхийг хориглоно.

15. Энэхүү дүрмийг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

1.2. Ажилтанд тавигдах шаардлага

16. Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжид ажил гүйцэтгэх ажилтан нь эрхэлсэн албан тушаалдаа тохирох боловсрол, мэргэжил эзэмшсэн, мэргэжлийн бэлтгэл хангасан байна.

17. Ажилтныг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулна.

18. Ажилтан нь цахилгаан гүйдлийн нөлөөнд өртсөн осолдогчийг хүчдэлээс чөлөөлөх, түүнд анхны тусламж үзүүлэх арга барил эзэмшсэн байна.

19. Цахилгаан төхөөрөмжид ажиллах ажилтан нь мэдлэгийн шалгалт өгч албан тушаал, мэргэжилдээ тохирох аюулгүй ажиллагааны групп (Хавсралт №1) авсан байх ёстой. Мэдлэгийн шалгалтад тэнцсэн ажилтанд баталгаат загварын үнэмлэх (Хавсралт №2) олгоно.

20. Ажилтан нь ажил гүйцэтгэх үедээ үнэмлэхээ биедээ авч явах, шаардлагатай тохиолдолд эрх бүхий ажилтан, албан тушаалтанд үзүүлэх үүрэгтэй.

21. Сургалтанд хамрагдаагүй, аюулгүй ажиллагааны зааварчилгаа аваагүй, тогтоосон хугацаанд шалгалт өгөөгүй буюу тэнцээгүй иргэн, ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

22. Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжид ажил гүйцэтгэх ажилтанд дараах тусгай ажлыг гүйцэтгэхээр зөвшөөрөл олгосон бол энэ тухай группын үнэмлэх (Хавсралт №2)-д тэмдэглэнэ. Үүнд:

- Өндөрт авирч гүйцэтгэх ажил;
- Хүчдэлтэй гүйдэл дамжуулах хэсэг дээр ажил гүйцэтгэх (тусгаарлагчийг угааж цэвэрлэх солих, утас трос засварлах, хэмжүүрийн штангаар тусгаарлагч болон залгаасны хавчааруудыг шалгах, трос тослох г.м.);
- Өндөр хүчдэлээр туршилт хийх (мегаомметрээр хэмжилт хийхээс бусад);

23. Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн онцлогийг харгалзан группын үнэмлэхэд тэмдэглэх тусгай ажлын нэмэлт жагсаалт гаргаж болно.

24. Шинэ ажилтныг туршлагатай ажилтанд дагалдуулан сургаж ажиллуулна.
25. Ажилтан бүр ажил үүргээ биелүүлэх явцад аюулгүй ажиллагааны нөхцөл зөрчигдөж хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай байдал бий болсон тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож, энэ талаар удирдлагадаа яаралтай мэдэгдэх үүрэгтэй.

1.3. Шуурхай ажиллагаа

26. Тухайн байгууллагын удирдлагын тушаалаар батлагдсан шуурхай ажиллагаа, шуурхай үйлчилгээ-засварын ажилтан сэлгэн залгалтыг гүйцэтгэнэ.
27. Сэлгэн залгалт хийхдээ заавал зөвшөөрөл авах ёстой. Сэлгэн залгалтыг зөвшөөрөл авмагц гүйцэтгэнэ.
28. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжид сэлгэн залгалтыг нэг нь аюулгүй ажиллагааны IV-өөс доошгүй групптэй, нөгөө нь III-аас доошгүй групптэй 2 хүн гүйцэтгэнэ.
29. Алслагдсан орон нутагт зайлшгүй шаардлагатай тохиолдолд 35 кВ хүртэлх хүчдэлийн цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжид сэлгэн залгалтыг IV-өөс доошгүй групптэй нэг хүн ажил олгогчоос баталсан аюулгүй ажиллагааны зааврын дагуу шуурхай ажиллагааны удирдах ажилтан (диспетчер)-ны холбооны хэрэгслээр тасралтгүй дамжуулан тавих хяналтан дор гүйцэтгэж болно. Энэ тохиолдолд тухайн ажилтны холбооны хэрэгсэл нь микрофонтой чихэвч болон 2 гар нь чөлөөтэй байх төхөөрөмжөөр тоноглогдсон байх ёстой.
30. 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжид шуурхай ажиллагааг “Ашиглалтын явцад хийх ажлын жагсаалт”-д ганцаараа гүйцэтгэхээр зааснаас бусад тохиолдолд III-аас доошгүй групптэй 2 хүн гүйцэтгэнэ.
31. Гар залууртай хуурай салгуур, таслуур, автомат, рубильник гэх мэт цахилгаан тоноглолыг таслах, залгахдаа зориулалтын бээлий, нүүр хамгаалах хэрэгсэл хэрэглэх ёстой.
32. Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжид нэг ажлын ээлжинд үйлчлэх ажилтны тоо, ажлын хуваарийг ажил олгогч эсвэл тухайн хэсэг, нэгжийн удирдлага батална.
33. Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжийн хаалт хашилтгүй хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсэгт хүн, машин механизм, ачаа өргөх кран 1 дүгээр хүснэгтэд зааснаас дотогш зайд ойртохыг хориглоно.

Хүснэгт 1

Хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсэгт ойртож болох зай хэмжээ

Хүчдэл (кВ)		Ажилтан ба тэдний хэрэглэж байгаа багаж хэрэгсэл, түр хаалт хашилт хүртэл зай (м)	Машин, ачаа өргөх кран, оосорлох хэрэгсэл ба ачааны ойртож болох зай (м)
1кВ хүртэл	Агаарын шугамд	0.6	1.0
	Бусад цахилгаан байгууламжид	Норм тогтоохгүй, хүрч шүргэж болохгүй	1.0
1-35 кВ		0.6	1.0
60* ; 110кВ		1.0	1.5
220кВ		2.0	2.5
330 кВ		2.5	3.5
400* ; 500		3.5	4.5

* тогтмол гүйдэл

1.4. Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжийн үзлэг

34. Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжид үйлчлэх эрх бүхий шуурхай ажиллагаа, шуурхай үйлчилгээ-засварын III-аас доошгүй групптэй ажилтан ээлжийн хугацаандаа өөрийн хариуцсан тоног төхөөрөмжид ганцаараа үзлэг хийж болно.
35. IV-өөс доошгүй групптэй тухайн байгууллагын удирдах ажилтан ганцаараа үзлэг хийх эрхтэй байна.
36. ЦДАШ-ын үзлэгийг энэ дүрмийн холбогдох заалтын дагуу гүйцэтгэнэ.

37. Цахилгаан байгууламжид ажилладаггүй 16 нас хүрсэн иргэн, ажилтан нь тухайн байгууламжид ганцаараа үзлэг хийх эрх бүхий ажилтны хяналтан дор орж болно.
38. Цахилгаан байгууламжид орж байгаа иргэн, ажилтны аюулгүй байдлыг түүнийг хариуцан орсон ажилтан хүлээнэ.
39. Үзлэг хийхдээ щит, самбар, үүр, удирдах самбарын болон тоноглолын хаалгыг онгойлгохыг зөвшөөрнө.
40. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжийн гүйдэл дамжуулах хэсэгт 1 дүгээр хүснэгтэд заасан зайнаас дотогш ойртох, хаалт хашилтгүй хэсэгт орох, мөн тавьсан хаалт хашилтын цаана нэвтрэхийг хориглоно.
41. Үзлэгийн үед ямар нэгэн ажил гүйцэтгэх, засвар, үйлчилгээ хийхийг хориглоно.
42. Алслагдсан болон байнгын жижүүргүй цахилгаан байгууламж, тоног төхөөрөмж, ЦДАШ-д гэмтэл гарсан тохиолдолд үзлэг хийх, гэмтлийг арилгах ажлыг хамтруулан хийж болох ба техникийн арга хэмжээг бүрэн авсан байх ёстой. Энэ тохиолдолд ажил гүйцэтгэгч нь IV-өөс доошгүй групптэй, бусад нь III-аас доошгүй групптэй гишүүн бүхий бригад байна.
43. 6-35 кВ-ын цахилгаан тоног төхөөрөмжид газардлага гарсан үед ХХБ-д газардсан цэгт 4 метр, ИХБ ба ЦДАШ-д 8 метрээс дотогш зайд ойртохыг хориглоно.
44. Зөвхөн шуурхай сэлгэн залгалт хийх ба хүчдэлд өртсөн хүнийг чөлөөлөх тохиолдолд аюулгүй байдлаа бүрэн хангасны дараа энэ дүрмийн 43-т зааснаас дотогш зайд ойртож болно.
45. Үзлэг хийж байгаагаас бусад цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжийн хаалгыг цоожилж, түгжсэн байна.
46. Хаалганы түлхүүрийг хадгалах, хүлээлцэх журмыг тухайн байгууллагын ажил олгогч баталсан байна.
47. Түлхүүрүүдийг дугаарлаж бүртгэн зориулалтын хайрцагт хадгалах ба түлхүүр тус бүрийн нэг хувийг тусгай нөөцөнд хадгална.
48. Түлхүүрийг дараах ажилтнуудад гарын үсэг зуруулж олгоно. Үүнд:
- Ганцаараа үзлэг хийх эрх бүхий ажилтан;
 - Шуурхай үйлчилгээ-засварын ажилтан;
 - Нарядаар ажил гүйцэтгэхэд ажлын удирдагч эсвэл ажилд оруулагч;
49. Түлхүүрийг үзлэг, үйлчилгээ дууссаны дараа тухай бүрт нь эргүүлэн хүлээлгэж өгнө.
50. Алслагдсан болон байнгын жижүүргүй цахилгаан байгууламжид хийсэн үзлэг, үйлчилгээг бүрэн дуусгаад дараагийн өдрийн ажил эхлэхээс өмнө тухайн байгууламжийн түлхүүрийг буцааж өгнө.
51. Цахилгаан байгууламжийн түлхүүрийг өгч авсан тухай бүртгэл хөтлөнө.

1.5. Ажил гүйцэтгэх журам ба нөхцөл

52. Цахилгаан байгууламжид аюулгүй ажиллагааны наряд, шийдвэр, ашиглалтын явцад хийх ажлын жагсаалтын дагуу ажил гүйцэтгэнэ. (Нарядын маягт ба түүнийг бичих зааврыг энэ дүрмийн Хавсралт №3-т тусгав)
53. Наряд, шийдвэр ба ашиглалтын явцад хийх ажлын жагсаалтын дагуу гүйцэтгэх ажлыг энэ дүрэм болон тухайн байгууллагын ажил олгогчийн бичгэн шийдвэрээр тодорхойлно.
54. Наряд, шийдвэр, ашиглалтын явцад хийх ажлын жагсаалтад зааснаас бусад ажлыг дур мэдэн гүйцэтгэх, ажлын байрыг өргөтгөх, өөрчлөхийг хориглоно.
55. Ослын үед осолдогчийг цахилгаан гүйдлийн нөлөөллөөс чөлөөлөхийн тулд холбогдох албан тушаалтанд мэдэгдэхгүйгээр цахилгаан тоног төхөөрөмжийн хүчдэлийг шууд таслаж болно.
56. Дараах ажлыг технологийн картын дагуу гүйцэтгэнэ. Үүнд:
- 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, засвар;
 - Цахилгаан байгууламжийн гүйдэл дамжуулах хэсэг дээр хүчдэлийг таслалгүй гүйцэтгэх ажил;
 - Цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралт, засвар;

57. Технологийн картаар гүйцэтгэх ажлын жагсаалтыг тухайн байгууллагын техникийн удирдах ажилтан батална.

58. 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжид хүчдэлтэй нөхцөлд ажиллахад дараах арга хэмжээнүүдийг заавал авна. Үүнд:

- Ажлын байрны зэргэлдээ байгаа санамсаргүй хүрч шүргэж болзошгүй хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсгүүдэд хаалт, хашилт хийх;
- Зориулалтын резинэн шаахай, бойтог өмсөх эсвэл тусгаарлагч тавиур буюу резинэн дэвсгэр дээр зогсож ажиллах;
- Тусгаарлагч бариултай багаж (отверткийн бариул төдийгүй гол төмөр нь тусгаарлагчтай байх), резинэн бээлий, нүүрний хамгаалалт хэрэглэх;

59. Ажлын хувцасныхаа бүх товчийг бүрэн товчилж ажиллах ёстой. Ажлын хувцсанд металл хийц болон сул унжиж салбайсан хэсэг байх ёсгүй. Богино буюу шамласан ханцуйтай хувцастай ажиллах, гутлын түрийг эргүүлэх буюу түрийг өмдний шуумагны гадуур гаргаж өмсөхийг хориглоно.

60. Цахилгаан байгууламжид ажил гүйцэтгэх үед бүх багаж хэрэгсэл нь зориулалтын байх бөгөөд тусгаарлагчгүй багаж хэрэгсэл (төмрийн хөрөө, төмөр метр, багс г.м)-ийг хэрэглэх, цахилгаан нумын үйлчлэлээс хамгаалахаас өөр зориулалтаар орчны гэрэлтүүлгийг бууруулах нүдний шил зүүх, шуурхай ажиллагаа явуулахаас бусад тохиолдолд утсаар ярихыг хориглоно.

61. Биеийн нугарсан байдлаас эгц болоход хүний биеээс хүчдэлтэй гүйдэл дамжуулах хэсэг хүртэл 1 дүгээр хүснэгтэд зааснаас дотогш зайд ойртохоор нөхцөлд ажил гүйцэтгэхийг хориглоно.

62. Хаалт хашилтгүй гүйдэл дамжуулах хэсэг биеийн ард буюу хоёр хажуу талд байхаар байрлалд ажиллахыг хориглоно.

63. Ажил гүйцэтгэж байгаагаас бусад цахилгаан байгууламжийн барилга, өрөө тасалгаа, үүрүүдийн хаалгыг цоож, түгжээтэй байлгана.

64. Ажил гүйцэтгэж буй хэсэгт хүчдэл залгахаас урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авсан байх ёстой. Энэхүү зорилгоор цоожлох, пайзлах журмыг ажил олгогчийн тушаалаар батлан мөрдүүлнэ.

65. Хүчдэлтэй байгаа цахилгаан тоног төхөөрөмжийн тусгаарлагчид хамгаалах хэрэгсэл хэрэглэлгүйгээр хүрч шүргэхийг хориглоно.

66. ИХБ-д цахилгаан дамжуулах утас (трос) огтлолцсон хэсэгт доор нь татагдсан утас, арматур, тусгаарлагчийг солихдоо дээр нь байрлалтай хүчдэлтэй байгаа утсанд хүрэхээс хамгаалж түүний доогуур ургамлын гаралтай буюу синтетик материалаар хийсэн хэц татна. Хэцийг утаснуудын огтлолцсон хэсгийн хоёр талд хөндлөн татаж бөх бат хийцэд бэхэлнэ. Утас (трос)-ыг алгуур тайван татаж өргөнө.

67. ИХБ-д цахилгаан дамжуулах утас, трос огтлолцсон хэсэгт дээд талд нь татагдсан хүчдэлтэй байгаа утас, трос, тусгаарлагч, арматурыг солих ажлыг утас, тросыг доош унахаас урьдчилан сэргийлэх болон нөлөөллийн хүчдэлээс хамгаалах арга хэмжээг авсан байх ёстой. Энэ ажлыг доогуур нь огтлолцож байгаа утасны хүчдэлийг таслахгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

68. Харанхуй буюу гэрэлтүүлэггүй газарт (байранд) ажил гүйцэтгэхийг хориглоно.

69. Ажлын байр, хэсэг, орц, гарц, зам талбайн гэрэлтүүлэг нь ажилтны нүдийг гялбуулахгүй, жигд байх ёстой.

70. Аянга цахилгаантай үед буюу аянга цахилгаан ойртох үед ХАШ, ЦДАШ, ИХБ, ХХБ-ын оруулга, гаргалгууд болон тэдгээрийн ил задгай хэсэг, антен-цамхагийн байр, байгууламж, ЦДАШ-тай холбогдсон ХХБ-ийн тасалж залгах аппаратууд дээр ажил гүйцэтгэхийг хориглоно.

71. Шуурхай ажиллагааны удирдлагын өрөөнөөс бусад эрчим хүчний тоног төхөөрөмж, цахилгаан байгууламжид ажиллагсад нь дуулга малгайг бүчлэж өмссөн байна.

72. ЦДАШ дээр ажил гүйцэтгэх хүн нь тухайн утас, трос (ган татлага) нь бүрэн бүтэн буюу чичиргээ, доргио, зэврэлтээс болон бусад шалтгаанаар тасарч гэмтээгүй тохиолдолд хүчдэлийн түвшин харгалзахгүйгээр 240 мм²-аас багагүй огтлолтой утас, 70 мм²-аас багагүй огтлолтой тросоор дамжин явж болно.

73. Салаалсан утас, тросоор дамжин явахдаа хамгаалах бүсний оосрыг тухайн утас, тросонд, хэрэв тусгай зориулалтын тэргэнцэр, араг хэрэглэж байгаа бол түүнд хамгаалах бүсний оосрыг бэхэлнэ.

74. Өндөрт ажил гүйцэтгэхдээ хамгаалах бүс заавал хэрэглэнэ.

75. Газар шорооны ажил гүйцэтгэхэд холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллана.

76. Согтуурсан буюу мансуурсан, биеэ хянах чадваргүй болон бригадын бүрэлдэхүүнд ороогүй хүнээр цахилгаан байгууламжид ажил гүйцэтгүүлэх, ажил гүйцэтгэж байх үед дэргэдээ байлгахыг хатуу хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

2.1. Аюулгүй ажиллагааг хариуцагчид ба тэдгээрийн эрх, үүрэг

77. Цахилгаан байгууламжид ажил гүйцэтгэхдээ аюулгүй ажиллагааг хангах дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Аюулгүй ажиллагаа хариуцагчдыг томилох;
- Наряд олгох, шийдвэр өгөх буюу ажлын даалгавар өгөх;
- Ажлын байр бэлтгэх ба ажилд оруулах зөвшөөрөл өгөх;
- Ажлын байр бэлтгэх;
- Ажилд оруулах;
- Ажлын явцад хяналт тавих;
- Ажлын завсарлага ба ажилд үргэлжлүүлэн оруулах;
- Ажил бүрэн дуусах үед ажлын байрыг хүлээлгэн өгөх ба хүлээн авах, наряд (шийдвэр) хаах;
- Ажлын байрыг хүлээн авч наряд (шийдвэр) хаасны дараа хүчдэлд залгах;

78. Цахилгаан байгууламжид гүйцэтгэх ажлын аюулгүй байдлыг дараах ажилтан нар хариуцна:

- Ажил олгогч
- Наряд олгогч, шийдвэр өгөгч, ажлын даалгавар өгөгч;
- Ажлын удирдагч;
- Ажлын байр бэлтгэх ба ажилд оруулах зөвшөөрөл олгогч (цаашид зөвшөөрөл олгогч гэх)
- Ажлын байр бэлтгэгч;
- Ажилд оруулагч;
- Ажлын хариуцлагатай гүйцэтгэгч (цаашид ажил гүйцэтгэгч гэх);
- Ажиглагч (Хянагч);
- Бригадын гишүүн;

79. Ажил олгогч нь аюулгүй байдлыг хариуцагчид болон цахилгаан байгууламжид ганцаараа үзлэг хийх эрх бүхий ажилтны нэрсийг энэхүү дүрмийн шаардлагад нийцүүлэн тухай бүр шинэчлэн батална.

80. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид V групптэй, 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжид IV-өөс доошгүй групптэй ажилтанд наряд олгох, шийдвэр өгөх эрх олгоно.

81. Осол, гэмтэл түүний хор уршгийг арилгах зайлшгүй шаардлагатай үед наряд, шийдвэр өгөх эрх бүхий ажилтан байхгүй тохиолдолд наряд олгох, шийдвэр өгөх үүргийг ажил олгогчоос баталсан журмын дагуу шуурхай ажиллагааны IV групптэй ажилтан гүйцэтгэж болно.

82. Наряд олгогч, шийдвэр болон ажлын даалгавар өгөгч нь тухайн ажлыг аюулгүй гүйцэтгэх шаардлага, бололцоог тодорхойлно.

83. Наряд олгогч нь наряддаа тусгасан аюулгүй ажиллагааны арга хэмжээ нь бүрэн, үнэн зөв болсон, түүнчлэн бригадын бүрэлдэхүүний мэдлэг чадварын түвшин, ажилтны тоо, аюулгүй ажиллагаа хариуцагч нарыг томилсон байдал, тэдгээрийн аюулгүй

ажиллагааны групп нь гүйцэтгэж байгаа ажилтайгаа тохирч байгаа эсэх, ажлын удирдагч, ажил гүйцэтгэгч, ажиглагч нарт тухайлсан зааварчилгаа өгөхийг хариуцна.

84. Ажлын удирдагчаар V групптэй ажилтныг батална.

85. Ажлын удирдагч нь нарыадад заасан аюулгүй байдлыг хангах бүх арга хэмжээний биелэлт, тэдгээрийн бүрэн хангалттай болсон эсэх, ажлыг аюулгүй гүйцэтгэх зохион байгуулалт болон ажил гүйцэтгэгчид тухайлсан зааварчилгаа өгөх, ажил гүйцэтгэгчээс бригадын гишүүдэд тухайлсан зааварчилгаа өгсөн эсэхийг тус тус хариуцна.

86. Ажлыг ажил удирдагчийн тасралтгүй хяналтан дор гүйцэтгэх шаардлагатай бол наряд олгогч нь нарядын “Тусгай заалт” мөрөнд энэ тухай бичих ёстой.

87. Ажлын удирдагчийг 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид ажил гүйцэтгэхэд томилох ба 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжид ажлын удирдагч томилохгүй байж болно.

88. Ажлын удирдагчийг дор дурьдсан ажлыг гүйцэтгэхэд хүчдэлийн түвшинг үл харгалзан заавал томилно. Үүнд:

- Машин, механизм ашиглан ажил гүйцэтгэх;
- Гүйдэл дамжуулах хэсгийг бүх талаас нь хүчдэлээс салгасан эсхүл цахилгаан холболтын энгийн хялбар бүдүүвч бүхий цахилгаан байгууламж, цахилгаан хөдөлгүүр, тэдгээрийн хуваарилах байгууламж доторх холболтууд болон энэ дүрмийн 115-д зааснаас бусад бүх төрлийн цахилгаан тоног төхөөрөмжийн хүчдэлийг тасалж ажил гүйцэтгэх;
- Тээврийн хэрэгслийн нягтрал ихтэй болон 2 ба түүнээс дээш тооны кабель шугам, холбооны шугам бүхий газарт ажил гүйцэтгэх;
- Агаарын шугамын бүх төрлийн тулгуур суурилуулах, босгох, буулгах, эд ангиудыг солих;
- Цахилгаан дамжуулах шугамын тээврийн хэрэгслийн гол зам болон бусад шугамтай огтлолцсон хэсэг, ил хуваарилах байгууламж доторх шугамын утас огтлолцсон хэсэгт тус тус ажиллах;
- Шинээр суурилуулсан цахилгаан байгууламж, цахилгаан дамжуулах шугамыг залгах;
- Цахилгаан байгууламж, цахилгаан дамжуулах шугамын утас ба троссын холболтын бүдүүвч (схем)-ийг өөрчлөх;
- Олон хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын тасалсан хэлхээн дээр нэг хэлхээ нь нөгөө хэлхээнийхээ дээр байрласан үед болон 2-оос олон хэлхээтэй шугамын нэг буюу түүнээс дээшх тооны хэлхээнд хүчдэлтэй үлдэх үед ажиллах;
- Тухайн цахилгаан байгууламжид хоёр ба түүнээс олон тооны бригад нэгэн зэрэг ажиллах;
- Агаарын шугамын фаз дээр ээлжлэн засвар хийх;
- Нөлөөллийн хүчдэлтэй үед ажиллах;

89. Ажил олгогчоос тусгайлан эрх олгосон, ажлын байрны тодорхойлолтод нь шуурхай ажиллагааг зохицуулахаар заасан аюулгүй ажиллагааны V групптэй ажилтан зөвшөөрөл олгогч байна.

90. Зөвшөөрөл олгогч нь нарыадад заасан аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нь бүрэн, үнэн зөв ба гүйцэтгэх ажлын онцлогт тохирсон эсэхэд хяналт тавих, ажлыг аюулгүй гүйцэтгэхийн тулд тоног төхөөрөмжид хийх таслалт, газардуулгын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжтой ба тэдгээр нь хангалттай болох, мөн түүнчлэн ажилд оруулж байгаа бригадуудын ажлын хуваарилалт, хугацаа болон ажлын байр бэлтгэгч, ажилд оруулагчид тухайлсан зааварчилгаа өгөхийг тус тус хариуцна.

91. Зөвшөөрөл олгогч нь ажлын байр бэлтгэгч (тухайн байгууламжийг хариуцсан шуурхай ажиллагаа буюу шуурхай үйлчилгээ-засварын ажилтан)-д мөн түүнчлэн ажилд оруулагчид тухайн цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжид урьдчилан гүйцэтгэсэн таслалт ба тавьсан газардуулгын тухай мэдэгдэх ёстой.

92. Ажлын байр бэлтгэгч нь нарыадад заасан (таслах, цоожлох, плакат өлгөх, хаалт хашилт, газардуулга тавих гэх мэт) ажлын байр бэлтгэх арга хэмжээнүүдийг бүрэн, үнэн зөвөөр гүйцэтгэхийг хариуцна.

93. Тухайн цахилгаан байгууламжид сэлгэн залгалт хийх зөвшөөрөлтэй шуурхай ажиллагааны буюу шуурхай үйлчилгээ-засварын ажилтан ажлын байр бэлтгэх эрхтэй байна.

94. Ажилд оруулагч нь аюулгүй байдлыг хангахаар авсан арга хэмжээ нь наряд (шийдвэрт)-т заагдсан арга хэмжээтэй тохирч үнэн зөв ба хангалттай болсныг, мөн түүнчлэн ажлын удирдагч, ажил гүйцэтгэгч, ажиглагч нарт тухайлсан зааварчилгаа өгөхийг тус тус хариуцна.

95. Ажлын байр бэлтгэгч, ажилд оруулагчийг шуурхай ажиллагааны буюу шуурхай үйлчилгээ-засварын ажилтан нараас томилох бөгөөд аюулгүй ажиллагааны IV-өөс доошгүй групптэй байх ёстой.

96. Ажил гүйцэтгэгч нь дор дурьдсан асуудлыг хариуцна. Үүнд:

- Бэлтгэсэн ажлын байр нь нарыдад заасан арга хэмжээтэй тохирч, аюулгүй байдлыг хангасныг;
- Бригадын гишүүдэд өгсөн тухайлсан зааварчилгаа бүрэн, чанартай болсныг;
- Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хамгаалах хэрэгсэл, багаж, бусад хэрэгсэлийн бүрэн, бүтэн байдлыг;
- Багаж, хэрэгслийг зөв ашиглаж, хэрэглэхийг;
- Тухайн ажлын байранд тавьсан газардуулга, хаалт хашилт, аюулгүй ажиллагааны плакат, тэмдэг, цоож, түгжээний бүрэн бүтэн, хөдөлгөөнгүй байдлыг;
- Ажлыг аюулгүй гүйцэтгэх, энэ дүрмийг өөрөө болон бригадын гишүүд дагаж мөрдөхийг;
- Бригадын гишүүдэд байнгын хяналт тавихыг;

97. Нарыдаар ажил гүйцэтгэх үед ажил гүйцэтгэгч нь 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид IV-өөс доошгүй групптэй, 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжид ажил гүйцэтгэх (хорт хий ялгарч болзошгүй газар доорх байгууламж, хүчдэлтэй тоног төхөөрөмж, байгууламжид буюу тэдгээрийн доор ажил гүйцэтгэхээс бусад) үед III-аас доошгүй групптэй байх ёстой.

98. Энэ дүрмийн 148, 150, 365, 744-т зааснаас бусад тохиолдолд шийдвэрээр ажил гүйцэтгэх үед ажил гүйцэтгэгч нь III групптэй байж болно.

99. Ажиглагчийг цахилгаан байгууламжид бие даан ажиллах эрхгүй ажилтнаас бүрдсэн эсвэл бригадын гишүүдийг хэд хэдэн ажлын байранд тараан байрлуулах үед бригадын ажиллагаанд давхар хяналт тавих зорилгоор томилно.

100. Ажиглагч нь аюулгүй ажиллагааны III-аас доошгүй групптэй байх ба дор дурьдсан байдалд ажиглалт хийж аливаа зөрчил илэрвэл ажил гүйцэтгэгч (ажлын удирдагч)-д нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Үүнд:

- Бэлтгэсэн ажлын байр нь аюулгүй байдлыг хангасан эсэх;
- Бригадын гишүүдэд өгсөн тухайлсан зааварчилгаа бүрэн, ойлгомжтой, чанартай болсон эсэх;
- Ажлын байранд тавьсан газардуулга, хаалт, хашилт, плакат, тэмдэг, цоож, түгжээ бүрэн, бүтэн эсэх;
- Аюултай нөхцөл байдал үүссэн эсэх;

101. Бригадын гишүүн бүр энэхүү дүрэм, ажил эхлэх ба ажлын явцад авсан зааварчилгаа, түүнчлэн ажил олгогчоос баталсан заавар, журмыг биелүүлэх үүрэгтэй.

102. Ажил гүйцэтгэх явцад бусдын анхаарлыг саринуулах, сэтгэл санааг үймүүлэх, тоглох үйлдэл гаргах, шаардлагагүй тохиолдолд утсаар ярихыг хатуу хориглоно.

103. Ажлын аюулгүй байдлыг хариуцах ажилтныг 2 дугаар хүснэгтэд заасны дагуу хавсран гүйцэтгүүлж болно.

Хүснэгт 2

Аюулгүй ажиллагаа хариуцах ажилтны үүргийг хавсран гүйцэтгэж болох тодорхойлолт

№	Аюулгүй ажиллагаа хариуцах ажилтан	Хэний үүргийг хавсран гүйцэтгэж болох
1	Наряд олгогч, шийдвэр өгөгч	Ажлын удирдагчийг;

		Байнгын жижүүргүй ажлын байранд ажилд оруулагчийг;
2	Ажлын удирдагч	Ажил гүйцэтгэгчийг;
3	Шуурхай үйлчилгээ-засварын хүн ажлын удирдагч байвал	Байнгын жижүүргүй ажлын байранд ажилд оруулагчийг;
4	Шуурхай үйлчилгээ-засварын хүн ажил гүйцэтгэгч байвал	Энгийн тодорхой схемтэй цахилгаан байгууламжид ажилд оруулагчийг;
5	Ажил гүйцэтгэгч IV групптэй байвал	Реле хамгаалалт, автоматикийн төхөөрөмжид ажилд оруулагчийг;
6	Шуурхай үйлчилгээ-засварын хүн ажилд оруулагч байвал	Бригадын гишүүнийг;

104. Хүчдэлийн түвшинээс үл хамааран ЦДАШ-д ажлын байр бэлтгэхдээ таслах, залгах аппаратаар үйлдэл хийхгүйгээр зөвхөн хүчдэлгүй болсныг шалгаад зөөврийн газардуулга тавих бол ажлын удирдагч эсхүл ажил гүйцэтгэгч нь засварын ажилтнаас томилогдсон тохиолдолд ажилд оруулагчийн үүргийг хавсран гүйцэтгэж болно.

2.2. Нарядаар гүйцэтгэх ажлын зохион байгуулалт

105. Нарядыг хоёр хувь бичнэ. Хэрвээ телефон, радио, факс, цахим шуудангаар дамжуулж байгаа бол наряд олгогч нь нэг хувь, түүнийг хүлээн авч байгаа ажилтан хоёр хувь бичиж, нягтлан шалгасны дараа наряд олгогчийн гарын үсэг зурах мөрөнд наряд олгогчийн нэрийг бичээд өөрийн гарын үсгээ зурж, бичлэгийн үнэн зөв болохыг батална.

106. Ажил гүйцэтгэгч нь ажилд оруулагчаар давхар томилогдсон тохиолдолд нарядыг дамжуулах аргаас нь үл хамааран хоёр хувь бичих ба нэг хувь нь наряд олгогчид үлдэх ёстой.

107. Тухайн онцлогоос нь (диспетчерийн байрлал) хамаарч нарядын нэг хувийг зөвшөөрөл олгогчид (диспетчерт) үлдээж болно.

108. Ажлын удирдагчид олгох нарядын тоог наряд олгогч тогтооно. Ажилд оруулагч, эсвэл ажил гүйцэтгэгчид ээлж дараатайгаар гүйцэтгэх ажлын хэд хэдэн нарядыг зэрэг олгож болно.

109. Өмнө нь өгсөн нарыдаар гүйцэтгэх ажлын хүрээнд дараа нь өгөх нарядын ажил ямар нэгэн давхцал үүсгэх, эсвэл аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагаа нь нэгдмэл байх шаардлагатай тохиолдолд түрүүчийн ажлын наряд олгогч, ажлын удирдагчтай зөвшөөрөлцөх ёстой.

110. Дээрх тохиолдолд нарядыг ажил эхлэхийн өмнө зөвшөөрөлцөөд нарядын “Тусгай заалт” мөрөнд “зөвшөөрсөн” гэж бичээд өмнө нь наряд олгосон хүн гарын үсэг зурсан байвал зохино. Энэ тухай зөвшөөрөл олгогч нь шуурхай ажиллагааны журналд тэмдэглэж өмнө өгсөн нарядын ажлын хариуцлагатай гүйцэтгэгчид мэдэгдэж, нарядын “Тусгай заалт”-д тэмдэглүүлэх ба ажил гүйцэтгэгч нь өөрт байгаа нарядын “Тусгай заалт” мөрөнд “зөвшөөрсөн” гэж бичээд зөвшөөрөл өгсөн хүний нэрийг бичиж өөрийн гарын үсгийг зурна.

111. Нарядыг ажил эхлэх өдрөөс хуанлийн 15 хоногоос илүүгүй хугацаатай олгоно. Ажлын завсарлагаар наряд нь хүчинтэй хэвээр байна.

112. Наряд олгосон ажилтан эсвэл тухайн цахилгаан байгууламжид наряд олгох эрхтэй өөр ажилтан нарядыг хуанлийн 15 хоногоос илүүгүй хугацаагаар нэг удаа сунгаж болно. Наряд сунгах зөвшөөрлийг телефон, факс, цахим шуудангаар эсвэл ажил гүйцэтгэгчид шууд өгч болно. Энэ тохиолдолд зөвшөөрөл авсан ажилтан нь нарыдад зөвшөөрөл өгсөн хүний нэрийг бичиж өөрөө гарын үсэг зурна.

113. Бүрэн дууссан ажлын нарядыг 185 хоног хадгалах ба дараа нь устгаж болно. Нарыдаар ажил гүйцэтгэх үед осол, аваари гарсан бол тухайн нарядыг зөрчлийг судалсан баримт бичигтэй хамт хадгална.

114. Нарыдаар гүйцэтгэсэн ажлыг “Наряд ба шийдвэрийн бүртгэлийн журнал” (Хавсралт №4)-д бичнэ.

115. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид гүйдэл дамжуулах хэсэг, түүний дотор ЦДАШ, КШ-ын оруулгын хүчдэлийг бүх талаас нь бүрэн тасалсан, зэргэлдээх цахилгаан байгууламжид орох боломжийг хааж түгжсэн (1000 В хүртэл

хүчдэлийн щит, цуглуулга нь хүчдэлтэй байж болно) тохиолдолд тухайн байгууламжийн бүх холболтууд дээр нэгэн зэрэг ажиллахад нэг наряд олгож болно.

116. 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжид гүйдэл дамжуулах хэсгийг бүх талаас нь бүрэн тасалсан тохиолдолд тухайн ХБ-н ерөнхий шин, хуваарилах щит, цуглуулга мөн түүнчлэн бусад холболтууд дээр нэгэн зэрэг ажиллахад нэг наряд олгож болно.

117. Агрегат (зуух, турбин, генератор г.м.) болон бие даасан технологийн байгууламж (үнс зайлуулах систем, сүлжээний ус халаагч, бутлуур г.м.)-ийг засварт гаргах үед тэдгээрийн цахилгаан хөдөлгүүр болон ХБ-д ажил гүйцэтгэх нэг наряд олгож болно.

118. БХБ маягийн шкафаар тоноглогдсон ХБ-ийн холболтууд ба тэдгээрээс тэжээгдэж байгаа цахилгаан хөдөлгүүр дээр нэг нарыдаар ажил гүйцэтгэхэд нэг ажлын байрнаас нөгөө ажлын байранд шилжих үйлдлийг нарыдад бичих шаардлагагүй ба бригадын гишүүдийг ажлын байранд тараан ажиллуулахыг зөвшөөрнө.

119. ХБ нь өөр хийцтэй бол түүний холболт болон цахилгаан хөдөлгүүр дээр ажилд оруулах ба ажлын нэг байрнаас нөгөө байранд шилжихийг нарыдад тэмдэглэх ёстой.

120. 3-110 кВ-ын ХБ-д нэг систем шинтэй бүх секцийг засварт гаргахад тэдгээр секцийн ерөнхий шин ба түүний бүх (эсвэл аль нэг) холболтод гүйцэтгэх ажилд нэг наряд олгохыг зөвшөөрнө. Эдгээр секцийн хүрээнд бригадын гишүүдийг тараан ажиллуулахыг зөвшөөрнө.

121. Нэг цахилгаан байгууламжийн нэг буюу хэд хэдэн холболт дээр нэгэн зэрэг эсвэл дэс дараатайгаар дор дурьдсан ажлыг гүйцэтгэхэд нэг наряд олгож болно.

- Цахилгаан тоног төхөөрөмжийг турших, реле хамгаалалт, автоматик, телемеханик, хориг түгжээ, хэмжих хэрэгслийг шалгаж тохируулах;
- Нэг холболтын сэлгэн залгалтын аппарат (түүний дотор тухайн аппаратын залуур нь өөр байранд байх)-д засвар хийх;
- Туннель, коллектор, худаг, ухсан нүхэнд байгаа дан кабелийг засах;
- Бригадын үйл ажиллагаанд ажил гүйцэтгэгч нь хяналт тавих бололцоотой ухсан хоёр нүх, эсвэл ХБ-ийн зэргэлдээ ухсан нэг нүхэнд хоёроос илүүгүй кабель шугамд засвар хийх;

Дээрх ажлыг гүйцэтгэхдээ бригадын гишүүдийг тараан ажиллуулж болох бөгөөд нэг ажлын байрнаас нөгөө ажлын байранд шилжих үйлдлийг нарыдад бичих шаардлагагүй.

122. Энэ дүрмийн 115, 116, 117, 120, 121, 125-д заасан нэг нарыдаар гүйцэтгэх бүх ажлын байрыг бригадыг ажилд оруулахаас өмнө бэлтгэсэн байх ёстой.

123. Нарыдаар гүйцэтгэх ажил бүрэн дуусахаас өмнө аль ч холболт, түүний дотор цахилгаан хөдөлгүүрийг ажиллуулж туршихаар хүчдэл залгах, залгах бэлтгэл хийхийг хориглоно.

124. Нарыдад бичигдсэн ажлын байрны хүрээнд III-аас доошгүй групптэй нэг болон хэд хэдэн бригадын гишүүнийг ажил гүйцэтгэгчээс тусад нь ажиллуулж болно. Энэ тохиолдолд ажил гүйцэтгэгч нь тусдаа ажил гүйцэтгэх бригадын гишүүдийг тухайн ажлын байранд нь хүргэж өгөөд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх ба зааварчилгаа өгсөн, авсан тэмдэглэл хөтлөх шаардлагагүй.

125. Хэд хэдэн дэд станц дээр эсвэл нэг дэд станцын хэд хэдэн холболт дээр дараалуулан гүйцэтгэх ижил төрлийн дараах ажилд нэг наряд олгож болно. Үүнд:

- Тусгаарлагчийг арчиж цэвэрлэх;
- Контакт авалцах холбоосыг чангалах;
- Тосны сорьц авах, тос нэмэх;
- Трансформаторын анцаф өөрчлөх;
- Реле хамгаалалт, автоматик, хэмжих багажийг шалгах;
- Гадны эх үүсвэрээс хүчдэл авч өндөр хүчдэлийн туршилт хийх;
- Тусгаарлагчийг штангаар шалгах;
- КШ-ын гэмтлийг тодорхойлох;

Энэ заалтаар олгосон наряд нэг хоногийн хугацаанд хүчинтэй байна.

126. Дэд станц ба холболт тус бүрт нь авах арга хэмжээг нарыдын холбогдох хэсэгт нь бичиж баталгаажуулна.

127. Дэд станц бүрийг нарыдад тусгагдсан ажил бүрэн дууссаны дараа хүчдэлд залгахыг зөвшөөрнө.

128. Хуваарилах байгууламжийн хашаанд байгаа ЦДАШ-д тухайн шугамд үйлчилгээ үзүүлэгч байгууллагын олгосон нарыдаар ажил гүйцэтгэнэ.

129. Байнгын жижүүртэй хуваарилах байгууламж дахь ЦДАШ-ын төгсгөлийн тулгуур дээр ажил гүйцэтгэхэд уг хуваарилах байгууламжийн шуурхай ажиллагааны ажилтан нь ажил гүйцэтгэх бригадад зааварчилгаа өгч, тухайн тулгуурт хүргэж өгөх үүрэгтэй.

130. Байнгын жижүүргүй цахилгаан байгууламжид шугамын бригадын ажил гүйцэтгэгч нь ХБ-ийн түлхүүрийг авч өөрөө тухайн тулгуурт бригадыг дагуулан очихыг зөвшөөрнө.

131. Ил хуваарилах байгууламжийн портал, хаалттай хуваарилах байгууламжийн барилга, иж бүрдмэл хуваарилах байгууламжийн дээвэр дээр ажил гүйцэтгэхэд тухайн хуваарилах байгууламжид үйлчилдэг шуурхай ажиллагааны ажилтанг ажилд оруулагчаар томилж нарядын дагуу бригадыг ажилд оруулна.

132. Бригад нь хуваарилах байгууламжаас ажил гүйцэтгэгчийн хамт гарч болох ба харин бригадын гишүүдийн хувьд энэ дүрмийн 202, 203, 204, 205-д заасныг мөрдлөг болгоно.

133. Хуваарилах байгууламжийн кабель шугамын холболт дээр хийгдэх ажлыг тухайн хуваарилах байгууламжийн үйлчилгээг хариуцагч байгууллагын олгосон нарыдаар гүйцэтгэнэ. Хэрэв хуваарилах байгууламж болон кабель шугам нь өөр өөр байгууллагын эзэмшилд байдаг бол дээр дурьдсан ажлыг энэ дүрмийн 12 дугаар бүлэгт заасны дагуу гүйцэтгэнэ. Дээрхийн аль ч тохиолдолд ХБ-ийн ашиглалт үйлчилгээ хариуцагч байгууллагын ажилтан ажилд оруулагч байна.

134. Хуваарилах байгууламж дахь холбооны төхөөрөмжид гүйцэтгэх ажлыг тухайн тоног төхөөрөмжийн үйлчилгээг хариуцагчийн олгосон нарыдаар гүйцэтгэнэ. Энэхүү ажлын нарядыг ХБ-ийн ашиглалт үйлчилгээг хариуцагч олгож болно.

135. Холбооны конденсатор, өндөр давтамжийн заградитель дээр зөвхөн ХБ-ийн ашиглалт үйлчилгээг хариуцагчийн олгосон нарыдаар ажил гүйцэтгэнэ.

136. Диспетчерийн ба технологийн удирдлагын хэрэгслийн төхөөрөмж дээр тухайн хуваарилах байгууламжийн үйлчилгээг хариуцагч ажилтан ажлын байр бэлтгэх ба ажилд оруулна.

137. ЦДАШ-д ажил гүйцэтгэхдээ бие даасан шугам эсхүл салбарласан шугам тус бүрт, харин олон хэлхээт шугамд ажил гүйцэтгэхдээ хэлхээ тус бүрт нь наряд олгоно. Доорх тохиолдолд хэд хэдэн агаарын шугам (тэдгээрийн хэлхээнд)-д нэг наряд олгож болно. Тухайлбал:

- Бүх хэлхээний хүчдэлийг тасалсан эсвэл бүх хэлхээ нь хүчдэлтэй байгаа олон хэлхээт агаарын шугамд ажил гүйцэтгэх;
- ЦДАШ-ын огтлолцсон хэсэгт ажил гүйцэтгэх;
- 1000 В хүртэл хүчдэлийн ЦДАШ-уудад тэдгээрийн тэжээлийн трансформатор (АТП, ХТП, КТП г.м.)-ын хүчдэлийг тасалсан нөхцөлд ээлж дараатайгаар ажил гүйцэтгэх;
- ЦДАШ-ын гүйдэл үл дамжуулах хэсэг дээр хүчдэлийг нь таслах шаардлагагүй ижил төрлийн ажил гүйцэтгэх;

Засварлах гэж байгаа ЦДАШ нь нөлөөллийн хүчдэлтэй эсэх болон тухайн ЦДАШ-тай огтлолцсон ЦДАШ-ын хүчдэлийг таслаж, газардуулга хэрхэн тавих шаардлагатайг (энэ дүрмийн 3.8-д заасны дагуу) нарыдад тодорхой бичнэ. Түүнчлэн ажлын нөхцлөөс хамааран ЦДАШ-ын ойролцоо байрлалтай ЦДАШ-ын хүчдэлийг таслах шаардлагатай бол энэ тухай нарыдад дээрхийн адил бичнэ.

138. ЦДАШ-ын өөр өөр хэсэг, тулгуур дээр нэг нарыдаар ажил гүйцэтгэх үед ажлын нэг байрнаас нөгөө байранд шилжих үйлдлийг нарыдад бичих шаардлагагүй.

139. Хүчдэлийг нь тасалсан агаарын шугамын 2 км-ээс илүүгүй урттай хэсэгт бригадыг тараан ажиллуулж болно. Харин анкерын их урттай алгасалтанд утас, трос угсрах ба буулгах үед бригадын ажиллах хэсгийн уртыг наряд олгогч тодорхойлно.

140. Хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсэг дээр ажил гүйцэтгэх үед бригад нь зөвхөн нэг тулгуур (завсарын нэг алгасалтан) дээр эсвэл зэргэлдээ орших хоёр тулгуур дээр л ажил гүйцэтгэж болно.

141. Фаз тус бүрээр гүйцэтгэх засварын ажлын үед фазын утасны солбицлын нэг хэсэгт л наряд олгоно.

2.3. Шийдвэрээр гүйцэтгэх ажлын зохион байгуулалт

142. Ажил гүйцэтгэх хугацаа нь тухайн ажлыг хийх ажилтны тухайн өдрийн ажлын цагаар хязгаарлагдах, энэ дүрмээр зөвшөөрсөн нэг удаа гүйцэтгэх ажлыг шийдвэрээр гүйцэтгэнэ. Ажлыг үргэлжлүүлэх шаардлага гарсан эсвэл ажлын нөхцөл, бригадын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд шийдвэрийг шинээр өгнө.

143. Шийдвэрээр ажил гүйцэтгэх үед ажлын завсарлагын дараа ажил гүйцэтгэгч нь ажилд оруулна.

144. Шийдвэрээр гүйцэтгэх ажлын жагсаалтыг ажил олгогч батлах бөгөөд наряд олгогч, шийдвэр өгөгчийн шийдсэнээр нарыдаар хийж болно.

145. Шийдвэр өгөгч нь ажил гүйцэтгэгчид шийдвэр өгөх ба ажил гүйцэтгэгч нь зөвшөөрөл олгогчоос зөвшөөрөл авсны дараа ажлыг гүйцэтгэнэ. Байнгын жижүүргүй цахилгаан байгууламжид урьдчилан ажлын байр бэлтгэх шаардлагагүй тохиолдолд шийдвэрийг гүйцэтгэх ажилтанд шууд өгч болно.

146. Шийдвэрийг хэд хэдэн цахилгаан байгууламж (холболт) дээр дараалуулан гүйцэтгэх ажилд нэг удаа өгч болно.

147. Шийдвэрээр гүйцэтгэж байгаа ажлыг “Наряд ба шийдвэрийн бүртгэлийн журнал”(Хавсралт №4)-д бүртгэнэ.

148. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид ажлын байр бэлтгэх хугацааг оролцуулахгүйгээр нэг цагаас илүүгүй хугацаанд хойшлуулшгүй гүйцэтгэх шаардлагатай ажлыг шуурхай ажиллагааны болон шуурхай үйлчилгээ-засварын ажилтан эсвэл түүний хяналтан дор засварын ажилтан шийдвэрээр гүйцэтгэж болно.

149. Хойшлуулшгүй боловч нэг цагаас илүү хугацаагаар, мөн ажиглагчийг оролцуулаад гурваас илүү хүн хийх ажлыг нарыдаар гүйцэтгэнэ.

150. Хойшлуулшгүй ажил гүйцэтгэж байгаа, эсвэл хяналт тавьж байгаа шуурхай ажиллагааны буюу шуурхай үйлчилгээ-засварын ажилтан нь 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид IV-өөс доошгүй групптэй, 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжид III-аас доошгүй групптэй байх ба бригадын гишүүд нь III-аас доошгүй групптэй байх ёстой.

151. Шийдвэрээр ажилд оруулахын өмнө шийдвэр өгөгчийн тодорхойлсон ажлын байр бэлтгэх техникийн бүх арга хэмжээг авсан байх ёстой.

152. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид дор дурьдсан ажлыг шийдвэрээр гүйцэтгэж болно. Тухайлбал:

- Кабелийг салгаж үзүүрүүдийг нь богино холбон газардуулсан цахилгаан хөдөлгүүр дээр хийгдэх ажил;
- Гаргалгын шин буюу кабелийг салгаж тусгаарласан генератор дээр хийгдэх ажил;
- Кабелийн бүх үзүүрүүдийг тайлж хөндийрүүлсэн үед кабелийн гэмтлийг тодорхойлох ажил;

153. 1000 В хүртэлх хүчдэлийн цахилгаан байгууламжид дор зааснаас бусад тохиолдолд шийдвэрээр ажил гүйцэтгэж болно. Үүнд:

- Нарыдаар гүйцэтгэхээр заасан;
- Хуваарилах байгууламжийн ерөнхий шин, эсвэл түүний холболтууд дээр ажиллахад ерөнхий шинд нь хүчдэл залгагдаж болзошгүй нөхцөлтэй;
- ЦДАШ-д ачаа өргөх машин, механизм ашиглан ажил гүйцэтгэх;
- Энэ дүрмийн 682-т зааснаас бусад тохиолдолд гадна гэрэлтүүлгийн сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний ажил гүйцэтгэх;
- Энэ дүрмийн 943-д заасан нөхцөлд;

154. Цахилгаан гүйдэлд хүн нэрвэгдэж болзошгүй онцгой аюултайд тооцогдогоос бусад өрөө тасалгаанд байгаа 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжид III-аас доошгүй групптэй ажилтан ажил гүйцэтгэгчийн эрхтэй бол шийдвэрээр ганцаараа ажиллаж болно.

155. Ажил гүйцэтгэгч нь реле хамгаалалт, хэмжүүрийн хэрэгсэл, автоматик, хоёрдогч хэлхээ, телемеханик, холбоо ба таслах залгах аппаратын залуур, удирдлагын шүүгээнд угсралт, засвар, ашиглалтын ажил гүйцэтгэх явцад тэдгээр нь хүчдэлтэй эсэхээс үл хамааран дээрх тоноглолуудыг шуурхай ажиллагааны ажилтны зөвшөөрлөөр таслах буюу залгах, реле хамгаалалт, цахилгаан автоматикийн тоноглолыг таслах залгах горимд шийдвэрээр ажиллуулан шалгаж болно.

156. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид III-аас доошгүй групптэй нэг ажилтан дараах ажлыг шийдвэрээр гүйцэтгэж болно. Үүнд:

- ИХБ-ийн дэвсгэр газрыг тохижуулах, өвс ургамлыг хадаж цэвэрлэх, зам талбайн цасыг цэвэрлэх;
- ХБ-ийн шүүгээний гадна газрын хөрс, шалнаас ажилтны хөлний ул хүртэл 1,2 метрээс илүүгүй өндөрт байрлалтай радио, телефон утсан холбооны тоноглол, гэрэлтүүлгэнд засвар үйлчилгээ хийх;
- Тос цэвэрлэх ба хатаах үед хатаагч төхөөрөмж ба түүнтэй адилтгах туслах аппаратад үйлчлэх;
- ХБ-ийн шүүгээний гадна байрлалтай тоног төхөөрөмжийн их бие дээрх бичлэгийг сэргээх;
- Ажиллагаанаас гаргасан трансформатор, генератор ба бусад тоног төхөөрөмжийг хатаах явцад хяналт тавих;
- Энэ дүрмээр зөвшөөрсөн бусад ажлыг гүйцэтгэх;

157. ЦДАШ-д хүчдэлийг нь таслах шаардлагагүй, гүйдэл үл дамжуулах хэсэгт гүйцэтгэх дараах ажлыг шийдвэрээр гүйцэтгэж болно. Үүнд:

- Газрын хөрснөөс ажил гүйцэтгэж буй ажилтны хөлний ул хүртэл 1,2 метр хүртэл өндөрт авирч гүйцэтгэх;
- Тулгуурын хийцийг задалж салгахгүйгээр гүйцэтгэх;
- Тулгуурын ёроол хэсгийн газрыг 0.5 метрээс илүүгүй гүн ухах;
- Тайрсан мод шугамын утсан дээр унахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагагүй, эсвэл тайрсан мод, мөчир нь унахдаа шугамын утсанд ойртож ажилтан, багаж хэрэгсэл, машин механизмд аюултай нөхцөл бүрдүүлэхээргүй тохиолдолд ЦДАШ-ын шугамын трассыг цэвэрлэх;
- Бүх түвшиний хүчдэлийн гүйдэл дамжуулах хэсэг нь хаалт, хашилттай нөхцөлд ХХБ-ын коридор, цахилгаан тоног төхөөрөмж бүхий өрөө тасалгааг шийдвэрээр II групптэй нэг хүн цэвэрлэж болно.

158. ЦДАШ-д II групптэй нэг хүн шийдвэрээр дараах ажлыг гүйцэтгэж болно. Үүнд:

- Хоногийн гэрэлтэй цагаар цаг агаарын аятай нөхцөлд ЦДАШ-д үзлэг хийх, тулгуурын бүрэн бүтэн байдлыг үнэлэх, модон тулгуурын өмхрөлтийг шалгах;
- Тулгуур дээрх байнгын санамж, бичлэгийг сэргээх;
- Өнцөг хэмжигчээр овор хэмжээг тодорхойлох;
- Тулгуурын эргэн тойронд цэвэрлэгээ хийх;
- Тулгуурын доод хэсгийн боолт бэхэлгээг будах;

159. 1000 В хүртэлх хүчдэлийн хуваарилах щит, хайрцгийг нь хааж, цоожилсон ил задгай кабельгүй өрөө тасалгааны цэвэрлэгээг I групптэй нэг хүн хийж болно.

2.4. Ашиглалтын явцад жагсаалтын дагуу гүйцэтгэх ажлын зохион байгуулалт

160. 1000 В хүртэлх хүчдэлийн цахилгаан байгууламжийн ашиглалтын явцад шуурхай ажиллагааны болон шуурхай үйлчилгээ-засварын ажилтан нь ээлжийн хугацаанд хийвэл зохих, өөрийн хариуцдаг хэсэг буюу тоног төхөөрөмж дээр ажлын байр бэлтгэн гүйцэтгэх багахан хэмжээний ажлын жагсаалтыг байгууллагын техникийн удирдлага ба хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнаар хянуулсны үндсэн дээр ажил олгогчоор батлуулна.

161. Ашиглалтын явцад гүйцэтгэх ажлын жагсаалтад цаашид ямар нэгэн нэмэлт удирдамж, шийдвэр, тухайлсан зааварчилгаа шаардагдахгүй байнга гүйцэтгэх ажил орох бөгөөд жагсаалтыг боловсруулахдаа дараах нөхцлийг харгалзана. Үүнд:

- Ажлыг аюулгүй гүйцэтгэх;
- Ажилтан уг ажлыг ганцаараа гүйцэтгэх боломжтой эсэх;
- Ажлын байрны тодорхойлолт;
- Ажилтны мэргэжил, мэргэшлийн түвшин;
- Цахилгаан байгууламж, түүний зарим хэсгийн технологийн үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол;

162. Ашиглалтын явцад гүйцэтгэх ажлын жагсаалтанд бригадаар гүйцэтгэх ажлын нэр төрлийг тусгасан байх ёстой.

163. Ашиглалтын явцад гүйцэтгэх ажлын жагсаалтад ажлыг хэрхэн бүртгэх (шууд харъяалах шуурхай ажиллагааны удирдах ажилтанд ажлын байр, гүйцэтгэх ажлын шинж чанар, эхлэх дуусах хугацаа, шуурхай ажиллагааны журналд хэрхэн тэмдэглэх г.м.) талаар тусгасан байна.

164. Ашиглалтын явцад гүйцэтгэх ажлын жагсаалтаар III-аас доошгүй групптэй нэг хүн дараах ажлыг гүйцэтгэж болно. Үүнд:

- Нэг талын тэжээлтэй цахилгаан хэлхээнд гүйцэтгэх ажил;
- Цахилгаан хөдөлгүүр болон тоног төхөөрөмжийн кабель, утсыг тайлж салгах буюу залгаж чангалах;
- Щит цуглуулгын хайрцагны гадна байрлалтай соронзон залгуур, рубильник, контактор, залгах товчлуур болон тэдгээртэй ижил төрлийн тасалж залгах аппаратад засвар хийх;
- Тусдаа ажиллагаатай цахилгаан төхөөрөмж (цахилгаан хөдөлгүүр, цахилгаан халаагуур г.м)-д засвар хийх;
- Тусдаа байрлалтай соронзон станц ба удирдлагын блокын засвар, цахилгаан машины аппаратын сойзонд үйлчилгээ хийх;
- Нэг фазын тоолуур, хэмжих багаж, хэрэгсэл (таслах, залгах, салгах г.м.) хэрэгслийг салгаж авах, тавих;
- Газрын хөрс, шалнаас ажилтны хөлийн ул хүртэл 1,2 метрээс илүүгүй өндөрт байрлалтай гал хамгаалагч, хайламтгай хамгаалуур, автомат солих, гэрэлтүүлгийн шугам, арматур засах г.м.;
- Энэхүү дүрмээр зөвшөөрөгдсөн бусад ажил;

165. Ашиглалтын явцад гүйцэтгэх ажлын жагсаалтаар II групптэй нэг хүн дараах ажлыг гүйцэтгэж болно. Үүнд:

- Тоолуурын заалт авах;
- Газрын хөрс, шалнаас ажилтны хөлийн ул хүртэл 1,2 метрээс илүүгүй өндөрт байрлалтай гэрлийн шил солих, заалт авах г.м.
- Нэг фазын автоматыг таслах, залгах, солих, унтраалга, розетка засварлах г.м.

166. Энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол байгууллагын онцлог, ажлын нөхцлөөс нь хамааран ажил олгогчийн зөвшөөрснөөр жагсаалтад дээр дурьдсанаас өөр нэмэлт ажлыг оруулж болно. Энэ тохиолдолд ямар ажлыг бригадаар гүйцэтгэхийг тодорхой зааж өгөх ёстой.

2.5. Бригадын бүрэлдэхүүн

167. Бригадын бүрэлдэхүүнд орох хүний тоо, тэдгээрийн аюулгүй ажиллагааны группыг тухайн ажлыг гүйцэтгэх нөхцөл, мөн түүнчлэн ажил гүйцэтгэгч (ажиглагч) бригадын гишүүдэд хяналт тавих бололцоог харгалзан тодорхойлох ёстой.

168. Бригадын бүрэлдэхүүнд ажил гүйцэтгэж байгаа, эсвэл хяналт тавьж байгаа шуурхай ажиллагааны буюу шуурхай үйлчилгээ-засварын ажилтан нь 1000 В-оос дээш

хүчдэлийн цахилгаан байгууламжид IV-өөс доошгүй групптэй, 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжид III-аас доошгүй групптэй байна.

169. Бригадын бүрэлдэхүүнд III-аас доошгүй групптэй гишүүн бүрт I-II групптэй нэг хүн оногдохоор тооцож оруулж болох боловч тухайн бригадад II групптэй хүн гурваас ихгүй, I групптэй хүн нэгээс ихгүй, нийт I-II групптэй хүн гурваас ихгүй байх ёстой.

170. Ээлжинд (жижүүрт) байгаа шуурхай үйлчилгээ-засварын ажилтныг удирдлагынхан зөвшөөрөлтэйгээр нарыадад оруулалгүйгээр шуурхай ажиллагааны журналд бичээд засварын бригадын ажилд оролцуулж болно.

171. Бригадын бүрэлдэхүүнд наряд олгосон ажилтан эсвэл тухайн цахилгаан байгууламж ба ажилд наряд олгох эрх бүхий ажилтан өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө.

172. Бригадын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахад энэхүү дүрмийн 169, 170, 171-д заасан шаардлагыг хангах бөгөөд бригадын бүрэлдэхүүнд шинээр орсон ажилтанд ажил гүйцэтгэгч нь тухайлсан зааварчилгаа өгөх ёстой.

173. Бригадын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах болсон тухай нарыадад өөрчлөлт оруулсан ажилтан нь утас, холбооны хэрэгсэл ашиглан ажлын удирдагчид, хэрвээ ажлын удирдагч томилоогүй бол ажил гүйцэтгэгчид мэдэгдэнэ. Бригадын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шийдвэрийг хүлээн авсан ажлын удирдагч, ажил гүйцэтгэгч нь шийдвэр өгсөн ажилтны нэр, бригадын бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг нарыадад бичнэ.

174. Ажлын удирдагч эсвэл ажил гүйцэтгэгч, түүнчлэн бригадын бүрэлдэхүүний 50 хувь нь өөрчлөгдсөн тохиолдолд нарыадаар заагдсан ажлын нөхцөл өөрчлөгдсөн гэж үзэж нарыадыг шинээр бичих ёстой.

2.6. Ажлын байр бэлтгэх ба ажилд оруулах зөвшөөрөл өгөх

175. Зөвхөн зөвшөөрөл олгогчоос зөвшөөрөл авсны дараа ажлын байр бэлтгэх, ажилд оруулах арга хэмжээг зохион байгуулна. Аваари, ослын үед болон хойшлуулшгүй ажлыг шийдвэрээр гүйцэтгэх үед ч ажлын байр бэлтгэх ба ажилд оруулах зөвшөөрлийг заавал авна.

176. Зөвшөөрлийг ажлын байр бэлтгэгч, ажилд оруулагчид шууд өгөх буюу эсвэл утас, холбооны хэрэгсэл, завсрын дэд станцын жижүүрээр дамжуулан өгч болно. Ийм зөвшөөрлийг урьдчилан өгөхийг хориглоно.

177. Зөвшөөрөл олгогч нь бригадуудын ажлын үргэлжлэх хугацаа, дараалал, ач холбогдлыг нь харгалзан зөвшөөрөл олгоно.

2.7. Наряд, шийдвэрээр ажлын байр бэлтгэх ба анх ажилд оруулах

178. Ажлын байр бэлтгэх талаар нарыадад заасан арга хэмжээг өөрчлөхийг хориглоно.

179. Ажлын байр бэлтгэх явцад нарыадад заасан арга хэмжээ нь хангалттай ба зөв болох, ажлыг аюулгүй гүйцэтгэх бололцоотой эсэхэд эргэлзээ төрвөл ажлын байр бэлтгэх ажиллагааг зогсоож, энэ тухай наряд олгогч, шийдвэр өгөгчид мэдэгдэнэ. Хэрэв дээрх эргэлзээ нь нотлогдвол аюулгүй ажиллагааг хангах техникийн арга хэмжээг бүрэн тусгасан шинэ наряд олготол ажлын байр бэлтгэх ажиллагааг зогсоох ёстой.

180. Ажил гүйцэтгэгч нь ажилд оруулагчийн үүргийг хавсран гүйцэтгэж байгаа тохиолдолд тэр нь бригадын III групптэй нэг гишүүний хамт ажлын байр бэлтгэх арга хэмжээг авна.

181. Ажилд оруулагч нь ажилд оруулахын өмнө ажлын байр бэлтгэх талаарх техникийн арга хэмжээг бүрэн гүйцэтгэсэн гэдэгт итгэлтэй болсон байх ёстой.

182. Ажлын удирдагч, ажил гүйцэтгэгч (ажиглагч) нар нь ажилд оруулахын өмнө ажилд оруулагчаас ажлын байр бэлтгэх талаар ямар арга хэмжээ авсныг тодруулаад энэхүү бэлтгэлийг ажилд оруулагчтай хамт өөрийн биеэр шалгаж үзэх ёстой.

183. Наряд ба шийдвэрээр ажилд оруулах арга хэмжээг тухайн ажлыг гүйцэтгэх ажлын байран дээр нь явуулах ёстой.

184. Ажлын байр бэлтгэх шаардлагагүй шийдвэрээр гүйцэтгэх ажилд, мөн ЦДАШ, ХАШ ба КШ-д заавал ажлын байранд нь ажилд оруулах шаардлагагүй.

185. Ажлын байрны бэлтгэлийг шалгаж ажилд оруулна. Энэ үед ажилд оруулагч нь дараах үүргийг гүйцэтгэнэ:

- Бригадын бүрэлдэхүүн нь наряд ба шийдвэрт заасантай тохирч байгаа эсэхийг ажилтан нэг бүрийн үнэмлэхийн нэрээр тулгаж шалгах;
- Ажил гүйцэтгэх хэсэг болон түүнтэй зэргэлдээ орших (хүчдэлгүй эсэхийг үл харгалзан) ойртож болохгүй тоног төхөөрөмж ба гүйдэл дамжуулах хэсэг, ажлын байрны хязгаарыг зааж өгөх;
- Ажил гүйцэтгэх гүйдэл дамжуулах хэсэг нь хүчдэлгүй болсон эсэхийг хүчдэл заагчаар шалгах, тавьсан газардуулгыг үзүүлэх замаар нотлох;
- 35 кВ ба түүнээс доош хүчдэлийн цахилгаан байгууламжид (хийц нь боломжтой газарт) ажил гүйцэтгэх гүйдэл дамжуулах хэсэг хүчдэлгүй болсныг гараар хүрч бригадад батлах;

186. Ажил эхлэхийн өмнө тухайн ажлыг аюулгүй гүйцэтгэх талаар аюулгүй ажиллагаа хариуцагч нар нь наряд олгогчоос бригадын гишүүд хүртэл шат дараалан тухайлсан зааварчилгаа өгнө.

187. Тухайлсан зааварчилгаа өгөхгүйгээр ажилд оруулахыг хатуу хориглоно.

188. Нарядаар ажил гүйцэтгэхэд доор дурьдсан дарааллаар зааварчилгаа өгнө.

Үүнд:

- Наряд олгогч нь ажлын удирдагчид, ажлын удирдагч томилоогүй тохиолдолд ажил гүйцэтгэгчид, ажиглагчид;
- Зөвшөөрөл олгогч нь ажлын байр бэлтгэгч, ажилд оруулагчид;
- Ажилд оруулагч нь ажлын удирдагч, ажил гүйцэтгэгч, ажиглагчид;
- Ажлын удирдагч нь ажил гүйцэтгэгчид;
- Ажил гүйцэтгэгч нь бригадын гишүүдэд;

189. Шийдвэрээр ажил гүйцэтгэхэд дор дурьдсан дарааллаар тухайлсан зааварчилгаа өгнө. Үүнд:

- Шийдвэр өгөгч нь ажилд оруулагч, ажил гүйцэтгэгчид, ажиглагчид эсвэл ажлыг гардан хийх ажилтанд;
- Ажил гүйцэтгэгч нь бригадын гишүүдэд (ажлыг гардан хийх ажилтанд);

190. Наряд олгогч, шийдвэр өгөгч, зөвшөөрөл олгогч нь тухайлсан зааварчилгааг холбооны хэрэгсэл ашиглан өгөхийг зөвшөөрнө. Энэ тохиолдолд зааварчилгаа өгөгч нь тухайлсан зааварчилгааны бүртгэлийн журналд энэ тухай тэмдэглэх бөгөөд зааварчилгаа авсан ажилтан нь нарядан дээр зааварчилгаа өгсөн хүний нэрийг бичээд өөрийн гарын үсэг зурж баталгаажуулна.

191. Бригадын бүрэлдэхүүнд шинээр ажилтан нэмж оруулах үед тухайлсан зааварчилгааг ажил гүйцэтгэгч өгнө.

192. Аюулгүй ажиллагаа хариуцагч нар нь тухайлсан зааварчилгаандаа ажлыг аюулгүй гүйцэтгэх, ачаа өргөх, зөөх машин, механизм, зориулалтын багаж төхөөрөмжөөр аюулгүй ажиллах, ажил гүйцэтгэх технологи, ажлын байран дахь дэг журам болон бригадын гишүүдийн шилжилт, хөдөлгөөний талаар гүйцэтгэх ажилтай нь уялдуулан тодорхой заавар өгнө.

193. Нарядаар ажил гүйцэтгэхэд өгсөн тухайлсан зааварчилгааг нарядын “Тухайлсан зааварчилгааны бүртгэл” (Хавсралт №3, хүснэгт 3)-д бүртгэж зааварчилгаа өгсөн ба авсан ажилтнууд гарын үсэг зурна.

194. Шийдвэрээр ажил гүйцэтгэхэд тухайлсан зааварчилгааг “Тухайлсан зааварчилгааны бүртгэлийн журнал”-ын холбогдох хуудсанд зааварчилгааны утга агуулгыг бичиж тухайн зааварчилгааг өгсөн ба холбооны хэрэгсэл ашиглан өгснөөс бусад тохиолдолд авсан ажилтнуудгарын үсэг зурна.

195. Ажилд оруулах үйл явцыг нарядын хоёр хувьд хоёуланд нь бичиж баталгаажуулаад нэг хувийг ажил гүйцэтгэгч, нөгөө хувийг ажилд оруулагч авч үлдэнэ. Ажил гүйцэтгэгч нь ажилд оруулагчийн үүргийг хавсран гүйцэтгэж байгаа тохиолдолд ажилд оруулах ажилбарын үйлдлийг нарядын нэг хувь дээр бичиж баталгаажуулж болно.

196. Шийдвэрээр ажилд оруулсан тухай “Наряд, шийдвэрээр гүйцэтгэсэн ажлын бүртгэл”-ийн журналд бүртгэнэ.

2.8. Ажил гүйцэтгэх үед хяналт тавих

197. Ажилд оруулсны дараа аюулгүй ажиллагааны шаардлагыг бригад хэрхэн биелүүлж байгаад ажил гүйцэтгэгч, ажлын удирдагч, ажиглагч нар хяналт тавих үүрэгтэй.

198. Ажил гүйцэтгэгч, ажиглагч нь хамгийн аюул ихтэй ажил гүйцэтгэж буй хэсэгт аль болох ойр байрлаж бригадын гишүүдэд жигд хяналт тавьж байхаар өөрийн ажлыг зохион байгуулах ёстой.

199. Ажлын удирдагч, ажил гүйцэтгэгч, ажиглагч нь зөвхөн хяналт тавих үүрэгтэй бөгөөд ажил гүйцэтгэхийг хориглоно.

200. Ажил гүйцэтгэгч, ажиглагч нь ажлын байрнаас түр хугацаагаар зайлшгүй гарах шаардлагатай болбол түүнийг ажлын удирдагч, ажилд оруулагч, наряд олгогч нараас орлон үлдэх боломжгүй тохиолдолд бригадыг ажлын байрнаас гаргах (ХБ-аас ажилтныг гаргаж орох хаалгыг цоожлох, ЦДАШ-ын тулгуураас ажилтныг буулгах г.м.) ёстой.

201. Ажил гүйцэтгэгчийг дээрх ажилтан нарын аль нэг нь орлон үлдэх тохиолдолд нарядыг тухайн ажилтанд үлдээнэ.

202. Цахилгаан байгууламжид ажил гүйцэтгэх явцад ажил гүйцэтгэгч (ажиглагч) нь ганцаараа үлдэх эсвэл бригадын гишүүд нь ажил гүйцэтгэгч буюу түүнийг орлох ажилтангүйгээр байхыг хориглоно.

203. Ажил гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр бригадын нэг буюу хэд хэдэн гишүүн ажлын байрыг түр орхин явж болох ба тэдгээр ажилтныг бригадын бүрэлдэхүүнээс хасах шаардлагагүй. Энэ тохиолдолд 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид ажлын байранд үлдсэн гишүүдийн тоо ажил гүйцэтгэгчийг оролцуулаад хоёроос цөөнгүй байх ёстой.

204. Бригадын III групптэй гишүүд бие даан ХБ-аас гарах ба ажлын байрандаа буцан ирж болно. Харин I-II групптэй гишүүд нь ХБ-аас гарах ба ажлын байрандаа буцаж ирэхдээ бригадын III ба түүнээс дээш групптэй гишүүн эсвэл цахилгаан байгууламжид ганцаараа үзлэг хийх эрх бүхий ажилтны хамт явж болно. ХБ-аас гарсны дараа хаалгыг түгжилгүй орхихыг хориглоно.

205. Ажлын байранд буцаж ирсэн бригадын гишүүн нь зөвхөн ажил гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр ажилд орно.

206. Ажил гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр хуваарилсан ажлаас бусад ажил гүйцэтгэхийг хатуу хориглоно.

207. Ажил гүйцэтгэж байгаа цахилгаан байгууламжийн байрыг цоожлох боломжгүй бол бригадын гишүүдийг эргэж иртэл ажил гүйцэтгэгч нь ажлын байрыг орхиж явахыг хориглоно.

208. Аюултай нөхцөл байдал үүссэн эсвэл энэхүү дүрмийг зөрчсөнийг илрүүлбэл бригадыг ажлын байрнаас нэн даруй гаргаж ажил гүйцэтгэгчээс нарядыг хурааж авах ёстой. Зөвхөн илрүүлсэн зөрчлийг арилгасны дараа л бригадыг анх ажилд оруулах шаардлагын дагуу шинэ нарыдаар ажилд оруулна.

2.9. Ажлын завсарлагаа ба ажилд үргэлжлүүлэн оруулах

209. Ажил завсарласан (хооллох, ажил гүйцэтгэх нөхцөлийн дагуу г.м.) үед бригадыг ажлын байрнаас гаргаж хаалгыг нь цоожлох ёстой.

210. Ажил гүйцэтгэгчид наряд үлдэх бөгөөд завсарлагааны дараа ажил гүйцэтгэгч нь бригадын гишүүдийг ажилд оруулна. Завсарласан тухай нарыдад тэмдэглэх шаардлагагүй.

211. Бригадын гишүүд нь завсарлагааны үед ажлын байранд орохыг хориглоно. Зөвхөн ажил гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр ажлын байранд орох, ажлаа үргэлжлүүлэхийг зөвшөөрнө.

212. Ажлын өдөр дуусч ажил завсарлах үед бригадыг ажлын байрнаас гаргаж плакат, хаалт хашилт, дарцаг, газардуулгыг байранд нь үлдээнэ.

213. Ажил гүйцэтгэгч нь нарыдаа ажилд оруулагчид өгөх ба түүний эзгүй үед хүчинтэй байгаа нарядын тусгай хавтсанд орхих ёстой.

214. Байнгын жижүүргүй цахилгаан байгууламжид ажлын өдөр дуусахад нарядыг ажил гүйцэтгэгч нь өөртөө хадгалж болно.

215. Ажлын дараагийн өдрүүдэд бэлэн байгаа ажлын байранд зөвшөөрөл олгогчийн зөвшөөрлөөр ажилд оруулагч эсвэл түүний зөвшөөрснөөр ажлын удирдагч, ажил гүйцэтгэгч бригадыг ажилд үргэлжлүүлэн оруулна.

216. Хэрэв бригадыг ажилд үргэлжлүүлэн оруулахыг нарядын “Тусгай заалт” гэсэн мөрөнд ажил гүйцэтгэгчид ажилд оруулахыг даалгасан байвал бэлтгэсэн ажлын байранд зөвшөөрөл олгогчийн зөвшөөрлөөр ажил гүйцэтгэгч нь ажилд оруулж болно.

217. Бригадыг шуурхай ажиллагааны буюу шуурхай үйлчилгээ-засварын ажилтан ажилд оруулсан бол энэ тухай нарядын хоёр хувьд хоёуланд нь харин ажлын удирдагч буюу ажил гүйцэтгэгч нь ажилд оруулсан бол энэ тухай нарядын ажил гүйцэтгэгчид байгаа хувьд тус тус бичнэ.

218. Ажилд оруулж байгаа этгээд нь өмнө нь үлдээсэн плакат, хаалт хашилт, дарцаг, газардуулгын найдвартай байгааг шалгаж итгэлтэй болсны дараа бригадыг ажилд үргэлжлүүлэн оруулах ёстой.

2.10. Ажил бүрэн дуусах үед ажлын байрыг хүлээлгэн өгөх ба хүлээн авах, наряд (шийдвэр) хаах

219. Ажил бүрэн дууссаны дараа ажил гүйцэтгэгч нь бригадыг ажлын байрнаас холдуулж, тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор өөрийн тавьсан түр хаалт хашилт, зөөврийн плакат, дарцаг, газардуулгыг авах ба цахилгаан байгууламжийн хаалгыг хааж цоожилсноор ажлыг бүрэн гүйцэтгэж дуусгасан тухай нарядад бичиж гарын үсэг зурна. Харин ажлын удирдагч нь ажлын байрыг шалгаж ажлыг бүрэн дууссан тухай нарядад бичиж гарын үсэг зурна.

220. Ажлын удирдагч (хэрвээ ажлын удирдагч томилоогүй бол ажил гүйцэтгэгч) нь зөвшөөрөл олгогчид ажлыг бүрэн дуусгасан тухай мэдээлэх ёстой. Ийнхүү мэдээлснийг зөвшөөрөл олгогч нь шуурхай ажиллагааны журналд тэмдэглэнэ.

221. Бүрэн дууссан ажлын нарядыг зөвшөөрөл олгогчид эсвэл түүний зөвшөөрснөөр ажилд оруулагчид өгөх ёстой. Хэрэв нарядыг дээрх байдлаар өгөхөд хүндрэлтэй байвал зөвшөөрөл олгогчийн зөвшөөрснөөр ажил гүйцэтгэгч нь өөртөө түр хадгалж болно.

222. Бүрэн дууссан нарядыг авсан ажилтан нь боломжит хамгийн бага хугацаанд наряд олгосон ажилтанд өгөх ёстой.

223. Наряд, шийдвэрээр ажил гүйцэтгэж дууссан тухай наряд, шийдвэрээр гүйцэтгэсэн ажлын бүртгэлийн журналд тэмдэглэнэ.

2.11. Ажил бүрэн дууссаны дараа хүчдэлд залгах

224. Зөвхөн зөвшөөрөл олгогчийн зөвшөөрлөөр цахилгаан байгууламжийг хүчдэлд залгаж болно.

225. Зөвшөөрөл олгогчийн зөвшөөрлөөр ажилд оруулагч нь ажлын байрыг шалгаж, өөрийн тавьсан түр хаалт хашилт, зөөврийн плакат, дарцаг, газардуулгыг авах ба зөвшөөрөл олгогчид ажил бүрэн дуусаж, цахилгаан байгууламжид хүчдэл залгах бололцоотой болсныг мэдээлнэ.

226. Зөвшөөрөл олгогч нь зөвхөн тухайн ажлын ажилд оруулагч, ажлын удирдагч (хэрвээ ажлын удирдагч томилоогүй бол ажил гүйцэтгэгч) тус бүрээс ажлыг бүрэн дуусган, хүчдэл залгах бололцоотой болсон тухай мэдээлэл авсны дараа цахилгаан байгууламжийг хүчдэлд залгах зөвшөөрөл өгнө.

227. Ажил бүрэн дууссаны дараа цахилгаан байгууламжид хүчдэл залгах зөвшөөрөл авсан ажилтан нь хүчдэл залгахын өмнө тухайн тоног төхөөрөмж хүчдэлд залгахад бэлэн болсон эсэх (ажлын байр бэлтгэх үед тавьсан түр хаалт хашилт, зөөврийн плакат аюулгүй ажиллагааны тэмдэг, газардуулгыг бүрэн авсан эсэх, цэвэрлэгээ хийгдсэн, гадны биет байхгүй эсэх г.м.)-ийг шалгаж байнгын хаалт, хашилтыг сэргээсний дараа хүчдэлд залгана.

228. Шуурхай үйлчилгээ-засварын ажилтнаас томилогдсон ажилд оруулагч нь нарядын “Тусгай заалт” гэсэн мөрөнд ажил бүрэн дууссаны дараа цахилгаан байгууламжийг хүчдэлд залгахаар заасан тохиолдолд ажил дууссаны дараа хүчдэлд залгаж болно.

Дээрх байдлаар хүчдэлд залгах эрхийг тухайн цахилгаан байгууламж буюу түүний хэсэгт өөр бригад ажил гүйцэтгээгүй тохиолдолд л олгож болно.

229. Засварт гаргасан цахилгаан тоног төхөөрөмж, байгууламжийг онцгой нөхцөл байдал үүссэн (аваари) үед түүн дээр ажил гүйцэтгэж байсан бүх ажилтан хүчдэлд нэрвэгдэхгүй байх бололцоог хангасны үндсэн дээр зөвшөөрөл олгогчийн зөвшөөрснөөр шуурхай ажиллагааны буюу шуурхай үйлчилгээ-засварын ажилтан эсвэл ажилд оруулагч хүчдэлд залгаж болно. Ингэхдээ ажил гүйцэтгэгч болон бригадын гишүүн нэг бүрт заавал мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдэх боломжгүй байсан бригадын гишүүдэд энэ тухай мэдэгдэх өөр арга хэмжээ (холбооны хэрэгсэл ашиглах, ажлын байран дээр нь мэдэгдэх үүрэг бүхий ажилтан зогсоох г.м.)-г заавал авсан байх ёстой.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТЕХНИКИЙН АРГА ХЭМЖЭЭ

3.1. Ажлын байр бэлтгэх техникийн арга хэмжээний дараалал

230. Хүчдэлийг нь таслан гүйцэтгэх ажлын байрыг бэлтгэх техникийн арга хэмжээг дараах дарааллын дагуу авна. Үүнд:

1. Шаардлагатай таслалтуудыг хийж, таслах залгах аппаратууд өөрөө залгагдах буюу тэдгээрийг андуурч залгахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;
2. Таслах, залгах аппаратын тасархай болсон эсэхийг нүдэнд харагдахуйц байдлаар нь шалгах;
3. Таслах залгах аппаратын гар залуур ба алсын удирдлагын түлхүүр дээр хориглох плакат өлгөх;
4. Гүйдэл дамжуулах хэсэг хүчдэлгүй болсныг шалгах;
5. Ажил гүйцэтгэх хэсэгт газардуулга тавьж (байнгын газардуулгыг залгах, зөөврийн газардуулга тавих г.м.), сануулах плакат өлгөх;
6. Шаардлагатай ажлын байр ба хүчдэлтэй үлдсэн гүйдэл дамжуулах хэсэгт хаалт, хашилт хийж, анхааруулах плакат өлгөх;
7. Ажил гүйцэтгэхээр бэлтгэсэн ажлын байранд зөвшөөрөх плакат өлгөх;

Тухайн ажлын байрны онцлогийг нь харгалзан гүйдэл дамжуулах хэсэгт газардуулга тавихын өмнө эсвэл дараа нь хаалт, хашилт хийж болно.

3.2. Таслалт хийх

231. Ажлын байр бэлтгэх үед дараах хэсгүүдийн хүчдэлийг тасалсан байх ёстой. Үүнд:

- Дээр нь ажил гүйцэтгэх гүйдэл дамжуулах хэсгүүд;
- Хүн, ачаа өргөх машин механизм 1 дүгээр хүснэгтэд зааснаас дотогш зайд ойртож болзошгүй хаалт хашилтгүй гүйдэл дамжуулах хэсгүүд;
- Хүчдэлийг нь тасалсан ЦДАШ-д ажил гүйцэтгэх үед уг шугамын элементүүд нь хүчдэлтэй байгаа бусад ЦДАШ-ын гүйдэл дамжуулах хэсэгт 1 дүгээр хүснэгтийн гуравдугаар баганад зааснаас дотогш ойртохоор бол хүчдэлтэй ЦДАШ;
- Засвар хийж байгаа ЦДАШ-тай нэг тулгуурт татсан ХАШ-ын тэжээл ба хэрэглэгч;
- Нөлөөллийн хүчдэл;

232. Цахилгаан байгууламжид ажиллах ажлын байранд таслах залгах аппаратаар хүчдэл өгч болох бүх талаас нь таслалт хийснийг нүдэнд үзэгдэхүйцээр гүйцэтгэсэн байна. Ийм үзэгдэхүйц тасархай байдлыг салгуур, ачаалал таслагч, тусгаарлуурыг таслах, хайламтгай хамгаалуурыг авах, шин буюу утсан холбоосыг тайлах гэх мэт замаар бий болгоно.

233. Ажил хийхээр бэлтгэсэн цахилгаан байгууламжийн хэсэгтэй холбоотой хүчний ба хүчдэлийн трансформаторын “нам” талаас эргэж өндөржсөн хүчдэл дамжин ирэх боломжийг хаахын тулд 1000 В хүртэл хүчдэлтэй талыг нь бас тасална.

234. Гар удирдлагатай таслуур, салгуур, тусгаарлуурыг тасалсны дараа ажлын байр бэлдэх үедээ тэдгээрийн бүх фаз нь таслагдсан байдал, тойруу (алгассан буюу шууд) түр холбоос байхгүйг нүдээрээ үзэж үнэмшсэн байх шаардлагатай.

235. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжийн таслах, залгах аппарат өөрөө залгагдах буюу андуурч залган хүчдэл өгөхөөс урьдчилан сэргийлж дараах арга хэмжээг авах ёстой. Үүнд:

- Салгуур, тусгаарлуур, таслуурын гар залуурыг таслагдсан байрлалд цоожлох;
- Штангаар тасалж залгадаг салгуурын байнгын хаалт хашилтыг цоожлох;
- Алсын удирдлагатай таслах, залгах аппаратын залуурын хүчний болон удирдлагын хэлхээг таслах, хийн шахуургат залуурын өгөх шугам хоолойн шахсан агаарын хаалтыг хааж түгжих, шахсан агаарыг гаргах хавхлагыг онгорхой байдалд орхиж цоожлох;
- Ачаатай ба пүрштэй залуурын залгах ачаа буюу пүршийг ажлын бус байрлалд оруулах;
- БХБ-ийн таслах залгах аппаратын тэргэнцрийг татан гаргаж, хүчдэлтэй үлдсэн гүйдэл дамжуулагч үүрийн хөшгөн хаалтыг хааж цоожлох;

236. 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжийн гүйдэл дамжуулах хэсэгт ажил гүйцэтгэхдээ гар залууртай таслах залгах аппаратаар хүчдэлийг бүх талаас нь тасалж хайламтгай хамгаалууртай бол түүнийг авна.

237. Хэлхээнд хайламтгай хамгаалуур байхгүй тохиолдолд таслах залгах аппарат андуурч залгахаас хамгаалж бариулыг буюу шүүгээний хаалгыг түгжих, товчлуурт хаалт хийх, контактын хооронд тусгаарлах жийрэг тавих зэрэг арга хэмжээ авна.

238. Алсын удирдлагатай таслах залгах аппаратаар хүчдэлийг таслахдаа залгах ороомгийн тэжээлийг тасалсан байх шаардлагатай.

239. Хэрэв аппаратын хийц боломжтой, ажлын шинж чанарт тохирч байвал дээр дурьдсан арга хэмжээний оронд шинийг тайлах буюу таслах залгах аппарат, эсвэл дээр нь ажил хийгдэх ёстой тоног төхөөрөмжөөс кабель, утасны үзүүрийг тайлж салгаж болно.

240. Таслах, залгах үйлдлийг хийхдээ зориулалтын туршсан бээлий, нүүрэвч заавал хэрэглэнэ.

3.3. Таслах, залгах аппаратын тасархай болсон эсэхийг харагдахуйц байдлаар нь шалгах

241. Боломжтой тохиолдолд таслах, залгах аппаратын тасархай болсон эсэхийг харагдахуйц байдлаар нь заавал шалгана.

242. Таслах, залгах аппаратын тасархай болсон эсэхийг нүдэнд харагдахуйц байдлаар нь дор дурьдсан аргаар шалгаж болно. Үүнд:

- Хяналт, дохионы гэрлээр;
- Байнгын хянах хэмжүүрээр;
- Таслуурын механик заагчаар;
- Гүйдлийн хэлхээ нь харагдахуйц тасархайтай таслуурын ажлын контактын байрлалаар г.м.

243. Таслах, залгах аппаратын тасархай болсон эсэхийг газар дээр нь шалгахдаа тэдний хооронд механик холбоос байгаа эсэхээс үл хамааран фаз тус бүрийг харна.

3.4. Ажлын байранд аюулгүй ажиллагааны хориглох плакат өлгөх

244. Ажлын байранд хүчдэл өгөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор бүх төрлийнхүчдэлийг таслах, залгах аппарат (автомат, салгуур, рубильник, унтраалга, алсын удирдлагын түлхүүр, товчлуур, салгуур, тусгаарлуур болон ачаалал таслагчийн залуур г.м.) дээр “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна” гэсэн плакат өлгөх ёстой.

245. Автомат, унтраалга буюу рубильник байхгүй 1000 В хүртэл хүчдэлийн холболтод хайламтгай хамгаалуурыг авч түүн дээр “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна” гэсэн плакат өлгөнө.

246. Штангаар залгаж тасалдаг салгуурт бол байнгын хаалт хашилт дээр нь, харин нэг туйлт салгуурын салгуур тус бүрийн залуур дээр “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна” плакат өлгөнө.

247. БХБ-ийн таслах залгах аппаратын тэргэнцрийг татан гаргаж, хүчдэлтэй үлдсэн гүйдэл дамжуулагч үүрийн хөшгөн хаалтыг хааж цоожлоод “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна” плакат өлгөнө.

248. Хийн шахуургат залууртай салгуурын агаар орохыг хаасан хаалт дээр “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна” гэсэн плакат өлгөнө.

249. ЦДАШ буюу КШ дээр ажил гүйцэтгэхээр тасалсан салгуурын залуур дээр тэнд ажиллаж байгаа бригадын тооноос үл хамааран “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна” гэсэн плакат өлгөх ёстой.

3.5. Хүчдэлгүй болсныг шалгах

250. Хүчдэлгүй болсныг зориулалтын туршигдсан хүчдэл заагчаар шалгах ба түүнийг хэрэглэхийн өмнө хамгийн ойр байгаа мэдээжийн хүчдэлтэй тоног төхөөрөмжийн гүйдэл дамжуулах хэсэгт ойртуулах буюу хүргэх замаар эсвэл тусгай багажийн тусламжаар ажиллагаатай байгаа эсэхийг шалгана.

251. Хүчдэлгүй болсныг шалгахдаа хүчдэл заагчийг ашиглалтын зааврын дагуу ажиллуулах ёстой.

252. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжийн хүчдэлийг хүчдэл заагчаар шалгахдаа тусгаарлах резинэн бээлий хэрэглэнэ.

253. Цахилгаан станц, дэд станцын 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид шуурхай ажиллагааны буюу шуурхай үйлчилгээ-засварын ажилтан IV-өөс доошгүй групптэй, 1000 В хүртэл цахилгаан байгууламжид III-аас доошгүй групптэй тохиолдолд ганцаараа хүчдэлгүй болсныг шалгаж болно.

254. 1000 В-оос дээш хүчдэлийн ЦДАШ-д IV ба III-аас доошгүй групптэй, 1000 В хүртэл хүчдэлийн ЦДАШ-д III-аас доошгүй групптэй хоёр хүн хүчдэлгүй болохыг шалгана.

255. Хүчдэлийн таслах залгах аппаратын хаалттай хийц бүхий салгуур, багц салгуур, татаж гаргадаггүй автоматуудын контактын тасархай байдалд хүчдэлгүй болсныг шалгах боломжгүй байвал тэдний гаргалгааны хавчаар дээр эсвэл гарч байгаа шин, утас буюу энэ таслах залгах аппаратад холбогдсон тоног төхөөрөмжийн хавчаар дээр хүчдэлгүй болсныг шалгана.

256. 6-20 кВ-ын ЦДАШ хүчдэлтэй эсэхийг модон ба төмөр бетон тулгуур, мөн түүнчлэн цамхагт шатан (вышка) дээр зогсож шалгахдаа багтаамжийн гүйдэл гүйх зарчимд ажилладаг хүчдэл заагчийн шаардагдах мэдрэх чадварыг сайжруулахын тулд хүчдэл заагчийн “ажлын хэсэг”-ийг газардуулна.

257. ЦДАШ-ын утасны хүчдэлгүй болсныг хамгийн доод талын утаснаас эхэлж дээш нь, ижил түвшинд татагдсан утасны хүчдэлийг хамгийн ойр утаснаас эхлэн дараалуулан шалгана.

258. 1000 В хүртэл хүчдэлийн саармаг цэг нь газардуулагдсан цахилгаан байгууламжид хүчдэлгүй болохыг хоёр туйлт хүчдэл заагчаар шалгахдаа фазуудын хооронд мөн фаз тус бүр болон тоног төхөөрөмжийн газардуулсан эх бие буюу газардуулгын утасны хооронд шалгана. Энэ тохиолдолд урьдчилан шалгасан вольтметр хэрэглэхийг зөвшөөрнө.

259. Заах дохиоллын хэрэгсэл, байнгын залгаатай байдаг вольтметр, хориг түгжээ гэх мэт нь зөвхөн туслах чанарын хэрэгсэл болдог тул тэдгээрийн заалтаар хүчдэлгүй гэсэн дүгнэлт хийхийг хориглоно.

3.6. Газардуулга тавих ерөнхий шаардлага

260. Гүйдэл дамжуулах хэсэгт хүчдэлгүй байгааг шалгаж тогтоомогц газардуулга тавих ёстой.

261. Зөөврийн газардуулгыг эхлээд газардуулах хэсэгт холбож дараа нь гүйдэл дамжуулах хэсэгт хүчдэлгүй байгааг шалгамагц түүнд газардуулга тавина. Газардуулга тавих схемийг Хавсралт №7-д харуулав.

262. Зөөврийн газардуулыг авахдаа газардуулга тавих дэс дарааллын эсрэг үйлдлээр буюу эхлээд гүйдэл дамжуулах хэсгээс дараа нь газардуулах хэсгээс салгаж авна.

263. Зөөврийн газардуулга тавих, авах үйлдлийг хийхдээ 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид тусгаарлах штангаар резинэн бээлийтэй, 1000 В хүртэлх хүчдэлийн цахилгаан байгууламжид резинэн бээлийтэй гүйцэтгэх ёстой.

264. Тавьсан зөөврийн газардуулгын хавчаарыг штангаар болон тусгаарлах резинэн бээлийтэй гараараа чангалж болно.

265. Энэ дүрмийн 416-д дурьдсанаас бусад тохиолдолд зориулалтын бус утас газардуулгад хэрэглэхийг хориглоно.

3.7. Цахилгаан станц, дэд станцын хуваарилах байгууламжид газардуулга тавих

266. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид ажил гүйцэтгэх үед хүчдэл өгч болох бүх талаас нь тасалж ажил гүйцэтгэхээр бэлтгэсэн гүйдэл дамжуулах хэсгийн фаз тус бүрт нь газардуулга тавих ёстой. Ажил хийхээр хүчдэлийг тасалсан цуглуулгын шинд нэг газардуулга (Хавсралт №7) тавихад хангалттай.

267. Хүчдэлийг нь тасалсан шугамын салгуур дээр ажиллах үед уг шугамын салгуурт газардуулгын хутга тавьсан ч гэсэн ЦДАШ-аас ирсэн буултын утсанд зөөврийн газардуулга нэмж тавина. Нэмэлт зөөврийн газардуулга нь салгуурт ямар ч үйлдэл хийхэд хөндөгдөхөөргүй байх ёстой.

268. Газардуулсан гүйдэл дамжуулах хэсэг нь хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсгээс нүдэнд үзэгдэхүйц тасарсан, тавьсан газардуулга нь хүчдэлтэй гүйдэл дамжуулах хэсгээс таслуур, салгуур, тусгаарлуур буюу ачаалал таслагчаар тасалсан, хайламтгай хамгаалуурыг нь авсан, шин буюу утсан холболтыг тайлсан, ХБ-ийн тэргэнцэрийг нь татаж гаргасан байдлаар тусгаарлагдсан байх ёстой.

269. Гүйдэл дамжуулах хэсэг дээр ажиллах үед нөлөөллийн хүчдэлтэй (потенциал) болж болзошгүй тохиолдолд ажил хийх тэр хэсэгт нэмэлт газардуулга тавих хэрэгтэй.

270. Зөөврийн газардуулгыг гүйдэл дамжуулах хэсгийн будгийг нь цэвэрлэсэн хэсэгт холбох замаар тавина.

271. 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжийн ХБ-ийн цуглуулгын шин, щит, цуглуулгын самбар дээр ажил гүйцэтгэхдээ шинээс хүчдэлийг нь тасалж, энэ шин дээр газардуулга тавих ёстой. ХБ, щит, цуглуулгын самбарын холболтууд ба тэдгээрээс тэжээгдэж байгаа тоног төхөөрөмжид газардуулга тавих боломж, шаардлагыг наряд (шийдвэр) олгогч тодорхойлно.

272. Тусгаарлагчийн эсэргүүцэл хэмжих зэрэг хийж байгаа ажлын шинж чанараас шалтгаалан ажлын байр бэлтгэх явцад тавьсан газардуулгыг жижүүрийн буюу шуурхай үйлчилгээ-засварын ажилтан эсвэл түүний зөвшөөрлөөр ажил гүйцэтгэгч түр хугацаагаар авч болно.

273. Нарядын "Тусгай заалт" мөрөнд хаана ямар зорилгоор газардуулгыг түр авах тухай тэмдэглэл хийсэн байх ёстой.

274. Газардуулга тавих боломжгүй буюу ингэж тавих нь аюул учруулахуйц хийц бүтээц бүхий цахилгаан байгууламжид (жишээ нь: зарим төрлийн БХБ, фазууд нь босоо байрласан хуваарилах хайрцаг зэрэг) ажлын байр бэлтгэх үед газардуулга тавихгүй байж болно.

275. Дээрх тохиолдолд салгуурын хутганд тусгаарлах углаас өмсгөх, таслах, залгах аппаратын контактын хооронд хатуу тусгаарлах материалаар хийсэн жийргэвч тавих утас кабель, шинийг салгаж авах зэрэг аюулгүй байдлыг хангах тусгай нэмэлт арга хэмжээг заавал авсан байх ёстой. Тийм цахилгаан байгууламжийн нэрсийн жагсаалтыг ажил олгогч гарган баталж тухайн хэсэгт ажил гүйцэтгэх ажилтан бүрт мэдэгдсэн байх ёстой.

276. 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжид жижүүрийн буюу шуурхай үйлчилгээ-засварын III-аас доошгүй групптэй нэг ажилтанд газардуулга тавих ба авахыг зөвшөөрнө.

277. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид дараах хүмүүс газардуулгыг тавих ба авна. Үүнд:

- Газардуулгыг нэг нь жижүүрийн буюу шуурхай ажиллагаа, шуурхай үйлчилгээ-засварын IV-өөс доошгүй групптэй, нөгөө нь III-аас доошгүй групптэй 2 хүн тавина. Харин хэрэглэгчийг тэжээж буй холболт дээр газардуулга тавих үед хоёрдогч хүн нь хэрэглэгч байгууллагын ажилтан байж болно.
- Алслагдсан дэд станцад газардуулга тавих үед хоёрдогч хүн нь захиргаа-техникийн ажилтан буюу зөвшөөрөл олгогчийн зөвшөөрснөөр III-аас доошгүй групптэй хэрэглэгч байгууллагын хүн байж болно.
- Жижүүрийн буюу шуурхай ажиллагаа, шуурхай үйлчилгээ-засварын III-аас доошгүй групптэй нэг хүн энэ дүрмийн шаардлагыг биелүүлсэн тохиолдолд газардуулгын хутгыг салгах ба зөөврийн газардуулгыг авч болно.

3.8. Цахилгаан дамжуулах агаарын шугамд газардуулга тавих

278. Агаарын шугамын янз бүрийн түвшинд татагдсан утсанд газардуулга тавихдаа хамгийн доод талын утаснаас эхэлж доороос нь дээш чиглэлд гүйцэтгэнэ.

279. Хэвтээгээр зэрэгцээ татагдсан утсанд газардуулга тавихдаа өөрт хамгийн ойр утаснаас эхлэн тавина.

280. 1000 В-оос дээш хүчдэлийн ЦДАШ-д түүний хүчдэлийг нь тасалсан бүх хуваарилах байгууламж ба секц холбодог таслах залгах аппаратуудын дэргэд газардуулга тавих ёстой. Олон салбар шугамтай 35 кВ ба түүнээс дээш хүчдэлийн гол ЦДАШ-ын хоёр талын төгсгөлд газардуулга тавьсан үед энэ шугамын салбаруудад холбогдсон дэд станцад ЦДАШ-ын талд газардуулга тавилгүй харин эдгээр дэд станцад таслагдсан шугамын салгуурын дэд станц талд (Хавсралт № 7) газардуулга тавьж болно.

281. 6-20 кВ-ын хүчдэлийн ЦДАШ-ын нэг хуваарилах байгууламж буюу нэг секцийн аппарат, эсвэл хуваарилах байгууламж болон секцийн аппаратад хамгийн ойр байгаа тулгуурт газардуулга тавина.

282. Ажлын байр ба ХБ буюу таслах залгах аппаратын хооронд ЦДАШ-д газардуулга тавьсан тохиолдолд хүчдэлийг нь тасалсан ЦДАШ-ын бусад хуваарилах байгууламж ба секц холбох аппаратад газардуулга тавихгүй байж болно.

283. ЦДАШ-д газардуулгыг газардуулгын хүрээтэй тулгуурын дэргэд (Хавсралт № 7) тавина.

284. 1000 В хүртэл хүчдэлийн ЦДАШ-д зөвхөн ажлын байран дээр нь газардуулга тавихад хангалттай.

285. Бригад бүрийн ажлын байран дээр 278-284-д заасан газардуулгад нэмэлт болгож бүх фазын утсанд, шаардлагатай тохиолдолд аянгын троссонд газардуулга тавих ёстой.

286. Анкерын алгаслалтад шугамын утас угсрах үед, түүнчлэн угсарсан шугамын хэсгийн анкерын тулгуурт гогцоо холбоос хийсний дараа эхний анкер ба төгсгөлийн хэсгийн аль нэг завсрын тулгуур дээр ЦДАШ-ын утас (трос)-д газардуулга тавих ёстой.

287. Угсарч дууссан анкерын алгаслалтын утас ба трос, мөн угсарч дууссан ЦДАШ-аас угсарч байгаа ЦДАШ-ын хэсгийн утас, тросонд аянгын цэнэгжилт ба бусад хэт хүчдэлийн чадавх шилжүүлэхгүйн тулд угсарч дууссан хэсгийн утас ба тросыг түүний төгсгөлийн анкерта газардуулахыг хориглоно.

288. Салаалмал (давхарласан) утастай ЦДАШ-ын фаз тус бүрт зөвхөн нэг утсыг газардуулахыг зөвшөөрөх ба тусгаарлах тэлүүртэй бол фазын бүх утсыг газардуулах шаардлагатай.

289. Нэг хэлхээт ЦДАШ-д газардуулгыг ажил гүйцэтгэх тулгуурт буюу зэргэлдээ тулгуурт нь тавина.

290. Газардуулга хоорондын зай 2 км-ээс хэтрэхгүй тохиолдолд ажил гүйцэтгэх ЦДАШ-ын хэсгийн хоёр талд газардуулга тавихыг зөвшөөрнө.

291. Тулгуураас тусгаарласан аянганаас хамгаалах трос бүхий тулгуурын хийц хэсэгт ажил гүйцэтгэх үед тросонд 1,0 м-ээс дотогш зайд ойртох шаардлагатай бол тросыг газардуулсан байх ёстой.

292. Газардуулгыг тулгуураас тусгаарласан тросын алгаслалт тал дээр эсвэл ажил гүйцэтгэх алгаслалтын хэсэг дээр тавина.

293. Газраас тусгаарласан аянганаас хамгаалалтын тросыг урьдчилан газардуулсны дараа түүнд газардуулагч буултыг холбох буюу салгаж болно.

294. Хэрэв энэхүү тросон дээрх мөстлөгийг хайлуулах ажил хийхээр төлөвлөсөн бол ажил эхлэхийн өмнө тросын салгуурыг тасалж, түүнд хүчдэл өгч болох талд нь газардуулга тавих ёстой.

295. Зөөврийн газардуулгыг төмөр тулгуурын хийц хэсэгт, харин төмөр бетон ба модон тулгуурт бол тэдгээрийн газардуулгын буултын утсанд түүний бүрэн бүтэн байдлыг урьдчилан шалгасны дараа холбоно. Газардуулгын буултгүй төмөр бетон тулгуурт газардуулгыг тулгуурын хөндлөвч болон газардуулах байгууламжтай холбогдсон бусад металл хэсэгт холбохыг зөвшөөрнө.

296. 1000 В хүртэл хүчдэлийн саармаг цэгийг нь газардуулсан цахилгаан шугам сүлжээний нойлын утас нь давтан газардуулгатай бол зөөврийн газардуулгыг энэ утсанд холбохыг зөвшөөрнө.

297. Тоног төхөөрөмжийн хийц хэсэг болон газардуулгын хэлхээний зөөврийн газардуулга холбох хэсгийн будгийг арилгаж цэвэрлэсэн байх ёстой.

298. Ажлын байранд тавих зөөврийн газардуулгыг газрын хөрсөнд 0,5 м-ээс багагүй гүнд суулгасан газардуулагч төмөр гадсанд холбох ба уг гадсыг сул овоолсон хөрс шороонд суулгахыг хориглоно.

299. 1000 В хүртэл хүчдэлийн ЦДАШ-д тулгуур, эсвэл шаттай машины тусгаарлах үегүй сунадаг шатан дээр байрлаж ажил гүйцэтгэх үед засвар хийх шугамын бүх утас болон тухайн тулгуурт татсан бүх утас тэдгээрийн дотор радиогийн болон телемеханикийн шугамын тусгаарлах бүрээсгүй утаснуудад газардуулга тавих ёстой.

300. Засварын ажил хийхээр хүчдэлийг нь тасалсан ЦДАШ-д зөөврийн газардуулга тавих, авах, тулгуурт байрлуулсан газардуулгын хутгыг залгах ажлыг жижүүрийн буюу шуурхай үйлчилгээ-засварын хоёр ажилтан гүйцэтгэнэ. Үүнд: 1000 В-оос дээш хүчдэлийн ЦДАШ-д IV-өөс доошгүй групптэй нэг хүн, 1000 В хүртэл хүчдэлийн ЦДАШ-д III-аас доошгүй групптэй нэг хүн байх ба хоёр дахь хүн нь III-аас доошгүй групптэй засварын хүн, харин хэрэглэгчийг тэжээж байгаа ЦДАШ-д III-аас доошгүй групптэй хэрэглэгчийн ажилтан байж болно.

301. Жижүүрийн буюу шуурхай үйлчилгээ-засварын III-аас доошгүй групптэй ажилтанд газардуулгын хутгыг ганцаараа таслахыг зөвшөөрнө.

302. ЦДАШ-ын ажлын байранд ажил гүйцэтгэгч нь бригадынхаа III-аас доошгүй групптэй нэг гишүүний хамт зөөврийн газардуулга тавьж болно. Энэхүү зөөврийн газардуулгыг ажил гүйцэтгэгчийн шийдвэрээр бригадын гишүүдийн III-аас доошгүй групптэй хоёр хүн авч болно.

303. ЦДАШ хүчдэлгүй болсон эсэхийг шалгах, мөн түүнд газардуулга тавих ба авах үед хоёр хүний нэг нь газарт байрлаж нөгөөдөө хяналт тавих ёстой.

304. Засварын ажил гүйцэтгэх ЦДАШ ба түүнтэй огтлолцож байгаа болон ойролцоо байрлалтай ЦДАШ-ын аль алинд нь ажилд оруулахын өмнө газардуулга тавьсан байх ёстой.

305. Ажил бүрэн дуусаж, ажилтныг тухайн ажлын байрнаас холдуулах хүртэл аль ч газардуулгыг авахыг хориглоно.

306. ЦДАШ-ын фазын засвар хийх үед тасалсан фазыг ХБ-д газардуулахыг хориглоно. Тасалсан фазын утсыг зөвхөн ажлын байран дээр газардуулах ёстой.

307. 35 кВ ба түүнээс дээш хүчдэлийн ЦДАШ дээр нэг фазын утас эсвэл фаз бүр дээр ээлжлэн ажиллах үед зөвхөн ажил гүйцэтгэх фазын утсыг газардуулах ёстой. Энэ үед газардуулаагүй үлдсэн бусад фазын утаснуудад 1 дүгээр хүснэгтэд зааснаас дотогш зайд ойртохыг хориглоно.

308. Фазын нэг бүрчилсэн засварын үед газардуулгын найдвартай байдлыг дээшлүүлэх зорилгоор зэрэгцээ хоёр газардуулга тавина.

309. Шугамын утсанд тавьсан газардуулгаас 20 м-ээс холгүй зайд ажиллахыг зөвшөөрнө.

310. Шугамын утсанд хэд хэдэн бригад нэгэн зэрэг ажиллах үед шугамын утсыг бригадын тоогоор цахилгаан холбоогүй хэсгүүд болгон салгасан байх ёстой.

311. Давхар газардуулга тавьсан нэг хэсэгт нэг л бригадыг ажилд оруулна.

312. 110 кВ ба түүнээс дээш хүчдэлтэй ЦДАШ-ын фазын нэг бүрчилсэн засварын үед нуман цахилгалт үүсэхээс сэргийлж газардуулга тавих ба авахын өмнө шугамын утсыг нум унтраагч төхөөрөмж бүхий туйван хэрэглэж урьдчилан газардуулсан байна. Туйвангийн газардуулагч утсыг газардуулагчид өмнө нь холбосон байх ёстой. Зөвхөн зөөврийн газардуулга тавьсан эсвэл авсны дараа туйванг салгаж авна.

313. ЦДАШ-ын зэрэгцээ байрласан фазын нэг бүрчилсэн засварын үед хүчдэлтэй байгаа фазын утасны хөндлөвчийн хэсгээр дамжих, шилжихийг хориглоно.

314. 35 кВ ба түүнээс дээш хүчдэлийн ЦДАШ-ын фазын нэг бүрчилсэн засварын ажил гүйцэтгэх нөхцөлийг нарядын “Тусгай заалт” мөрөнд тусгах ёстой.

3.9. Ажлын байранд хаалт хашилт тавих, плакат өлгөх

315. Цахилгаан байгууламжийн газардуулсан хэсэгт андуурч хүчдэл өгөхөөс урьдчилан сэргийлж салгуур, тусгаарлуур, ачаалал таслагчуудын залуур дээр, мөн тасалж залгах аппаратуудын алсын удирдлагын түлхүүр, товчлуурууд дээр “Газардуулсан” гэсэн плакат өлгөнө.

316. Хүчдэлтэй үлдсэн гүйдэл дамжуулах хэсгээс тусгаарлах зорилгоор цахилгаан үл дамжуулах материалаар хийсэн түр зуурын хаалт, хашилт, самбар, сараалж зэргийг хэрэглэж болно.

317. Хүчдэлийг таслалгүйгээр түр хаалт хашилт тавихад тэдгээрээс гүйдэл дамжуулах хэсэг хүртэлх зай нь энэ дүрмийн 1 дүгээр хүснэгтэд заасан хэмжээнээс багагүй байх ёстой. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд 6-10 кВ-ын цахилгаан байгууламжид энэ хэмжээг 0,35 метр хүртэл багасгаж болно.

318. Түр хаалт хашилт дээр “Зогс! Өндөр хүчдэл” плакат буюу зохих аюулгүй ажиллагааны плакатуудыг өлгөж бэхэлсэн байх ёстой.

319. 6-10 кВ-ын цахилгаан байгууламжийн гүйдэл дамжуулах хэсгийг тусгаарлахсамбараар хааж боломжгүй тохиолдолд хүчдэлтэй байгаа ба таслагдсан гүйдэл дамжуулах хэсгийн хооронд (жишээ нь: таслагдсан салгуурын контакт хооронд) тусгаарлах жийрэг хэрэглэхийг зөвшөөрнө.

320. Тусгаарлах жийрэг нь хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсэгт хүрч болно.

321. Жийргийг тавих буюу авахдаа III ба IV-өөс доошгүй групптэй (ахлагч нь шуурхай үйлчилгээ-засварын хүн байх) хоёр хүн туршсан резинэн бээлий ба тусгаарлах штанг эсвэл бахь ашиглаж гүйцэтгэнэ.

322. Ажлын байртай зэргэлдээ орших шүүгээ, самбар, өрөөний хаалт хашилт дээр “Зогс! Өндөр хүчдэл” гэсэн плакат өлгөсөн байх ёстой.

323. ИХБ-д суурь ба тусгай хийц дээр байрлуулсан тоног төхөөрөмж дээр эсвэл газарт зогсож ажил гүйцэтгэх үед ажлын байрыг олс буюу мяндсан татлагаар дунд нь хүн явж өнгөрөхөөр зай үлдээн хашиж түүн дээр “Зогс! Өндөр хүчдэл” гэсэн плакатыг хашсан талбай руу харуулж өлгөнө. Тухайн ажлын байрны бүсэд ороогүй хашсан талбайн гадна үлдсэн хийц хэсгээс татлагыг уяж бэхлэхийг зөвшөөрнө.

324. Шугамын салгуураас бусад ИХБ-ийн тоног төхөөрөмжөөс хүчдэлийг нь тасалсан тохиолдолд олсоор хашилт хийж түүн дээр “Зогс! Өндөр хүчдэл” гэсэн плакатыг бичгийг нь хашсан талбайгаас гадна тийш харуулан өлгөнө.

325. ЦДАШ буюу кабель шугамаас бусад цахилгаан байгууламжид бэлтгэсэн ажлын байранд “Энд ажиллаж болно” гэсэн плакат өлгөнө.

326. ИХБ-д ажлын байрнаас хүчдэлтэй байгаа зэргэлдээ хэсгүүдэд дамжин очиж болох хийцийн хэсэг дээр “Зогс! Өндөр хүчдэл” гэсэн плакат тавина. Энэ плакатыг III-аас доошгүй групптэй засварын ажилтан ажилд оруулагчийн удирдлаган дор тавьж болно.

327. Авирч гарахыг зөвшөөрсөн хийц хэсгийн зэргэлдээ орших хийц хэсгийн доод талд “Бүү авир! Аюултай” гэсэн плакат тавина.

328. Ажил гүйцэтгэх явцад авирч гарахыг зөвшөөрсөн хийц, шатан дээр “Энд авирч болно” гэсэн плакат тавина.

329. Ажлын байр бэлтгэх үед тавьсан хаалт, хашилт, плакатыг ажил бүрэн дуусахаас өмнө авах буюу зөөж тавихыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ОНЦЛОГ НӨХЦӨЛТЭЙ ЦАХИЛГААН БАЙГУУЛАМЖИД АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ

4.1. Цахилгаан ба соронзон орны нөлөөллийн орчинд ажил гүйцэтгэх

330. Бүх түвшний хүчдэлийн цахилгаан байгууламжид хүний бие организмд хортой нөлөө үзүүлэх цахилгаан ба соронзон орны нөлөөллөөс ажилтныг хамгаалах арга хэмжээг авсан байх ёстой.

331. 330 кВ ба түүнээс дээш хүчдэлийн ИХБ ба ЦДАШ-ын цахилгаан орны нөлөөллийн орчинд ажиллах үед тусгай заавар (стандарт)-ын дагуу энэ бүсэд хүн байх хугацааг хязгаарлах шаардлагатай.

332. Цахилгаан орны нөлөөлөлд хүний байж болох хүчлэгийн дээд хэмжээ нь 25 кВ/м байх ба түүнээс дээш хүчлэгтэй цахилгаан орны нөлөөллийн бүсэд тусгай хамгаалах хэрэгсэлгүйгээр ажил гүйцэтгэхийг хориглоно. Энэ тохиолдолд ажлын үргэжлэх хугацаа 8 цагаас илүүгүй байна.

333. Цахилгаан орны хүчлэг 20-25 кВ/м байх үед тусгай хамгаалах хэрэгсэлгүйгээр 10 минут хүртэл байж болох бөгөөд 5-20 кВ/м үед түүний нөлөөлөлд ажиллах хугацааг дараах томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$T=50/E-2;$$

энд: E – Цахилгаан орны үйлчлэх хүчлэгийн хэмжээ, кВ/м;
T – Хүн ажиллах зөвшөөрөгдөх хугацаа;

334. 5 кВ/м хүртэлх хүчлэг бүхий цахилгаан орны нөлөөлөлтэй орчинд ажилтан 8 цаг хүртэл байхыг зөвшөөрнө.

335. Соронзон орны хүчлэг (H, нэгж нь А/м) буюу соронзон орны индукцын (B, нэгж нь мкТл) хэмжээнээс хамааруулан тэдгээрийн нөлөөллийн бүсэд хүн бүх биеэрээ эсвэл биеийн аль нэг хэсгээр байж болох хугацааны нормыг баримталж ажиллах ёстой. Хүснэгт 3-ийг үз.

Хүснэгт 3

Нөлөөллийн орон зайд байх хугацаа (цаг)	Соронзон орны хүчлэг H (А/м), индукц (B, нэгж нь мкТл)-ийн нөлөөллийн байж болох хэмжээ	
	Бүх биеээр	Биеийн аль нэг хэсгээр
≤1	1600/2000	6400/8000
2	800/1000	3200/4000
4	400/500	1600/2000
8	80/100	800/1000

Хугацааны хязгааруудын хоорондох хугацаанд байж болох хүчлэг ба индукцын хэмжээг интерполяцийн аргаар бодож тодорхойлно.

336. Өөр өөр хэмжээтэй соронзон орны нөлөөллийн орчинд ажиллах тохиолдолд аль хэмжээний соронзон орны зайд ажиллах нийт хугацаа нь 3 дугаар хүснэгтэд тогтоосон нормоос илүүгүй байвал зохино.

337. Цахилгаан ба соронзон оронд байж болох зөвшөөрөгдсөн хугацааг ажлын нэг өдөрт нэг удаа бөөнөөр нь буюу хэсэг хэсгээр нь ашиглаж болно. Ажлын өдрийн үлдсэн хугацаанд хамгаалах хэрэгсэл хэрэглэх буюу 5 кВ/м хүртэл хүчлэгтэй цахилгаан оронд ажиллаж болно.

338. Цахилгаан ба соронзон орны түвшинг дараах тохиолдлуудад хэмжиж шалгана. Үүнд:

- Шинээр ашиглалтад оруулж байгаа болон өргөтгөл шинэтгэл хийгдсэн цахилгаан байгууламжид;

- Цахилгаан байгууламжийн ойролцоо байгаа хүн байнга болон түр ажиллах ажлын байр, тоног төхөөрөмжид (зөвхөн соронзон орны хүчлэгийн хувьд хэмжинэ);
- Ажлын байрны нөхцөл тогтоох аттестатчилал явуулахад;

339. Цахилгаан орны хүчлэг, түүний нөлөөлөх бүс болон халхавч хамгаалалтаар хязгаарлах бүсийн заагийг хэмжилтээр тодорхойлно.

340. Ажил гүйцэтгэж байх үед хүн байж болох бүх хэсэг, бүх тохиолдолд өөрчлөгдөөгүй цахилгаан орны хүчлэгийг хэмжих ёстой. Тоног төхөөрөмж, хийц хэсэгт авиралгүйгээр ажиллах тохиолдолд дор дурьдсан нөхцөлд цахилгаан орны хүчлэгийн хэмжилт хийх ёстой. Үүнд:

- Газрын хөрснөөс 1,8 м өндөрт кабелийн сувгийн таган дээр ажиллахад;
- Тоног төхөөрөмжийн хийц хэсэгт авирч гаран газрын гадаргуугаас 0,5; 1 ба 1,8 м өндөрт ба эсвэл тоног төхөөрөмжийн газардуулсан гүйдэл дамжуулах хэсгээс 0,5 м зайд ажиллах үед хэмжилт хийх ёстой. Хяналтын бүсэд байх зөвшөөрөгдөх хугацааг хэмжсэн хүчлэгийн хамгийн их хэмжээгээр бодож тооцно.

341. Соронзон орны хүчлэгийн (индукцын) хэмжилтийг ажлын байрны талбайн шал, газар, өрөөний шал, шилжих дамжуургын хучилтаас 0,5; 1,5; 1,8 м өндөрт хийх ба харин ажлын байрны дор соронзон орны үүсгэгч байгаа бол ажлын байрны талбайн шалны түвшин дээр нэмэлт хэмжилт хийнэ. Хяналтын бүсэд байх зөвшөөрөгдөх хугацааг хэмжигдсэн хүчлэгийн хамгийн их хэмжээгээр бодож тогтооно.

342. Соронзон орны хүчлэгийг тухайн цахилгаан байгууламжийн хамгийн их ажлын гүйдэлтэй (I_{max})-тай үед эсвэл хэмжсэн утгыг I_{max}/I гэсэн хугацаагаар үржүүлж хамгийн их ажлын гүйдэлд шилжүүлэн тооцно. Энд: I - хэмжилт хийх үеийн соронзон орны үүсгэгчийн гүйдэл;

343. Цахилгаан орны хүчлэгийг (индукцыг) цахилгаан байгууламжийн гүйдэл дамжуулах хэсэгт 20 м-ээс дотогш зайд байрлалтай ажилтан байнга ажилладаг үйлдвэрийн өрөө тасалгаанууд тэдгээрийн дотор ханаар тусгаарлагдсан ажлын байруудад хэмжинэ.

344. Цахилгаан орны үйлчлэлээс тусгаарлан хамгаалах хэрэгсэлд ИХБ-д суурин эсвэл зөөврийн халхавч хамгаалалтын төхөөрөмж (экран), ЦДАШ-д бол нэг бүрийн халхавч хамгаалалтын (экрантай) иж бүрэн хувцсыг хэрэглэх ёстой. Иж бүрэн халхавч хамгаалалтын төхөөрөмж нь тусгай заавар (стандарт)-ын шаардлагыг хангасан байх ёстой.

345. Машин механизм, явуулын засварын байр, лабораторын бүхээг, тэвшийг газардуулсан үед түүнчлэн төмөр бетон байшин, төмөр бетон хучилттай болон төмөр хийц ба төмөр дээвэртэй байшин зэрэг нь газардуулгатай бол тэдгээрт ажиллахад цахилгаан ба соронзон орны нөлөөлөл байдаггүй тул хамгаалах хэрэгсэл хэрэглэх шаардлагагүй.

346. Зөөврийн ба явуулын тусгай халхавч хамгаалалтын төхөөрөмжийг байрлуулсан газрыг 10 мм^2 -аас багагүй хөндлөн огтлолтой уян зэс утсаар газардуулгын байгууламжтай холбож газардуулна.

347. Машин механизм дээр байрлуулсан салгаж авдаг халхавч (экран)-тай хамгаалалтын төхөөрөмжийг уг машин механизмтай нь цахилгаан гүйдэл дамжуулах утсаар холбох ёстой. Энэ тохиолдолд машин механизмыг газардуулсан бол салгаж авдаг халхавч хамгаалалтын төхөөрөмжийг газардуулах шаардлагагүй.

348. Тусгаарлах суурь (будагтай төмөр, тусгаарлавч, модон дэвсгэр г.м.) дээр зогсож буюу газардуулсан хийц хэсэгт гараар (бээлий буюу гарын углаасгүй) хүрч ажиллах үед халхавч хамгаалалтын хувцсыг 10 мм^2 хөндлөн огтлолтой зориулалтын уян утсаар газардуулгын байгууламж буюу газардуулсан хийцтэй холбож нэмэлт газардуулга тавих ёстой.

349. Гүйдэл дамжуулах хэсэгт хүрч шүргэж болзошгүй, түүнчлэн тоног төхөөрөмжид өндөржүүлсэн хүчдэлээр туршилт хийх, цахилгаан гагнуур хийх үед халхавч

хамгаалалтын (экрантай) иж бүрэн хувцас хэрэглэхийг хориглоно. Энэ тохиолдолд ажил гүйцэтгэх ажилтныг халхавч хамгаалалтын тусгай төхөөрөмжөөр хангана.

350. Цахилгаан байгууламжийн хүчдэлийг тасалсан гүйдэл дамжуулах хэсэг дээр ажиллахдаа нөлөөллөөр бий болох чадавхийг шавхахын тулд түүнийг газардуулах шаардлагатай.

351. Хүчдэлийг тасалсан боловч газардуулаагүй гүйдэл дамжуулах хэсэгт хамгаалах хэрэгсэлгүйгээр хүрэхийг хориглоно.

352. Газраас тусгаарласан багаж хэрэгсэл ба тоноглолыг газардуулсан байх ёстой.

353. Цахилгаан орны нөлөөллийн бүсэд байгаа хийн дугуйт машин механизмыг шилжин явахад үүсэх чадавхийг арилгахын тулд түүний арал буюу тэвшийг төмөр гинжээр (гинж нь чирэгдэж явахаар) газардуулах ёстой.

354. Цахилгаан орны нөлөөллийн бүс дотор машин механизмыг шатах тослох материалаар цэнэглэхийг хориглоно.

355. Цахилгаан орны нөлөөллийн бүсэд байгаа тоног төхөөрөмж, хийц хэсэгт авирч ажиллах тохиолдолд цахилгаан орны хүчлэгийн хэмжээ ба ажиллах хугацааг үл харгалзан хамгаалах хэрэгсэл хэрэглэх ёстой.

356. Сунадаг шат буюу өргүүрийн ажлын тавцанг хамгаалах, эсвэл халхавч хамгаалалтын хувцас хэрэглэх ёстой.

357. ИХБ-ийн хийц хэсгийн дотор халхавч хамгаалалтын төхөөрөмжтэй бүсэд хүн байх, мөн түүнчлэн хүчний трансформаторын тосны түвшний реле ба хийн реле рүү хүн шатаар авирах үед цахилгаан орны үйлчлэлээс хамгаалах хэрэгслийг хэрэглэхгүй байж болно.

358. ИХБ-д эргүүл үзлэг хийх, ажлын байранд очихдоо тусгай тогтоосон чиглэлээр явах ёстой.

359. Цахилгаан ба соронзон орны хүчлэг нь зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн цахилгаан байгууламжид хаалт хашилт хийгээд түүн дээр анхааруулга бичих буюу плакат өлгөнө.

360. Цахилгаан ба соронзон орны нөлөөллийн орчинд ажиллахад аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээг нарядын “Тусгай заалт” гэсэн мөрөнд бичнэ.

4.2. Генератор ба синхрон компенсатор

361. Соронзон орон унтраах автомат төхөөрөмж нь тасархай, сэргээлт (өдөөлт) өгөгдөөгүй, эргэж байгаа генераторыг (голыг эргүүлэх төхөөрөмжөөс эргэлтэд орохоос бусад тохиолдолд) хүчдэлтэйд тооцно.

362. Соронзон орон унтраах автомат төхөөрөмж (өдөөлтийн үед хэрэглэдэг) нь тасархай, сэргээлтийн (өдөөлт) гүйдлийг мөн тасалсан байхад ажлын давтамжтай эргэж байгаа генераторыг туршихад түүний схем буюу блокийн схемийн хэсэгт газардуулга тавьсны дараа уг схемд тусгай зориулалтын богино холбоос тавих буюу авна.

363. Генератор, трансформаторын блокийн өсгөх трансформаторын өндөр хүчдэлтэлд мөн өөрийн хэрэгцээний трансформаторын нам хүчдэлийн холболтууд газардуулагдсан, хүчдэлийн трансформатораар дамжин хүчдэл ирэх боломжийг хаасан бол зогсоосон блок генераторын схемд ажил гүйцэтгэх үед түүний гаргалгаанууд дээр газардуулга тавихгүй байж болно.

364. Соронзон орон унтраах автомат төхөөрөмж нь тасархай сэргээлт (өдөөлт) өгөгдөөгүй эргэж байгаа генераторын статорын хэлхээнд үлдэгдэл хүчдэлийг хэмжих, фазын дарааллыг тодорхойлох, ороомгийн идэвхитэй эсэргүүцлийг хэмжих гэх мэтийн ажил хийж болно.

Эдгээр ажлыг шуурхай ажиллагааны ажилтны хяналтан дор тусгаарлах хэрэгсэл ашиглан мэргэжлийн алба, лаборатори, туршилт тохируулгын байгууллагын ажилтан нарыдаар гүйцэтгэнэ.

365. Ажиллаж байгаа генераторын гол дээр хүчдэл ба роторын ороомгийн эсэргүүцэл хэмжих ажлыг IV ба III групптэй хоёр хүн шийдвэрээр гүйцэтгэхийг зөвшөөрнө.

366. Ажиллагаанаас гаргасан генераторын өдөөгчийн коллектор өнгөлөх, роторын контактын цагирагийг зорох ба өнгөлөх ажлыг цахилгаан техникийн бус нэг хүн шийдвэрээр гүйцэтгэж болох ба энэ үед нүдний шилтэй ажиллавал зохино.

367. Ажиллагаанд байгаа генераторын сойзын аппаратад үйлчилгээ хийх ажлыг энэ ажилд тусгайлан сургаж бэлтгэсэн III-аас доошгүй групптэй ажилтан ганцаараа гүйцэтгэж болно. Энэ үед дараах урьдчилан сэргийлэх арга хэмжээг мөрдвөл зохино.

- Машины эргэлдэх хэсэгт орооцолдохооргүй бүрэн товчилсон ажлын тусгай хувцас өмсөх;
- Нүүрэвчтэй дуулга өмсөх;
- Тусгаарлах резин шаахай буюу дэвсгэр хэрэглэх;
- Хоёр туйлын гүйдэл дамжуулах хэсэгт эсвэл гүйдэл дамжуулах хэсэг ба газардуулгатай хэсэгт нэг зэрэг хүрэхгүй байх;

4.3. Цахилгаан задлагын төхөөрөмж

368. Цахилгаан задлагын (электролиз) төхөөрөмжийн ашиглалтын явцад устөрөгч ба хүчилтөрөгч эсвэл устөрөгч ба агаарын тэсрэх аюул бүхий хольц үүсгэхийг хориглоно.

369. Даралт тохируулах төхөөрөмжийн түвшин харах шилэнд шингэний түвшин үзэгдэхгүй бол цахилгаан задлагын төхөөрөмжийг ажиллуулахыг хориглоно. Устөрөгч ба хүчилтөрөгчийн системүүдийн даралтын зөвшөөрөгдөх хамгийн их зөрүү нь 1961.4 Па (200мм усны багана)-аас хэтрэхгүй байх ёстой.

370. Хий хураах савуудаас бусад цахилгаан задлагын төхөөрөмжийн шугам хоолой, аппарат тоноглолуудыг ажилд залгахын өмнө азотоор (ГОСТ 9293-71, II ангилал) үлээлгэх ёстой. Эдгээр тоноглолуудыг нүүрсхүчлийн хийгээр үлээлгэхийг хориглоно.

371. Цахилгаан задлагын төхөөрөмжийн хий хураах савуудыг азотоор буюу нүүрсхүчлийн хийгээр (ГОСТ 8050-85, хүнсний буюу техникийн ангилал) үлээлгэж болно.

372. Нэг буюу хэд хэдэн хий хураах саванд дотоод үзлэг хийх шаардлагатай үед тэдгээрийг хий хураах савуудын бусад хэсгээс хаалтаар тусгаарлаж фланцаас илүү гарсан бариултай бөглөөс (таглаас, заглушка) тавьж доторх устөрөгчийг шахаж гаргахын тулд эхлээд нүүрсхүчлийн хий буюу азотоор, дараа нь цэвэр агаараар үлээлгэвэл зохино.

373. Хий хураах савуудад инертийн хий, агаар ба устөрөгчөөр үлээлэг хийхдээ түүний доторх хийнүүдийн хольцын найрлага 4 дүгээр хүснэгтэд заасан хэмжээнд хүртэл үлээлгийг үргэлжлүүлэн явуулбал зохино.

374. Хий хураах савуудын үлээлгэд 0,05 хүртэл хувийн агуулгатай техникийн ангиллын нүүрсхүчлийн хийн исэл ашиглах ба түүнийг хүнсний ангиллын нүүрсхүчлийн хийнээс тусад нь хадгална.

375. Цахилгаан задлагын төхөөрөмжийн хүчдэлийг 4 цагаас илүү хугацаагаар таслах тохиолдолд түүний тоноглол, шугам хоолойг азотоор заавал үлээлгэнэ.

376. Системийг 1-4 цаг таслах тохиолдолд устөрөгч буюу хүчилтөрөгчийг $(9,807-19,614) \cdot 10^3$ Па $(0,1-0,2 \text{ кг/см}^2)$ даралттай үлдээж болно.

377. Төхөөрөмжийг 1 цаг хүртэл хугацаанд таслах үед тоноглолын доторх хийнүүдийг хэвийн даралтад үлдээхийг зөвшөөрөх бөгөөд энэ үед устөрөгч ба хүчилтөрөгчийн даралт тохируулах аппарат дахь даралтын зөрүү ихсэлтийг мэдээлдэг дохиоллыг ажлаас гаргахыг хориглоно.

378. Хэрэв технологийн горимын зөрчилтэй холбогдуулан хүчдэлийг тасалж байгаа эсвэл хүчдэлийг тасалсан цахилгаан задлагын төхөөрөмж доторх уусмалын шулуутгагчийн тэжээлийг таслах хэрэгцээтэй бол заавал азотоор үлээлгэнэ.

Хүснэгт 4

Хий хураах савуудыг үлээлгэх дараалал

Юуг юугаар үлээлгэж гаргах	Сорьц авах цэг	Шинжилж тодорхойлох хийн нэр	Агуулагдвал зохих хэмжээ, %
Агаарыг нүүрсхүчлийн хийгээр	Хий хураах савын дээд хэсгээс	Нүүрсхүчлийн хий	85,0
Агаарыг азотоор	Хий хураах савын дээд хэсгээс	Хүчилтөрөгч	3,0
Нүүрсхүчлийн хийг устөрөгчөөр	Хий хураах савын доод хэсэг	Нүүрсхүчлийн хий	1,0

		Хүчилтөрөгч	0,5
Азотыг устөрөгчөөр	Хий хураах савын доод хэсэг	Азот	1,0
		Хүчилтөрөгч	0,5
Устөрөгчийг нүүрсхүчлийн хийгээр	Хий хураах савын дээд хэсэг	Нүүрсхүчлийн хий	95,0
Устөрөгчийг азотоор	Хий хураах савын дээд хэсэг	Устөрөгч	3,0
Азотыг агаараар	Хий хураах савын доод хэсгээс	Хүчилтөрөгч	20,0
Нүүрсхүчлийн хийг агаараар	Хий хураах савын доод хэсгээс	Нүүрсхүчлийн хий	Байхгүй

379. Цахилгаан задлагын төхөөрөмжийн устөрөгч дамжуулах шугам хоолой, хий хураах сав болон бусад аппарат тоноглолын засварын ажлыг нарыдаар гүйцэтгэнэ. Хэрэв ажлын байр бэлтгэхэд нэмэлт техникийн арга хэмжээ авах шаардлагагүй бол тухайн байгууламжийн ашиглалт үйлчилгээ хариуцдаг шуурхай үйлчилгээний ажилтны хяналтан дор засварын ажлыг шийдвэрээр гүйцэтгэж болно.

380. Цахилгаан задлагын төхөөрөмжийн байрлах өрөө, түүний тоноглол, хий хураах сав, түүнээс гарах, орох шугам хоолой дээр буюу тэдгээрээс дотогш 10 м-ийн дотор зайд ил гал (цахилгаан, хийн гагнуур гэх мэт) гаргаж хийх ажлыг нарыдаар гүйцэтгэх ёстой. Нарядын “Тусгай заалт” гэсэн мөрөнд ажлын аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээ (хаалт хашилт тавих, тасалгааны агаарын найрлагад устөрөгч байхгүй болохыг батлах шинжилгээ хийх г.м.)-г заасан байх ёстой.

381. Устөрөгчөөр дүүргэсэн шугам хоолой, тоноглолуудын их бие, хий, тосны системийн төхөөрөмж дээр галтай ажил гүйцэтгэж болохгүй, “Галын аюултай! Устөрөгч” гэсэн плакат өлгөсөн байх ёстой.

382. Цахилгаан задлагын төхөөрөмжийн тоноглолуудыг задлан онгойлгож хийх засвар буюу гагнуурын ажлын үед түүний эцсийн цэгт устөрөгчгүй болтол үлээлэг хийх ёстой.

383. Цахилгаан задлагын төхөөрөмжийн өрөө тасалгаанд ил гал гаргаж хийх ажлыг уг төхөөрөмжийг тасалж, агаарт устөрөгч байхгүй болохыг шинжилгээгээр баталж тасралтгүй үлээлэг, агааржуулалт хийсний дараа гүйцэтгэх ёстой.

384. Нэг байранд суурилуулсан цахилгаан задлагын төхөөрөмжүүдийн аль нэг аппарат дээр ил гал гаргаж ажиллах үед ажиллагаатай байгаа тоноглолуудын шугам хоолой нь зогсоосон тоноглолын шугам хоолойтой нийлсэн холболтыг таслаад бариултай таглаас тавьбал зохино. Ил галтай ажиллах ажлын байранд битүү хаалт хашилт хийсэн байх ёстой.

385. Устөрөгчөөр дүүргэсэн аппарат тоноглолд засварын ажил хийхийг хориглоно.

386. Хөлдсөн шугам хоолой, хаалтыг зөвхөн уур буюу халуун усаар гэсгээж болно.

387. Холбоосоор хий алдаж байгаа эсэхийг хий алдалт илрүүлэх багажаар эсвэл савангийн хөөсөөр тодорхойлно.

388. Хий алдалтыг илрүүлэх ба гэсгээх зорилгоор ил гал хэрэглэхийг хориглоно.

389. Цахилгаан задлагын төхөөрөмжийн өрөө тасалгаа болон хий хураах савны дэргэд ил гал гаргах, 12 В-оос дээш хүчдэлийн цахилгаан халаагуурба зөөврийн гэрэл ашиглах, тамхи татахыг хориглоно.

390. Аппаратад дотоод үзлэг, засвар хийх үед түүний гэрэлтүүлгэнд 12 В-оос ихгүй хүчдэлтэй, тэсрэлтийн хамгаалалттай төмөр торон бүрхүүлтэй зөөврийн гэрэл ашиглахыг зөвшөөрнө.

391. Цахилгаан задлагын төхөөрөмжийн байранд болон хаалганы гадна талд ил гал гаргахыг хориглосон плакат, харин устөрөгчийн хий хадгалах саван дээр “Галын аюултай! Устөрөгч” гэсэн галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж байрлуулсан байх ёстой.

392. Цахилгаан задлагын төхөөрөмжийн байранд амархан гал авалцах, тэсэрч дэлбэрэх материал хадгалахыг хориглоно.

393. Задрах уусмалтай ажиллахад ажлын тусгай хувцас (даавуун өмд, цамц, резинэн гутал, резинэн хормогч, резинэн бээлий) өмсөж, нүдний шил зүүсэн байвал зохино.

394. Шингэн буюу хатуу шүлт хүний арьс, үс ялангуяа нүдэнд орж түлэгдэлт үүсэхээс хамгаалах ёстой.

395. Задрах уусмалын нягтыг шалгах сорьцыг зөвхөн даралтыг буулгасан үед авна.

396. Цахилгаан задлагын төхөөрөмжид ялангуяа тэдгээрийн төгсгөлийн хавтангуудад хамгаалах хэрэгсэлгүй хүрэхийг хориглоно.

397. Бэхэлгээний боолтуудыг тусгаарлах шаантаг ба туйлуудын хавтангийн тусгаарлагчид шүлт хүргэж болохгүй. Эдгээр хийцүүдийн тусгаарлагч гэмтвэл нум үүсэж гал, осол гарах аюултай тул урьдчилан сэргийлэх ёстой.

398. Цахилгаан задлагын төхөөрөмжийн шалыг цахилгаан тусгаарлагч материалаар хийсэн байх ёстой.

399. Цахилгаан задлагын төхөөрөмжийн тоноглол, шугам хоолой, хий хураах сав ба тэдгээрээс машины өрөөнд очсон шугам хоолойнууд нь залгаасгүй, ил задгай бус цахилгаан хэлхээтэй байх ба газардуулгын төхөөрөмжид холбогдсон байх ёстой.

400. Цахилгаан задлагын төхөөрөмжийн тоноглол ба шугам хоолойг хоёроос цөөнгүй цэгт газардуулсан байх ёстой.

401. Генераторын их бие, хий тосны системийн тоноглолыг задлах, онгойлгохын өмнө устөрөгчийг инертийн хийгээр, инертийн хийг агаараар тус тус шахаж гаргах ёстой.

402. Нүүрсхүчлийн хий азотыг түрж гаргах үед хүчилтөрөгчийнагуулагдах хэмжээ 20 хувиас багагүй болсон нь шинжилгээгээр батлагдсаны дараа хажуу талын самбар, нээлхий зэргийг онгойлгохыг зөвшөөрнө.

403. Их бие дэх устөрөгчийг шахаж гаргалгүйгээр зогсоосон синхрон генераторын (компенсаторын) контактын цагирагийн үүрийг нээж инертийн хий шахахаас өмнө уг үүрийн генераторын (компенсаторын) их биеэс тусгаарлах хаалтын нягтыг шалгавал зохино. Энэ үүрийн дотор талыг инертийн хийгээр үлээлгэсний дараа (түүнийг агаараар шахаж гаргалгүй) хийн шинжилгээ хийгээд ажлыг эхэлж болно.

404. Хий тосны системийн тоног төхөөрөмж ба шугам хоолойг засварт гаргах үед засварлах хэсгийн хаалтуудын нягт бус хэсгээр устөрөгч болон инертийн хий нэвтрэх нөхцөлийг арилгахын тулд шугам хоолойнуудын холболтыг салгаж бөглөөс тавих ёстой.

405. Цахилгаан задлагын төхөөрөмжөөс хийн хуримтлуурууд хүртэлх шугам хоолойнууд, мөн түүнчлэн генераторын хөргөлтийн хий, тосны системийн дамжуулах хоолойнуудын ашиглалт үйлчилгээг тухайн ашиглагч байгууллагын заавраар зохицуулна.

406. Хамгаалах хавхлагыг шалгахын тулд төхөөрөмжийг зогсоож азотоор үлээлгэх ёстой.

407. Төхөөрөмж ажиллаж байхад түүний хамгаалах хавхлагыг туршихыг хориглоно.

408. Даралттай байгаа аппарат тоноглол болон хаалт арматуруудад чангалгаа хийхийг хориглоно. Шланг, штуцеруудийг найдвартай бэхэлсэн байх ёстой.

409. Угсралт, их засварын дараа буюу удаан хугацаанд зогссон цахилгаан задлагын төхөөрөмжийг инженер техникийн ажилтны хяналтан дор ажилд оруулж залгах ёстой.

4.4. Цахилгаан хөдөлгүүр

410. Цахилгаан хөдөлгүүр буюу түүгээр хөдөлгөөнд ордог механизмын гүйдэл дамжуулах болон эргэх хэсэгт хүрч ажиллах үед цахилгаан хөдөлгүүрийн хүчдэлийг тасалсан байх ёстой.

411. Олон шатлалт хурдтай цахилгаан хөдөлгүүр дээр ажиллахад статорын ороомгийн тэжээлийн бүх хэлхээг таслаад энэ дүрэмд заасан урьдчилан сэргийлэх техникийн арга хэмжээг авна.

412. Цахилгаан хөдөлгүүрийн гүйдэл дамжуулах хэсэг болон тухайн хөдөлгүүрээр хөдөлгөөнд ордог механизм, эргэх хэсэгт хүрэхгүй тохиолдолд ажиллагаанд байгаа цахилгаан хөдөлгүүр дээр ажиллаж болно.

413. Цахилгаан хөдөлгүүр, технологийн механизмын эргэх хэсэг болон бусад тоноглолын хамгаалалтын хаалтыг салгаж авах, тэдгээргүйгээр ажиллуулахыг хориглоно.

414. Цахилгаан хөдөлгүүр дээр ажил гүйцэтгэх үед хөдөлгүүрийг хуваарилах байгууламжийн секц, цуглуулгын самбартай холбосон кабель шугамын аль ч хэсэгт газардуулга тавьж болно.

415. Хэрэв хүчдэлийг нь тасалсан цахилгаан хөдөлгүүр дээр ажиллаагүй буюу ажил хэд хоногоор завсарлаж байгаа бол тэжээлийн кабелийн үзүүрийг тайлаад цахилгаан хөдөлгүүр талд нь газардуулга тавих ёстой.

416. 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан хөдөлгүүрийн кабелийн судлын хөндлөн огтлол нь зөөврийн газардуулга тавих бололцоогүй тохиолдолд түүний судлын хөндлөн огтлолоос багагүй хөндлөн огтлолтой зэс утсаар газардуулах буюу кабелийн судлуудыг хооронд нь холбоод тусгаарласан байж болно.

417. Хөдөлгүүрийн кабелийн судлуудыг хооронд нь холбоод газардуулсан болон судлуудыг хооронд нь холбоод тусгаарласан хэсэг нүдэнд ил харагдахуйц байх ёстой. Тийм газардуулга буюу кабелийн судлуудын холболтыг шуурхай ажиллагааны журналд зөөврийн газардуулгын адил бүртгэж тооцох ёстой.

418. Насос, утаа сорогч, салхилуур зэрэг механизмын цахилгаан хөдөлгүүр дээр ажилд орохын өмнөхэрэв уг цахилгаан хөдөлгүүр нь түүнд холбогдсон механизмын хүчээр эргэлтэнд орох боломжтой бол хаалт, шибенийг хааж цоожлох, цахилгаан хөдөлгүүрийн роторыг эргэхгүй болгох, холболтын муфтыг тайлахзэрэг арга хэмжээ авах ёстой.

419. Хаалт болон гүйцэтгэх механизм, тоноглол нь цахилгаан дамжуулгатай холбоотой үед түүний цахилгаан дамжуулгыг ажиллуулж шалгах ажлыг тэдгээрийг суурилуулсан цехийн даргын зөвшөөрлөөр тусгай бригад гүйцэтгэх ёстой. Зөвшөөрөл олгосон тухай цех (хэсэг)-ийн шуурхай ажиллагааны журнал, мөн хөдөлгүүрийг шалгах зөвшөөрөл авсан тухай хөдөлгүүрийг шалгах цех (хэсэг)-ийн шуурхай ажиллагааны журналд тус тус бичих ёстой.

420. Гар болон алсын зайн автомат удирдлагатай цахилгаан хөдөлгүүрийн тэжээлийн автоматыг залгах ба таслахад заавал зориулалтын резинэн бээлийтэй ажиллах ёстой.

421. Хаалт, шибер, вентилүүдийн бариул, залуур дээр “Бүү онгойлго! Хүмүүс ажиллаж байна”, харин төхөөрөмжүүдийн удирдлагын түлхүүр, товчлуур дээр “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна” гэсэн плакатуудыг өлгөсөн байх ёстой.

422. Засварлах хөдөлгүүрийн дэргэдэх түүнтэй адил төстэй буюу ойролцоо овор хэмжээтэй өөр хөдөлгүүр дээр түүнийг ажиллаж байгаа эсэхийг нь үл харгалзан “Зогс! Өндөр хүчдэл” гэсэн плакат өлгөх ёстой.

423. Технологийн агрегат, технологийн дамжлагад байгаа засварт гаргасан нэг түвшингийн хүчдэлийн цахилгаан хөдөлгүүрүүд дээр ажил гүйцэтгэх үед энэ дүрмийн 117-119-т заасны дагуу гүйцэтгэнэ. Урьдчилан бэлтгэсэн ажлын байруудад нэг зэрэг ажилд оруулж болох ба ажлын нэг байрнаас нөгөөд шилжихийг нарыадад бичих шаардлагагүй. Энэ тохиолдолд нарыадад тусгасан бүх цахилгаан хөдөлгүүр дээрх ажил бүрэн дуусахаас өмнө аль нэг хөдөлгүүрийг ажиллуулж шалгахыг хориглоно.

424. Цахилгаан хөдөлгүүрийг ажиллуулж шалгахад дараах журмыг баримтлана:

- Ажил гүйцэтгэгч нь бригадыг ажлын байрнаас гаргаж, ажил дууссаныг нарыадад бичээд, нарыадыг шуурхай ажиллагааны ажилтанд хүлээлгэн өгнө.
- Шуурхай ажиллагааны ажилтан тавьсан плакатууд, газардуулгыг авч схем цуглуулна.

425. Цахилгаан хөдөлгүүрийг ажиллуулж шалгасны дараа засварын ажлыг үргэлжлүүлэн хийх шаардлагатай бол нарыадын дагуу ажлын байрыг шинээр бэлтгэж бригадыг ажилд оруулна.

426. Ажиллагаанд байгаа цахилгаан хөдөлгүүрийн гүйдэл дамжуулах болон эргэлдэх хэсэгт ойртохгүйгээр хийх ажлыг шийдвэрээр гүйцэтгэж болно.

427. Ажиллаж байгаа цахилгаан хөдөлгүүрийн сойзын аппаратын үйлчилгээг энэ ажилд тусгайлан сургасан III-аас доошгүй групптэй хүн шийдвэрээр гүйцэтгэж болно. Энэ үед дараах урьдчилан сэргийлэх арга хэмжээг мөрдвөл зохино.

- Машины эргэх хэсэгт орооцолдохооргүй бүрэн товчилсон ажлын тусгай хувцас өмсөх;
- Нүүрэвчтэй дуулга өмсөх;

- Зориулалтын резинэн шаахай буюу дэвсгэр хэрэглэх;
- Хоёр туйлын гүйдэл дамжуулах хэсэгт эсвэл гүйдэл дамжуулах хэсэг ба газардуулгатай хэсэгт нэг зэрэг хүрэхгүй байх;

Ажиллагаанд байгаа цахилгаан хөдөлгүүрийн роторын цагиргийг зөвхөн тусгаарлах материалаар хийсэн хэвээр (колодок) өнгөлж болно.

428. Байгууллага нь ашиглаж байгаа цахилгаан машины төрөл, хэлбэр хийц, асаах болон ажиллагааг тохируулах аппарат, механизм болон технологийн схемийн онцлог нөхцөлийг харгалзан аюулгүй ажиллагааны заавартаа цахилгаан хөдөлгүүр дээр ажил гүйцэтгэх үед ажлын байрыг бэлтгэх, аюулгүй ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар тодорхой тусгаж өгнө.

4.5. Таслах, залгах аппарат

429. Таслах, залгах аппаратыг санамсаргүйгээр залгах, залгагдахаас урьдчилан сэргийлэх техникийн арга хэмжээг бүрэн авч, аюулгүй байдлыг хангасны дараа таслах, залгах аппарат дээр ажил гүйцэтгэж болно.

430. Агаар хуримтлуулах савны дотор хүн орж ажил гүйцэтгэхийн өмнө дараах арга хэмжээ авна. Үүнд:

- Агаар хуримтлуулах сав доторх даралттай агаарыг гаргаж юүлэх;
- Цорго (дренаж), хаалт хавхлагыг онгорхой орхих;
- Уг саванд агаар шахах болох бүх шугам хоолойн хаалт, тэдгээрийн удирдлагын бариулыг хааж цоожлоод тэдгээрт “Бүү онгойлго! Хүмүүс ажиллаж байна” гэсэн плакат өлгөх;
- Агаар хуримтлуулах сав руу агаар шахах шугам хоолойн холболтыг салгаад түүнд таглаас хийнэ.

431. Чичиргээ намжаагч (демпфер) тохируулах, чичиргээ тодорхойлох, хэмжүүрийн багажийн утас холбох болон салгах, агаарын алдагдаж байгаа шалтгааныг тодорхойлох гэх мэт туршилт тохируулгын ажлын үед ажлын даралттай агаар бүхий хийн таслуур дээр авирч гарахыг зөвшөөрнө. Тохируулга, зүгшрүүлэлт хийхээр хийн таслуур дээр гарахын өмнө дараах арга хэмжээг авах ёстой.

- Удирдлагын хэлхээний хүчдэлийг таслах;
- Удирдах товчлуур, асаах хавхлагт хориг түгжээ хийх (Жишээ нь: агаар дамжуулах шугам хоолойг салгах, шүүгээ, шитийг хааж цоожлох г.м.);
- Таслуурт үйлдэл хийх үүрэг бүхий ажилтныг ажилд оруулах тухайлсан зааварчилгаа авсан бригадын нэг гишүүнийг таслуурын дэргэд байлгах;

432. Даралттай хийн таслуур дээр ажил гүйцэтгэж байгаа үед удирдлагын ба хуваарилах шүүгээ, самбар дээрх бүх ажлыг зогсоосон байх ёстой. Түүнчлэн ашиглалтад байгаа 220 кВ ба түүнээс дээш хүчдэлийн таслууруудын гаргалгаан дээр нөлөөллийн хүчдэлээс хамгаалах зорилгоор газардуулга тавьсан байх ёстой.

433. Агаар дүүргэсэн тусгаарлуур бүхий хийн таслуурын тусгаарлуур нь ажлын даралттай байгаа үед тасалсан хийн таслуур дээр ямар ч тохиолдолд авирч гарахыг хориглоно.

434. Алсын удирдлагатай таслах, залгах аппарат дээр ажилд оруулахын өмнө аюулгүй ажиллагааг хангах дараах арга хэмжээг авах ёстой.

- Залуурын (удирдлага, дохиолол, халаагуур, болон бусад хэлхээ) хэлхээний хүчдэлийг таслах;
- Шахсан хийгээр удирддаг таслуур ба залуурт агаар өгөх шугам хоолойн хаалтуудыг хааж тэдгээрт байгаа агаарыг гарган юүлж, бөглөөг (хавхлагыг) онгорхой үлдээх;
- Залгах ачаа болон пүршийг ажлын бус байрлалд тавих;
- Алсын удирдлагын түлхүүр дээр “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна”, хаасан хаалтан дээр “Бүү онгойлго! Хүмүүс ажиллаж байна” гэсэн плакатыг тус тус өлгөнө.

435. Таслуурын бортого, агаар хуримтлуулах сав дээрх манометрийн заалт “0” зааж байгаагаар тэдгээрт даралттай агаар байхгүй гэж үзэж болохгүй.

436. Агаар хуримтлуулагчийн орох нүх, нээлхийн таган дээрх эрэг боолтыг тайлж эхлэхийн өмнө ажил гүйцэтгэгч өөрийн биеэр агаар гаргах хавхлага буюу хаалт

онгорхой байгааг лавлан харж, сав дотор даралттай агаар байхгүй гэдгийг магадлах ёстой. Агаар хуримтлуулагчийн орох нүх, нээлхийн тагийг бэхэлдэг бүх эрэг, боолтыг чангалсны дараа л түүний агаар гаргагч хаалт хавхлага, бөглөөг хаахыг зөвшөөрнө.

437. Хийн таслуурын сорилт, зүгшрүүлэлт хийх ба ажиллуулж шалгах зорилгоор түүнийг тасалж залгах үед таслуурын ойролцоо хүн байхыг хориглоно.

438. Туршилт, зүгшрүүлэлт хийж байгаа бригадын ажил гүйцэтгэгч (эсвэл түүнээс эрх олгосон бригадын гишүүн) нь бригадын бүх гишүүдийг таслуураас аюулгүй зайд холдуулсны дараа таслуурыг залгах буюу таслах үйлдэл хийх зөвшөөрөл өгөх ёстой.

439. Таслах, залгах аппаратын тохируулга зүгшрүүлэлтийн үед сорилтын таслалт, залгалт хийхэд нарядыг хаалгүйгээр түүний залуурын хүчний хэлхээ ба гүйдлийн хэлхээнд түр хугацаагаар хүчдэл өгч таслуур ба залуурт агаар шахаж болно. Энэ үед “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна”, “Бүү нээ! Хүмүүс ажиллаж байна” гэсэн плакатуудыг авсан байх ёстой.

440. Таслах, залгах аппаратыг сорилтын журмаар таслах буюу залгах үйлдлийг зөвшөөрөл олгогчийн зөвшөөрлөөр ажил гүйцэтгэгч хийж болох ба энэ тухай нарядын “Тусгай заалт” гэсэн мөрөнд бичсэн байх ёстой. Дээрх үйлдлийг ажил гүйцэтгэгчийн зөвшөөрснөөр шуурхай ажиллагаа-засварын ажилтан гүйцэтгэж болно.

441. Сорилт дууссаны дараа таслах, залгах аппарат дээрх ажлыг үргэлжлүүлэх шаардлагатай тохиолдолд ажил гүйцэтгэгч буюу шуурхай ажиллагаа-засварын ажилтан (аппаратын сорилтын таслах үйлдэл хийсэн хүн) энэ дүрмийн 434 дүгээр зүйлд заасан шаардлагыг биелүүлэх ёстой.

4.6. Бүрдмэл хуваарилах байгууламж

442. БХБ-ийн үүрэн дотор эсвэл тэргэнцрийн тоног төхөөрөмж дээр ажиллахад тэргэнцрийг засварын байрлалд татаж гаргавал зохих ба хүчдэлтэй үлдсэн гүйдэл дамжуулагч үүрийн хөшгөн хаалтыг хааж цоожлоод “Зогс! Өндөр хүчдэл”, ажил гүйцэтгэх тэргэнцэр эсвэл үүрэн дотор “Энд ажиллаж болно” гэсэн плакатыг тус тус өлгөнө.

443. БХБ-ийн гадна талд түүнд холбогдсон тоног төхөөрөмж эсвэл түүнээс гарсан ЦДАШ ба кабель шугам дээр ажиллах үед таслууртай тэргэнцрийг үүрнээс нь татаж гаргавал зохих ба хөшгөн хаалт буюу хаалгыг цоожлоод тэдгээрт “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна” гэсэн плакат өлгөнө. Энэ үед дараах арга хэмжээг авна:

- Газардуулгын хутга ба таслууртай тэргэнцэр хоёрын хооронд хориг түгжээтэй бол газардуулгын хутгыг залгасны дараа таслууртай тэргэнцрийг хяналтын байрлалд тавих;
- Дээр дурьдсан хориг түгжээ байхгүй эсвэл газардуулгын хутгагүй бол тэргэнцрийг цоожлох боломжтой тохиолдолд хяналтын (туршилтын) ба засварын байрлалын хооронд тавих;
- Тэргэнцрийг газардуулсан эсэхээс үл хамааран завсарын байрлалд тавьж болно.

444. БХБ-ийн гарсан ЦДАШ-д ажиллах үед түүний үүрэнд газардуулга тавихдаа энэ дүрмийн 3.6.1-т заасан шаардлагыг баримталбал зохино.

445. БХБ-ийн хайламтгай хамгаалуур (гал хамгаалагч)-тай тэргэнцэрээр хүчдэлтэй боловч ачаалалгүй нөхцөлд таслалт залгалт хийж болно.

446. БХБ-аас гарсан ЦДАШ, кабель шугам ба тэдгээрт холбосон тоног төхөөрөмж, цахилгаан хөдөлгүүрийн механизм дээр ажил гүйцэтгээгүй, эсвэл БХБ-ийн үүрэнд газардуулга тавьсан байвал таслууртай тэргэнцрийн хамгаалалтын ажиллагааг шалгаж үзэх, удирдлагын хэлхээнд нь ажиллах зорилгоор уг тэргэнцрийг хяналтын байрлалд тавихыг зөвшөөрнө.

447. Вакуум таслуураар тоноглогдсон хуваарилах байгууламжийн нум унтраах камерыг амплитуд нь 20 кВ-оос дээш хүчдэлээр туршихад үүсэх рентген туяанаас ажилтныг хамгаалах тусгай халхавч (экран) хэрэглэнэ.

4.7. Агаарын болон бүрдмэл дэд станц (АТП, КТП)

448. Гүйдэл дамжуулах хэсэгт 1 дүгээр хүснэгтэд зааснаас дотогш зайд ойртохооргүй нөхцөлд агаарын болон бүрдмэл дэд станц (АТП, КТП)-ын 1000 В-оос дээш

хүчдэлийн тэжээлийн шугамыг таслахгүйгээр тавцан дээр зогсож үзлэг, ажил гүйцэтгэж болно. Хэрэв энэхүү зай нь зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байвал 1000 В-оос дээш хүчдэлийн гүйдэл дамжуулах хэсгийн хүчдэлийг тасалж, газардуулга тавьсан нөхцөлд ажил гүйцэтгэнэ.

449. Агаарын болон бүрдмэл дэд станц (АТП, КТП)-д шугам нь хүчдэлтэй эсэхийг үл харгалзан эхлээд 1000 В хүртэл хүчдэлийн таслах, залгах аппаратуудыг тасалсны дараа нь 1000 В-оос дээш хүчдэлийн салгууруудыг тасалж гүйдэл дамжуулах хэсгүүдэд газардуулга тавьсны дараа ажилд оруулна.

450. Хэрэв нам (330/220В) талаас нь шугамаар хүчдэл ирж болзошгүй тохиолдолд тухайн шугамын эсрэг тэжээлийн талаас нь таслаад өөрөө залгагдах буюу санамсаргүйгээр залгахаас урьдчилан сэргийлсэн арга хэмжээ авч, дэд станц дээр ирж байгаа шугамын төгсгөлд залгах, салгах аппаратын талд газардуулга тавьсан байх ёстой.

451. Агаарын дэд станц (АТП), сэлгэн залгалтын болон бусад байгууламж нь хашаагүй бол хуурай салгуур, ачаалал таслагчийн залуур, 1000 В-оос дээш хүчдэлийн шүүгээ, 1000 В хүртэл хүчдэлийн цитийг цоожилсон байх ёстой. Үйлчилгээний тавцангийн байнгын шатыг салгуурын залууртай холбож цоожилсон байна.

4.8. Хүчний трансформатор, тосон шунтлагч ба нум унтраагч реактор

452. Хүчний трансформатор, тосон шунтлагч ба нум унтраагч реакторын үзлэгийг газраас эсвэл байнгын шат тавцан дээрээс хийнэ. Үзлэгийн шат тавцан нь хашлагатай буюу түгжих хийцтэй байна.

453. Ажиллагаанд байгаа трансформатор (реактор)-ын үзлэг хийх тавцанд нь хаалттай байх ба “Бүү авир! Үхэл” гэсэн анхааруулах плакат өлгөсөн байна.

454. Ажиллагаанд байгаа трансформатор (реактор)-ын хийн реленээс хий авах ажлыг хүчдэлийг тасалсны дараа гүйцэтгэнэ.

455. Трансформатор (реактор)-ын савны доторх идэвхтэй хэсгийг сугалж авах ажлыг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог нөхцөлийг нарийвчлан тусгасан ажил гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

456. Трансформатор (реактор)-ын дотор үзлэг хийх, ажил гүйцэтгэхийг трансформатор (реактор)-ын дотор шилжин явах замаа сайн мэддэг, аюулгүй ажиллагаанд тусгайлан сургаж бэлтгэсэн ажилтнаар гүйцэтгүүлнэ.

457. Ажил гүйцэтгэж байгаа ажилтны ажлын хувцас нь цэвэр, хөдөлгөөнд саад учруулахааргүй, төмөр товчгүй, биеийг хэт халаахааргүйгээс гадна тос нэвчихээргүй тусгай зориулалтын байна. Трансформатор (реактор)-ын дотор хамгаалалтын дуулга, бээлий, резинэн гуталтай ажиллана.

458. Трансформаторын дотор орохын өмнө азот болон бусад хийг бүрэн шахах гаргасан, 20%-иас доошгүй хэмжээний хүчилтөрөгчтэй байхаар хангалттай үлээлэг хийсэн эсэхийг мэдсэн байх ёстой. Энэ ажлыг нарыдаар гурван хүн гүйцэтгэх бөгөөд хоёр нь харах нээлхий, хэрэв нээлхий байхгүй бол оруулгуудыг суурилуулсан нүхний дэргэд байрлаж трансформаторын дотор байгаа ажилтны ажиллагааны нөхцөл байдал, үйлдлийг хянаж, шаардлагатай тохиолдолд татаж гаргах мөрөвчтэй хамгаалалтын бүснээс зүүсэн олсноос барьж байнгын харилцаа холбоотой байх ёстой.

Шаардлагатай тохиолдолд трансформаторын дотор ажиллаж байгаа хүн нь агаар дамжуулах хоолойтой хорт хийнээс хамгаалах багтай байна. Энэхүү ажлын ажил гүйцэтгэгч нь аюулгүй ажиллагааны IY-өөс доошгүй групптэй байна.

459. Трансформаторын дотор ажиллахдаа шил нь төмөр торон хамгаалалттай аккумуляторын батерейгаар ажилладаг зөөврийн гэрэл хэрэглэнэ.

460. Трансформаторын их биеийн дотор ажиллаж байхад хуурайшуулсан (тундасжих температур -40°C -ээс ихгүй байх) агаар өгөх нөхцөлтэй байвал трансформатор дотор ажиллаж байгаа ажилтан хоногт 4 цагаас илүү хугацаанд ажиллаж болохгүй.

461. Трансформаторын тосыг шүүж цэвэрлэх, хатаах, хийгүйжүүлэх ажил гүйцэтгэх хүн нь хамгаалалтын хувцас, гуталтай ажиллана.

462. 110 кВ ба түүнээс дээш хүчдэлийн трансформатораас тос юүлж авах, нэмэх ажлын үед тухайн трансформаторын оруулгуудад цахилгаан цэнэг бий болохоос урьдчилан сэргийлж газардуулга тавьсан байх ёстой.

4.9. Хэмжүүрийн гүйдлийн трансформатор

463. Гүйдлийн трансформаторын хоёрдогч ороомогт холбогдсон хэлхээг таслахыг хориглоно. Ийм хэлхээг заавал таслах шаардлагатай бол таслах цэгээс гүйдлийн трансформаторт ойр талд богино холбоос хийж өгөх ёстой. Ийм холбоос хийхдээ тусгаарлах бариултай багаж хэрэглэвэл зохино.

464. Гүйдлийн трансформатор буюу түүний хоёрдогч ороомогт холбосон хэлхээнд ажиллахад дор дурьдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ёстой. Үүнд:

- Хоёрдогч хэлхээ түүний цахилгаан хэмжүүрийн багаж, реле хамгаалалт автоматикийн төхөөрөмжийн угсралтын ажил дуустал хоёрдогч ороомгийн гаргалтуудыг богино холбосон байх;
- Хоёрдогч хэлхээг гүйдлийн трансформаторт холбосны дараа богино холбоосыг хамгийн ойрын цуглуулга дээр шилжүүлэн тавьж байгаад хоёрдогч хэлхээний угсралтыг бүрэн дуусгаж, холболтын үнэн зөвийг шалгасны дараа уг богино холбоосыг авах;
- Хэлхээний туйлыг шалгахын тулд анхдагч ороомогт гүйдлийн импульс өгөхийн өмнө хэмжүүрийн багажийг хоёрдогч ороомогт холбох;

465. Угсралт ба гагнуурын ажлын үед гүйдлийн трансформаторын хэлхээн дэхь анхдагч ороомгийн шинийг гүйдэл дамжуулах утасны оронд ашиглахыг хориглоно.

4.10. Цахилгаан зуух

466. Электродтой цахилгаан зуухны их бие нь тусгаарлагч бүрхүүлтэй байвал түүнийг цоожилсон байх ёстой. Зуухны хүчдэлийг тасалсны дараа л бүрхүүлийн цоожийг онгойлгож болно.

467. Хүчдэлд залгаатай байгаа цахилгаан зуухын шугам хоолой дээр түүний хамгаалалтын газардуулгыг эвдэж, гэмтээж болзошгүй ямар нэгэн ажил гүйцэтгэхийг хориглоно.

468. Шугам хоолойг хувааж таслах (хаалт солих, хоолойны хэсэгт ажиллах г.м.)-тай холбоотой ажил гүйцэтгэхийн өмнө хуваах гэж байгаа хоёр хэсгийн хоолойг төмрөөр найдвартай цахилгаан холбоосүүсгэн гагнавал зохино. Харин дээрх хэсгүүд нь тойруу шугам хоолойгоор холбоотой бол ийм холбоос хийх шаардлагагүй.

469. 0,07 МПа-аас дээш ажлын даралттай уурын цахилгаан зуух, 115°C–ээс дээш хэмийн усан халаалтын зуухнуудын ашиглалтыг холбогдох дүрмийн шаардлагын дагуу явуулах ёстой.

4.11. Цахилгаан шүүлтүүр

470. Цахилгаан шүүлтүүр ба түүний сэгсрэх механизмын цахилгаан тоног төхөөрөмж дээр болон цахилгаан шүүлтүүр, утааны хийн хоолой дотор гүйцэтгэх бүх ажлыг нарыдаар хийнэ.

471. Цахилгаан шүүлтүүрийн ашиглалтын (засварын) үед дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:

- Нарядын тусгай заалтад зааснаас бусад тохиолдолд сэгсрэх механизмыг турших, тохируулах болон бусад зорилгоор ажиллуулах;
- Цахилгаан шүүлтүүрийн идэвхт хэсэг бункерүүдэд нэг зэрэг ажиллах;
- Хянах хэмжүүрүүд гэмтэлтэй үед;
- Тэжээлийн агрегатын хориг түгжээ, тусгаарлах хайрцаг нээлхийн таглаа ба секцүүдийн нүхний бөглөө байхгүй буюу эвдэрхий болон бусад гэмтэлтэй цахилгаан шүүлтүүр, түүний тэжээлийн кабельд хүчдэл өгөх;

472. Шүүлтүүрийн аль ч секц, бэлтгэл шин, секцийн цахилгаан тэжээлийн аль ч кабель дээр ажил гүйцэтгэх үед тухайн цахилгаан шүүлтүүрийн бусад секцийг тэжээдэг бүх агрегатын ба кабелийн хүчдэлийг тасалж газардуулсан байх ёстой.

473. Цахилгаан шүүлтүүрийн хүчдэлийг тасалсны дараа түүний болон тэжээлийн кабелийн үлдэгдэл цэнэгийг агрегат, нээлхийг газардуулах замаар шавхсан байх ёстой.

474. Цахилгаан шүүлтүүрийн газардуулаагүй хэсэгт хүрэхийг хориглоно.

475. Цахилгаан станцууд нь өөрийн онцлогийг харгалзан тусгасан цахилгаан шүүлтүүрийг ашиглах аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулан баталж мөрдөх ёстой.

476. Дээрх зааварт цех хоорондын үйлчилгээний заагийг үндэслэн цахилгаан шүүлтүүр дээр ажилд орох зөвшөөрөл ба наряд олгох журмыг тогтоосон байх ёстой. Зааврыг боловсруулахдаа энэ дүрэм болон цахилгаан станц, дулааны шугам сүлжээний дулааны механикийн тоноглолын ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг баримталбал зохино.

4.12. Аккумуляторын байгууламж

477. Аккумуляторын байгууламжийн нь байнга цоожтой байх ёстой. Энэ байгууламжид үзлэг хийх, ажил гүйцэтгэх ажилтанд тогтоосон журмын дагуу түлхүүрийг олгоно.

478. Аккумуляторын байгууламжид тамхи татах, гал гаргах, оч гаргаж болохуйц цахилгаан халаагуур, багаж, тоноглол хэрэглэхийг хориглоно. (492 дугаар заалт үүнд хамаарахгүй).

479. Аккумуляторын байгууламжийн хаалган дээр “Аккумуляторын байгууламж”, “Галын аюултай”, “Тамхи татахыг хориглоно” гэсэн бичиглэл хийх буюу ил гал хэрэглэх ба тамхи татахыг хориглосон тухай бусад анхааруулах, хориглох тэмдэг, тэмдэглэгээг байрлуулна.

480. Аккумуляторыг цэнэглэхийн өмнө сорон-үлээж гадагшлуулах салхилуурыг залгах ба цэнэглэж дууссаны дараа 1,5 цагаас багагүй хугацаагаар ажиллуулж, ялгарсан бүх төрлийн хийг гаргасны эцэст салхилуурыг зогсоох ёстой.

481. Аккумуляторын байгууламж бүрт дараах зүйлс байх ёстой. Үүнд:

- задрах уусмал (элетролит)-ыг бэлтгэх ба нэмэхэд зориулсан 1,5-2 литр багтаамжтай цорготой, шилэн буюу шаазан аяга (эсвэл гүц);
- хүчлийн уусмалтай ажиллах бол 2,5%-ийн хүнсний содын саармагжуулах уусмал, шүлтийн уусмалтай ажиллах бол 10%-ийн борын хүчил эсвэл цууны хүчлийн охийг 8:1 (8 нэгж усанд 1 нэгж) харьцаатайгаар бэлтгэсэн саармагжуулах уусмал;
- Гар угаах ус, алчуур;

482. Задрах уусмал, нэрмэл ус, саармагжуулах уусмал хийсэн бүх саван дээр нэрийг нь тодорхой бичсэн хаягтай байх ёстой.

483. Хүчлийг зориулалтын бөглөөтэй шилэн саванд хадгалах ба дээр нь нэр, найрлагын орцыг бичсэн шошготой байвал зохино.

484. Батерейн ашиглалтад шаардагдах хүчилтэй болон хоосон шилэн савнуудыг аккумуляторын байгууламжийн ойролцоо тусдаа өрөөнд хадгалах ёстой.

485. Шилэн савыг сагс буюу хамгаалалтын сараалжин модон хайрцагт хийж шалан дээр байрлуулбал зохино.

486. Хүчил, шүлт, хар тугалгатай холбоотой бүх төрлийн ажлыг тусгайлан сургасан ажилтнаар гүйцэтгүүлэх ёстой.

487. Хүчил, шүлттэй шилэн савыг заавал хоёр хүн дамжлан зөөнө. Сагстай шилийг бариул бүхий модон хайрцагт хийж, эсвэл сагстай шилний өндрийн 2/3 хэсгийг доош оруулан бэхэлж болох дундаа нүхтэй тусгай дамнуургаар зөөнө.

488. Хүчлийн уусмалыг бэлтгэхдээ шаазан буюу дулаанд тэсвэртэй савтай нэрмэл усан дээр хүчлийг сэнжтэй аягаар нарийхан гоожуулж (уусмал огцом халахаас болгоомжлон) алгуур хийвэл зохино. Энэ үед уусмалаа шүлтэнд тэсвэртэй материалаар хийсэн хутгуур, эсвэл шилэн саваа, хоолойгоор байнга хутгаж байх хэрэгтэй.

489. Бэлэн болсон уусмал дээр ус нэмж хийхийг зөвшөөрөх ба хүчил дээр ус хийж уусмал бэлтгэхийг хориглоно.

490. Хүчил ба шүлттэй ажиллахад шаардлагатай тусгай зориулалтын хувцас(хүчилд бүдүүн ноосон, шүлтэнд хөвөн даавуун эдлэлээр хийсэн), резинэн гутал, эсвэл шаахай, резинэн хормогч, резинэн бээлий өмсөж, нүдний хамгаалах шил зүүсэн байх ёстой.

491. Идэмхий шүлтийн хэлтэрхийг эхлээд уутанд хийж тусгай байранд аваачиж нунтаглана.

492. Аккумуляторын өрөөнд батерейн ялтсуудыг гагнахад дараах нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой. Үүнд:

- Цэнэг шавхалт дууссанаас хойш 2-оос доошгүй цаг өнгөрсөн байх;
- Үргэлжлүүлэн цэнэглэх горимоор ажилладаг батерейг гагнуур хийхээс 2 цагийн өмнө цэнэг шавхах горимд шилжүүлсэн байх;
- Гагнуур эхлэхийн өмнө өрөөг 1 цагийн турш агааржуулсан байх;
- Гагнуур хийж байхад салхилуурыг тасралтгүй ажиллуулж байх;
- Гагнуур хийж байгаа газрыг бусад хэсгээс галд тэсвэртэй хаалтаар тусгаарласан байх;
- Хар тугалга болон түүний нэгдлүүдийн хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор аккумуляторын батерейн байгууламжийн ашиглалт засварын зааварт заасны дагуу ажлын өдрийн горим тогтоож, урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ авах;
- Ажлыг нарыдаар гүйцэтгэх;

493. Аккумуляторын батерей ба цэнэглэх төхөөрөмжийн үйлчилгээг тусгайлан сургасан III-аас доошгүй групптэй хүн гүйцэтгэх ёстой.

4.13. Конденсаторын төхөөрөмж

494. Конденсаторын төхөөрөмж дээр ажил гүйцэтгэхийн өмнө түүний болон түүнд холбоотой гүйдэл дамжуулах хэсгүүдийн тэжээлийн хүчдэлийг тасалж бүх хэсгүүдийн цэнэгийг шавхана.

495. Конденсаторын цэнэгийг шавхах буюу үлдэгдэл хүчдэлийг тэг болгохдоо газардуулгын утас бүхий тусгаарлах штангийн тусламжтайгаар конденсаторын гаргалгын утаснуудыг хооронд нь богино холбож металл шинүүдээр их биетэй нь холбоно.

496. Цахилгаан схемд холбогдоогүй боловч цахилгаан орны нөлөөллийн (нөлөөллийн хүчдэлтэй) орчинд байрлах конденсаторын гаргалгуудад богино холбоос хийнэ.

497. Хуурмаг чадлыг саармагжуулах өөрийн тоноглолтой, хүчдэлийг нь тасалсан асинхрон хөдөлгүүрийн ороомгийн гаргалгаанд конденсаторуудын цэнэгийг шавхахаас өмнө гар хүрч болохгүй.

498. Трихлордифенилээр нэвчсэн, гоожилттой конденсаторт нүцгэн гараар хүрч болохгүй. Трихлордифенил арьсанд хүрвэл савантай усаар, нүдэнд орвол борын хүчлийн сулавтар уусмал эсвэл натрийн хоёр нүүрсхүчлийн уусмалаар (стакан усанд 1 цайны халбага хүнсний сод) тус тус угаах хэрэгтэй.

4.14. Кабель шугам

4.14.1. Газар шорооны ажил

499. Газар доорхи байгууламж, шугам сүлжээ байрласан бүсэд кабелийн засвар, угсралттай холбоотой газар шорооны ажил хийхэд ажлын удирдагч томилно. Ийм ажлыг газар доорхи байгууламж ба шугам сүлжээг хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагаас бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу гүйцэтгэх ёстой. Зөвшөөрлийн бичигт газар доорх байгууламж, шугам сүлжээний байршил ба оршиж байгаа гүний хэмжээг заасан план зураг хавсаргасан байх ёстой.

500. План зурагт тусгаагүй кабель, шугам хоолой, газар доорх байгууламж мөн түүнчлэн байлдааны хэрэгсэл илэрвэл илэрсэн даруйд холбогдох байгууллагуудад мэдэгдэж, зөвшөөрөл автал газар шорооны ажлыг түр зогсооно.

501. Кабелийн трассаас 5 метрийн дотор цохилтын ажиллагаатай машин механизм хэрэглэхийг хориглоно.

502. Кабелийн трассаас 1 метрээс дотогш газар энэхүү кабелийг ухахаас бусад тохиолдолд газар ухагч машин, механизмаар ажил гүйцэтгэхийг хориглоно.

503. Кабелийн эгц дээр нь газар ухах машин, хийн шахуургатай багаж, лоом, царил, жоотуугаар тухайн кабель шугамын дээр 30 см зузаан хөрс үлдээхээр гүнд газар ухахыг зөвшөөрөх ба үлдсэн газрыг зөвхөн хүрээр ухах ёстой.

504. Өвлийн улиралд газар ухахын тулд заавал гэсгээнэ. Энэ тохиолдолд дулааны эх үүсвэрийг кабельд 15 см-ээс дотогш ойртуулахыг хориглоно.

505. Ухсан нүх шуудуунд дүрмийн дагуу хашлага хийж хамгаалсан байх ёстой. Хашлага дээр анхааруулах тэмдэг, шөнийн цагаар гэрлэн дохио тавьсан байх ёстой.

506. Зөөлөн чийглэг хөрстэй газарт шуудуу ухахад хана нь нурах аюултай байвал түүнийг найдвартай бэхлэх ёстой. Нуранги хөрстэй газарт ажиллахад шуудууны ханыг бэхлэлгүйгээр хөрсний шороо нурахааргүй гүнд тохируулан ухаж болно.

507. Суларсан шороог нүх, шуудууны захаас 0,5 метрээс багагүй зайд гаргана. 2 метрээс гүн нүх, шуудууны гадна гаргасан шороог холбогдох дүрэмд заасны дагуу бэхэлж, зайлуулна.

508. Ойр орчимд нь газар доорхи байгууламж байхгүй тохиолдолд байгалийн ердийн чийгтэй, хөрсний усгүй хөрсөнд бэхэлгээгүй босоо ханатай нүх, шуудууг элс ба хайрган хөрсөнд 1 м, элстэй шаварлаг хөрсөнд 1,25 м, шаварлаг ба шавартай хөрсөнд 1,5 м-ээс ихгүй гүн ухаж болно.

509. Хатуу барьцадмал хөрсөнд босоо ханатай шуудууг ротортой болон шуудууны эксковатороор ханыг нь бэхлэлгүйгээр 3 м хүртэл гүн ухаж болно. Ингэж ухсан нүх, шуудуунд хүн орохыг хориглох ба заавал орох шаардлага гарсан үед тухайн хэсэгт ханын бэхэлгээ хийх буюу нурахгүй байхаар налуу гаргаж ухсан байх ёстой.

510. Өвлийн улиралд хөрс хөлдөх гүн хүртэл (хуурай хөрснөөс бусад газарт) шуудууг ханын бэхэлгээгүй ухаж болно.

511. Дээр (508-510)-т дурьдсанаас бусад тохиолдолд нүх, шуудуунд хүн орж ажиллах тохиолдолд тухайн хэсэгт ханын бэхэлгээ хийх буюу нурахгүй байхаар налуу гаргаж ухсан байвал зохино.

512. 3 м хүртэл гүнтэй нүх, шуудууны бэхэлгээ нь нэг маягийн зургийн дагуу тусгайлан бэлтгэсэн, байгууллагын бүртгэлтэй байх ёстой.

513. Ухсан нүх, шуудууны ойролцоо машин механизм, тээврийн хэрэгсэл, лебёдка, тоног төхөөрөмж, материал зэргийг байрлуулах, ажиллуулах, шилжүүлэн зөөвөрлөхдөө ажил гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу 5 дугаар хүснэгтэд зааснаас (хэвтээ чиглэлд) багагүй, шороо нурахааргүй зай хэмжээг баримтлана.

Ухсан нүх, шуудууны хаяанаас машин механизм, бараа материал хүртэл зөвшөөрөгдөх хамгийн ойрын зайн хэмжээ:

Хүснэгт № 5

Нүх, шуудууны гүн (м)	шорооны ангилал			
	Элсэн(м)	Элсэрхэг(м)	Шаварлаг(м)	Шавар, шороо(м)
1.0	1.5	1.25	1.00	1.00
2.0	3.0	2.40	2.00	1.50
3.0	4.0	3.60	3.25	1.75
4.0	5.0	4.40	4.00	3.00
5.0	6.0	5.30	4.75	3.50

4.14.2. Кабель ба муфтыг зүүж бэхлэх

514. Ухаж ил гаргасан муфтанд банзаар битүү хайрцаган хамгаалалт хийгээд шуудуун дээгүүр хөндлөн тавьсан банзнаас ган татлага буюу төмөр утсаар зүүж бэхлэх ёстой. Хамгаалалтын хайрцагны нэг ханыг авч болохоор (хадалгүй) бэхлэсэн байх ёстой.

515. Ухаж гаргасан кабель дээрх хайрцаган хамгаалалт дээр “Зогс! Өндөр хүчдэл” тэмдэг тавих ёстой.

516. Кабелийг зүүхэд түүний зэргэлдээх кабель, шугам хоолой зэргийг ашиглахыг хориглоно.

517. Кабелийг шилжилт үүсгэхгүй байхаар татаж зүүнэ.

4.14.3. Муфт задлах, кабель тайрах

518. Муфт задлах, кабель тайрах ажилд орохын өмнө уг ажлыг хийх гэж байгаа кабель лавтай мөн болохыг магадлаад түүний хүчдэлийг тасалж ажилд ороход шаардлагатай техникийн арга хэмжээг бүрэн авсан эсэхийг баттай мэдсэн байх ёстой.

519. Засварлах гэж буй кабелийг дараах байдлаар тодорхойлно:

- Хонгил, суваг, коллектор болон барилгын ханаар ил татсан кабелийг түүний байрлалын зураг, бүдүүвч, хадсан пайзтай нь тулгах замаар эхнээс нь дагууд нь маш хянамгай мөрдөж тодорхойлно;
- Газар дор олон кабель зэрэгцээ тавигдсан үед тэдгээрийн байрлалыг гүйцэтгэлийн зурагтай нь тулган шалгах замаар тодорхойлно. Үүний тулд зэрэгцээ олон кабель дээр хөндлөн шуудуу ухаж бүх кабелийг ил гаргаж тодорхойлох хэрэгтэй.

520. Нүдэнд үзэгдэх ил гэмтэл байхгүй бүх тохиолдолд кабелийн гэмтэл тодорхойлох тусгай багажаар гэмтсэн кабелийг олох ёстой.

521. Кабель тайрах, холболтын муфтыг задлахын өмнө кабель хүчдэлгүй болохыг тусгаарлах штанган бариултай, кабелийг нэвт цоолох ган хошуутай тусгай багажаар (кабелийн бүрээс ба хуяг, гүйдэл дамжуулах судлыг нэвт цоолж, судлын хооронд газартай богино холбоо үүсгэдэг хийцтэй байх ёстой) шалгах ёстой.

522. Кабель нэвт цоолох тусгай багаж хэрэглэхдээ шаардлагатай хаалт хамгаалалт, хамгаалах хэрэгсэл хэрэглэвэл зохино.

523. Худаг, хонгил, коллектор дотор зэргэлдээ өөр кабель шугам буюу кабелийн байгууламж байгаа тохиолдолд зөвхөн алсын удирдлагатай цоолох багажаар шалгах ёстой.

524. Кабелийг цоолж шалгахдаа зориулалтын резинэн бээлий өмсөж, нүүрэвч зүүгээд шуудууны гадна тавьсан тусгаарлагч дээр кабелиас аль болох хол зайд зогсож ажиллавал зохино.

525. Кабель цоолох ажлыг тухайн ажлыг хийх дадлага туршлагатай хоёр хүн хамт хийж гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэгч нь IY-ээс доошгүй групптэй, бригадын гишүүн нь III-аас доошгүй групптэй байх бөгөөд нэг нь биечлэн гүйцэтгэж, нөгөө нь хяналт тавих ёстой.

526. Хэрэв кабелийн гэмтлээр кабелийн гүйдэл дамжуулах бүх судал нь ил гарсан бол цоолох багаж хэрэглэлгүйгээр уг кабелийн бүх судал нь хүчдэлгүй болсон эсэхийг хүчдэл заагчаар шалгаж болно.

527. Кабель цоолох багажныажлын хэсгийг газрын гүнд 0,5м-ээс багагүй гүнд шаасан газардуулгын гадас эсвэл кабелийн төмөр хуягт газардуулсан байх ёстой. Газардуулгын утсыг кабелийн хуягт хүзүүвч (хомут)-ээр чанга боон холбож болно. Ингэхдээ хүзүүвчийн доорх хуягийн гадаргууг сайтар цэвэрлэх ёстой. Хуягийн төмөр зэвэрсэн тохиолдолд кабелийн хөнгөн цагаан буюу тугалган бүрхүүлд холбож газардуулж болно.

528. Цахилгаан станц, дэд станцын доторх кабелийн урт, кабелийг угсарсан байдал нь зураг, пайз, кабель тодорхойлох багаж зэргийн тусламжтайгаар засварлах кабелийг шууд тодорхойлох боломжтой үед кабелийг тайрах ба муфтыг задлахын өмнө наряд олгогчийн зөвшөөрлөөр түүнийг цоолохгүй байхыг зөвшөөрнө.

529. Урьдчилан цоолж шалгаагүй кабелийг тайрах ба муфтыг задлахдаа туршсан резинэн бээлий өмсч, нүүрэвч зүүж, газардуулсан багаж хэрэгсэл ашиглан тусгаарлагч дэвсгэр дээр байрлан гүйцэтгэх ёстой. Харин урьдчилан цоолт хийсэн үед кабель дээрх ажлыг гүйцэтгэхдээ дээр дурьдсан аюулгүй ажиллагааны нэмэлт арга хэмжээг авахгүй байж болно.

4.14.4. Кабель сунгах, шилжүүлж тавих, муфт зөөх

530. Кабельтай дамрыг өнхрүүлэхийн өмнө ажилтны хувцастай орооцолдож болзошгүй сөрдийж сэртийсэн зүйлийг түүнээс арилгах ёстой.

531. Кабельтай дамрыг зөвхөн хатуу, тэгш гадаргуугаар зогсоох хэрэгсэлтэй нөхцөлд өнхрүүлэх ёстой.

532. Кабель, хоосон дамар, машин механизм, багаж хэрэгслийг шуудууны нурах хэсгийн гадна ба шуудууны ирмэгээс 1 метрээс ойргүй зайд байрлуулбал зохино.

533. Кабелийг гараар сунгахад нэг эрэгтэй ажилтанд 35 кг, эмэгтэй ажилтанд 15 кг-аас илүүгүй жинтэй кабелийн хэсэг ноогдож байхаар бодож ажилтны тоог тогтоох ёстой.

534. Кабель сунгах ажлыг брезентэн бээлийтэй гүйцэтгэнэ.

535. Кабелийг сунгаж байхад эргэлтийн өнцгийн дотор талд ажилтан зогсох, мөн түүнчлэн шуудууны эргэлтийн хэсэг дээр гараар татахыг хориглоно. Эргэлтийн хэсэг дээр кабелийг дамжуулж сунгах ажлыг хөнгөвчлөхөд зориулж тусгай дамар бүхий дамжуулах хэрэгслийг ашиглавал зохино.

536. Цахилгаан гүйдлээр кабелийг гэсгээхэд 380 В-оос дээш хүчдэлтэй трансформатор хэрэглэхийг хориглоно.

537. Кабель шилжүүлж тавих, муфтыг зөөх ажлыг уг кабелийн хүчдэлийг тасалсны дараа гүйцэтгэвэл зохино.

538. Кабелийг хүчдэлтэй байхад нь зайлшгүй шилжүүлэн тавих шаардлагатай бол дор заасан нөхцөлийг бүрдүүлсний дараа зөөж болно. Үүнд:

- Шилжүүлж тавих кабель нь +5°C-ээс багагүй температуртай байх;
- Шилжүүлэх кабельд байгаа муфтыг банзан дээр хөдөлгөөнгүй даруулж (хомут) хүзүүвчээр бэхэлсэн байх;
- Ажлыг гүйцэтгэхдээ тусгаарлах резинэн бээлий өмсөөд түүнийг механик гэмтэлд өртөх, урагдахаас хамгаалж гадуур нь брезентэн бээлий давхарлан өмссөн байх;
- Туршлага бүхий V групптэй хүний хяналтан дор гүйцэтгэх ёстой.

4.14.5. Газар доорх байгууламжид байгаа кабель дээр ажиллах

539. Газар доорх байгууламжид хийх ажлыг хоёроос цөөнгүй хүн хийж гүйцэтгэх ёстой.

540. Цахилгаан станц, дэд станцын аюулт хий ялгардаггүй коллектор, хонгилын үзлэгийг тогтвортой ажиллагаатай холбооны хэрэгсэл бүхий III-аас доошгүй групптэй нэг хүн шийдвэрээр хийж болно.

541. Аюулт хий үүсч болзошгүй газар доорх байгууламжид гүйцэтгэх ажлыг гурваас цөөнгүй хүн нарыдаар хийх ба тэдгээрээс нэг нь ажил гүйцэтгэж, нөгөө хоёр нь хяналт тавьж байх ёстой. Ажил гүйцэтгэгч нь IV групптэй байна.

542. Алба, салбар, цех, хэсэг бүрт аюулт хий ялгарч болзошгүй газар доорх байгууламжийн жагсаалт гарган баталж, үйлчлэх ажилтанд танилцуулж гарын үсэг зуруулсан байх ёстой.

543. Аюулт хий ялгарч болзошгүй газар доорх бүх байгууламжийг схем дээр тэмдэглэсэн байх ёстой.

544. Газар доорх байгууламжид ажил эхлэхийн өмнө байгалийн эсвэл албадмал агааржуулалтаар хангаж өгсөн байх ёстой.

545. Байгалийн агааржуулалт хийхийн тулд хоёроос цөөнгүй нээлхийг онгойлгоод тэдгээрт агаарын урсгалыг чиглүүлсэн саравч хийж өгнө. Байгалийн агааржуулалтыг ажил эхлэхээс 20-иос доошгүй минутын өмнө хийсэн байх ёстой.

546. Албадмал агааржуулалтыг салхилуур буюу шахуургын тусламжтайгаар үлээх хоолойны үзүүрийг нь газар доорх байгууламжийн ёроолд 25 см орчим зайд ойртуулан 10-15 минут үлээлгэж хийнэ.

547. Агааржуулалт явуулахад шахсан хийтэй баллон хэрэглэхийг хориглоно.

548. Газар доорх байгууламжид аюулт хий байхгүй эсэхийг шалгалгүйгээр ажил эхлэхийг хориглоно.

549. Хийн шинжилгээг тусгайлан бэлтгэсэн ажилтан багаж ашиглан шалгах ёстой. Шалгалт хийх ажилтны нэрсийн жагсаалтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагаас баталсан байх ёстой.

550. Аюулт хий байгаа эсэхийг ил галаар шалгахыг хатуу хориглоно.

551. Сорон-үлээх агааржуулагчаар тоноглогдсон коллектор ба хонгилд ажил эхлэхийн өмнө агааржуулагчийг ажиллуулаад тухайн ажлыг хийж дуустал тасралтгүй ажиллуулах ёстой. Энэ тохиолдолд аюулт хий байгаа эсэхийг шалгахгүй байж болно.

552. Коллектор ба хонгилд ажил гүйцэтгэх үед хүмүүс байрлах хэсгийн хоёр талд нээлхий буюу хаалгыг онгойлгосон байх ёстой. Онгорхой нээлхий дээр анхааруулах тэмдэг эсвэл хашилт тавина.

553. Ажил эхлэхийн өмнө ажилтнуудад газар доорх байгууламжийн план зургийг танилцуулж, болзошгүй аюулын үед гарах гарцыг зааж өгнө.

554. Худгийг онгойлгохдоо оч үүсгэдэггүй багаж, хэрэгсэл ашиглах ба таглааг нээлхийн амсарт цохихгүй байвал зохино. Нээлттэй худгийн амсарт анхааруулах тэмдэг, хаалт хашилт тавина.

555. Зориулалтын татлага бүхий хамгаалалтын бүстэй III-аас доошгүй групптэй хүн худаг доторганцаараа ажил гүйцэтгэж болно. Татлагын үзүүрийг худагны гадна талд нөгөө ажилтан нь барьж, шаардлагатай тохиолдолд ажилтныг татаж гаргахад бэлэн байх ёстой.

556. Худаг дотор паяльник асаах, шатамхай хийтэй баллон байрлуулах, гагнуурын хийхийг хориглоно.

557. Ил галаар ажиллахад галын дөлний тархалтыг галд тэсвэртэй хавтангуудаар хязгаарлаж гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байх ёстой.

558. Кабелийн коллектор, хонгил, кабелийн хагас давхар ба түүний адил байрнуудад пропан, бутан (шатамхай хий) хэрэглэж ажиллахад баллонуудын нийлбэр эзэлхүүн 5 литрээс илүүгүй байх ёстой. Ажил дууссаны дараа хийтэй, хийгүй бүх баллоныг зайлуулж агааржуулах ёстой.

559. Кабелийг цахилгаан гүйдлээр нэвчүүлэн шатааж байхад худаг дотор хүн байхыг хориглоно. Коллектор, хонгил дотор зөвхөн хоёр онгорхой орцны дунд байрлаж болно.

560. Кабелийг цахилгаан гүйдлээр нэвчүүлэн шатааж байхад түүн дээр ажил гүйцэтгэхийг хориглоно.

561. Кабелийг цахилгаан гүйдлээр нэвчүүлэн шатаасны дараа гал гарахаас болгоомжлон үзлэг явуулах ёстой.

562. Хонгилд кабелийн ажилд оруулах ба үзлэг явуулахын өмнө түүний доторх галаас хамгаалах тоноглолыг автомат ажиллагаанаас алсын удирдлагад шилжүүлээд автомат ажиллагааны залгуурын удирдлагын түлхүүр дээр “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна” гэсэн плакат өлгөх ёстой.

563. Худаг, коллектор, хонгил дотор болон онгорхой нээлхийн амнаас 5 метрээс дотогш зайд тамхи татахыг хориглоно.

564. Худаг, коллектор ба хонгил дотор удаан хугацаагаар ажиллах үед тэдгээрт байж болох хугацааг тухайн ажлын гүйцэтгэх нөхцөлөөс хамааруулан наряд олгогч тодорхойлно.

565. Худаг, коллектор ба хонгил дотор аюулт хий бий болсныг илрүүлмэгц бүх ажлыг нэн даруй зогсоож хий бий болсон шалтгааныг илрүүлэн зөрчлийг арилгаж дуустал ажиллагсадыг аюултай бүсээс холдуулах ёстой.

566. Аюулт хийг шахан зайлуулахад заавал албадмал агааржуулалт хэрэглэх шаардлагатай.

567. Худаг, туннель дотор ажлын байрыг 12 В-ын гэрэл, эсвэл тэсрэлтээс хамгаалалттай аккумуляторын чийдэнгээр гэрэлтүүлнэ. Гэрэлтүүлгийн тэжээлийн трансформаторыг худгийн гадна байрлуулах ёстой.

4.15. Цахилгаан дамжуулах агаарын шугам, тулгуур, түүний хийц хэсэг дээр ажиллах

4.15.1. Ерөнхий шаардлага

568. ЦДАШ-ын тулгуур, тулгуурын эд анги, хэлхмэл тусгаарлагчийг солих, утас буулгах, татах ажлыг технологийн карт (аюулгүй ажиллагааны горим)-ын дагуу гүйцэтгэнэ.

569. Тулгуур, шон, ялангуяа түүний суурь, хөл тогтвортой, найдвартай, бат бөх гэдгийг лавтай мэдсэний дараа түүнд авирах буюу ажил гүйцэтгэж болно.

570. Бат бөх нь (тухайлбал хангалтгүй гүнд суулгасан, мод нь өмхөрсөн, бетонд ан цав гарсан, хөрс нь овойсон, суусан гэх мэт) эргэлзээтэй тулгуур, шонд ажил гүйцэтгэгч эсвэл ажлын удирдагчийн зөвшөөрөлгүйгээр авирч ажил гүйцэтгэхийг хатуу хориглоно.

571. Модон тулгуурын суурийн бат бөхийг тулгуур суулгасан газрыг 0,5 метрээс багагүй гүн ухаж өмхрөлтийг үзэх замаар шалгана.

572. Төмөр-бетон тулгуур, төмөр бетон хөлний бөх батыг шалгахдаа бетонд зөвшөөрөгдөх хүлцэлээс илүү цав гарсан эсэх, тухайн тулгуурын эргэн тойронд хөрсний суулт, овойлтын хэмжээ ямар байгаа болон тулгуур (хөлний) бетоны задрал байгаа эсэхийг газрыг нь 0,5 метрээс багагүй гүн ухаж шалгана.

573. Төмөр тулгуурын цутгамал суурь эвдэрсэн эсэх, татлагын боолт, бүх төмөр хийцүүд, эрэг боолт байгаа эсэх, тэдгээрийн чангалалтын байдал, газардуулгын холбоосуудын бүрэн бүтэн байдлыг үзэж шалгана.

574. Бөх бат нь эргэлзээтэй тулгуур, шонг бэхлэх эсэх, яаж бэхлэх аргыг газар дээр нь ажил гүйцэтгэгч эсвэл ажлын удирдагч тодорхойлно.

575. Тулгуурыг татаж уях замаар бэхлэх ажлыг тулгуурт авирч гаралгүйгээр зэргэлдээх тулгуур дээрээс эсвэл сунадаг шаттай машин, хүн өргөх зориулалттай механизм дээрээс гүйцэтгэнэ. Эсвэл тулгуурт авиралгүйгээр татлагыг бэхэлж болох тусгай зориулалтын хэрэгсэл ашиглавал зохино.

576. Бат бөх нь эргэлзээтэй тулгуурыг бэхэлсний дараа л дээш авирч гарахыг зөвшөөрнө.

577. Утас ба тросоор нэг талаасаа татагдаж байхаар тооцоологдоогүй боловч түр хугацаанд нэг тийш таталтанд өртөх тулгуур, шонг унахаас хамгаалж урьдчилан бэхэлгээ хийсэн байх ёстой.

578. Завсрын тулгуур, шонг унахаас хамгаалж урьдчилан бэхэлгээ хийхгүйгээр утасны бүрэн бүтэн байдлыг алдагдуулах, боолт, залгаасны бэхэлгээг тайлахыг хориглоно.

579. Өндөрт авирч ажиллах эрхтэй дор дурьдсан бригадын гишүүд тулгуур, шонд авирахыг зөвшөөрнө. Үүнд:

- Тулгуурын орой хүртэл бүх төрлийн ажил гүйцэтгэхэд III-аас доошгүй групптэй хүн;
- ЦДАШ-ын гүйдэл дамжуулахгүй хэсгүүд дээр ажил гүйцэтгэж байгаа хүний толгой шугамын доод утаснаас 2 метрээс багагүй зайд байх хэсэгт ажил гүйцэтгэхэд II групптэй хүн;
- Газраас хүний хөлний ул хүртэл хүртэл 1,2 метрээс илүүгүй өндөрт авирч гүйцэтгэх бүх төрлийн ажилд I групптэй хүн (энэ тохиолдолд өндөрт авирч ажиллах тусгайлсан эрх олгох шаардлагагүй);

580. Өндөрт хийх зарим төрлийн ажлыг энэ дүрэмд заасан аюулгүй ажиллагааны групптэй 2-оос цөөнгүй ажилтан гүйцэтгэх ёстой.

581. Тулгуур, шон дээр авирч ажиллахдаа хамгаалах бүсний оосрыг тулгуур, шонгийн цаад талаар оруулж бэхлэнэ.

582. Тулгуур, шонгийн эд хэсгийг солиход түүнийг унах буюу хазайхаас сэргийлсэн арга хэмжээг авсан байх ёстой.

583. Тулгуур дээр ажиллах үед хамгийн ойр байгаа хүчдэлтэй шугамын утсыг хараандаа байнга байлгахаар байрлах хэрэгтэй.

584. Шөргөн тусгаарлагчтай өнцгийн тулгуур дээр дотоод өнцөг талаас авирч ажиллахыг хориглоно.

585. Тулгуур дээр ажиллахдаа дуулга малгайг бүчлэн өмсөж, хамгаалах бүс хэрэглэх ба хэрэв дөрөө ашиглаж байгаа бол сайн жийж ажиллах ёстой.

586. П болон АП хэлбэрийн тулгуурын дан буюу хос хөлийг солих үед хоёр хөлийн нүхийг зэрэг ухахыг хориглоно. Ийм тулгуурын нэг хөлийн нүхийг эхэлж ухан хөлийг суулгаж боогоод бэхлэх ба газрыг чигжиж хатууруулсны дараа нөгөө хөлийг солих ажилд орно. Хос хөлийг дээрх дарааллаар солино.

587. Хөлийг татаж гаргах буюу хийх үед ухсан нүхэн дотор хүн байхыг хориглоно.

588. Тулгуур, шонг босгож байрлуулах ба унагаах аргыг тодорхойлох, тэдгээрийг хазайхаас урьдчилан сэргийлж бэхлэх шаардлагатай эсэхийг ажлын удирдагч тодорхойлно.

589. Дэгээтэй татлага хэрэглэж байгаа үед дэгээ нь мултрахаас хамгаалах түгжээтэй байх ёстой.

590. Хэлхмэл тусгаарлагч (изолятор) дээр ажиллахад дараах байдлаар шилжиж ажиллахыг зөвшөөрнө. Үүнд:

- Нэг болон олон хэлхээт шугамын 2 ба түүнээс дээш тооны хэлхмэл тусгаарлагч дээгүүр;

- Олон хэлхээт таталтын хэлхмэл тусгаарлагч дээгүүр;

591. Нэг хэлхээт таталтын хэлхмэл тусгаарлагч дээр тусгай зориулалтын хэрэгсэл ашиглаж ажиллана. Тусгай зориулалтын хэрэгсэлбайхгүй тохиолдолд хэлхмэл тусгаарлагч дээр хэвтээд тулгуурын хөндлөвчид хоёр хөлөөрөө тулж биеийнхээ байрлалыг тогтвортой болгон ажиллахыг зөвшөөрнө.

592. Тулгуурын хэлхмэл тусгаарлагч дээр ажиллахад хамгаалах бүсний оосрыг тулгуурын хөндлөвч (траверс)-д бэхэлсэн байх ёстой. Хэрэв хамгаалах бүсний оосор нь богинодож байвал бүсэнд бэхэлсэн хоёр татлага оосор хэрэглэх ёстой. Нэг татлагыг тулгуурын хөндлөвчид оосорлож, нөгөөг хөндлөвч дээгүүр гаргаж газарт унжуулаад дор байгаа хүн хэрэгцээний хэрээр султгаж, эсвэл татаж өгч байна.

593. Таталтын хэлхмэл тусгаарлагч дээр ажиллах үед хамгаалах бүсний оосрыг хөндлөвчид эсвэл түүнийг бэхлэхэд зориулсан хэрэгсэлд бэхэлнэ.

594. Хоёр ба түүнээс дээш зэрэгцээ тулгуурын болон таталтын тусгаарлагч дээр ажиллахад хамгаалах бүсний оосрыг дээр нь ажил хийгээгүй байгаа хэлхмэл тусгаарлагчийн аль нэгэнд бэхлэхийг зөвшөөрнө. Энэ оосрыг дээр нь ажил хийж байгаа хэлхмэл тусгаарлагчид бэхлэхийг хориглоно.

595. Тусгаарлагчийн хэлхээс тасрахад хүргэж болохуйц гэмтэл согог илрүүлбэл ажлаа зогсоох ёстой.

596. Утас, трос, тусгаарлагчийг хөндлөвч дээр гаргах, буулгах болон чангалах үед тухайн хөндлөвч дээр эсвэл түүний доор хүн байхыг хориглоно.

597. Ачаа өргөх схемийг сонгож авах ба өргөх дамруудыг байрлуулахдаа тулгуурт гэмтэл учруулах хүч үүсэхгүй байхаар тооцоолж гүйцэтгэвэл зохино.

598. Тулгуурыг будахад тусгаарлагч ба шугамын утсан дээр будаг дусаахгүй (тосгуур хэрэглэх г.м.) байх арга хэмжээ авсан байна.

4.15.2. Хэд хэдэн агаарын шугамын утас татаж бэхэлсэн тулгуур дээр болон гэр, байшингийн оруулга дээр ажиллах

599. Тулгуур, шаттай машин, шингэн шахуургатай өргүүр дээрээс ажил гүйцэтгэх үед ажил гүйцэтгэж байгаа хүн ба түүний багаж хэрэгсэл, канат татлага нь 1000 В хүртэлх хүчдэлтэй утсанд (цахилгаан дамжуулах, радио нэвтрүүлэгийн, телемеханикийн) 0,6 метрээс багагүй зайтай байвал зохино.

600. Утсанд (цахилгаан дамжуулах, холбооны радио нэвтрүүлэгийн, телемеханикийн) 0,6 метрээс дотогш зайд ойртох нөхцөл бий болохоор ажил гүйцэтгэхэд эдгээр шугамын хүчдэлийг таслаж ажлын байранд дээр газардуулга тавина.

601. 1000 В-оос дээш хүчдэлийн ЦДАШ-ын тулгуурт татсан 1000 В хүртэл хүчдэлийн ЦДАШ, гудамжны гэрлийн шугамын утсыг сунгаж татах, солихдоо бүх шугамын хүчдэлийг таслаж ажил гүйцэтгэх хэсгийн хоёр талд газардуулга тавьсан байх ёстой.

602. 601-т заасан ажлыг нарыдаар хоёроос доошгүй ажилтантай бригад гүйцэтгэх бөгөөд ажил гүйцэтгэгч нь IY групптэй байна.

4.15.3. Хүчдэлтэй нөхцөлд ажиллах

603. Хүчдэлтэй байгаа цахилгаан дамжуулах агаарын шугамд ажил гүйцэтгэх үед аюулгүй байдлыг дараах хоёр хувилбарын аль нэгээр нь хангаж болно. Үүнд:

- **“Утас-тусгаарлагч-хүн-газар”**

Энэ нь хүчдэлтэй утаснаас хүнийг тусгаарлсан нөхцөлд ажиллах хувилбар юм.

- **“Утас-хүн-тусгаарлагч-газар”**

Энэ нь хүчдэлтэй утасны чадавхийн нөлөөлөл дор хүнийг газраас тусгаарласан нөхцөлд ажиллах хувилбар юм.

604. Дараах нөхцөлийг бүрдүүлсэн тохиолдолд хүчдэлтэй утасны чадавхийн нөлөөний дор ажиллаж болно. Үүнд:

- Хүчдэлийн түвшинд нь тохирох зориулалтын тусгаарлагчаар хүнийг газраас хөндийрүүлсэн;
- Халхавчтай тусгаарлах хувцас хэрэглэсэн;
- Утас, халхавчтай тусгаарлах хувцас, ажлын тавцан гурвын чадавхийг адил болгосон (потенциалыг тэгшитгэсэн) байх ёстой.

605. Чадавхиудыг адил болгох үйлдлийг чадавхи шилжүүлэх зориулалттай тусгай штангаар гүйцэтгэнэ.

606. ЦДАШ-д авирч эхлэхийн өмнө халхавчтай тусгаарлах хувцсыг чадавхи шилжүүлэх штангтай, мөн өргөгч сагс хэрэглэж байгаа бол түүнтэй холбосон байх ёстой. Эдгээр ажлын үед хүнээс цахилгаан тоног төхөөрөмжийн газардуулагдсан хэсэг хүртэл 1 дүгээр хүснэгтэд зааснаас багагүй зайтай байх ёстой.

607. Чадавхийн нөлөөний дор гүйцэтгэх зарим төрлийн ажлыг тусгайлан баталсан аюулгүй ажиллагааны зааврын дагуу технологийн карт, ажил гүйцэтгэх төлөвлөгөөгөөр гүйцэтгэх ёстой.

608. Хүчдэлтэй шугам дээр хүнийг утаснаас тусгаарласан нөхцөлд ажиллахад тухайн хүчдэлд тохирсон зориулалтын цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглах ёстой.

609. 1000 В хүртэлх хүчдэлтэй агаарын шугамд зориулалтын резинэн бээлий, тусгаарлагчтай багаж хэрэгсэл ашиглан шууд хүрч ажиллах бөгөөд 1000 В-оос дээших хүчдэлийн агаарын шугамд үндсэн (тусгаарлагч штанг, клещ) болон туслах (резинэн бээлий, бот г.м.) хамгаалах хэрэгсэл ашиглан зайнаас ажиллана.

610. 1000 В-оос дээш хүчдэлийн агаарын шугамд утасны чадавхийн нөлөөний дор гүйдэл дамжуулах хэсэгт хамгаалах хэрэгсэл ашиглан хүрч ажил гүйцэтгэх ажил гүйцэтгэгч нь IV групптэй, бригадын бусад гишүүд нь III групптэй байх ёстой.

611. Шугамын утастай тэнцүү чадавхитай тусгаарлах төхөөрөмжийн тавцан дээр ажиллаж байхад шугамын утаснаас ялгаатай чадавхитай хэлхмэл тусгаарлагч болон бусад хэсгийн эд ангид хүрэх, мөн түүнчлэн тухайн тавцангаас бусад газарт байгаа хүнд багаж хэрэгсэл дамжуулж өгөхийг хориглоно.

612. Засвар хийж байгаа фазын өөр өөр чадавхитай утас ба хэлхмэл тусгаарлагч хэсгүүдийг холбох эсвэл тусгаарлахад туршсан резинэн бээлий заавал өмсөнө.

613. Хэлхмэл тусгаарлагч дээр ажил гүйцэтгэхийн өмнө хэмжүүрийн штангаар тусгаарлагчийн бат бэх байдал, түгжигч, цоожлогчийн бүрэн бүтэн байдлыг шалгаж магадлана.

614. Мултарч болзошгүй хавчаарт бэхэлгээтэй хэлхмэл тусгаарлагч дээр ажил гүйцэтгэхийн өмнөөжил гүйцэтгэх тулгуур болон түүний зэргэлдээх тулгуур дээр мултарч унахааргүй бэхэлгээ хийсэн байвал зохино.

615. Хамгаалах хэрэгслээс шугамын утас хүртэлх хэлхмэл тусгаарлагчийн 70-аас доошгүй хувь нь гэмтэлгүй тохиолдолд хэлхмэл тусгаарлагчийн зарим хэсгийг болон тусгаарлагчийн тоногийг солих, шилжүүлэн гогцоодох ажлыг тусгаарлах төхөөрөмж эсвэл хөндлөвч дээр байрлан гүйцэтгэж болно.

616. Хэлхмэл тусгаарлагчийг шилжүүлэн зүүх ажлыг хөндлөвч дээр байрлан гүйцэтгэх үед шаардлагатай багаж хэрэгслийг бэхлэх болон түүнийг хөндлөвчөөс тайлж авахад резинэн бээлийтэй ажиллана. Энэ үед 35 кВ-ын шугамд хэлхмэл тусгаарлагчид хоёр бүтэн тусгаарлагчтай тохиолдолд хөндлөвч талаас эхний тусгаарлагчийн толгойд, 110 кВ ба түүнээс дээш хүчдэлийн шугамд нэг ба хоёр дахь тусгаарлагчийн толгойд хүрэхийг зөвшөөрнө.

617. 35-110 кВ-ын ЦДАШ-д хүчдэлийг таслахгүйгээр цэнэг шавхагч тавихад түүний гаднах электрод нь шугамын утсанд зааснаас дотогш зайд ойртохоос урьдчилан сэргийлэх, зайг тохируулах тусгай багаж хэрэглэнэ.

618. Цэнэг шавхагчийн гаднах электродыг шугамын утсанд ойртуулах болон цэнэг шавхагчийг тайлж авах үед түүний тургих зай дотор хүн байхыг хориглоно. Цэнэг шавхагчийн гаднах электродыг ойртуулах эсвэл холдуулах үйлдлийг тусгаарлах штанг ашиглаж хийнэ.

619. Тулгуураас тусгаарласан аянганы тросод 1 метрээс дотогш зайд ойртохыг хориглоно.

620. Тросыг утасны мөсжилтийг хайлуулахад хэрэглэх тохиолдолд уг тросонд ойртож болох зөвшөөрөгдөх зайг мөсжилтийг гэсгээх хүчдэлийн хэмжээнээс хамааруулан тогтооно.

621. Манантай, бороотой, цастай болон шөнийн харанхуйд, түүнчлэн тулгуур дээр ажиллахад хүндрэл үүсгэх салхитай үед хүчдэлтэй байгаа ЦДАШ, ХАШ-д ажил гүйцэтгэхийг хориглоно.

4.15.4. Ажиллагаатай байгаа ЦДАШ-тай огтлолцсон алгасалтад ажиллах

622. ЦДАШ-ын утас, тросыг угсрах, солих үед угзралгүй алгуур татах ба татлага оосрыг татаж байгаа утас хүчдэлтэй байгаа утсанд ойртох буюу орооцолдохооргүйгээр чиглүүлэн байрлуулж татна.

623. Чангалж байгаа утсыг хүчдэлтэй утаснаас холдуулж байх даавуу, мяндсан олсон татлагын уртыг шаардлагатай хамгийн бага хэмжээгээр тохируулж аваад ажлын үед султгахгүйгээр татаж байвал зохино.

624. Ажилд хэрэглэж байгаа ган татлага болон татах механизмыг газардуулсан байх ёстой.

625. Утас угсрах, солих үед дамарт байгаа утсыг сунгаж эхлэхийн өмнө газардуулах ёстой.

626. Хүчдэлтэй байгаа ЦДАШ-тай огтлолцсон алгасалтад утас солих буюу татах үед утсыг огтлолцлын хоёр талд нь газардуулах ёстой.

627. Шугамын утас ба трос гүйлгэх металл дамар, хавчаарыг газардуулахад хангалттай. Утас гүйлгэх дамар, хавчаар нь төмөр болон төмөр бетон тулгуурын металл хийцтэй шууд холбоотой байвал дамар, хавчаарыг газардуулах шаардлагагүй.

628. Шаттай машины сунадаг шат болон өргүүрийн тавцан дээр байрлан шугамын утсанд ажил гүйцэтгэх үед 10 мм²-аас багагүй хөндлөн огтлолтой уян зэс утсаар угсарч (буулгаж) байгаа утас, ажлын тавцан хоёрыг тусгай штангийн тусламжтайгаар холбож тэдгээрийн чадавхийг ижил болгох ба сунадаг шат буюу өргүүрийг газардуулсан байх ёстой. Энэ тохиолдолд татаж (буулгаж) байгаа утсыг хамгийн ойрын тулгуур дээр эсвэл алгасалтын дунд газардуулсан байх ёстой.

629. Сунадаг шатны ажлын тавцанг угсарч буулгаж байгаа утастай холбосны дараа машины бүхээгт орох, буух түүнчлэн газарт зогсож байгаад сунадаг шатны их биед хүрэхийг хориглоно.

630. Утасны үзүүрт залгах болон утас хоорондын зайг хязгаарлах татлагад металл татлага хэрэглэхийг хориглоно.

631. Зэргэлдээх хоёр таталтын тулгуурын алгасалтад угсралтын ажлыг бүрэн дууссаны дараа хоёр алгасалтын утаснуудын уулзварын гогцоо холбоосыг хийнэ.

632. 110 кВ ба түүнээс дээш хүчдэлийн ЦДАШ-ын тулгуур дээр утасны уулзварын гогцоо холбоосыг холбож бэхлэхийн өмнө түүнийг шугамын утсанд эсвэл таталтын хэлхмэл тусгаарлагчаас бэхэлнэ. Гэхдээ хөндлөвчөөс эхлэн тоолоход дөрөв дэхь тусгаарлагчаас ойргүй байх ёстой. Харин 35 кВ ба түүнээс доош хүчдэлийн шугамд зөвхөн утсанд тогтооно.

633. Хүчдэлтэй байгаа бусад ЦДАШ-тай огтлолцсон ЦДАШ-ын алгасалтанд ажиллахад газардуулгыг ажил гүйцэтгэж байгаа тулгуурын дэргэд тавина. Хэрэв энэ алгасалтын утасыг солих буюу татаж байгаа бол татаж байгаа болон сольж байгаа утасны аль алиныг нь огтлолцолын хоёр талд нь газардуулах ёстой.

634. Хүчдэлтэй байгаа ЦДАШ-ын доор байрласан огтлолцсон ЦДАШ-ын утас (трос), түүнтэй холбоотой тусгаарлагч болон эд ангийг солих үед дээр байрласан шугамын утас (трос)-ны нөлөөллөөс сэргийлэхийн тулд сольж байгаа шугамын утас(трос)-ны дээгүүр гүйдэл дамжуулдаггүй синтетик болон байгалийн гаралтай олс, мяндсан татлага, оосрыг давуулан татсан байх ёстой. Ингэхдээ хоёр газар, тухайлбал огтлолцож байгаа газрын хоёр талын хийц хэсгүүдэд татлагаа бэхэлсэн байх ёстой. Шугамын утас (трос)-ыг алгуур аажим өргөнө.

635. Хүчдэлтэй байгаа ЦДАШ-ын дээр байрласан огтлолцсон ЦДАШ-ын утас (трос) болон түүнтэй холбоотой тусгаарлагч, хийц хэсгүүд дээр хийх ажлыг аж ахуйн нэгж, байгууллагын техникийн удирдах ажилтны баталсан ажил гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шугамын утас (трос) доош бууж унжихаас хамгаалсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан байх ёстой.

636. Хүчдэлтэй байгаа ЦДАШ-ын дээр байрласан ЦДАШ-ын утасыг солих буюу татах ажлыг хүчдэлийг нь заавал тасалж хийнэ.

4.15.5. Нөлөөллийн хүчдэлтэй ЦДАШ дээр ажиллах

637. Шугамын хүчдэлийг тасалсны дараа нөлөөллийн хүчдэлтэй үлдэх ЦДАШ-ын жагсаалт, нөлөөллийн хүчдэлийн хэмжээг шуурхай үйлчилгээ-засварын болон засварын ажилтнуудад танилцуулсан байх ёстой.

638. ЦДАШ-д нөлөөллийн хүчдэл байгаа тухай нарядын “Тусгай заалт” мөрөнд бичих ёстой.

639. Хүчдэлийг нь тасалсан ч нөлөөллийн хүчдэлд үлдсэн ЦДАШ, ХАШ-д утас, трос зэргийг залгах, эсвэл салгахын өмнө тэдгээр хэсгүүдийн чадавхийг ижил болгож тэгшитгэх хэрэгтэй. Ингэхийн тулд эдгээр хэсгүүдийг хооронд нь утсаар холбох, эсвэл салгах гэж буй газрын хоёр талд газардуулга тавьж нэг газардуулагч (газардуулагч төхөөрөмж)-д холбоно.

640. Нөлөөллийн хүчдэлтэй байгаа ЦДАШ-аас унжсан утсанд газарт зогсоод хүрч ажиллахад цахилгааны хамгаалах хэрэгсэл (резинэн бээлий, штанг) хэрэглэх буюу уг утастай холбож чадавхийг нь тэнцүүлсэн металл тавцан дээр байрлаж ажиллана.

641. Шугамын утсанд хүрч ажиллах хэсгийн шууд дэргэд нь газардуулга тавьсан тохиолдолд цахилгааны хамгаалах хэрэгсэл болон металл тавцан хэрэглэлгүйгээр газар дээр байрлаж ажил гүйцэтгэж болно.

642. Нөлөөллийн хүчдэлтэй байгаа ЦДАШ-ын утсыг угсрах үед хэрэглэх ган татлагыг эхлээд татах механизмд бэхэлж, дараа нь чадавхийг нь тэнцүүлэхийн тулд татах гэж байгаа утсыг газардуулсан тэр газардуулагчид нь холбосон байх ёстой. Зөвхөн энэ нөхцөлийг бүрдүүлсний дараа ган татлагыг татах утсанд бэхлэхийг зөвшөөрнө.

643. Утас ба татлагыг салгахдаа заавал чадавхийг тэнцүүлсний дараа өөрөөр хэлбэл утас ба татлагыг нэг газардуулагчид холбосны дараа гүйцэтгэж болно.

644. Нөлөөллийн хүчдэлтэй байгаа ЦДАШ-ын угсралтын (утас өргөх, татах, таталтыг тохируулах, утсыг сунгах дамраас хавчаарт шилжүүлэн бэхлэх г.м.) үед утсыг татаж эхэлсэн болон төгсгөлийн тулгуур, тэдгээрийн хооронд байгаа бүх тулгуур дээр татаж байгаа утсыг газардуулсан байх ёстой.

645. Дундын тулгуур дээрх ажил дууссаны дараа тулгуур дээрх шугамын утаснаас газардуулгыг авч болно. Тулгуурын утсанд хүрч хийх ажлыг дахин хийх үед газардуулгыг мөн тулгуур дээр дахиж тавих ёстой.

646. Нөлөөллийн хүчдэлтэй байгаа ЦДАШ-ын утсыг сунгах, жижиг дамруудаас утас зүүж тогтоох, хавчаарт шилжүүлж бэхлэх ажлыг уг утсыг сунгасан чиглэлийн эсрэг чиглэлд хийвэл зохино.

647. Утсыг шилжүүлэн бэхлэхийн өмнө шилжүүлэг хийж эхлэх таталтын тулгуур дээрх газардуулгыг аваад харин шилжилт хийх гэж байгаа таталтын тулгуур дээрх газардуулгыг хэвээр нь үлдээх ёстой.

648. Нөлөөллийн хүчдэлтэй байгаа ЦДАШ-ын утсыг хавчаарт бэхэлж тухайн тулгуур дээр хийх ажил бүрэн дууссаны дараа тэр тулгуурт тавьсан газардуулгыг авч болно.

649. Нэг таталтын алгасалтад утсыг хавчаарт шилжүүлэн угсарч байх үед түүний зэргэлдээх таталтын алгасалтад утсыг шилжүүлэн бэхлэх ажил дууссан бол түүнийг нөлөөллийн хүчдэлтэй шугам гэж үзнэ. Ийм алгасалтад ажил гүйцэтгэхдээ ажлын байран дээр нь заавал газардуулга тавина.

650. ЦДАШ-ын засвар, үйлчилгээг гүйцэтгэгч байгууллага нь нөлөөллийн хүчдэлтэй байж болзошгүй ЦДАШ-ын хүчдэлийг таслаж, төгсгөлүүд (ХБ)-д нь газардуулга тавьж, зэргэлдээ байрлалтай хүчдэлтэй агаарын шугамыг хамгийн их гүйдэлтэй байх үед газардуулсан агаарын шугамд 24 В-оос дээш нөлөөллийн хүчдэл үүсч байгаа эсэхийг хэмжиж тодорхойлсон байх ёстой. Ийм шугам дээр цахилгааны үндсэн хамгаалах хэрэгсэл хэрэглэлгүйгээр утсанд хүрч гүйцэтгэх бүх төрлийн ажлыг технологийн карт буюу ажил гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу явуулах ёстой. Технологийн карт буюу ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд ажлын байранд байгаа шугамын утсанд 24 В-оос дээш хүчдэл үүсэхгүй байхаар тооцоолон газардуулга тавих цэгүүдийг заасан байх ёстой.

651. Хэрэв ЦДАШ-ын утсанд бий болж байгаа нөлөөллийн хүчдэлийг 24 В-оос доош ортол бууруулж чадахгүй бол газардуулгыг зөвхөн ажил гүйцэтгэх нэг тулгуурт, эсвэл зэргэлдээх хоёр тулгуурт тавьж ажиллавал зохино. Энэ тохиолдолд ЦДАШ буюу түүний хэлхээг ХБ-д газардуулахыг хориглоно. Бригадыг зөвхөн газардуулга тавьсан нэг тулгуур дээр буюу зэргэлдээх хоёр тулгуурын хоорондох алгасалтын шугамын утсан дээр ажиллахыг зөвшөөрнө.

652. ЦДАШ буюу түүний нэг хэлхээний хоёр ба түүнээс дээш алгасалтад (хэсэгт) нэг зэрэг ажиллах шаардлагатай тохиолдолд уг хэсгүүдийн хооронд байгаа таталтын тулгууруудад утаснуудын холболтыг тайлан цахилгаан хэлхээг тасархай болгож

ажиллавал зохино. Тийм хэсгүүдэд дэргэд нь газардуулга тавьсан ажлын байр тус бүрт зөвхөн нэг бригад ажиллаж болно.

653. Нэг нь нөгөөгийнхөө дээр байрлалтай олон хэлхээт ЦДАШ-д хүчдэлтэй байгаа хэлхээний доор нь байрласан тасалсан хэлхээн дээр ажил гүйцэтгэж болно. Энэ үед ажил гүйцэтгэх шугамын утсыг солих, унжилтыг тохируулах ажил гүйцэтгэхийг хориглоно.

654. Хэвтээ байрлалтай олон хэлхээт ЦДАШ-ын нэг хэлхээний хүчдэлийг тасалж ажил гүйцэтгэх үед тулгуурын хүчдэлтэй үлдсэн хэлхээний талд улаан дарцагууд бэхэлсэн байх ёстой. Ажил гүйцэтгэгч нь бригадын III групптэй гишүүний хамт газраас 2-3 метрийн өндөрт дарцагуудыг бэхэлнэ.

655. Хүчдэлтэй байгаа хэлхээний талаас тулгуурт авирах, мөн ажлын үед энэ талын хөндлөвчид шилжиж гарахыг хориглоно. Хэрэв тулгуурт авирахад зориулсан гишгүүртэй бол аль ч хэлхээний тал өөд авирч болох боловч хэрэв уг зориулалтын гишгүүр нь хүчдэлтэй байгаа хэлхээний талд байвал доор үлдсэн ажил гүйцэтгэгч эсвэл III групптэй бригадын гишүүний хяналтан дор тулгуурт авирч болно.

656. Олон хэлхээт ЦДАШ-ын бусад хэлхээ нь хүчдэлтэй байхад нэг хэлхээний хүчдэлийг таслаад түүний утсанд тулгуур дээр байрлаж ажил гүйцэтгэхэд ажил гүйцэтгэх тулгуур бүр дээр хүчдэлийг тасалсан хэлхээний утсанд газардуулга тавина.

4.15.6. ЦДАШ-ын дагуух ургаа модыг унагааж цэвэрлэх

657. ЦДАШ-ын дагуу ургаа модыг унагаах цэвэрлэх ажлыг нарыдаар гүйцэтгэнэ.

658. Модыг унагааж эхлэхийн өмнө ажлын байрыг чөлөөлж цэвэрлэсэн байх ёстой. Өвлийн улиралд унаж байгаа модноос түргэн холдоход зориулан модны унах зүгийн эсрэг зүгт цасыг нь цэвэрлэж 5-6 метр урттай 2 зам гаргана.

659. Дутуу хөрөөдсөн, дутууцавчсан модонд авирахыг хориглоно.

660. Ажил гүйцэтгэгч нь ажил эхлэхийн өмнө унагаах мод, татлага ба бусад зүйлс нь ЦДАШ-ын утсанд ойртох, хүрч шүргэж болзошгүйг бригадын бүх гишүүдэд урьдчилан анхааруулах ёстой.

661. Мод шугамын утсан дээр унасан тохиолдолд шугамын хүчдэлийг таслахааснааш түүнд 8 метрээс дотогш ойртохыг хориглоно.

662. Модыг аль зүгт унагаахаа хөрөөдөх ажилтан бусаддаа урьдчилан мэдэгдэх ёстой.

663. Модны унах ба түүний эсрэг талд байрлахыг хориглоно.

664. ЦДАШ-ын утсан дээр мод унахаас сэргийлэн татлага оосор хийсний дараа цавчиж хөрөөдөх ёстой.

665. Модыг хөрөөдөлгүй буюу цавчилгүй унагаах, нэвт хөрөөдөж унагахыг хориглоно. Хоёр талаас нь зөрүүлж хөрөөдөн хазгай модыг хазайсан тал руу нь унагана. Гэхдээ тухайн хазгай мод нь ЦДАШ дээр унах аюултай байвал хүчдэлийг нь таслах хүртэл модыг унагаж болохгүй.

666. Хөрөөдөж буюу цавчиж эхэлсэн, дутуу хөрөөдсөн, дутуу цавчсан модыг ажлын завсарлагаанаар эсвэл өөр мод руу шилжихдээ ч унагаалгүй орхихыг хориглоно.

667. Өмхөрсөн ба хатсан модыг унагаахын өмнө бөх батыг заавал шалгаад дараа нь хөрөөднө. Ийм модыг цавчихыг хориглоно.

668. Олон модыг урьдчилан хөрөөдсөний дараа бөөнөөр нь нэг зэрэг унагаах, эсвэл нэг модыг нөгөө дээр нь унагах аргаар унагаахыг хориглоно.

669. Өмхөрсөн ба түлэгдсэн модыг эхний ээлжинд унагаах ёстой. ЦДАШ-ын хамгаалалтын зурваст байгаа модыг тайрах ажлыг байгаль орчины асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу гүйцэтгэнэ.

4.15.7. Цахилгаан дамжуулах агаарын шугамын эргүүл, үзлэг

670. ЦДАШ ба түүний тоноглолд үзлэг хийх үед ямар нэг ажил буюу засвар хийх, тулгуур ба түүний хийц хэсэгт ЦДАШ-ын дээд хэсэгт үзлэг хийхээс бусад тохиолдолд авирахыг хориглоно.

671. ЦДАШ-ын эргүүл ба үзлэг хийхэд ажил гүйцэтгэгч томилох шаардлагагүй боловч тухайлсан зааварчилгаа өгсөн байх ёстой.

672. Явахад бэрхшээлтэй газар (намаг, ус, уул, ой модтой г.м.), цаг агаарын тааламжгүй (бороотой, цастай, хэт хүйтэн г.м.) нөхцөлд түүнчлэн харанхуй үед ЦДАШ-ын үзлэгийг II-оос доошгүй групптэй хоёр хүн гүйцэтгэх ба нэгийг нь ахлагчаар томилсон байна. Бусад нөхцөлд ЦДАШ-ын үзлэгийг II групптэй нэг хүн гүйцэтгэж болно.

673. Харанхуй үед ЦДАШ-ын үзлэг хийхэд шугамын утасны доогуур явахыг хориглоно.

674. Шугамын гэмтэл илрүүлэх үзлэг хийж байгаа хүн урьдчилан сэргийлэх плакат, тэмдгүүдийг өөртөө авч явах ёстой.

675. Үзлэг хийж байгаа хүнийг диспетчертэй харилцах холбооны хэрэгслээр хангасан байх ёстой.

676. 1000 В-оос дээш хүчдэлийн ЦДАШ-ын газар дээр хэвтэж байгаа утсанд 8 м-ээс дотогш зайд ойртохыг хориглоно. Тийм утсанд хүн, амьтан ойртуулахгүйн тулд бололцоотой тохиолдолд хүн байлгаж, плакат, тэмдэг тавиад энэ тухай холбогдох байгууллагад нь мэдээлж таслуулна.

677. 1000 В-оос дээш хүчдэлийн ЦДАШ-ын тусгаарлагч нь гэмтсэн, утас нь тулгууртаа хүрч шүргэсэн, хөрсний чийг ууршиж байгаа, тулгуурын аль нэг хэсэгт болон тулгуурын хөрс рүү орсон хэсэгт цахилгаан нум үүссэн, оч хаясан гэх мэт газардлагын гүйдэл газрын хөрсөнд тархаж байгаа шинж тэмдэг илэрвэл тухайн тулгуурт 8 м-ээс дотогш зайд хүчдэлийг нь таслуулахгүйгээр ойртохыг хориглоно.

4.15.8. Тээврийн хэрэгслийн замтай ойртсон буюу түүнтэй огтлолцсон ЦДАШ-ын хэсэгт ажиллах

678. Тээврийн хэрэгслийн замтай (авто, төмөр ба усан зам г.м.) ойртсон буюу түүнтэй огтлолцсон ЦДАШ-ын хэсэгт ажил гүйцэтгэх үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр зогсоох бол шаардлагатай тохиолдолд наряд олгогч нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулагч эрх бүхий ажилтныг холбогдох байгууллагад нь хандаж ажиллуулах үүрэгтэй.

679. Тээврийн хэрэгсэл өнгөрөх үед шугам дээрх ажлыг түр зогсоох эсвэл тээврийн хэрэгсэл уг ажлын байр руу ойртон ирж байгааг мэдээлэх, тээврийн хэрэгслийн жолооч нарт урьдчилан анхааруулах, тэдгээрийг зогсоох үүрэгтэй ажилтнууд (дохиочид)-ыг бригадын бүрэлдэхүүнд оруулна.

680. Дохиочид нь замын ЦДАШ-тай огтлолцсон хэсгээс хоёр тийш тус бүр 100 метрийн зайд өдрийн цагт улаан дарцагтай, шөнө улаан гэрэлтэй ажиллах үүрэгтэй.

681. Тээврийн хэрэгслийг өнгөрүүлэхийн тулд түүний хөдөлгөөнд саад болох утсыг дээш нь аюулгүй зайд өргөнө.

4.15.9. Гудамжны гэрэлтүүлгийн сүлжээний үйлчилгээ

682. Дараах тохиолдолд гэрэлтүүлгийн сүлжээний хүчдэлийг таслалгүй шийдвэрээр ажил гүйцэтгэж болно. Үүнд:

- Газардуулгын буултын утасгүй модон тулгуурт гэрэлтүүлэгч нь хүчдэлтэй утасны доор 0,6 м-ээс багагүй зайд байрласан бол модон тулгуурт авирч буюу модон шатан дээрээс ажиллах;
- Тусгаарлах үетэй сунадаг цамхагт шат ашиглаж ажиллах;

683. Дүрмийн 682-т зааснаас бусад тохиолдолд тулгуурт байгаа бүх утасны хүчдэлийг таслаад газардуулга тавьж ажлыг нарыдаар гүйцэтгэнэ.

684. Хийн цахилалтын гэрлийн шилтэй гэрэлтүүлэгчийн асаах тохируулах аппаратад ажил гүйцэтгэхэд түүнийг гэрэлтүүлгийн ерөнхий схемээс салгахын өмнө тэжээлийн сүлжээнд холбосон утсыг тайлж салгаад гэрэлтүүлэгт байгаа конденсаторын цэнэгийг (цэнэг шавхах эсэргүүцэлтэй байсан ч гэсэн) шавхах ёстой.

4.15.10. Хамгаалах бүрээстэй утас бүхий 6-20 кВ-ын ЦДАШ-д ажиллах

685. 6-20 кВ-ын хамгаалах бүрээстэй ЦДАШ-д хүчдэлийг тасалсан нөхцөлд ажиллана.

686. Ажил гүйцэтгэж байгаа ажилтнаас агаарын шугамын утас болон түүнтэй холбоотой эд анги хүртэлх болон агаарын шугамын утаснаас машин механизм, ачаа өргөх кран хүртэл зай нь 1 дүгээр хүснэгтэд зааснаас багагүй байна.

687. Хамгаалах бүрээстэй утаснаас мод, ургамал хүртэл 0,6 метрээс багагүй зайтай байна.

688. Шугамын утсан дээр унасан модыг зайлуулахын тулд ЦДАШ-ын хүчдэлийг таслаж газардуулсан байна.

689. Хүчдэлийг таслаагүй ЦДАШ дээр шугамын утсанд тохогдсон зүйлс, мөчир зэргийг туршсан штанг ашиглан авч болно. Эдгээр ажлыг хамгаалах хэрэгсэл ашиглахгүйгээр хийх тохиолдолд ЦДАШ-ын хүчдэлийг тасалж газардуулга тавьсан байх ёстой.

4.15.11. Тусгаарлагч бүрээстэй 0,4 кВ хүчдэлийн ЦДАШ-д ажиллах

690. Тусгаарлагч бүрээстэй 0,4 кВ хүчдэлийн ЦДАШ дээр хүчдэлийг таслалгүй гүйцэтгэх ажлыг нарыдаар гүйцэтгэнэ.

691. Тусгаарлагч бүрээстэй 0,4 кВ хүчдэлийн нэг буюу хэд хэдэн шугам, тэдгээрийн хэсгүүдэд дараалуулан ажилд оруулах тохиолдолд нэг наряд олгож болно.

692. Тусгаарлагч бүрээстэй 0,4 кВ хүчдэлийн ЦДАШ дээр шугамын утасны бүрээсийг туушид нь солих, галын болон тэсрэх аюултай орчин (шатахуун түгээгүүр г.м.)-д байгаа утасны нэг буюу хэд хэдэн судлыг залгах, салгах ажлыг хүчдэл тасалсан нөхцөлд гүйцэтгэнэ.

693. Тусгаарлагч бүрээстэй шугамын зөвхөн ажил гүйцэтгэх утасны хүчдэлийг таслаад ажиллаж болно. Ингэхдээ ажил гүйцэтгэх утсыг зөв тодорхойлоод пайз зүүж, бүх талаас нь таслалт хийж, хүчдэлгүй болсныг шалгамагц ажлын байранд хүчдэл ирж болзошгүй бүх талд газардуулга тавина.

694. Тусгаарлагч бүрээстэй 0,4 кВ хүчдэлийн ЦДАШ дээр дараах ажлуудыг хүчдэл таслалгүй гүйцэтгэж болно. Үүнд:

- Шугамын тулгуур, түүний хийц хэсэг, шугамын арматур солих;
- Утас чангалах;
- Залгаасны, салаалалтын болон таталтын хавчааруудыг солих;
- Цахилгаан хэрэглэгчийг тэжээх салбар шугамыг залгах эсвэл таслах;
- Аль нэг фазын утасны бүрээсийг солих буюу сэргээх;

695. Фазын утас нь тусгаарлагч бүрээстэй, нойлийн утас нь бүрээсгүй шугам дээр хүчдэлийг таслалгүй ажиллахад нойлийн утас болон төмөр арматуруудыг зориулалтын материалаар тусгаарлана.

696. Тусгаарлагч бүрээстэй 0,4 кВ хүчдэлийн ЦДАШ дээр дараах тохиолдолд хүчдэлийг нь таслахгүйгээр ажиллахыг хориглоно. Үүнд:

- Андуурч тасалсан буюу тодорхойгүй шалтгаанаар хүчдэлгүй болсон шугамд;
- ЦДАШ-д гэмтэл илэрсэн үед түүнийг арилгахад ажлын технологийг алдагдуулахаар нөхцөлд;
- Техник хэрэгсэл ба хамгаалах хэрэгсэл байхгүй, эсвэл эвдрэл гэмтэлтэй тохиолдолд;
- Хүчтэй бороо, цас, салхи, өтгөн манантай үед;
- Тулгуурт мөстлөг үүссэн тохиолдолд;
- Ажлын аюулгүй байдалд нөлөөлөх бусад хүчин зүйл бүрдсэн нөхцөлд;

697. Хүчдэлийг нь таслалгүйгээр ажиллахад ажил гүйцэтгэгч нь IV групптэй, бригадын гишүүд нь III групптэй байна.

698. Тусгаарлагч бүрээстэй 0,4 кВ хүчдэлийн ЦДАШ-д хүчдэлийг нь таслахгүйгээр өндөрт авирч ажиллах ажил гүйцэтгэгч ба бригадын гишүүд нь зохих дасгал сургуулалт хийж шалгалт өгч эрх авсан байна. Энэ тухай группын үнэмлэхийн “Олгосон эрх (Ажил)” гэсэн хэсэгт (Хавсралт №2) бичсэн байна.

699. Газраас тусгаарласан аянга хамгаалах тросод газардуулгын буултыг холбох буюу салгахын өмнө тросыг газардуулах ёстой.

ТАВДУГААР БҮЛЭГ. ТУРШИЛТ, ХЭМЖИЛТ

5.1. Гадны гүйдэл үүсгэгчээс өндөржүүлсэн хүчдэл өгч туршилт хийх

700. Дор дурьдсан шаардлагыг хангасан хүн туршилтын ажил гүйцэтгэх эрхтэй байна.

- Өндөр хүчдэлийн туршилт хийх ажилд тусгай хөтөлбөрийн дагуу суралцсан;
- Дүрмийн энэ бүлгийн заалтуудыг бүрэн судалж 1000 В-оос дээш хүчдэлтэй цахилгаан байгууламжид V групптэй, 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжид IV групптэй тоног төхөөрөмжийн туршилтын мэргэжилтэн оролцсон шалгалтын комисст шалгалт өгч тэнцсэн байх;
- Туршилтын ажлын дадлага туршлагатай хүнийг дагалдан 1 сараас доошгүй хугацаанд гардан ажиллаж бие дааж ажиллах чадвартай болсон байх;

701. Туршилт хийх эрхийг группын үнэмлэхэд (Хавсралт №2) бичсэн байна.

702. Хэмжүүрийн төхөөрөмж, цахилгааны лаборатори нь эрчим хүчний хяналтын байгууллагад бүртгэлтэй байх ёстой.

703. Өндөр хүчдэлийн туршилтын ажлыг нарыдаар хийнэ.

704. Ашиглалтад байгаа цахилгаан байгууламжийн туршилт хийхэд энэ дүрмийн 2.7-д заасны дагуу шуурхай ажиллагааны ажилтан ажилд оруулах бөгөөд цахилгаан байгууламжийн бүсээс гадна бол ажлын удирдагч, томилогдоогүй бол ажил гүйцэтгэгч нь ажилд оруулна.

705. Угсралт, засварын ажлын явцад туршилт хийх талаар нарыдын “Даалгах нь” мөрөнд тайлбарлан бичнэ.

706. 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжийн туршилтыг шийдвэрээр гүйцэтгэж болно.

707. Туршилтын ажлыг бригадаар гүйцэтгэх ба түүний ажил гүйцэтгэгч нь IV-оос доошгүй, бригадын гишүүн нь III-аас доошгүй, хамгаалалтад байх ажилтан нь II-оос доошгүй групптэй байх ёстой.

708. Туршилт хийх бригадын бүрэлдэхүүнд ажлын бэлтгэл хангах ба тоноглолын байдалд хяналт тавиулах зорилгоор туршилтын ажил гүйцэтгэх эрхгүй засварын ажилтныг оруулж болно.

709. Засвар, угсралтын ажил гүйцэтгэж байгаа бригадын бүрэлдэхүүнд тохируулга, зүгшрүүлэлтийн буюу цахилгаан лабораторийн хүнийг туршилт хийлгэхээр оруулж болно. Энэ тохиолдолд туршилтыг удирдах үүргийг ажил гүйцэтгэгч эсвэл түүний зөвшөөрснөөр лабораторийн IV-өөс доошгүй групптэй ажилтан гүйцэтгэж болно.

710. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжийн гүйдэл дамжуулах хэсэг нь нэлэнхүйдээ битүү буюу сараалжин хаалтаар хаагдсан, хаалга нь хориг түгжээтэй, туршилтын суурин тоног төхөөрөмж ашиглан тусгаарлах эд материал, хэрэгслийг (хамгаалах хэрэгсэл, янз бүрийн тусгаарлах материал г.м.) олноор нь турших ажлыг III-аас доошгүй групптэй нэг хүн ганцаараа ашиглалтын явцад гүйцэтгэх ажлын хүрээнд туршилтын зохих зааврын дагуу гүйцэтгэж болно.

711. Туршилтын төхөөрөмжийг ажиллуулагчийн ажлын байр 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжийн хэсгээс тусдаа байх ёстой.

712. 1000 В-оос дээш хүчдэлтэй төхөөрөмжийн хэсгийн хаалга онгойсон тохиолдолд хүчдэлийг таслах, мөн хаалга онгорхой байх үед хүчдэл өгөх боломжгүй хоригтой байх ёстой.

713. Туршигчийн ажлын байр нь 1000 В хүртэл ба түүнээс дээш хүчдэл залгахад асдаг тус тусдаа гэрлэн дохиотой байхаас гадна туршилтын хүчдэл өгснийг мэдээлэх дуут дохиотой байх ёстой.

714. Зөөврийн туршилтын төхөөрөмж нь туршилтын төхөөрөмжийн гаргалгаа дээр хүчдэл бий болмогц автоматаар ажилладаг гадна гэрлэн дохио, туршилтын хүчдэл өгснийг мэдээлэх дуут дохиогоор тоноглогдсон байна.

715. Туршилт хийж байгаа хүн туршилтын хүчдэл залгахаас өмнө тусгаарлах резинэн дэвсгэр буюу тусгаарлах тавцан дээр зогссон байх ёстой.

716. Туршилт хийх гэж байгаа тоног төхөөрөмж, тоноглол дээр ажиллаж байсан бригад, ажилтныг ажлын байрнаас гарган холдуулж, нарыдыг ажилд оруулагчид буцаан өгсний дараа туршилт хийх, түүнд бэлтгэх нарыдаар ажилд оруулна.

717. Байнгын жижүүргүй буюу ажилд оруулагчид нарядыг буцааж өгөх боломжгүй цахилгаан байгууламжид ажил гүйцэтгэгч бригадыг ажлын байрнаас гаргасны дараа нарыадад ажлын завсарлагааг тэмдэглэн бичээд түүнийг өөртөө хадгалахыг зөвшөөрнө.

718. Туршиж байгаа тоног төхөөрөмж, туршилтын төхөөрөмж ба тэдгээрийн холболтын утаснуудын эргэн тойронд хашлага ба олсоор хаалт хийж түүн дээр “Туршилт! Амь насанд аюултай” гэсэн плакатыг бичигтэй талаар нь гадагш харуулан тавих ёстой. Хаалт, хашилт, плакатыг туршилт хийх хүн тавина.

719. Шаардлагатай гэж үзвэл туршилтын төхөөрөмж, холбоос утас, туршиж байгаа тоног төхөөрөмжид хүн ойртохоос сэргийлж бригадын гишүүдийн дотроос II-оос доошгүй групптэй ажилтныг харуулд гаргана.

720. Харуулын үүрэг гүйцэтгэгч бригадын гишүүн нь хаалтын гадна байрлах ёстой ба туршиж байгаа тоноглолыг хүчдэлтэйд тооцох ёстой.

721. Харуулын үүрэг гүйцэтгэгч нь зөвхөн ажил гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр ажлын байраа орхиж болно.

722. Кабель шугам турших үед хэрвээ түүний нөгөө талын үзүүр нь бүрдмэл хуваарилах байгууламжийн түгжээтэй шүүгээ, өрөө буюу байранд байрласан бол түүний хаалга буюу хаалтан дээр “Туршилт! Амь насанд аюултай” гэсэн плакат өлгөнө. Хэрвээ энэ хаалга, хаалт нь түгжээгүй, эсвэл турших гэж байгаа кабелийг түүний замын дунд үзүүрлэсэн байвал тэдгээрт плакат тавихаас гадна бригадын бүрэлдэхүүнд орсон II-оос доошгүй групптэй хүнээр эсвэл жижүүрийн ажилтнаар харуул тавих ёстой.

723. Туршилтын төхөөрөмж ба туршиж байгаа тоног төхөөрөмж нь өөр өөр байр тасалгаанд эсвэл хуваарилах байгууламжийн өөр өөр хэсэгт байрласан тохиолдолд туршиж байгаа тоног төхөөрөмжийн байдалд ажиглалт хийж байгаа III-аас доошгүй групптэй ажилтан нь ажил гүйцэтгэгчээс тусдаа байрлаж болно. Эдгээр ажилтан нь хаалт хашилтын гадна талд байрлах ёстой бөгөөд туршилт эхлэхийн өмнө ажил гүйцэтгэгч тухайлсан зааварчилгаа өгсөн байна.

724. Ажлын байр бэлдэх үед тавьсан газардуулга нь туршилт хийхэд саад болохоор тохиолдолд газардуулгыг авах, дараа нь дахин тавих үйлдлийг туршилтын төхөөрөмжийн өндөр хүчдэлийн гаргалгыг газардуулсны дараа туршилтын ажлыг удирдаж байгаа ажил гүйцэтгэгчийн шийдвэрээр гүйцэтгэхийг зөвшөөрнө.

725. Газардуулгыг түр хугацаанд авч буцаан тавих зөвшөөрлийг нарядын “Тусгай заалт” мөрөнд бичсэн байх ёстой.

726. Их бие нь зөвхөн ажлын схемээр газардуулагдсан явуулын төхөөрөмжөөр туршилт хийхийг хориглоно.

727. Туршилтын схем бэлтгэх үед юуны өмнө турших төхөөрөмжид ажлын болон хамгаалалтын газардуулга тавина. Газардуулгын зэс утасны хөндлөн огтлол 4 мм²-аас багагүй байх шаардлагатай.

728. Зөөврийн туршилтын төхөөрөмжийн их биеийг 10 мм²-аас багагүй хөндлөн огтлолтой уян зэс утсаар тусад нь газардуулсан байх ёстой.

729. Туршилтын өмнө их биеийн газардуулгын найдвартай байдлыг шалгавал зохино.

730. Туршилтын төхөөрөмжийг 380/220 В-ын сүлжээнд холбохын өмнө түүний өндөр хүчдэлийн гаргалгаан дээр газардуулга тавьсан байх ёстой.

731. 380/220 В-ын хүчдэлийн сүлжээнд туршилтын төхөөрөмжийг хэлхээний тасархай байдал ил харагдах таслах залгах аппаратаар дайруулан, эсвэл туршилтын төхөөрөмжийн удирдах байранд байрлуулсан сэрээ залгуураар дамжуулан холбох ёстой.

732. Таслах залгах аппарат нь өөрөө залгагдахаас сэргийлсэн хоригоор тоноглогдсон эсвэл түүний хөдлөх ба үл хөдлөх контактын хооронд тусгаарлагч жийрэг тавьсан байх ёстой.

733. 380/220 В-ын хүчдэлийн сүлжээнээс тэжээгдэж байгаа туршилтын төхөөрөмжийн тэжээлийн утас буюу кабель нь энэ шугаманд тавигдсан автомат салгуур буюу хайламтгай хамгаалууртай байх ёстой.

734. Зөөврийн туршилтын төхөөрөмжийг сүлжээнд холбох ажлыг сүлжээг ашиглагч байгууллагын ажилтан гүйцэтгэнэ.

735. Турших тоноглол ба туршилтын төхөөрөмжийн холбох утсыг эхлээд түүний газардуулсан өндөр хүчдэлийн гаргалгаанд холбоно. Энэ утсыг хүчдэлтэй гүйдэл

дамжуулах хэсэгт 1 дүгээр хүснэгтийн 3 дугаар баганад зааснаас дотогш зайд ойртохгүйгээр сайн бэхэлнэ.

736. Туршиж байгаа тоноглолын фаз ба туйлд эсвэл кабелийн судалд туршилтын холболтын утсыг газардуулгын хутгыг залгасан буюу зөөврийн газардуулга тавьсан, лабораторийн газардуулгыг залгасан нөхцөлд л туршилтыг удирдаж байгаа хүний зөвшөөрлөөр холбох ба тайлж авна.

737. Туршилтын хүчдэл өгөх бүрийн өмнө ажил гүйцэтгэгч дараах үүргийг гүйцэтгэнэ: Үүнд:

- Схемийг зөв угсарсан эсэхийг шалгах;
- Ажлын ба хамгаалалтын газардуулга найдвартай холбогдсон эсэхийг шалгах;
- Бригадын бүх гишүүд ажлын байраа зөв эзэлсэн, харуулд тавьсан ажилтан зохих газартаа байгаа болон гадны хүмүүс холдсон эсэх, тоноглолд туршилтын хүчдэл өгөх бэлтгэл хангагдсаныг тус тус шалгах;
- Хүчдэл өгөх гэж байгаа тухайгаа “Хүчдэл залгалаа!” гэж тод чангаар урьдчилан хэлж мэдэгдэх;
- Бригадын бүх гишүүн түүнийг сонссон эсэхийг магадлаад, туршилтын төхөөрөмжийн гаргалгаанаас газардуулгыг авч түүнд 380/220 В-ын хүчдэл залгах;

738. Туршилтын төхөөрөмжийн гаргалгаанаас газардуулгыг авсан мөчөөс эхлэн туршилтын төхөөрөмж төдийгүй туршиж байгаа тоног төхөөрөмж, туршилтын бүдүүвчид холбогдсон бүх тоног төхөөрөмж, холболтын утсыг хүчдэлтэй болсонд тооцож туршилтын бүдүүвчид ямар нэгэн ажил (холбох, салгах г.м.) хийхийг хориглоно.

739. Туршилтын төхөөрөмжийн гаргалгаанд хүчдэл өгснөөс хойш явуулын лабораторт орох, гарах, туршиж байгаа тоноглолын дээр, доор байх, түүнчлэн газар дээр зогсож туршилтын төхөөрөмжийн их биед хүрэхийг тус тус хориглоно.

740. Кабелийг газардуулгын хүрээтэй талаас нь турших ба шатаах хэрэгтэй.

741. Ихээхэн хэмжээний багтаамжийн гүйдэл бүхий тоноглолыг (кабель, генератор) туршсаны дараа түүний үлдэгдэл цэнэгийг шавхах ёстой.

742. Ажил гүйцэтгэгч туршилт дууссаны дараа туршилтын төхөөрөмжийн хүчдэлийг тэг болтол бууруулан 380/220 В-ын сүлжээнээс туршилтын төхөөрөмжийг таслан, туршилтын төхөөрөмжийн гаргалгааг газардуулаад энэ тухайгаа бригадад “Хүчдэлийг тасалсан” гэж чанга хэлж мэдэгдэнэ.

743. Зөвхөн “Хүчдэлийг тасалсан” гэж ажил гүйцэтгэгч чанга хэлсний дараа л утсыг өөрчлөн холбох буюу туршилт бүрэн дууссан бол туршилтын төхөөрөмжийн холболтыг тайлах, хаалт хашилтыг авах ажлыг гүйцэтгэж болно.

5.2. Гүйдэл хэмжих бахь, хэмжүүрийн штангаар ажиллах

744. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид гүйдэл хэмжих бахиар хэмжилт хийх ажлыг шийдвэрээр 2 хүн гүйцэтгэх бөгөөд түүний нэг нь IV-өөс доошгүй групптэй шуурхай ажиллагаа, шуурхай үйлчилгээ-засварын ажилтан, нөгөө нь III групптэй засварын ажилтан байна.

745. Гүйдэл хэмжих бахиар хэмжилт хийхдээ заавал тусгаарлах резинэн бээлий хэрэглэнэ.

746. Хэмжилт хийх үед багажны заалтыг бөхийж харахыг хориглоно.

747. 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламжид гүйдэл хэмжих бахиар хэмжилт хийх ажлыг III-аас доошгүй групптэй нэг хүн хийж болно.

748. ЦДАШ-ын тулгуурт гарсан үед гүйдэл хэмжих бахиар хэмжилт хийхийг хориглоно.

749. Хэмжүүрийн штангаар ажиллах үед ажлыг 2-оос цөөнгүй хүн нарыдаар гүйцэтгэх бөгөөд тэдний нэг нь IV-өөс доошгүй, бусад нь III-аас доошгүй групптэй байна.

750. Сунадаг шат ба хийц хэсэг өөд авирах, мөн түүнээс буухдаа хэмжүүрийн штангийг биедээ авч явахыг хориглоно.

751. Штанг хэрэглэн ажиллах үед тусгаарлах резинэн бээлий хэрэглэхгүй байж болно.

5.3. Лугшилтын хэмжүүр ашиглаж ЦДАШ-д ажиллах

752. Зөвхөн хүчдэлийг таслаж газардуулга тавьсан ЦДАШ-д лугшилт (импульс)-ын хэмжүүр холбохыг зөвшөөрнө.

753. Холболтыг дараах журмаар хийх ёстой. Үүнд:

- Штангаар ажиллах үед тусгаарлах резинэн бээлий хэрэглэнэ.
- Холболтын утсыг эхлээд хамгаалалтын байгууламжаас гарч буй лугшилтын хэмжүүрийн газардуулгын утсанд холбож дараа нь ЦДАШ-ын утсанд тусгаарлах штангаар холбоно.
- ЦДАШ-д холболтын утсыг холбоход ашигласан штангийг хэмжилтийн үед шугамын утсанд орхино.
- ЦДАШ-аас газардуулгыг авахдаа лугшилтын хэмжүүр холбогдсон төгсгөлөөс нь авна. Шаардлагатай бол шалгаж байгаа ЦДАШ-ын бусад төгсгөл дэх газардуулгыг авахыг зөвшөөрнө.
- ЦДАШ-аас газардуулгыг авсны дараа холболтын утас, хамгаалах байгууламж ба түүний холболтын утсыг хүчдэлтэйд тооцож тэдгээрт хүрэхийг хориглоно.
- Лугшилтын хэмжүүрийн утаснаас газардуулгыг авна.

754. Лугшилтын хэмжүүрийн утсыг ЦДАШ-д тусгаарлах штангаар холбох ажлыг IV-өөс доошгүй групптэй шуурхай ажиллагааны ажилтан, эсвэл түүний хяналтан дор лабораторийн ажилтан гүйцэтгэх ёстой.

755. Лугшилтын хэмжүүрийг ЦДАШ-д холбоотой суурин таслах залгах аппаратаар дамжуулан холбох, хэмжилт хийх ажлыг шуурхай ажиллагааны ажилтан ганцаараа, эсвэл IV-ээс доошгүй групптэй лабораторийн ажилтан шийдвэрээр гүйцэтгэж болно.

756. ЦДАШ-д хэмжилт хийж дууссаны дараа ЦДАШ-д газардуулгыг дахин тавих ба зөвхөн түүний дараа холболтын утас бүхий штангийг эхлээд ЦДАШ-аас дараа нь лугшилтын хэмжүүрийн утаснаас салгана.

757. Өндөр хүчдэлийн лугшилтын генераторгүй лугшилтын хэмжүүрээр хэмжилт хийхэд ЦДАШ-д ажиллаж байгаа бригадыг ажлын байрнаас гаргахгүй байхыг зөвшөөрнө.

5.4. Мегометр ба цахилгаан хэмжүүрийн багажтай ажиллах

758. Мегомметрээр тусгаарлагчийн эсэргүүцлийг хэмжихээс бусад хэмжилтийг тусгайлан сургасан IV-өөс доошгүй групптэй ажилтан гүйцэтгэнэ.

759. Мегомметрээр тусгаарлагчийн эсэргүүцлийг хэмжих ажлыг III групптэй тусгайлан сургасан ажилтан гүйцэтгэж болно.

760. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид энэ дүрмийн 152-т зааснаас бусад тохиолдолд нарыдаар, 1000 В хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламж болон хоёрдогч хэлхээнд шийдвэрээр хэмжих ажлыг гүйцэтгэнэ.

761. Мегомметрээр тусгаарлагчийн эсэргүүцлийг хэмжих ажлыг гүйдэл дамжуулах хэсгийн хүчдэлийг таслаад урьдчилан газардуулж цэнэгийг шавхсаны дараа хийнэ.

762. Мегомметрийг холбосны дараа л гүйдэл дамжуулах хэсгээс газардуулгыг салгана.

763. Мегомметрээр гүйдэл дамжуулах хэсгийн тусгаарлагын эсэргүүцлийг хэмжих үед холболтын утсыг тусгаарлах штангаар холбох ба 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид резинэн бээлий заавал хэрэглэнэ.

764. Мегомметрээр ажиллах үед түүнтэй холбосон гүйдэл дамжуулах хэсэгт хүрэхийг хориглоно.

765. Ажил дууссаны дараа гүйдэл дамжуулах хэсгийг түр газардуулах замаар үлдэгдэл цэнэгийг шавхана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХҮЧДЭЛТЭЙ НӨХЦӨЛД
ТУСГААРЛАГЧИЙГ УГААХ БА ЦЭВЭРЛЭХ

766. Цахилгаан байгууламжийн ил задгай орчинд байрлах хэлхмэл тусгаарлагчид, тулгуурын тусгаарлагч, тоног төхөөрөмжийн шаазан тусгаарлагчийг хүчдэлийг нь таслалгүйгээр шүршиж угааж болно. Энэхүү ажлыг тухайн байгууллагын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, аюулгүй ажиллагааны зааврын дагуу гүйцэтгэнэ.

767. Шүршиж байгаа усны цацрагийн урт нь 6 дугаар хүснэгтэд зааснаас багагүй байна.

Хүснэгт № 6

Шүршигч хошууны нүхний голч(мм)	Цахилгаан байгууламжийн хүчдэлийн түвшин ба усны цацрагийн зөвшөөрөгдөх хамгийн бага урт (м)				
	10кВ хүртэл	35кВ	110-150кВ	220кВ	330кВ
10	3.0	4.0	5.0	6.0	7.0
12	3.5	4.5	6.0	8.0	9.0
14	4.0	5.0	6.5	8.5	9.5
16	4.0	5.0	7.0	9.0	10.0

768. Ус дамжуулах хоолой, сунадаг шаттай машин, шат ба устай савыг шүршиж угаах үед газардуулсан байх ёстой.

769. Сунадаг шаттай машин хэрэглэж угаах үед шүрших хоолойн хошууг өргөх тавцангийн хашлага ба автомашины их биетэй 25 мм²-аас багагүй хөндлөн огтлолтой уян зэс утсаар холбосон байх ёстой.

770. Газар дээрээс, эсвэл сунадаг шаттай машин, авто машин болон зориулалтын төмөр талбай ашиглаж угаах үед туршигдсан резинэн бээлий хэрэглэнэ.

771. Газар дээр зогсож угаалга хийх үед угаалгад ашиглаж байгаа машин механизмд хүрэх, машины бүхээг болон тэвшиндгарч орохыг хориглоно.

772. Угаалгад хэрэглэж байгаа машин механизмд гадны хүн ойртуулахгүй байх арга хэмжээг урьдчилан авсан байна.

773. Шүршиж байх үед ус дамжуулах хоолойг зөөхийг хориглоно.

774. ХХБ-ийн гүйдэл дамжуулах хэсгийн хүчдэлийг таслалгүйгээр тусгаарлагчийг цэвэрлэх ажлыг зориулалтын штанганд бэхэлсэн тусгай сойз, эсвэл хөндий хоолойтой тусгаарлах штанг бүхий хошуутай тоос сорогч ашиглан гүйцэтгэнэ.

775. Цэвэрлэгээг шалан дээр зогсож, эсвэл тогтвортой суурилуулсан тавцан дээр байрлаж хийх ёстой.

776. Гүйдэл дамжуулах хэсгийн хүчдэлийг таслалгүйгээр тусгаарлагчийг цэвэрлэх үед резинэн бээлий заавал хэрэглэнэ.

777. Штангийг хэрэглэхийн өмнө тусгаарлах хэсгийн гадаргын тоосыг цэвэрлэсэн байх ба тоос сорогч ашиглах үед хошууны хөндийн тоосыг үе үе цэвэрлэж байвал зохино.

778. Тусгаарлагчийг цэвэрлэх үед фаз хооронд богино холбоо үүсгэхгүйн тулд хөндий хоолойтой тусгаарлагч штангийн үзүүрт суулгах сорох хошууг тусгаарлагч материалаар хийсэн байх ёстой.

779. Хүчдэлтэй нөхцөлд тусгаарлагчийг цэвэрлэх ажлыг гүйцэтгэж байгаа аргаас нь үл хамаарч хоёр хүн нарыдаар гүйцэтгэнэ.

780. Хүчдэлтэй нөхцөлд тусгаарлагчийг цэвэрлэх ажлыг IV-өөс доошгүй групптэй ажил гүйцэтгэгчийн хяналтан дор III групптэй ажилтан гүйцэтгэнэ. Эдгээр ажилтан нь уг ажлыг гүйцэтгэх сургалтанд хамрагдаж, дасгал сургуулилт хийж шалгалт өгсөн байх ба группын үнэмлэхийн “Олгосон эрх (Ажил)” гэсэн мөрөнд “Хүчдэлтэй нөхцөлд тусгаарлагч цэвэрлэх” гэж бичсэн байх ёстой.

781. ХХБ-д тусгаарлагч цэвэрлэх ажлыг цэвэрлэх багаж хэрэгслээр чөлөөтэй ажиллаж болох хангалттай зай талбай бүхий орчинд шал буюу тавцан дээр байрлаж гүйцэтгэнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. ДИСПЕТЧЕРИЙН БА ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГЫН ХЭРЭГСЭЛ

7.1. Ерөнхий шаардлага

782. Энэхүү бүлгийн заалтуудыг холбооны агаарын ба кабель шугам, эрчим хүчний барилга байгууламж дахь холбооны зангилгаа ба сүлжээ, диспетчерийн ба

технологийн удирдлагын тоног төхөөрөмж хэрэгсэл, холбооны төхөөрөмж, цахилгаан дамжуулах агаарын шугам дахь өндөр давтамжийн холбоо, шилэн кабель, реле хамгаалалт, телемеханикийн байгууламж, телевизийн байгууламж, тооцоолон бодох төхөөрөмжид ажил гүйцэтгэх үед мөрдөнө.

783. Энэ дүрмийн 88-д заасан болон дор дурьдсан тохиолдолд ажлын удирдагч заавал томилоно. Үүнд:

- Цамхагтай огтлолцол байгуулах, төгсгөлийн болон эргэлтийн тулгуур солих;
- ХКШ-ыг турших;
- Байнгын үйлчлэгчгүй өсгөх цэгт ажиллах;
- Газардуулгын хутгыг залгаагүй үед шүүлтүүрийг задлахгүйгээр холболтын шүүлтүүрт үзлэг хийхээс бусад ажил гүйцэтгэх;

784. Наряд олгогч нь шаардлагатай тохиолдолд дээр дурьдсанаас бусад ажилд ажлынуудирдагч томилж болно.

785. Хэрэв ажлын байр бэлтгэхэд таслах, залгах аппаратаар үйлдэл хийхгүй бол ажлын удирдагч эсвэл ажил гүйцэтгэгч нь диспетчерийн ба технологийн удирдлагын хэрэгсэл (ДБТУХ)-ийн төхөөрөмжид ажилд оруулагчийн үүргийг хавсран гүйцэтгэж болно. Энэ тохиолдолд ажил гүйцэтгэгчид хайламтгай хамгаалуур (гал хамгаалагч)-ыг авах, бригадын гишүүний хамт зөөврийн газардуулга тавихыг зөвшөөрнө.

786. ДБТУХ-ийн төхөөрөмжид энэ дүрмийн 2.3 дугаар хэсэгт дурьдсан болон дараах ажлуудыг шийдвэрээр гүйцэтгэж болно. Үүнд:

- Цахилгаан дамжуулах шугам ба радио нэвтрүүлгийн 1 дүгээр ангиллын шугамын нөлөөлөлд ороогүй, хүчдэлийг нь тасалсан ХАШ, ХКШ дээр гүйцэтгэх ажил;
- Байнгын үйлчлэгчгүй өсгөх цэгийн аппаратууд ба ХБ-д байрлуулсан хэт өндөр давтамжийн аппаратуудаас бусад ДБТУХ-ийн төхөөрөмжийн засвар, угсралт, тохируулгын ажил, холбооны өндөр давтамжийн сувгийн холболт ба боловсруулах элементүүдэд гүйцэтгэх ажил;

787. ХБ-ийн дэвсгэр газарт байрласан ДБТУХ-ийн байгууламж дээр хийгдэх ажлыг дүрмийн 134-136-д заасны дагуу зохион байгуулах ёстой.

788. ХБ-ийн гадна ЦДАШ-д тавьсан өндөр давтамжийн хаалт (заградитель) дээр хийх ажлыг ЦДАШ-ыг ашиглалтыг хариуцсан байгууллагын олгосон нарядын дагуу гүйцэтгэнэ.

7.2. Холбооны кабель шугам

789. Холбооны кабель шугам (ХКШ)-д өндөржүүлсэн хүчдэлээр туршилт хийх үед туршиж байгаа хэсгээ хязгаарлаж туршилтад ороогүй хэсэгт туршилтын хүчдэл бий болгохгүйн тулд тэдгээрийн хоорондох бүх холбоосыг авсан буюу тайлсан байх ёстой.

790. ХКШ-ын тусгаарлагчийн цахилгааны бөх батыг туршиж байгаа үед уг кабелийн хоёр үзүүрт байгаа ажилтнууд холбооны хэрэгслээр хоорондоо мэдээлэл солилцох бололцоотой байх ёстой.

791. ХКШ-ыг туршиж эхлэх хүртэл уг кабелийн алсын төгсгөлд байгаа телефон аппаратыг судал тус бүрээр нь тусгаарлах конденсатороор (0,1мкФ багтаамжтай 5-6 кВ хүчдэлийн) дамжуулан холбосон байх ёстой.

792. Телефон аппарат, конденсаторыг ухсан нүх болон худагнаас гадна байрлах тусгаарлагч резинэн дэвсгэр дээр тавьсан модон тавцан дээр байрлуулсан байна. Телефон яриаг кабель дээр туршилтын хүчдэлгүй үед зөвхөн ажлын удирдагчийн дуудлагаар хийх ёстой.

793. Туршилт хийж байх үед телефон аппарат болон түүний холболтын утаснуудад хүрэхийг хориглоно.

794. Кабельд туршилт хийж байх үед ажлын удирдагчийн телефон аппарат салгагдсан байх ба туршилт дуусч, кабелиас цэнэгийг шавхсаны дараа л телефон аппаратыг кабельд холбоно.

795. Кабельд туршилтын хүчдэл өгөхөөс өмнө туршилт эхэлж кабельд хүчдэл өгөх гэж байгаа тухай ажлын удирдагч телефон утсаар бригадын гишүүдэд мэдээлэх ёстой.

796. Туршилтын үед холбооны кабелийн бокс, кабелийн задалсан төгсгөлд ямар нэгэн сэлгэн залгалт хийх мөн кабельд хүрэхийг хориглоно.

797. Хэмжүүрийн багаж төхөөрөмж, түүний металл хайрцгийг ажил эхлэхийн өмнө заавал газардуулах ба хэмжилтийн ажил бүрэн дууссаны дараа салгана.

798. Цахилгаанжуулсан төмөр замын хувьсах гүйдлийн цахилгаан хангамжийн аюултай нөлөөллийн бүсэд байгаа ХКШ-д хэмжилт хийх үед заавал хамгаалах хэрэгсэл ашиглах ёстой.

* “аюултай нөлөөллийн бүс” гэдгийг цахилгаанжуулсан төмөр замын дүрэмд зааснаар ойлгоно.

799. Кабелийг зэврэлтээс хамгаалах төхөөрөмжид залгах, төөрмөл гүйдлийн эх үүсвэрт хамгаалах төхөөрөмж залгах, катодын төхөөрөмж дээр хүчдэлийг таслалгүй гүйцэтгэх ажлын үед резинэн бээлийтэй ажиллах ёстой.

800. Дренажийн байгууламжийн засварын ажлыг контактын шугам сүлжээ ба кабелийн талаас хүчдэлийг нь таслан дренажийн кабелийг цахилгаанжсан төмөр замын талаас нь газардуулсны дараа гүйцэтгэхийг зөвшөөрнө.

801. Илүүдэл даралттай тоног төхөөрөмж агуулдаг холбооны кабелийн ашиглалтыг даралтат савыг төхөөрөмжлөх ба ашиглах аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу явуулах ёстой. Эдгээр тоног төхөөрөмж дээр кабелийн хүчдэлийг салгаж ажлын байр бэлтгэсний дараа шийдвэрээр ажил гүйцэтгэж болно. Тоног төхөөрөмжийг хүчдэлээс салгаснаас хойш 15-аас доошгүй минутын дараа хатаалтын ба автоматикийн блокоос самбар тайлах, ажил гүйцэтгэж эхлэхийг зөвшөөрнө. Ажиллах үедээ тусгаарлах дэвсгэр хэрэглэнэ.

802. ХКШ-д дор дурьдсан ажил гүйцэтгэх үед байнгын үйлчлэгчгүй өсгөх цэгийг алсаас тэжээдэг тогтмол ба хувьсах гүйдлийн тэжээлийг тасална. Үүнд:

- Кабель угсрах, салгах, зөөх;
- Телефон холбооны гэмтлийг засах;
- Кабельд хэмжилт хийх;

803. Холбооны кабель шугамын газар доорх байгууламжид хийх ажлыг энэ дүрмийн 4.14.5-т заасны дагуу гүйцэтгэнэ.

7.3. Байнгын үйлчлэгчгүй өсгөх цэгийн тоноглолд ажиллах

804. Байнгын үйлчлэгчгүй өсгөх цэг (БҮӨЦ)-ийн алсын тэжээлийн хүчдэлийг ДБТУХ-ийн жижүүрийн захиалгаар тасална. ДБТУХ-ийн жижүүр нь байнгын үйлчлэгчтэй өсгөх цэгийн жижүүрт захиалгаа өгөх ёстой. Уг захиалгад кабелийн нэр, алсын тэжээлийн хэлхээний дугаар, ажиллах хэсэг, ажлын шинж байдал, эхлэх дуусах хугацаа, алсын тэжээлийн төрөл, ажлын удирдагчийн овог нэрийг заасан байна.

805. БҮӨЦ-ийн жижүүр нь эрх бүхий хүнээс зөвшөөрөл авсны дараа БҮӨЦ-ийн алсын тэжээлийг таслана.

806. Алсын тэжээлийн хүчдэлийг тасалсан түлхүүр ба товчлуурууд дээр “Бүү залга! Шугаман дээр хүнтэй” гэсэн плакат өлгөнө.

807. Таслалтыг алсын тэжээлийн дамжуулалтын хэлхээнд байгаа холбоосыг тайлах, хайламтгай хамгаалуур болон бусад хэсгийг авах зэргээр харагдахуйц байдлаар хийвэл зохино. Энэ үед резинэн бээлийтэй ажиллах ёстой.

808. Ажлын удирдагч нь БҮӨЦ-т ажил гүйцэтгэх зөвшөөрөл авсны дараа засвар хийх шаардлагатай кабелийг тодорхойлж, хүчдэл байгаа эсэхийг шалгаж, цэнэггүй болгоно. Энэ ажиллагааг нүүр хамгаалах хэрэгсэл, бээлийтэй гүйцэтгэнэ.

809. БҮӨЦ-ийн кабельд хийх ажлын аюулгүй байдлыг дээшлүүлэхийн тулд алсын тэжээлийн хэлхээнд нэмэлт тасархайнууд гаргах хэрэгтэй.

810. Ажлын удирдагч нь аюулгүй байдлын бүх арга хэмжээг авсны дараа БҮӨЦ-ийн кабельд бригадыг ажилд оруулна.

811. Аж ахуйн нэгж, байгууллага бүр нь алсын тэжээлтэй бүх тоноглолын жагсаалтыг гаргаж, түүн дээр үйлчилгээ хийдэг ажилтнуудад танилцуулсан байх ёстой.

812. БҮӨЦ-т хийгдэх ажлыг нарыаар гүйцэтгэх бөгөөд ажил гүйцэтгэгч нь IV-өөс доошгүй групптэй, бригадын гишүүд нь III-аас доошгүй групптэй байна.

813. Байнгын агааржуулагчгүй БҮӨЦ дахь камеруудыг ажлын эхэнд болон ажлын явцад агааржуулж байх зайлшгүй шаардлагатай. Ажил гүйцэтгэх явцад камерийн хаалга нээлттэй байх ба агааржуулагчтай БҮӨЦ-т ажиллах үед агааржуулагчийн сувгууд нээлттэй байх ёстой.

814. Алсын тэжээлийн аппаратад туршилт хийхийн өмнө бүх БҮӨЦ ба байнгын үйлчлэгчтэй өсгөх цэгийг хооронд нь холбооны хэрэгслээр хангасан байх ёстой.

815. Аппаратаас тусгаар хавтанг салгаж авахдаа зөвхөн ажлын удирдагчийн зөвшөөрлөөр алсын тэжээлийн хүчдэлийг салгасны дараа гүйцэтгэнэ.

816. Хүчдэлтэй байгаа БҮӨЦ-ийн тоноглолд засвар үйлчилгээ хийхийг хориглоно.

7.4. Холбооны агаарын шугам

817. Цахилгаанжуулсан төмөр зам, трамвай, троллейбусны авцалдаа (контакт)-ны шугам сүлжээтэй огтлолцсон, хөндлөн гарсан холбооны агаарын шугам (ХАШ)-ын утсыг засварлах, хөндлөн огтлолцлыг зохион байгуулах ажлыг авцалдааны сүлжээний хүчдэлийг таслаж ажлын байранд газардуулга тавьсан нөхцөлд уг шугам сүлжээний ашиглагч байгууллагын төлөөлөгчийн оролцоотойгоор урьдчилан боловсруулсан ажил гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ёстой.

818. ЦДАШ-тай огтолцуулан холбооны шугамын утас татах үед гудамжинд зорчих хүн ба тээврийн хэрэгсэлд урьдчилан анхааруулга өгөх зорилгоор дарцаг барьсан дохиочдыг ажиллуулах ёстой.

819. ЦДАШ-ын доогуур, эсвэл дээгүүр татсан холбооны утсыг чангалах ба тохируулах үед энэ дүрмийн 4.15.4-т заасан шаардлагыг биелүүлэх ёстой.

820. Ажил эхлэхийн өмнө ХАШ-ын утаснуудад (утас-газар хооронд) 24 В-оос илүүгүй хүчдэл байгаа эсэхийг шалгах шаардлагатай. ХАШ-ын утаснуудад 24 В-оос их хүчдэл илэрвэл хүчдэл бий болсон шалтгааныг тогтоож 24 В хүртэл бууруулахаас нааш ажил эхлүүлэхийг хориглоно.

821. Нөлөөллийн хүчдэлтэй байгаа ХАШ-д ажиллах үед энэ дүрмийн 4.15.5-д заасан шаардлагыг биелүүлэх ёстой.

822. Нөлөөллийн хүчдэлтэй байгаа ХАШ-ын утсыг дренажийн ороомгоор дамжуулан зөөврийн газардуулга тавих зориулалтын штангаар газардуулна.

823. Нөлөөллийн хүчдэлтэй байгаа ХАШ-д ажиллах үед сунгаж байгаа буюу угсарч байгаа утсыг алгасалтын эхэнд мөн ажлын байрны дэргэд газардуулна. Газар дээр байгаа утсыг шугамын болон дараачийн хэсгүүдэд сунгасан утастай шүргэлцүүлэхгүй байх ёстой.

824. Шинээр татаж, чангалж байгаа утасны унжилтыг тохируулах, бэхлэх ажлыг түрүүчийн хэсгийн утастай холбохоос өмнө гүйцэтгэх ёстой.

825. Тусгаар хэсгүүдийг хооронд нь холбохын өмнө холболт хийх газрын хоёр талд газардуулсан байх ёстой.

7.5. Радио ба радиорелейний шугам

826. Радио тоноглолууд дээр хийх ажлыг шийдвэрээр гүйцэтгэж болно. III-аас доошгүй групптэй нэг хүн үйлчилгээ хийж болох ба энэ үед ямар нэгэн засварын ажил гүйцэтгэхийг хориглоно.

827. 60 кГц-300 ГГц-ын зурвас бүхий давтамжтай цахилгаан соронзон орон дотор ажиллах үед холбогдох стандартын шаардлагыг биелүүлэх ёстой.

828. Өндөр давтамжийн аппарат тоноглолд тохируулга, туршилт хийхдээ цахилгаан гүйдэлд нэрвэгдэх болон өндөржсөн цахилгаан соронзон цацрагаас хамгаалах хэрэгслүүдийг ашиглах ёстой. Тухайлбал металлжуулсан шил бүхий нүдний шилийг ашиглана.

829. Антенн фидерийн төхөөрөмжийг угсрах, задлах, түүний гэмтлийг устгах, схемд өөрчлөлт оруулах ажлыг тэдгээрийн хүчдэлийг салгасны дараа хийнэ. Дор дурьдсан үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:

- Цахилгаан соронзон цацраг байгааг гар буюу биеийн хэсгийг халаах үйлчлэлээр тодорхойлох;
- Хамгаалах хэрэгслгүйгээр зөвшөөрөгдөх хэмжээнээс их нягтралтай энерги бүхий цацрагийн зурваст орох, байрлах;
- Цахилгаан соронзон цацрагийн үүсвэрийн халхавчийг гэмтээх;
- Ил задгай ажиллаж буй антенн фидерийн тоноглолын өмнө байх;

830. Антенн цамхагийн байгууламж дээрх гаднах антенн фидерийн тоноглолд угсралт, тохируулга, үйлчилгээний ажлыг IV, III групптэй ажилтнаас бүрдсэн бригад хийнэ. Ажил эхлэхийн өмнө өндөр давтамжийн тоноглолыг салгах ёстой.

831. Антенн цамхагийн байгууламжид ажиллах үед дараах шаардлагуудыг биелүүлэх ёстой. Үүнд:

- Антенн цамхагт авирч гарах ажилтан нь өндөрт ажиллах эрхтэй байх;
- Ажил эхлэхийн өмнө цамхагийн дохионы гэрэл болон антеннийн халаагуурын тэжээлийн хүчдэлийг салгаж “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна” гэсэн плакат өлгөх;
- Цамхагийн дохионы гэрлийн шилийг солих үед энэ дүрмийн 682-684-т заасныг мөрдөх;

7.6. ЦДАШ ба аянгын трос дээрх өндөр давтамжийн холбоо

832. 1000 В-оос дээш хүчдэлийн ЦДАШ ба ХБ-д байгаа өндөр давтамжийн холбоо (ӨДХ)-ны тоноглолд хийх засвар үйлчилгээ, тохируулгын ажлыг IV-өөс доошгүй групптэй нэг хүний хамт хоёроос доошгүй хүн гүйцэтгэх ёстой.

833. Өндөр давтамжийн хаалт (заградитель)-ын гүйдэлгүй болсон гогцоо утас нөлөөллийн хүчдэлтэй байж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

834. Ажиллагатай байгаа ӨДХ-ны аппарат тоноглолын панель, блокийг онгойлгож хийх ажлыг зохих хамгаалах хэрэгсэл ашиглаж III-аас доошгүй групптэй нэг хүн гүйцэтгэхийг зөвшөөрнө.

835. Ажил эхлэхийн өмнө өндөр давтамжийн шугамын холболт дээр хүчдэл байхгүй эсэхийг шалгана.

836. Өндөр давтамжийн шугамын холболт дээр 24 В-оос дээш хүчдэлтэй бол ажиллахыг хориглоно.

837. Өндөр давтамжийн гүйдэл дамжуулах элементүүдийн схемд өөрчлөлт хийх, задаргаа ба цуглуулга хийх, гэмтлийг устгах ажлыг зөвхөн ЦДАШ-ын холболтын хүчдэлийг салгасны дараа хийнэ.

838. Кабель ба холболтын шүүлтүүр дээр ажиллах үед холбооны конденсаторын доод ялтастай газардлагын хутгыг залгана.

839. Холбооны конденсаторын доод ялтсыг газардуулалгүйгээр ЦДАШ-д залгагдсан өндөр давтамжийн тоног төхөөрөмжийн хамгаалах төхөөрөмж, бусад эд ангиудаас газардуулагч утаснуудыг салгахыг хориглоно.

840. Газардлагын хутгын тусламжтайгаар холбооны конденсаторын доод хэсгийн ялтсыг газардуулсны дараа зөвхөн холбооны конденсатор ба холболтын шүүлтүүр хоёрын хоорондох хэлхээнд хэмжүүрүүдийг залгах ба салгахыг зөвшөөрнө.

841. Хэмжүүрийн багажаар хэмжилт хийх бүрт конденсаторын доод хэсгийн ялтсыг газардуулна.

842. Шуурхай ажиллагааны IV-өөс доошгүй групптэй хүний хяналтан дор IV групптэй нэг хүн шийдвэрээр 1 цагаас илүүгүй хугацаанд хэмжилт хийж болно. Энэ хэмжилтүүдийг зөвхөн холболтын шүүлтүүр дотор холбооны конденсаторын доод ялтасны газардуулгын хутга тасархай үед цэнэг шавхуурыг таслалгүйгээр гүйцэтгэнэ. Энэ үед хэмжүүрийн багажуудыг газардуулсан байх ёстой.

843. Хэмжилтийг хамгаалах хэрэгсэл (резинэн бээлий, бойтог, тусгаарлагч бариултай багаж) ашиглан гүйцэтгэнэ.

844. Нэг цагаас илүү хугацаанд үргэлжлэх хэмжилтийн ажлыг нарыдаар гүйцэтгэнэ.

7.7. Зөөврийн өндөр давтамжийн холбоо

845. Зөөврийн өндөр давтамжийн холбооны тоноглолыг угсрах ба буулгах ажлыг IV групптэй нэг, бусад нь III групптэй нийт хоёроос доошгүй хүнтэй бригад гүйцэтгэнэ.

846. Антенныг ЦДАШ-ын доод талын утаснаас 110 кВ ба түүнээс доош хүчдэлд 3 метр, 220 кВ-ын хүчдэлд 4 метрээс багагүй зайд байхаар шугамын тулгуурт бэхэлнэ.

847. Антеннийн унжилт ЦДАШ-ын утасны унжилтаас их байх ёстой.

848. Антенныг зүүхийн өмнө антенны ороомогтой бүхээг (пост)-ийг тулгуурт 1-1,5 метр өндөрт бэхлээд газардуулсан байх ёстой. Бүхээгт орж байгаа антенны төгсгөлийг бүхээг доторх дросселиор дамжуулан мөн дроссельтой зэрэгцээ холбоотой газардуулгыг дамжуулан газардуулна. Дроссельтой зэрэгцээ 1 кВ-ын цэнэг шавхагчийг залгасан байх ёстой. Антенныг угз таталгүй алгуур татаж чангалбал зохино.

849. Антеннын утсыг дээш өргөх буюу буулгах үед нэг алгасалтын дунд хэсэгт трассаас хол зогсоод антеннын утас нь хүчдэлтэй байгаа ЦДАШ-ын утсанд энэ дүрмийн 846-д зааснаас дотогш зайд ойртохоос сэргийлэн хянаж байвал зохино. Энэ үед антеннын утасны доор байрлахыг хориглоно.

850. Антеннын утсыг доош буулгахын өмнө газардуулгын хутга буюу зөөврийн газардуулга ашиглаж түүнийг газардуулсан байна.

7.8. ДБТУХ-ийн аппаратын байр

851. Цахилгаан станц, дэд станц болон үйлдвэрийн цахилгаан байгууламжийн аппаратын өрөөнд байрлуулсан холбооны болон радио нэвтрүүлгийн аппарат гэх мэтийг залгах, салгах, засварлах ажлыг III-аас доошгүй групптэй нэг хүн гүйцэтгэж болно.

852. Холбооны кабель ба агаарын шугамын оруулгын ба оруулга туршилтын суурь, алсын тэжээлийн суурь, хүчдэл тохируулах автомат болон гүйдэл хуваарилах тоноглолын суурийн өмнөх шалан дээр тусгаарлах резин дэвсгэр буюу тусгаарлах тавцан тавьсан байх ёстой.

853. Алсын удирдлагын тэжээл авч байгаа тоног төхөөрөмж дээр хүчдэлтэй болохыг анхааруулсан тэмдэг тавих ёстой.

854. Реле ба илрүүлэгчийн авалцааг тэдгээрийн хүчдэлийг тасалсны дараа цэвэрлэнэ.

855. Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээг хийхдээ ил задгай металл бүхий багс, тоос сорогчийн металл хошуу, хоолой гэх мэтийг ашиглахыг хориглоно.

856. Ламп солих ажлыг аппаратын хүчдэлийг тасалсны дараа хийх ёстой. 250 В хүртэл хүчдэлийн лампыг цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглан хүчдэлтэй байхад солихыг зөвшөөрнө.

857. Оруулга туршилтын суурьт залгаастай холбооны шугам болон кроссын хамгаалалтын бүсэд цахилгаан дамжуулах шугам, алсын тэжээлийн аппарат зэргээс 24 В-оос дээш гадны хүчдэл орж ирвэл жижүүрийн ажилтан тийм хүчдэлтэй болсон шугамын хүчдэлийг цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглан таслаад түүнийг тусгаарлах ёстой. 24 В-оос дээш хүчдэл бий болсон тухай тухайн объектын шуурхай ажиллагааны ажилтанд мэдэгдэх ба түүнийг байхгүй бол дээд шатны ажилтанд мэдэгдэх ёстой.

858. Зөвхөн гадны хүчдэл байхгүй үед л цэнэг шавхагч болон хайламтгай хамгаалуурыг солихыг зөвшөөрнө.

859. Цахилгаан дамжуулах шугам ба цахилгаанжсан төмөр замын нөлөөлөлд байгаа холбооны шугамын аппарат дээр ажиллах үед шугамын хамгаалах тоноглолыг солихдоо резинэн дэвсгэр дээр зогсож, резинэн бээлий, тусгаарлах бариултай бахь, нүүрэвч хэрэглэнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ. РЕЛЕ ХАМГААЛАЛТ, АВТОМАТИКЫН ТӨХӨӨРӨМЖ, ХЭМЖҮҮР, ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТООЦООНЫ ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛ, ХОЁРДОГЧ ХЭЛХЭЭ

860. Хэмжүүр, хэмжих хэрэгсэл ба реле хамгаалалт, автоматик (РХА)-ын хэлхээнд ажил гүйцэтгэх үед аюулгүй байдлыг хангах зорилгоор гүйдэл, хүчдэлийн трансформаторын хоёрдогч хэлхээг газардуулсан байх ёстой.

861. Реле хамгаалалтын нарийн нийлмэл бүдүүвчтэй хэмжүүрийн трансформаторуудын цахилгаан холбоо бүхий хоёрдогч ороомгуудыг нэг цэгээр газардуулахыг зөвшөөрнө.

862. Хэмжүүр, хэмжих хэрэгсэл ба РХА-ын гүйдлийн хэлхээг салгах шаардлагатай үед гүйдлийн трансформаторын хоёрдогч ороомгийн хэлхээг зориулалтын хавчаар дээр эсвэл туршилтын блок дээр урьдчилан богино холбож өгнө.

863. Гүйдлийн трансформатор ба богино холбосон утасны хооронд гүйдлийн хэлхээг салахад хүргэхүйц ажил гүйцэтгэхийг хориглоно.

864. Хүчдэлийн трансформаторын хоёрдогч ороомог болон түүнд холбосон тоног төхөөрөмжид хүчдэл өгөх шаардлагатай үед трансформаторын бусад ороомогоор дамжин хүчдэл тархах бүх боломжийг хаасан байх ёстой.

865. Реле хамгаалалт, автоматикийн төхөөрөмжийн ажиллагаа (түүний дотор сэлгэн залгалтын аппаратыг тасалж, залгах)-г шалгах, туршихдаа энэ дүрмийн 161-т заасныг мөрдөнө.

866. Реле хамгаалалт, автоматикийн төхөөрөмжид үйлчилгээ явуулдаг IV-өөс доошгүй групптэй ажил гүйцэтгэгчид ажилд оруулагчийн үүргийг хавсран гүйцэтгүүлж болно. Энэ тохиолдолд ажил гүйцэтгэгч нь ажлын байр бэлтгэхэд шаардлагатай аюулгүй ажиллагааны бүх арга хэмжээг тодорхойлох ёстой.

867. 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид ажлын байр бэлтгэхэд таслалт хийх, газардуулга болон хаалт хашилт тавих шаардлагагүй тохиолдолд ажил гүйцэтгэгч, ажилд оруулагчийн үүргийг нэг хүнд хавсруулан гүйцэтгүүлж болно.

868. Хэрэв РХА-ийн төхөөрөмжүүд нь 1000 В-оос дээш хүчдэлийн гүйдэл дамжуулах хэсэг байхгүй өрөө тасалгаа, хуваарилах байгууламжид байрласан, эсвэл тэдгээр нь хаалт хашилтаар бүрэн тусгаарлагдсан, хаалт хашилт тавих шаардлагагүй өндөрт байрласан байвал IV-өөс доошгүй групптэй ажил гүйцэтгэгч ганцаараа, мөн III-аас доошгүй групптэй бригадын гишүүд (энэ дүрмийн 124-т заасан нөхцөлд) реле хамгаалалт автоматикийн төхөөрөмж, хоёрдогч хэлхээнд бие биеэсээ тусдаа ажил гүйцэтгэж болно.

869. Эрчим хүчний тооцооны хэмжих хэрэгсэлтэй холбоотой ажлыг хүчдэлийг нь тасалсны дараа гүйцэтгэнэ.

870. Нэг фазын тоолуурын хэлхээнд тодорхой нэр төрлийн ажлыг эрчим хүчээр хангагч байгууллагын III-аас доошгүй групптэй ажилтан хүчдэлийг бүрэн тасалж, ашиглалтын явцад хийгдэх ажлын жагсаалтын дагуу ганцаараа гүйцэтгэж болно.

871. Хэрэв нэг фазын тоолуур хүртэл таслах аппарат байхгүй тохиолдолд аюул багатай, хуурай орчинд уг ажлыг хүчдэлийг нь таслалгүй гүйцэтгэж болно. Харин ачааллыг заавал тасалсан байна. Энэ үед резинэн бээлий, нүүрэвч хэрэглэнэ.

872. Энэ дүрмийн 869-871-т заасан ажлыг гүйцэтгэх заагийг цахилгаан эрчим хүчээр хангах гэрээнд заасан байна.

873. Эрчим хүчээр хангагч байгууллага тооцооны хэмжих хэрэгсэлд гүйцэтгэх ажлын технологийн карт, зааврыг ажилбар бүрээр боловсруулж батлуулсан байх ёстой.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ДУЛААНЫ АВТОМАТИК, ХЯНАХ ХЭМЖҮҮР БА ХАМГААЛАЛТЫН(ДАХХХ) ЦАХИЛГААНЫ ХЭСЭГ

874. Дүрмийн энэ бүлгийн шаардлагыг дулааны автомат, хянах хэмжүүр ба хамгаалалт (ДАХХХ), мөн удирдлагын автомат системийн цахилгааны хэсэгт ажиллахад мөрдөнө.

875. Дулааны автомат, хянах хэмжүүр ба хамгаалалтын дулаан механикийн хэсгийн үйлчилгээний үед аюулгүй ажиллах арга хэмжээг “Цахилгаан станц ба дулааны шугам сүлжээний дулаан механикийн тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрэм”-д тусгасны дагуу авна.

876. ДАХХХ-ын тоноглолын удирдлагын самбар, хуваарилах щит ба цуглуулга дээр таслах залгах аппаратаар хийх үйлдлийг шийдвэрээр IV-өөс доошгүй групптэй шуурхай ажиллагааны ажилтан эсвэл нарыдаар шуурхай үйлчилгээ-засварын III-аас доошгүй групптэй ажил гүйцэтгэгч хийнэ. Наряд олгогч нь нарядын “Тусгай заалт” мөрөнд таслах залгах аппаратаар хийх үйлдэлийн тухай бичсэн байна.

877. Хэрэв шийдвэрээр ажил гүйцэтгэж байгаа бол шийдвэрийг бүртгэх журналд бүртгэсэн байна.

878. Цахилгаан ба дулааны ачаалалд нөлөөтэй ДАХХХ-ын тоноглолын цахилгаан тоног төхөөрөмжийн хүчдэлийг таслах ажиллагааг станцын ээлжийн дарга буюу технологийн цехийн даргаас зөвшөөрөл (шийдвэр) авсны дараа гүйцэтгэнэ.

879. ДАХХХ-ын тоноглол дээр ажилд ороход технологийн тоног төхөөрөмжийн хэсгийг бэлтгэх ажлыг уг тоног төхөөрөмжийн шуурхай удирдлагыг хариуцдаг цех, хэсгийн шуурхай ажиллагааны ажилтан гүйцэтгэх ёстой.

880. Тохируулах автоматын засвар, зүгшрүүлэлт хийх явцад ДАХХХ-ын тоноглолын зангилаа, бүдүүвчийн хэсгүүд, тодорхой эд ангиудад сорилтын залгалт хийх, хүчдэл өгч шалгах ажлыг технологийн цех, хэсгийн ээлжийн ахлагчийн зөвшөөрөлөөр шуурхай ажиллагааны ажилтан гүйцэтгэнэ.

881. Тоног төхөөрөмжийн ажлын горим, технологийн бүдүүвчид өөрчлөлт оруулах шаардлагагүй ДАХХХ-ын тоноглолын засвар, тохируулга, зүгшрүүлэлт сорилтын ажлыг шийдвэрээр гүйцэтгэж болно.

882. Засварын үед ДАХХХ-ын тоноглолын тусгаар элемент, схемийн хэсэг буюу зангилгаанд хүчдэл өгч хийх сорилт шалгалтын ажлыг дор дурьдсан арга хэмжээг авсан нөхцөлд технологийн цех, хэсгийн ээлжийн ахлагчийн зөвшөөрөлтэйгээр шуурхай ажиллагааны ажилтан гүйцэтгэнэ. Үүнд:

- Засварын ажлыг зогсоосон байх;
- Сорилт хийж байгаа тоног төхөөрөмжөөс хүмүүсийг гаргаж холдуулсан байх;
- Хамгаалах газардуулга, хаалт хашилт ба плакатуудыг авсан байх;

883. Сорилтын үед зэргэлдээх хэсгүүдийн хүчдэлийг таслаж, сорилт хийх тоног төхөөрөмжөөс тусгаарлах хаалт хашилт тавьсан, ажиллагсадын аюулгүй байдлыг хангасан тохиолдолд тэнд ажилтнууд ажлаа үргэлжлүүлж болно.

884. Сорилтын үед цахилгаан тоног төхөөрөмжийг олон удаа залгах, салгахтай холбогдсон ажлыг тухай бүр шаардлагатай техникийн арга хэмжээг авч нарыадад завсарлага хийсэн тухай тэмдэглэхгүйгээр гүйцэтгэнэ.

885. ДАХХХ-ын тоноглолд шийдвэрээр III-аас доошгүй групптэй нэг хүн дор дурьдсан ажлыг гүйцэтгэж болно. Үүнд:

- Багажнуудын бичлэг хийх хэсгийн зүгшрүүлэлт;
- Манометр (цахилгаан контактаас бусад) дифманометр, термпарыг солих;
- Удирдлагын блок ба бүлэг шит дээрх дулааны хяналтын багажны гэмтлийг арилгах;
- Удирдлагын автомат системийн тооцоолон бодох техникийн иж бүрдлийг засварлах;
- Автомат тохируулагчийн электрон блокийн зүгшрүүлэлт, нарийвчлан тохируулах хэрэгслийн үзүүлэлтүүдийг шалгах;
- Хавчаарын хайрцагны нягтруулга хийх;
- Төрөл бүрийн панель, датчик, стендийн хаяг, бичиглэл хийх, төрөл ангийг тодорхойлох;
- Щит, панелиудыг даралттай агаараар үлээлгэх;

886. Цех, хэсэг болгонд байрлах ДАХХХ-ын тоноглолд гүйцэтгэх ажлыг тухайн ажлыг гүйцэтгэх гэж байгаа цехийн, хэсгийн ээлжийн дарга (шуурхай ажиллагааны ажилтан)-ын зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэх ёстой.

887. ДАХХХ-ын тоноглол дээр наряд, шийдвэрээр ажилд оруулагч нь тухайн технологийн цех, хэсэг, объектын III-аас доошгүй групптэй шуурхай ажиллагааны ажилтан байна.

888. Нутаг дэвсгэрийн хувьд алслагдсан газарт наряд, шийдвэрээр гүйцэтгэх ажлын ажилд оруулагч нь III-аас доошгүй групптэй шуурхай үйлчилгээ-засварын хүн байж болно.

889. Зөөврийн газардуулга тавих ба авах ажлыг ДАХХХ-ын цех, хэсгийн шуурхай ажиллагааны буюу шуурхай үйлчилгээ-засварын хүн гүйцэтгэнэ.

890. Цахилгаан цехийн үйлчилгээнд байдаг таслах залгах аппаратаар ДАХХХ-ын тоноглолын хүчдэлийг таслах ба энэ тасалсан аппаратын дэргэд газардуулга тавих ажлыг цахилгаан цехийн ажилтан гүйцэтгэх ёстой.

АРАВДУГААР БҮЛЭГ. ЗӨӨВРИЙН ЦАХИЛГААН БАГАЖ ХЭРЭГСЭЛ БА ГЭРЭЛ, ТУСГААРЛАХ ТРАНСФОРМАТОР

891. Зөөврийн цахилгаан багаж хэрэгсэл, гэрэл, гараар барьж ажиллуулдаг цахилгаан машин, тусгаарлах трансформатор болон бусад туслах тоног төхөөрөмж нь цахилгааны аюулгүй байдлыг хангасан, стандарт, техникийн нөхцөлийн шаардлагад нийцсэн байх ба энэ дүрмийн дагуу ашиглах ёстой.

892. Трансформатор, давтамжийн хувиргуур, хамгаалах таслалтын төхөөрөмж зэрэг туслах тоног төхөөрөмжийг цахилгаан сүлжээнд таслах ба залгах үйлдлийг тухайн цахилгаан сүлжээний ашиглагч байгууллагын III-аас доошгүй групптэй ажилтан гүйцэтгэнэ.

893. Галын болон тэсрэх аюултай ангилалд ордог өрөө тасалгаанд зөөврийн цахилгаан багаж хэрэгсэл, гараар барьж ажиллуулдаг 1 дүгээр ангиллын цахилгаан машиныг II групптэй хүн ажилуулж болно.

894. Зөөврийн цахилгаан багаж, цахилгаан машины ангилал нь тухайн өрөө тасалгааны зэрэглэл, ажлын нөхцөл, зарим тохиолдолд цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглаж ажил гүйцэтгэх зэрэгт тохирч байх ёстой. Эдгээр нөхцөлийг бүрдүүлэх шаардлагыг 7 дугаар хүснэгтэд тусгав.

Хүснэгт 7

Төрөл бүрийн ангиллын зөөврийн цахилгаан багаж, хэрэгслийг ашиглах орчин нөхцөлүүд

Ажлын байр	Цахилгаан машин, багажийн хамгаалалтын ангилал	Цахилгаан хамгаалах хэрэгсэл ашиглах нөхцөл
Аюулгүй байр	0	Наад зах нь цахилгааны 1 хамгаалах хэрэгсэл ашиглах
	I	TN-S системд- хамгаалах таслалтын төхөөрөмжөөр дайруулан залгагдсан үед цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглах шаардлагагүй, эсвэл наад зах нь цахилгааны 1 хамгаалах хэрэгсэл ашиглах TN-C системд -Наад зах нь цахилгааны 1 хамгаалах хэрэгсэл ашиглах
	II	Цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглах шаардлагагүй
	III	Цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглах шаардлагагүй
Аюултай байр	0	TN-S системд- наад зах нь цахилгааны 1 хамгаалах хэрэгсэл ашиглах ба хамгаалах таслалтын төхөөрөмжөөр дайруулан залгагдсан үед эсвэл ганц цахилгаан хэрэглэгчийг (машин, багаж) тодорхой нэг үүсвэрээс тэжээсэн үед (тусгаарлагч трансформатор, генератор, хувиргуур) TN-C системд -Наад зах нь цахилгааны 1 хамгаалах хэрэгсэл ашиглах ба зөвхөн нэг цахилгаан хэрэглэгчийг нэг үүсвэрээс тэжээсэн үед
	I	TN-S системд- цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглахгүй, хамгаалах таслалтын төхөөрөмжөөр дайруулан залгагдсан үед эсвэл зөвхөн нэг цахилгаан хэрэглэгчийг (машин, багаж) тодорхой нэг үүсвэрээс тэжээсэн үед (тусгаарлагч трансформатор, генератор, хувиргуур) TN-C системд -Наад зах нь цахилгааны 1 хамгаалах хэрэгсэл ашиглах
	II	Цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглах шаардлагагүй
	III	Цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглах шаардлагагүй
Онцгой аюултай байр	0	Ашиглахыг хориглоно
	I	Хамгаалах таслалтын төхөөрөмж хэрэглэх, эсвэл цахилгааны ямар нэг хамгаалах хэрэгсэл ашиглах

Онцгой таатай бус нөхцөл (хөдөлгөөн хязгаарлагдмал, гарахад болон явахад хүндрэлтэй худаг, сав, болон бусад битүү сав, байгууламж дотор ажиллах нөхцөл)	II	Цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглах шаардлагагүй
	III	Цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглах шаардлагагүй
	0	Ашиглахыг хориглоно
	I	Ашиглахыг хориглоно
	II	Наад зах нь цахилгааны 1 хамгаалах хэрэгсэл ашиглах. Хамгаалах таслалтын төхөөрөмжөөр дайруулан залгагдсан, эсвэл зөвхөн нэг цахилгаан хэрэглэгчийг тодорхой нэг үүсвэрээс тэжээсэн үед цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглахгүй
	III	Цахилгааны хамгаалах хэрэгсэл ашиглах шаардлагагүй

895. Аюултай болон онцгой аюултай өрөө тасалгаанд 12 В-оос илүүгүй хүчдэлийн зөөврийн гэрэл хэрэглэнэ.

896. Зөөврийн цахилгаан багаж хэрэгсэл, гэрэл, цахилгаан машинтай ажиллахдаа ажил эхлэхийн өмнө дараах үйлдлүүдийг хийнэ. Үүнд:

- Цахилгаан машин, багажны ангилал, зориулалтыг үйлдвэрлэгчийн паспортаар нь тогтоох;
- Цахилгаан машин, багажны бүрэн бүтэн байдал, эд ангиудын нь бэхэлгээний бөх батыг шалгах;
- Тэжээлийн кабель (утас), сэрээ залгуур, хамгаалалтын гуурс, багажны их биеийн тусгаарлага, бариул, сойз тогтоогчийн таглаа, хамгаалалтын бүрхүүл зэрэгт гадаад үзлэг хийн бүрэн бүтэн байдлыг магадлах;
- Залгуурын зөв сайн ажиллаж байгааг магадлах;
- Хамгаалалтын таслалтын төхөөрөмжийг шаардлагатай үед туршиж үзэх;
- Цахилгаан машин, багажны хоосон явалтыг шалгах;
- 1 дүгээр ангиллын цахилгаан машины газардуулгын хэлхээг (машины их бие, сэрээ залгуурын газардуулгын авцалдааг) шалгах;

897. Цахилгаан машин, багаж хэрэгсэл, гэрэлтүүлэг тэдгээрийн туслах тоноглол нь ямар нэгэн гэмтэлтэй эсвэл ээлжит шалгалт, туршилтанд ороогүй бол ашиглахыг хориглоно.

898. Цахилгаан машин, багаж, зөөврийн гэрлийн тэжээлийн утсыг (кабель) аль болох өндөрт дүүжилсэн байвал зохино. Тэжээлийн утас (кабель)-ыг халуун, чийглэг, тослог гадаргад хүргэх, шүргүүлэхийг хориглоно.

899. Утас (кабель)-ыг механик гэмтлээс хамгаалсан байх ёстой.

900. Кабелийг огцом нугалах, мушгих, сунгах болон дээр нь ачаа бараа тавих бусад кабель, хийн гагнуурын хоолой, тростой огтолцуулахыг хориглоно.

901. Зөөврийн цахилгаан багаж хэрэгсэл, гэрэл, цахилгаан машинд гэмтэл илэрвэл ажлыг яаралтай зогсооно.

902. Ажилд хэрэглэгдэж байгаа цахилгаан машин, зөөврийн багаж хэрэгсэл, гэрэлтүүлгийг батлагдсан нормын дагуу туршиж баталгаажуулсан байвал зохино.

903. Цахилгаан машин, зөөврийн багаж хэрэгсэл, гэрэлтүүлгийн туршилтыг ажил олгогчоос баталсан III-аас доошгүй групптэй ажилтан гүйцэтгэнэ.

904. Хүчдэл тасарсан болон ажлын завсарлагааны үеэр цахилгаан машин, зөөврийн багаж хэрэгслийг тэжээлээс салгасан байна.

905. Цахилгаан машин, зөөврийн багаж хэрэгсэл ашиглан ажил гүйцэтгэх үед дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:

- Цахилгаан машин, багаж хэрэгслийг бусдад түр хугацаагаар ч гэсэн өгөх;
- Цахилгаан машин, багаж хэрэгслийг задлах, ямар нэг засвар хийх;
- Цахилгаан машин, багаж хэрэгслийн тэжээлийн утас, кабелиас барих, татах, эргэлдэх хэсэгт хүрэх, тухайн машин, багаж хэрэгсэл бүрэн зогсоогүй байхад үртэс, зоргодсыг цэвэрлэх;

- Цахилгаан машин, багаж хэрэгслийн тэжээлийг бүрэн салгалгүйгээр түүний патронд өрөм, хутга, диск гэх мэт ажлын хэсгийг суулгах, бэхлэх, авах, түүнчлэн ямар нэгэн засвар тохиргоо хийх;
- Налуулж тавьсан шатан дээр зогсож ажиллах (бөх бат угсармал шат тавцан дээр байрлаж ажиллахыг зөвшөөрнө);
- Зуухны тогоо, төмөр торхон дотор зөөврийн трансформатор, давтамжийн хувьсгуур зэргийг оруулах;

906. Тусгаарлах трансформатор хэрэглэхэд дараах заалтуудыг мөрдлөг болгоно.

Үүнд:

- Трансформатораас зөвхөн ганцхан хэрэглэгчийг тэжээнэ;
- Трансформаторын хоёрдогч ороомгийг газардуулж болохгүй;
- Трансформаторын тэжээлийн сүлжээний саармагийн горимоос хамааруулан түүний их биеийг газардуулах буюу тэглэнэ. Энэ тохиолдолд тухайн трансформатораас тэжээгдэж байгаа цахилгаан хэрэглэгчийн их биеийг газардуулахгүй байж болно.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АЧАА ӨРГӨХ МАШИН МЕХАНИЗМ, АВТОМАШИН, ШАТ ХЭРЭГЛЭЖ АЖИЛЛАХ

11.1. Ерөнхий шаардлага

907. Ашиглалтад байгаа цахилгаан байгууламж, түүний хамгаалалтын бүсэд ачаа өргөх машин механизм ашиглан гүйцэтгэх ажлыг нарыдаар “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн дагуу гүйцэтгэнэ.

908. Өргөх машин механизмаар ачаа өргөж шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаа хариуцагч нь IV-аас доошгүй групптэй ИТА байх ёстой. Энэ үүргийг наряд олгогч эсвэл ажлын удирдагч хавсран гүйцэтгэж болно.

909. Өргөх машин механизмаар ачаа өргөж шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагааны хянагчийн үүргийг ажил гүйцэтгэгчид хариуцуулж болно.

910. Ажил гүйцэтгэгчид өргөх машин механизмаар ачаа өргөж шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаанд хяналт тавих даалгавар өгсөн тухай нарядын “Тусгай заалт” гэсэн мөрөнд бичсэн байх ёстой.

911. Ашиглалтад байгаа цахилгаан байгууламж, түүний хамгаалалтын бүсэд ажил гүйцэтгэх жолооч, кранчин, оосорлогч нар нь II-оос доошгүй групптэй байх ёстой. Гаднын аж ахуйн нэгж, байгууллагын болон иргэний өргөх машин механизмын машинчийг “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн шаардлагын дагуу ажилд оруулна.

912. ИХБ ба ЦДАШ-ын хамгаалалтын бүсэд автомашин, өргөх машин механизмыг шилжин явах, түүнчлэн суурилуулах ажлыг IV-өөс доошгүй групптэй шуурхай ажиллагаа, шуурхай үйлчилгээ-засварын ажилтан эсвэл ажлын удирдагчийн хяналтан дор гүйцэтгэнэ.

913. Ачаа өргөх машин механизм ЦДАШ-ын доогуур болон ИХБ-аар явж өнгөрөх үед тэдгээрийн өргөх ба сунадаг хэсэг нь тээвэрлэлтийн байдалд байх ёстой. Хэрэв үйлдвэрлэгчээс зөвшөөрөгдсөн бол ачаа өргөх машин механизмын ажлын хэсгийг өргөсөн байрлалтай боловч дээр нь хүн ба ачаагүй байх нөхцөлд ажлын байрны хүрээний дотор тэгшхэн газарт шилжин явахыг зөвшөөрнө. Энэ үед хүчдэлийг таслаагүй ЦДАШ-ын утас ба шинийн доогуур явахыг хориглоно.

914. ИХБ-д машин механизмын хөдөлгөөний хурдыг тухайн нөхцөлөөр тодорхойлогдох ба 10 км/ц-аас их байж болохгүй.

915. Ачаа өргөх машин, механизм, автомашин нь ЦДАШ-ын доогуур утасны унжилт хамгийн бага газраар (тулгуурын дэргэд) гарвал зохино.

916. Краныг газар дээр нь байрлуулах, ажиллуулахын өмнө ажлын удирдагч эсвэл ажил гүйцэтгэгч нь ажилд оруулагчийн хамт краны сумыг шилжүүлэх орон зайн хязгаарыг тогтоож, зориулалтын хэцээр хашилт хийж, өдрийн цагт дарцаг хатгах башөнийн цагт дохионы гэрлээр хангасан байх ёстой.

917. Хүчдэлтэй байгаа ЦДАШ-ын хамгаалалтын бүсэд өргөгч механизм, машин байрлуулах ба түүгээр ажил гүйцэтгэхийг хориглоно.

918. Ачаа өргөх машины ажлын хэсгийг тулгуур дээр нь байрлуулах ба тээвэрлэлтийн байрлалаас ажлын байрлалд оруулах ажлыг машинч нь гүйцэтгэнэ. Энэ ажлыг гүйцэтгэхэд бусад ажилтныг оролцуулахыг хориглоно.

919. Ачаа өргөх машин, механизм, автомашин явах, тэдгээрийг байрлуулах ба ажиллуулах үед мөн тэдгээрийн өргөх ба хөдөлгөөнт хэсэг, ачаа оосорлох хэрэгсэл, ачаа болон түүний татлагаас хүчдэлтэй гүйдэл дамжуулах хэсэг хүртэлх зай 1 дүгээр хүснэгтэд зааснаас багагүй байх ёстой.

920. Сунадаг цамхагт шаттай машин болон шингэн шахуургатай өргөгчийг ажиллуулахын өмнө түүний хөдөлгөөнт ба сунадаг хэсэг, сунадаг цамхагт шаттай машины өргөх хэсгийг эгц босоо байрлалд оруулж тэр байрлалд нь тогтоон бэхлэх хэрэгтэй.

921. Өнцгийн тулгуурын тусгаарлагч ба утас солих, арматур хийцийг засварлах үед шугамын эргэлтийн өнцгийн дотор талд сунадаг шаттай машин (шингэн шахуургат өргөгч)-ийг байрлуулахыг хориглоно.

922. ИХБ, ЦДАШ-ын хамгаалалтын зурвас дотор хүчдэлийг нь таслалгүйгээр хийх бүх төрлийн ажлын үед хийн дугуйт ачаа өргөх машин, механизм, автомашиныг газардуулсан байх ёстой.

923. Газардуулга тавихаас өмнө автомашины (ачаа өргөх машин механизмын) их биед хүрэх, мөн түүний ажлын хэсэг, ачаа оосорлох хэрэгсэл ба тулгуурын эд ангийг ямар нэг хэлбэрээр хөдөлгөж шилжүүлэхийг хориглоно.

924. Гинжит явах ангитай ачаа өргөх машин, механизмыг шууд газарт байрлуулсан үед түүнийг газардуулах шаардлагагүй.

925. Краны сум буюу өргөх механизм хүчдэлтэй гүйдэл дамжуулах хэсэгт шүргэсэн тохиолдолд ойр орчинд байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээгяаралтай авна. Энэ үед хүчдэлтэй болсон машин механизмд хүрэхийг хатуу хориглоно.

926. Ачаа өргөх машин, механизмын ажиллагааны үед өргөж байгаа ачаа, сунадаг цамхагт шаттай машины ажлын тавцангийн дор байрлах, мөн татаж байгаа утас, (трос), тулгуур, бэхэлгээ, ажиллаж байгаа механизмаас 5 метр ойр зайд хүн байхыг хориглоно.

927. Сунадаг цамхагт шаттай машин (шингэн шахуургат өргөгч)-аар ажил гүйцэтгэх үед түүний ажлын тавцан дээр байгаа хүн, жолооч хоёр аль болох бие биенээ харж байхаар байрлах ёстой. Бие биенээ харахааргүй байрлалтай тохиолдолд жолоочийн ойролцоо бригадын гишүүдээс нэг нь байрлаж ажлын тавцанг буулгах буюу өргөх дохиог жолоочид дамжуулан өгч байх ёстой.

928. Сунадаг шаттай машинаар (шингэн шахуургат өргөгчөөр) ажил гүйцэтгэх үед ажилтан ажлын тавцангийн шалан дээр бат зогсож, хамгаалалтын бүсний оосрыг хашлаганд нь сайтар бэхэлсний дараа ажиллуулж эхлэх ёстой.

929. Ажлын тавцангаас тулгуур буюу тоноглолд шилжих ба буцаж ажлын тавцан дээр гарах үйлдлийг зөвхөн ажил гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

930. Хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсэгт машин, механизм шүргэсэн, хүрсэн тохиолдолд түүнээс газарт буух буюу түүний дээр гарах, хүрэхийг хориглоно.

931. Машинч нь өөрийн машин механизм хүчдэлтэй болсон тухай ойролцоо байгаа хүмүүст анхааруулах үүрэгтэй.

932. Хүчдэлтэй болсон автомашин, ачаа өргөх машин механизм шатах тохиолдолд жолооч (машинч) нь хоёр хөлөө нийлүүлэн гараа машинд хүргэлгүйгээр газарт үсрэн буух ёстой. Дараа нь газраас хөндийрөхгүйгээр өсгий, өлмий чирэх эсвэл дэгдэх замаар машинаас 8 метрээс багагүй зайд холдох ёстой.

933. ХБ-д зөөврийн төмөр шат хэрэглэхийг хориглоно.

934. Ачаа өргөх машины өргөж байгаа ачаа, ачаа оосорлох хэрэгсэл, татлага нь хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсэгт аюулгүйн зайнаас дотогш ойртох нөхцөл бүрдүүлж болзошгүй хүчтэй салхи шуургатай үед ачаа өргөх машин механизмаар ажил гүйцэтгэхийг хориглоно.

11.2. Шат, тавцан, тоног төхөөрөмж, хийц хэсэг дээр гарч гүйцэтгэх ажил

935. Хийц хэсэг, тулгуурт хамгаалалтын бүсний оосрыг бэхлэх боломжгүй ажлын үед тулгуур болон хийц хэсэгт урьдчилан бэхэлсэн хамгаалалтын татлагыг хэрэглэвэл

зохино. Энэ ажлыг хоёр хүн гүйцэтгэх ба нэг нь хамгаалалтын татлагыг шаардагдах хэмжээгээр нь аажмаар татах буюу суллаж өгч байх ёстой.

936. Тавцант угсармал шатыг тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас баталсан зааврын дагуу хийх ёстой.

937. Угсармал шат, вандан, ажлын тавцан нь газрын хөрс буюу хучилтаас 1,2 метрээс илүү өндөрт байвал тэдгээрт хашлага хийсэн байх ёстой.

938. Шат, тавцан, вандан хэрэглэх боломжгүй үед тоног төхөөрөмж, хийц хэсэг дээр гарч ажиллахад тухайн нөхцөл тус бүрт аюулгүй ажиллах арга хэмжээг технологийн карт, ажил гүйцэтгэх төлөвлөгөө буюу бусад аюулгүй ажиллагааг хангах баримт бичгээр тодорхойлно.

939. Хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсгийн дээд талд байрлалтай хийц хэсэг дээр ажиллах үед засварын багаж хэрэгсэл доош унахаас хамгаалсан (оосорлох, тусгаарлах хавтан тавих г.м.) байх ёстой.

940. Цахилгаан ба хийн гагнуурчид нь төмөр гинжин оосортой хамгаалах бүс хэрэглэх ёстой. Хэрэв ажлын байр ба түүнд очих зам нь хаалт хашилтгүй, бүсний төмөр гинжин оосор нь доош унжихдаа гүйдэл дамжуулах хэсэгт 1 дүгээр хүснэгтэд зааснаас бага зайд ойртохоор бол уг гүйдэл дамжуулах хэсгийн хүчдэлийг заавал тасалж ажил гүйцэтгэнэ.

941. Тоног төхөөрөмж буюу хийц хэсэг дээр ажиллаж байгаа хүнд эд анги ба багаж хэрэгслийг битүү гогцоо татлагаар дамжуулж өгнө. Дор нь байгаа хүн өгч байгаа зүйлээ савлаж гүйдэл дамжуулах хэсэгт хүрэхээс сэргийлж хамгаалах татлагаас барьж чиглүүлж байх ёстой.

942. Тулгуур, хийц хэсэг, хэц, тоног төхөөрөмж дээр ажиллаж байгаа хүн нь хөдөлгөөнд саад болохооргүй бариу биш хувцас өмсөж, багаж хэрэгслээ цүнхэнд хийсэн байх ёстой.

943. Машины өрөө, цехийн таазанд байрлалтай гэрэлтүүлгийн тоноглолд гүүрэн краны тэргэнцэр дээр байрлаж үйлчлэх ажлыг хоёроос цөөнгүй хүн гүйцэтгэх ба III-аас доошгүй групптэй хүн тухайн ажлыг гардан хийнэ. Нөгөө хүн нь ажил гүйцэтгэж байгаа хүний дэргэд байж аюулгүй ажиллагааны шаардлагатай арга хэмжээнд хяналт тавьж байна.

944. Краны тэргэнцэр дээр зөөврийн шат, тавцан мэтийн хэрэгсэл байрлуулж болохгүй. Краны тэргэнцрийн өөрийн тавцан эсвэл түүнд суурин байрлуулсан тавцан дээр ажиллавал зохино.

945. Гүүрэн краны тэргэнцэр дээр авирч гарахын өмнө краны цахилгаан тэжээлийн шугамын хүчдэлийг тасалсан байна.

946. Кранчин краны гүүр ба тэргэнцрийг зөвхөн ажил гүйцэтгэгчийн дохиогоор шилжүүлж явуулна.

947. Гүүрэн краныг шилжүүлэн явуулж байхад ажиллагсад нь краны бүхээгт эсвэл гүүрний шалан дээр байрлана.

948. Тэргэнцэр дээр хүн байх үед краны гүүр болон тэргэнцрийг хөдөлгөх, шилжүүлэх, явуулахыг хориглоно.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ. АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ

949. Эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны (төв) байгууллага, түүний харъяа газар, аж ахуйн нэгж, байгууллага (газар, цахилгаан станц, цахилгаан ба дулааны сүлжээ, угсралт, туршилт, тохируулга, ашиглалт, засварын компани г.м.) болон хэрэглэгч, бэлтгэн нийлүүлэгч, хяналтын болон бусад холбогдох байгууллагаас цахилгаан, дулааны станц, цахилгаан ба дулааны сүлжээ, шинээр болон техникийн өргөтгөл шинэчлэл хийж байгаа, ашиглалтад байгаа цахилгаан байгууламж дээр ажил гүйцэтгүүлэхээр томилсон хүмүүсийг албан томилолтоор ажил гүйцэтгэгч гэнэ. Албан томилолтоор ажил гүйцэтгэгчид эрх бүхий байгууллагаас хяналт, шалгалт, үзлэг хийж яваа ажилтнууд хамаарахгүй.

950. Ашиглалтад байгаа цахилгаан байгууламжийн хамгаалалтын бүсэд ажил гүйцэтгүүлэхээр явуулсан барилга угсралтын байгууллагын хүнийг томилолтоор ажиллаж байгаад тооцож болно.

951. Ажил гүйцэтгэх гэрээнд аюулгүй ажиллагааг хэн хариуцах талаар хэрхэн зааснаас үл хамаарч цахилгаан байгууламжид албан томилолтоор ажиллах хүнийг энэ дүрмийн дагуу ажилд оруулна.

952. Албан томилолтоор ажиллах ажилтан аюулгүй ажиллагааны дүрмийн шалгалт өгч, цахилгааны аюулгүй ажиллагааны группын батлагдсан загварын үнэмлэх авсан ба түүнийг биедээ авч явах ёстой.

953. Томилолтоор явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь гүйцэтгэх ажлын зорилгыг тодорхойлж, өөрийн байгууллагын аюулгүй ажиллагааг хариуцагч нарын нэрсийн жагсаалт, группыг албан бичгээр өгөх ёстой.

954. Тухайн цахилгаан байгууламжийн үйлчилгээг хариуцагч байгууллагын удирдлага нь албан томилолтоор ирж байгаа хүмүүсийг уг албан бичигт заасан аюулгүй ажиллагааг хариуцагчаар ажиллуулах эсэхийг шийдвэрлэж албан бичиг дээр цохолт хийнэ. Шаардлагатай тохиолдолд хүн нэг бүрийн үүргийг тогтоож бичгэн шийдвэр гаргаж болно.

955. Албан томилолтоор ажиллах хүн нь энэ дүрмийн 1.2-т заасан шаардлагыг хангаж буйг томилж явуулсан байгууллага хариуцна.

956. Албан томилолтоор ажиллах хүмүүс нь ажил гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагадаа ирээд ажил гүйцэтгэж эхлэхийн өмнө тухайн цахилгаан байгууламжийн онцлогийг тусгасан цахилгааны бүдүүвчтэй танилцаж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг авах ёстой.

957. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг холбогдох дүрэм, журам, стандартад заасны дагуу өгнө.

958. Томилолтоор ажиллах хүмүүсийг ажилд оруулах, тэднийг цахилгаан гүйдэл болон нөлөөллийн хүчдэлд нэрвэгдэхээс хамгаалах аюулгүй ажиллагааны арга хэмжээний биелэлтэнд цахилгаан байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцагч аж ахуйн нэгж, байгууллага хяналт тавина.

959. Цахилгаан байгууламжид томилолтоор яваа ажилтныг ажлын байр бэлтгэж ажилд оруулах үйлдлийг энэ дүрмийн дагуу гүйцэтгэх ба ямарч тохиолдолд энэ ажлыг тухайн цахилгаан байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцагч байгууллагын ажилтан хэрэгжүүлнэ.

960. Албан томилолтоор ажиллаж байгаа бүх хүмүүс нь цахилгаан байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцагч байгууллагын ажилтны аюулгүй ажиллагаатай холбогдуулан тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ. АШИГЛАЛТАД БАЙГАА ЦАХИЛГААН БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ХАМГААЛАЛТЫН БҮСЭД БАРИЛГА УГСРАЛТ, ЗАСВАРЫН БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГЫН ХҮМҮҮСИЙГ АЖИЛД ОРУУЛАХ

13.1. Ерөнхий шаардлага

961. Ашиглалтад байгаа цахилгаан байгууламж, түүний хамгаалалтын бүсэд ажил гүйцэтгэхдээ тухайн цахилгаан байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцагч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэх бөгөөд гэрээнд хийж гүйцэтгэх ажлын агуулга, хэмжээ болон цаг хугацаа, аюулгүй ажиллагааг аль байгууллага хариуцахыг заасан байх ёстой.

962. Хамгаалалтын бүсэд ажил гүйцэтгэх байгууллага нь ажил эхлэхийн өмнө тухайн цахилгаан байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцагч байгууллагад ажил гүйцэтгэх хүмүүсийн мэдээллийг өгч, бичгээр зөвшөөрөл авах ёстой.

963. Ажил гүйцэтгэх бичгэн зөвшөөрөлд дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:
- Ажлын байр (ажиллагаатай байгаа цахилгаан байгууламжийн хэсгийн нэр, хаяг, дугаар, ХБ, ЦДАШ, КШ-ын нэр, тулгуурын ба хэлхээний дугаар г.м.);
 - Ажил гүйцэтгэх хугацаа (эхлэх ба дуусах);
 - Ашиглагч байгууллагын ажил эхлэх зөвшөөрөл олгох ажилтны нэр, албан тушаал, утасны дугаар (ажил эхэлсэн болон дууссан тухай мэдээллийг авах);

- Аюултай болон хортой хүчин зүйлсийн тодорхойлолт;
- Ажиллагаатай байгаа цахилгаан байгууламж ба шугамын ойролцоо цахилгаан соронзон орон, нөлөөллийн хүчдэл байгаа эсэх;
- Ашиглагч байгууллагын байнгын хяналтан дор ажил гүйцэтгэх тохиолдолд хяналт тавих ажилтны нэр, албан тушаал, утасны дугаар;
- Ажилд оруулах болон нарыадад гарын үсэг зурах эрх бүхий ажилтныг зааж өгнө.

964. Цахилгаан байгууламж, шугамын ашиглалт үйлчилгээг хариуцагч байгууллага нь ажил гүйцэтгэх хэсгийн дэвсгэр зургийг зурж, түүнд цахилгаан байгууламж ба шугам хүртэлх зай, хаалт хашилт, хязгаарлалт хийх зааг, орц гарц, ажлыг аюулгүй гүйцэтгэх арга хэмжээг тодорхой тусгаж, ажлын байрыг газар дээр нь зааж өгч акт үйлдэнэ.

965. Актад ажил гүйцэтгэх ба цахилгаан байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцагч байгууллагын захиргаа техникийн ажилтнууд гарын үсэг зурж баталгаажуулсан байвал зохино.

966. Ашиглалтад байгаа цахилгаан байгууламж, түүний хамгаалалтын бүсэд ажил гүйцэтгэхдээ ашиглагч байгууллагын эрх бүхий ажилтнаас ажил эхлэх зөвшөөрөл авалгүйгээр, түүнчлэн хянагч ажилтан томилогдсон тохиолдолд түүнгүйгээр ажлаа эхлэхийг хориглоно.

967. Хамгаалалтын бүсэд ажил гүйцэтгэх байгууллагын ажил олгогч нь өөрийн байгууллагын хүмүүстээ ажил эхлэхийн өмнө ашиглалтын байгууллагын холбогдох ажилтнаар аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгүүлэх ёстой. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг холбогдох дүрэм, журам, стандартад заасны дагуу өгнө.

968. Цахилгаан байгууламжийн ашиглагч байгууллагын эрх бүхий ажилтан нь зааварчилгаа өгөгдөөгүй, хянагч ажилтан томилогдсон тохиолдолд түүнгүйгээр ажил эхлэх зөвшөөрөл өгөхийг хориглоно.

969. Хамгаалалтын бүсэд ажил гүйцэтгэх байгууллага болон ашиглагч байгууллагын аль аль нь зааварчилгааны журналд зааварчилгаа авсан хүний нэр, сэдвийг бүртгэн бичиж гарын үсэг зуруулсан байна.

970. Хамгаалалтын бүсэд ажил гүйцэтгэх байгууллага нь энэ дүрмийн 1.2-т заасан шаардлагыг ажилтнууд нь хангаж буйг хариуцна.

971. Цахилгаан байгууламжийн хүчдэлийг нь таслах шаардлагатай, түүнчлэн хүчдэлтэй байгаа цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын бүсэд цахилгаан байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцагч байгууллагын олгосон нарыадаар тухайн байгууллагын ажилтан анх ажилд оруулна.

972. Ажлын байранд хүрэхийн тулд ажиллагаатай байгаа цахилгаан байгууламжийн хаалт, хашилтгүй хэсгээр зайлшгүй дамжин өнгөрөх тохиолдолд ашиглагч байгууллагын ажилтан анх удаа болон давтан ажилд оруулна.

973. Ажиллагаатай байгаа цахилгаан байгууламж, түүний хамгаалалтын бүсэд ажил гүйцэтгэхдээ цахилгаан байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцагч байгууллагаас томилогдсон хянагч ажилтны байнгын хяналтан дор гүйцэтгэнэ.

974. Хянагч нь барилга угсралт, засварын болон бусад байгууллагын ажлыг хариуцан гүйцэтгэгч ажилтны нэгэн адил тавьсан хаалт, хашилт, плакатыг хөдөлгөхгүй байх, цахилгаан байгууламжийн хүчдэлтэй гүйдэл дамжуулах хэсэгт тогтоосон зайнаас дотогш ойртуулахгүй байх, кабель шугам дээр механизмаар ажил гүйцэтгүүлэхгүй байх зэрэг аюулгүй ажиллагааг хангах үүрэгтэй.

975. Хамгаалалтын бүсэд байгаа бүх хүмүүс нь цахилгаан байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцагч байгууллагын ажилтны аюулгүй ажиллагаатай холбогдуулан тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

976. Барилга угсралт, засварын болон бусад байгууллагын хүмүүсийн ажиллаж байгаа хүчдэлийг нь тасалсан хэсэг рүү хүчдэл залгахгүй байхыг ашиглагч байгууллага хариуцна.

13.2. Цахилгаан станц, дэд станц, хуваарилах байгууламжид ажилд оруулах

977. Барилга угсралт, засварын болон бусад байгууллагын ажилтанд ажил гүйцэтгүүлэхээр гаргаж өгсөн ажлын байрны эргэн тойронд битүү буюу торон хаалт

хашилт хийж эдгээр хүмүүс ажиллагаатай байгаа цахилгаан байгууламжид нэвтрэн орох боломжгүй болгосон байх ёстой.

978. Барилга угсралт, засварын болон бусад байгууллагын ажилтны ажиллах хаалт хашилттай хэсэг рүү машин, механизм, хүн явж очих зам нь ажиллагаатай байгаа цахилгаан байгууламжийн дэвсгэр газар болон байрны дундуур өнгөрөхөөр байж болохгүй.

979. Хэрэв барилга угсралт, засварын болон бусад байгууллагын ажилтны ажиллах хаалт, хашилттай хэсэг рүү машин, механизм, хүн явж хүрэх зам нь ажиллагаатай байгаа цахилгаан байгууламжийн дэвсгэр газар болон байрны дундуур зайлшгүй өнгөрөх шаардлагатай бол ажил гүйцэтгэх хүмүүсийг ашиглагч байгууллагын ганцаараа үзлэг хийх эрх бүхий ажилтан дагуулан нэвтрүүлнэ.

980. Барилга угсралт, засварын болон бусад байгууллагын хүмүүсийн ажиллах хэсэгт хаалт, хашилт тавих боломжгүй эсвэл аюулгүй ажиллагааг хангах нэмэлт арга хэмжээ шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ашиглагч байгууллагын IV-өөс доошгүй групптэй хянагчийн хяналтан дор ажил гүйцэтгэх ба энэ тухай нарыдад бичсэн байх ёстой.

13.3. Цахилгаан дамжуулах кабель, ЦДАШ-ын хамгаалалтын бүсэд ажилд оруулах

981. ЦДАШ ба кабель шугамын хамгаалалтын бүс, түүнчлэн ЦДАШ-тай огтлолцсон алгасалтад барилга угсралт, засварын болон бусад байгууллагын ажилтан, иргэнийг тухайн шугамын ашиглалт үйлчилгээг хариуцагч байгууллага нарыдаар ажлын байр бэлтгэж, ажилд оруулах ёстой.

982. Ажиллагаатай байгаа цахилгаан байгууламжийн бүсэд ажилд оруулагч нь барилга угсралт, засварын болон бусад байгууллагын бригад нэг бүрийн ажил гүйцэтгэгч, ажлын удирдагчийг эхэлж ажилд оруулаад дараа нь бригадын бусад гишүүдийг ажилд оруулна.

983. Хүчдэлийг нь тасалсан цахилгаан дамжуулах шугам болон түүний хамгаалалтын бүсэд ажилд оруулагч нь барилга угсралт, засварын болон бусад байгууллагын ажил хариуцан гүйцэтгэх хүнийг ажилд оруулах бөгөөд тэр нь бусад хүмүүсээ ажилд оруулахыг зөвшөөрнө.

984. КШ-ын хамгаалалтын бүсэд ажил гүйцэтгэх зөвшөөрөл (ажилд оруулах акт)-д кабелийн байрлал, оршиж байгаа гүнийг нарийвчлан заасан байх ёстой.

985. КШ-ыг хамгаалалтын бүсэд газар шорооны ажил эхлэхийн өмнө ашиглагч байгууллагын ажилтны хяналтан дор хяналтын хөндлөн шуудуу ухаж кабелийн байршил, гүнийг нарийвчлан тогтоогоод газар ухах машины ажиллах хэсгийг зөөврийн хаалт хашилтаар хязгаарлаж өгнө.

986. Газар шорооны ажлын явцад баримт бичигт тусаагүй кабель илрүүлбэл ажлаа нэн даруй зогсоож ажил гүйцэтгэх зөвшөөрөл (ажилд оруулах акт) өгсөн байгууллагад мэдээлэх ёстой.

987. ЦДАШ-ын хамгаалалтын зурваст ачаа өргөх, газар өрөмдөх, ухах болон бусад хөдөлгөөнт механизмтай машинаар ажил гүйцэтгэх үед тухайн механизмын хамгийн өндөр өргөгдсөн болон хэвтээ шилжилтийн хамгийн алслагдсан цэгээс шугамын хамгийн ойрын утас хүртэл 8 дугаар хүснэгтэд зааснаас багагүй байх ёстой.

Хүснэгт 8

Машин механизмаар ажил гүйцэтгэх үед хүчдэлтэй гүйдэл дамжуулах хэсэгт ойртож болох зай хэмжээ

ЦДАШ-ын хүчдэл, кВ	Зай /метр/	
	Хамгийн бага	Техник хэрэгслээр хэмжигдэх хамгийн бага
1 хүртэл	1.5	1.5
1-ээс дээш 35хүртэл	2.0	2.0
35-аас дээш 110 хүртэл	3.0	4.0
110-аас дээш 220 хүртэл	4.0	5.0
220-иос дээш 400 хүртэл	5.0	7.0
400-өөс дээш 750 хүртэл	9.0	10.0

988. Ачаа өргөх, газар өрөмдөх, ухах болон бусад хөдөлгөөнт механизмтай машинаар ажил гүйцэтгэх үед тухайн шугамыг ашиглагч байгууллага нь ажлын байрны хязгаарыг тогтоож хаалт хашилт тавьж, плакат өлгөсөн байна.

ЦАХИЛГААНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ГРУППЫН АНГИЛАЛ

Групп	Ажилтны биечлэн гүйцэтгэх ажил, албан тушаалын ангилал	Цахилгаан байгууламжид ажилласан туршлага	Нас	Мэдлэг чадварын тодорхойлолт
I	Цахилгаан техникийн мэргэжилгүй, аюулгүй ажиллагааны дүрмийн мэдлэгийн шалгалт өгдөггүй /цэвэрлэгч, будагчин г.м./ ажилтан, ажиллаж эхлэж байгаа машин механизмын жолооч, машинч, цахилгаан ба хийн гагнуурчин, цахилгааны слесарь, холбоочин ба цахилгаан байгууламжийн цэвэрлэгч, дадлагын оюутан, сонсогчид;	Хугацаа тогтоохгүй	18 ба түүнээс дээш	Цахилгаан техникийн мэдлэггүй боловч цахилгаан гүйдлийн аюулын талаар тодорхой мэдлэгтэй, гүйдэл дамжуулах хэсэгт ойртож болохгүй зай хэмжээг мэддэг байх; Осолд өртсөн хүнд анхны тусламж үзүүлж чаддаг байх; Эдгээр хүмүүс цахилгаан байгууламжийн гүйдэл дамжуулах хэсэг дээр бие даан ажиллах, үзлэг, үйлчилгээ хийх эрхгүй.
II	Цахилгааны мэргэжлээр суралцагч оюутан, сонсогчид үйлдвэрлэлийн дадлага хийх хугацаанд;	Хугацаа тогтоохгүй	16 нас хүрсэн	Цахилгаан гүйдэл хүчдэлийн аюулынталаар мэдлэгтэй, гүйдэл дамжуулах хэсэгт ойртож болох зай хэмжээг мэддэг байх; Цахилгаан техникийн онолын анхны мэдэгдэхүүнтэй байх; Цахилгаан байгууламж тоног төхөөрөмжийн хийц, бүтэцийн ажиллах зарчмыг мэддэг байх; Аюулгүй ажиллагааны талаар энэ дүрмийн заалтыг албан тушаалын хүрээнд мэддэг байх; Осолд өртсөн хүнд анхны тусламж үзүүлж чаддаг байх;
	Цахилгааны слесарь, холбоочин ба 1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжийн цэвэрлэгчид;	Тухайн цахилгаан байгууламжид нэг сараас доошгүй	18 ба түүнээс дээш	
	Цахилгаан техникийн мэргэжилгүй ажилтан;	Хоёр сараас доошгүй	18 ба түүнээс дээш	
	-Машин механизмын жолооч, машинч -Цахилгаан ба хийн гагнуурчин;	Хоёр сараас доошгүй	18 ба түүнээс дээш	
III	Цахилгааны монтер, цахилгааны слесарь, цахилгаан гагнуурчин, машин механизмын жолооч;	Өмнөх группэд 6-аас доошгүй сар ажилласан	18-аас дээш	Цахилгаан байгууламж дээр ажиллахад аюултай байдлын талаар бүрэн мэдлэгтэй байх; Цахилгаан техникийн онолын үндсийг мэддэг байх; Цахилгаан байгууламжийн бүтэц түүний схем, засвар үйлчилгээний зааврыг мэддэг байх; Хашиж байгаа албан тушаалын хүрээнд энэ дүрэм болон техник ашиглалт, галын аюулгүй ажиллагааны дүрмийг сайн мэддэг байх; Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч чаддаг байх; Цахилгаан байгууламжид ажил хийж байгаа ажилтанд хяналт тавьж чаддаг, ажлыг аюулгүй гүйцэтгэх чадвартай байх; Осолд өртсөн хүнд анхны тусламж үзүүлж чаддаг байх;
	Ажиллаж эхэлж байгаа цахилгааны инженер;	Хугацаа тогтоохгүй	18-аас дээш	

IV	Цахилгааны слесарь, монтёр, ИТА;	Өмнөх группэд 1 жилээс доошгүй, харин цахилгаан техникийн бүрэн дээд боловсролтой бол өмнөх группэд 6-аас доошгүй сар ажилласан байх	18-аас дээш	Цахилгаан байгууламж дээр ажиллахад аюултай байдлын талаар нарийн мэдлэгтэй байх; Цахилгаан техникийн онолыг сайн мэддэг байх; Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжийн бүтэц хийц тэдгээрийн онцлог схем, горимыг нарийн мэддэг байх; Хашиж байгаа албан тушаалын хүрээнд энэ дүрэм болон техник ашиглалт, галын аюулгүй ажиллагааны дүрмийг нарийн мэддэг байх; Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, сургалт явуулж чаддаг байх; Аюулгүй ажиллагааг ажлын байранд зохион байгуулж холбогдох арга хэмжээг биечлэн авч, ажиллаж байгаа ажилтанд хяналт тавьж чаддаг байх; Осолд өртсөн хүнийг хүчдэлээс чөлөөлж, анхны тусламж үзүүлж чаддаг байх;
V	Цахилгааны монтёр, цахилгааны слесарь, мастер, техникч;	Өмнөх группэд 1 жилээс доошгүй ажилласан байх	20-аас дээш	Үйлчилж байгаа цахилгаан байгууламжийн схем горим, онцлог, үйлдвэрлэлийн технологийн процессыг нарийн мэддэг байх; Хашиж байгаа албан тушаалын хүрээнд энэ дүрмийн заалт тус бүрийн онолын үндэслэлийг мэддэг, хэрэгжүүлж чаддаг байх;
	Мастер, техникч, инженер (цахилгаан техникийн мэргэжлийн бүрэн дээд боловсрол эзэмшсэн);	Өмнөх группэд 6 сараас доошгүй ажилласан байх	20-аас дээш	Цахилгаан техник, тоног төхөөрөмжид хэрэглэх хамгаалах хэрэгслийг ашиглах, турших талаар бүрэн мэддэг, хэрэгжүүлж чаддаг байх; Бүх хүчдэлийн цахилгаан байгууламжид ажлын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулж, биечлэн гүйцэтгэж, хяналт тавьж чаддаг байх; Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, сургалт явуулж чаддаг байх; Осолд өртсөн хүнийг хүчдэлээс чөлөөлж, анхны тусламж үзүүлж чаддаг байх;

Тайлбар: Аюулгүй ажиллагааны групп нь мэргэжлийн зэргээс илүү байж болохгүй.

1000 В-оос дээш хүчдэлийн цахилгаан байгууламжид ажилладаг ажилтны ажилласан хугацааг тооцохдоо зөвхөн уг цахилгаан байгууламжид ажилласан хугацааг авч тооцно.

Аюулгүй ажиллагааны группын ангиллын хугацааг тооцохдоо тухайн үйлдвэр, байгууллагын хэмжээнд ажилласан хугацааг тооцно.

Дээрх хүснэгтэд дурьдсан цахилгааны аюулгүй ажиллагааны мэдлэгт тавих шаардлага нь хамгийн доод түвшингээр тогтоосон тул аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага /ажил олгогч/ нь өөрийн үйлдвэрлэл, технологи, тоног төхөөрөмжийн тусгай нөхцөл, онцлог байдалд тохируулан энэ дүрэмд харшлахгүй аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааврын мэдлэг, мэргэжил, дадлагын нэмэлт шаардлагыг тавьж болно.

Аюулгүй ажиллагааны I групптэй хүнд үнэмлэх олгохгүй байж болно.

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР

**АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
ЭРХИЙН ҮНЭМЛЭХ**

Зураг

Байгууллагын нэр
Нэгжийн нэр.....

№

Овог Нэр

Албан тушаал

..... кВ хүртэлх хүчдэлийн цахилгаан байгууламжид ажиллана.

Олгосон 20 он сар өдөр

Комиссын дарга / /

1. Аюулгүй ажиллагааны дүрэм						
Он сар өдөр	Шалгасан шалтгаан	Мэргэшлийн групп	Ерөнхий дүн	Дараа шалгуулах он,сар,өдөр	Олгосон эрх (Ажил)	Комиссын даргын гарын үсэг

2. Техник ашиглалтын дүрэм						
Он сар өдөр	Шалгасан шалтгаан	Шалгалтын протоколын дугаар	Ерөнхий дүн	Дараа шалгуулах он,сар,өдөр	Мэргэшлийн нэр	Комиссын даргын гарын үсэг

Үнэмлэх эзэмшигчийн анхааралд		Аюулгүй ажиллагааны санамж	
1. Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм (ТАД) болон аюулгүй ажиллагааны дүрэм (ААД)-ийн мэдлэгийн шалгалтад тэнцсэн хүнд энэхүү үнэмлэхийг олгоно.		1. Цахилгаан байгууламжид үзлэг хийх үед ажил гүйцэтгэхийг хориглоно.	
2. Эрчим хүчний барилга байгууламжид нэвтрэх, ажил гүйцэтгэх үед үнэмлэхийг биедээ заавал авч явна.		2. Цахилгаан байгууламжийн хаалт хашилтгүй гүйдэл дамжуулах хэсэгт ААД-д заасан зайнаас дотогш ойртох, хаалт хашилтын цаана нэвтрэхийг хориглоно.	
3. Эрх бүхий ажилтан шаардсан тохиолдолд үнэмлэхээ шалгуулах үүрэгтэй.		3. Цахилгаан байгууламжид ажил гүйцэтгэхийг өмнө хамгаалах хэрэгслүүдийг бүрэн хэрэглэ!	
4. Үнэмлэх нь тухайн байгууллага, албан тушаалд ажиллаж байх хугацаанд хүчинтэй байна.		4. Хүчдэлтэй байгаа тоног төхөөрөмжийн тусгаарлах хэсгүүдэд хамгаалах хэрэгсэлгүйгээр хавирч шүргэж болохгүй.	
5. Тамга тэмдэггүй, зураггүй, шалгалтын хугацаа дууссан үнэмлэхийг хүчингүйд тооцно.		5. Цахилгаан байгууламжид ажил гүйцэтгэхдээ наряд, шийдвэрт зааснаас бусад ажлыг дур мэдэн гүйцэтгэх, ажлын байр өргөтгөхийг хориглоно.	
6. Үнэмлэхийг бусдад шилжүүлэхийг хатуу хориглоно.			

Нүүрэн тал**АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ НАРЯД №**

Байгууллагын нэр
 Хэсэг, нэгжийн нэр
 Ажлын удирдагч Ажилд оруулагч
 Ажлын хариуцлагатай гүйцэтгэгч Ажиглагч
 Бригадын бүрэлдэхүүн

Дараах ажлыг гүйцэтгэхийг даалгав:

Ажлыг эхлэх хугацаа оны сарын өдрийн цаг минут

Ажлыг дуусгах хугацаа оны сарын өдрийн цаг минут

Хүснэгт 1**Ажлын байр бэлтгэх арга хэмжээ**

Таслалт хийх ба газардуулга тавих цахилгаан байгууламжийн нэр	Таслах аппаратын нэр, хаана газардуулга тавих

Тусгай заалт

Наряд олгосон хүний нэр гарын үсэг

Наряд олгосон: оны сарын өдрийн цаг минут

Наряд сунгасан хүний нэр гарын үсэг

Нарядыг оны сарын өдрийн цаг минут хүртэл сунгав.

Наряд сунгасан оны сарын өдрийн цаг минут

Хүснэгт 2**Ажлын байр бэлтгэх ба ажилд оруулах зөвшөөрөл**

Ажлын байр бэлтгэх ба ажилд оруулах зөвшөөрөл олгосон хүний нэр, албан тушаал, гарын үсэг	Он, сар, өдөр, цаг, минут	Ажлын байр бэлтгэх ба ажилд оруулах зөвшөөрөл авсан хүний нэр, гарын үсэг

Нарядын маягтын ар тал

Техникийн арга хэмжээг бүрэн авч ажлын байр бэлтгэв. Хүчдэлтэй үлдсэн:.....

Ажлын байр бэлтгэгч Ажилд оруулагч
 /гарын үсэг/ /гарын үсэг/

Ажлын удирдагч Ажлын хариуцлагатай гүйцэтгэгч
 /гарын үсэг/ /гарын үсэг/

Хүснэгт 3

Тухайлсан зааварчилгааны бүртгэл

Зааварчилгаа өгсөн		Зааварчилгаа авсан			
Аюулгүй ажиллагаа хариуцагч	Гарын үсэг	Аюулгүй ажиллагаа хариуцагч		Гарын үсэг	
Наряд олгогч		Ажлын удирдагч			
		Ажлын хариуцлагатай гүйцэтгэгч			
		Ажиглагч			
Ажлын удирдагч		Ажлын хариуцлагатай гүйцэтгэгч			
Зөвшөөрөл олгогч		Ажлын байр бэлтгэгч			
		Ажилд оруулагч			
Ажилд оруулагч		Ажлын удирдагч			
		Ажлын хариуцлагатай гүйцэтгэгч			
		Ажиглагч			
Ажлын хариуцлагатай гүйцэтгэгч		Гишүүн		Гишүүн	
		Гишүүн		Гишүүн	
		Гишүүн		Гишүүн	
		Гишүүн		Гишүүн	
		Гишүүн		Гишүүн	
		Гишүүн		Гишүүн	

Хүснэгт 4

Өдөр бүрийн ажилд оруулалт ба ажлын төгсгөл

Бригадад зааварчилгаа өгөөд бэлтгэсэн ажлын байранд ажилд оруулсан					Ажил дуусгаж бригадыг ажлын байрнаас гаргасан		
Ажлын байрны нэр	Он, сар, өдөр, цаг, минут	Зөвшөөрөл олгогчийн нэр	Гарын үсэг		Он, сар, өдөр, цаг, минут	Ажил гүйцэтгэгч	Өөрийн тавьсан газардуулгыг авсан тухай (хэнд мэдэгдсэн)
			Ажилд оруулагч	Ажлын удирдагч (Ажил гүйцэтгэгч)			
1	2	3	4	5	6	7	8

Хүснэгт 5

Бригадын бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлт

Бригадын бүрэлдэхүүнд нэмж оруулсан хүний нэр	Бригадын бүрэлдэхүүнээс гаргасан хүний нэр	Он, сар, өдөр, цаг, минут	Зөвшөөрсөн хүний гарын үсэг

Ажлыг бүрэн дуусгаад бригадыг ажлын байрнаас гаргаж, бригадын ажлын байранд тавьсан газардуулгыг авсныг оны сарын өдрийн цаг минутанд
 ажилтай -нд мэдэгдсэн болно.

Ажлын хариуцлагатай гүйцэтгэгч
 /гарын үсэг/

Ажлын удирдагч
 /гарын үсэг/

Аюулгүй ажиллагааны нарядыг бөглөх заавар

1. Нарядыг гаргацтай бичнэ. Нарядыг бал, үзэг ашиглан бичиж болохоос гадна компьютер ашиглаж болно.
2. Наряд нь дугаартай байх бөгөөд засварлахыг хориглоно.
3. Нарядынбөглөж бичих шаардлагагүй мөрөнд зураас татах ба баганад **Z** үсэг тавина.
4. Он, сар, өдөр, цаг, минут тус бүрийг хоёр цифртэй бичнэ.(Жишээ нь: 13.09.29, 12.12.14 гэх мэт)
5. Нарядад хүний нэрийг бичихдээ овгийн эхний үсгийг тавьж, нэрийг нь бүтнээр бичнэ. Нэрийн ард аюулгүй ажиллагааны группыг ром цифрээр бичнэ. (Жишээ нь: Х.Болд IV)
6. Цахилгаан байгууламж, холболт, тоног төхөөрөмж, тэдгээрийн хэсгийн нэр, дугаарыг зөвхөн диспетчерийн нэгдсэн нэр хаяг, тэмдэглэгээний дагуу бичнэ.
7. Нарядыг бичих үед түүний мөр буюу баганад бичих зүйл маягтад багтахгүйэсвэл тухайлсан зааварчилгаа авах бригадын гишүүд нь гарын үсэг зурахад 3 дугаар хүснэгт хүрэлцэхээргүйбайгаа бол уг нарядтай ижил дугаартай нарядын маягтыг хавсарган түүн дээр зөвхөн багтаагүй мөр буюу баганыг үргэлжлүүлэн бичээд бусад мөрөнд зураас татаж наряд олгогч гарын үсэг зурна. Энэ тохиолдолд бичсэн нарядын үндсэн маягтын багтаагүй мөр буюу баганын доод талд “хавсралт нарядыг үз!” гэж бичнэ.
8. Нарядын техникийн арга хэмжээг бичихдээ үйл үгийг нь захиран тушаах төлөвт товчлохгүйгээр бичнэ. (Жишээ нь: 1. яч.№21 ТТ тасла!)
9. Техникийн арга хэмжээг бичихдээ тавих плакатуудыг ойлгомжтой байдлаар товчилж болно. (Жишээ нь: хориглох плакатыг ХП г.м.)

Нарядын маягтын нүүрэн талыг бөглөж бичих

- 10.Байгууллагын нэр, хэсэг, нэгжийн нэр гэсэн мөрөнд ажил гүйцэтгэх гэж байгаа үйлдвэр, байгууллага нэгж (алба, цех, гэх мэт)-ийн нэрийг бичнэ.
- 11.“Ажлын удирдагч”, “Ажиглагч” гэсэн мөрөнд хэрэв ажлын удирдагч, ажиглагч томилоогүй бол “Томилоогүй” гэж бичнэ.
- 12.“Ажилд оруулагч” гэсэн мөрөнд шуурхай ажиллагаа, шуурхай үйлчилгээ-засварын хүмүүсээс эсвэл ажилд оруулагчийн үүргийг хавсран гүйцэтгэх засварын хүмүүсээс томилогдсон ажилд оруулагчийн нэрийг бичнэ.
- Жижүүрийн хүн нь ажилд оруулах цахилгаан байгууламжийн ажилд нарядыг бичихдээ ажилд оруулагчийн нэрийг заалгүйгээр “ш/а ажилтан” гэж бичиж болно.
- 13.“Бригадын бүрэлдэхүүн” гэсэн мөрөнд ажлын хариуцлагатай гүйцэтгэгч, ажиглагч нараас бусад бригадын бүрэлдэхүүнд орж байгаа хүмүүсийн нэрийг бичнэ. Автомашин, механизм, өөрөө явдаг краны төрөл, хэлбэрийг, жолооч, краны машинч, дохиочин, оосорлогч нарыг нэр зааж ялган бичнэ. Жишээ нь: А.Бат II, ТВ-26 шаттай машины жолооч; С.Дорж II, КС-2561 краны машинч; Р.Болд IV, оосорлогч-дохиочин гэх мэт
- 14.“Дараах ажлыг гүйцэтгэхээр даалгав” гэсний дараах мөрүүдэд цахилгаан станц, дэд станцын цахилгаан байгууламж ба кабель шугамд ажил гүйцэтгэх гэж байгаа бол дээр нь ажил гүйцэтгэх цахилгаан байгууламж ба түүний холболтын нэр, хийх ажлын агуулгыг бичнэ. Жишээ нь: Улаанбаатар дэд станц, ИХБ-110, секц холбох тосон таслуурын С фазын оруулга солих гэх мэт бичих ёстой.
- Дүрмийн 115, 116-д заасан ажилд зөвхөн цахилгаан байгууламжийн нэр ба гүйцэтгэх ажлын агуулга хэмжээг бичнэ. Агаарын шугамд ажил гүйцэтгэх бол ЦДАШ-ын нэр, ажил гүйцэтгэх хэсгийн хязгаар (дээр нь буюу дунд нь ажил гүйцэтгэх тулгуур шонгуудын дугаар, аль алгасалтад ажиллах)-ыг гүйцэтгэх ажлын хамт тодорхой

бичнэ. Олон хэлхээт ЦДАШ-дажил гүйцэтгэхэд хэлхээний нэр,фаз тус бүрээр засварлах үед тухайн фазын нэр тэдгээрийн тулгуур дээрх байршилтыг тодорхой бичнэ. Жишээ нь: Төгсгөлийн тулгуур ба ИХБ-ийн порталынхооронд, Дархан-Эрдэнэтийн 220кВ-ын шугамын нэгдүгээр хэлхээнд 48-60 тулгуурын хооронд утас чангалах гэх мэт.

15.“Ажил эхлэх”, “Ажлыг дуусгах” гэсэн мөрөнд тухайн нарыдаар гүйцэтгэх ажлыг эхлэх болон дуусгах он, сар, өдөр, цаг, минутыг бичнэ.

16.“Ажлын байр бэлтгэх арга хэмжээ” гэсэн хүснэгтийг бөглөж бичихдээ цахилгаан станц, дэд станц, ХБ ба кабель шугамд ажил гүйцэтгэх үед:

1-р дүгээр баганад: таслах, залгах аппаратаар үйлдэл хийх ба газардуулга тавих ёстой цахилгаан байгууламжийн нэрийг бичнэ.

2-р багананд: таслах ба залгах үйлдэл хийх тоног төхөөрөмжийн таслах, залгах аппаратын нэр, болон газардуулга тавих хэсгийн нэрийг энэхүү дүрэмд заасан техникийн арга хэмжээний дарааллын дагуу тодорхой бичнэ.

17.ЦДАШ-д ажил гүйцэтгэхэд нарыдын 1-р хүснэгтийг дор дурдсан байдлаар бөглөнө. Үүнд:

1-р баганад: “Даалгав” гэсэн мөрөнд бичсэн шугам хэлхээ, утасны нэр түүнчлэн тухайн ЦДАШ-д ажил гүйцэтгэхэд аюулгүй байдлыг хангахын тулд хүчдэлийг нь тасалбал зохих ба газардуулга тавих шаардлагатай бусад ЦДАШ, хэлхээний нэрийг бичнэ. Жишээ нь: Засварлаж байгаа шугамтай огтлолцсон эсвэл түүнтэй ойрхон байгаа ЦДАШ, олон хэлхээт ЦДАШ-ын бусад хэлхээнүүд г.м.

2-р багананд: ХБ-ын таслах, залгах аппаратуудын нэр, газардуулгаас гадна ЦДАШ-д газардуулга тавих ёстой бүх тулгуур ба алгасалтын дугаарыг бичнэ.

Хэрэв нарыд бичиж олгох үед газардуулга тавих цэгийг тодорхойлж боломжгүй буюу газардуулгыг шилжүүлэн тавьж ажиллах хэрэгтэй байвал энэ багананд “ажлын байранд газардуулга тавь!” гэж бичнэ. 2 дугаар баганад ажил гүйцэтгэгч газардуулга тавих шаардлагатай ажил гүйцэтгэх шугамын ойролцоо байгаа буюу түүнтэй огтлолцсон ЦДАШ-ын нэрийг бичнэ. Хэрэв эдгээр огтлолцсон буюу ойролцоох ЦДАШ-ыг өөр иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашигладаг бол “Тусгай заалт” гэсэн мөрөнд тэр шугамыг ашиглагчийн (нэрээр) тавьсан газардуулгыг “шалга!” гэж бичнэ.

18.1 дүгээр хүснэгтэд ажлын байр бэлтгэхэд шууд хийвэл зохих таслах, залгах аппаратаар гүйцэтгэх үйлдлүүдийг бичих ёстой. Ажлын байр бэлтгэх явцад шууд хамааралтай бус схемийг өөрчлөх зорилготой сэлгэн залгалтуудыг (жишээ нь: нэг систем шинээс нөгөөд шилжүүлэх, сүлжээний хэсгийг нэг талын тэжээлээс нөгөө талын тэжээлд шилжүүлэх гэх мэт) энэ хүснэгтэд бичихгүй.

19.Ажлын байр бэлтгэх шаардлагагүй ажил гүйцэтгэх үед 1-р хүснэгтийн багануудад “шаардлагагүй” гэж бичнэ.

20.“Тусгай заалт” гэсэн мөрөнд дор дурьдсан арга хэмжээнүүдийг бичнэ. Үүнд:

- Ажиллагсадын аюулгүй байдлыг хангах нэмэгдэл арга хэмжээ (хаалт хашилт тавих, байрны доторх агаарт устөрөгчийн хольц байхгүйг шалгах, галын аюулгүй байдлыг хангах г.м.)-г;
- Ажлын удирдагч нь биечлэн тасралтгүй хяналт тавьж гүйцэтгүүлэх ёстой ажлын хэсэг буюу үйлдлүүд;
- Ажлын удирдагч ба ажлын хариуцлагатай гүйцэтгэгчид бригадыг ажлын өөр байранд шилжүүлэх зөвшөөрөл олгосон тухай;
- Ажлын хариуцлагатай гүйцэтгэгчидажилд үргэлжлүүлэн оруулах зөвшөөрөл олгосон тухай;
- Шуурхай үйлчилгээ-засварын ажилтнаас томилогдсон ажилд оруулагч нь ажил бүрэн дууссаны дараа цахилгаан байгууламжийг хүчдэлд залгахаар зөвшөөрөл олгосон тухай;
- Газардуулгыг түр авч, тавих зөвшөөрөл олгосон тухай;

- Ажил гүйцэтгэгчид таслах, залгах аппаратаар үйлдэл хийх зөвшөөрөл олгосон тухай;
- Өргөх машин механизмаар ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа хариуцагчийг томилсон тухай (Жишээ нь: ӨММ хариуцагч Ц.Болд IV);
- Цахилгаан ба соронзон орны нөлөө бүхий ажлын байранд аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээнүүд;
- Засварлаж байгаа шугам нь нөлөөллийн хүчдэлтэй байгааг;
- Наряд олгогч нь гүйцэтгэх ажилтай холбогдолтой бусад арга хэмжээг энэ мөрөнд бичиж болно.

21. “Наряд олгосон” ба “Нарядыг сунгасан” гэсэн мөрүүдэд наряд олгогч нь он, сар, өдөр, цаг, минут, нэрээ бичээд гарын үсэг зурна.

22. 2-р хүснэгтийг ажлын байр бэлтгэх ба ажилд оруулах зөвшөөрөл өгөх, авах үед бөглөж бичээд гарын үсэг зурна.

Энэ хүснэгтийн: **1-р баганад:** ажлын байр бэлтгэх ба ажилд оруулах зөвшөөрлийг шууд биечлэн өгч байгаа хүн нэрээ бичиж гарын үсэг зурна. Хэрэв ажлын байр бэлтгэх ба ажилд оруулах зөвшөөрлийг утсаар буюу бие хүнээр дамжуулан авч байгаа бол ажилд оруулагч зөвшөөрөл өгсөн хүний нэр, албан тушаалыг бичнэ. Мөн хүснэгтийн **2-р баганад:** зөвшөөрөл олгосон он, сар, өдөр, цаг, минутыг бичнэ.

3-р баганад: зөвшөөрлийг авсан хүн нэрээ бичээд гарын үсэг зурна.

Хэрэв ажлын байр бэлтгэх ба ажилд оруулах зөвшөөрлийг 2 өөр хугацаанд өгч байгаа бол 2-р хүснэгтэд 2 мөр бөглөж бичнэ. Үүнд: нэг мөрөнд нь ажлын байр бэлтгэх зөвшөөрлийг, нөгөө мөрөнд нь ажилд оруулах зөвшөөрлийг бичнэ.

Нарядын маягтын ар талыг бөглөж бичих

23. Цахилгаан станц, дэд станцын болон бусад цахилгаан байгууламж, КШ дээр ажиллах үед “Техникийн арга хэмжээг бүрэн авч ажлын байр бэлтгэв. Хүчдэлтэй үлдсэн:” гэсэн мөрөнд ажилд оруулагч нь ажлын байранд хамгийн ойр засвар хийгдэж байгаа ба түүний зэргэлдээх холболтын тоног төхөөрөмжийн хүчдэлтэй үлдсэн гүйдэл дамжуулах хэсгийн нэрийг бичнэ.

ЦДАШ-д ажил гүйцэтгэх үед энэ мөрөнд наряд олгогчоос “Тусгай заалт” гэсэн мөрөнд бичсэн гүйдэл дамжуулах хэсгүүдийг бичихээс гадна шаардлагатай бол бусад гүйдэл дамжуулах хэсгийг бичих ёстой. Ажилд оруулагч ба ажлын удирдагч (хэрэв ажлын удирдагч томилоогүй бол ажил гүйцэтгэгч) нар “Техникийн арга хэмжээг бүрэн авч ажлын байр бэлтгэсэн, Хүчдэлтэй үлдсэн:” гэсэн мөрийг бөглөж бичээд ард нь зөвхөн ажилд анх эхлэн оруулахад гарын үсэг зурна.

24. Нарядаар ажил гүйцэтгэхдээ бригадыг ажилд оруулахаас өмнө энэ дүрэмд заасны дагуу тухайлсан зааварчилгааг өгч зааварчилгаа өгсөн ба авсан бүх хүн 3 дугаар хүснэгтийн дагуу гарын үсэг зурсан байх ёстой. Тухайлсан зааварчилгаа аваагүй хүнээр ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

Тухайлсан зааварчилгааны бүртгэлийн хүснэгтэд нарядад оролцогчид бүгд гарын үсэг зурсан байх нь зааварчилгаа өгсөн ба авсан гэдгийн баталгаа болно.

25. “Өдөр бүрийн ажилд оруулалт ба ажлын төгсгөл ” гэсэн хүснэгтэд өдөр бүр ажилд оруулсан ба ажил дууссан, түүнчлэн ажлын өөр байранд шилжүүлэн ажиллуулсныг бүртгэн бичнэ.

Хэрэв ажил гүйцэтгэгч нь ажилд оруулагчийн үүргийг хавсран гүйцэтгэж байгаа, түүнчлэн ажил гүйцэтгэгчид ажилд дахин оруулахыг зөвшөөрсөн тохиолдолд хүснэгтийн 3 ба 4-р багануудад гарын үсэг зурна.

Ажлын удирдагчид бригадыг ажилд дахин оруулахыг зөвшөөрсөн тохиолдолд тэр хүн 3-р багананд гарын үсэг зурна.

26. “Бригадын бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлт” гэсэн хүснэгтэд бригадын бүрэлдэхүүнээс автомашины жолооч, механизм, краны машинчийг гаргах, аль эсвэл тэдгээрийг бригадын бүрэлдэхүүнд нэмж оруулах тохиолдолд жолооч буюу машинчийн нэрийг эзэмшиж байгаа машин, механизм, краны төрөл, загварыг хамт бичнэ.

Хүснэгтийн 4-р баганад бригадын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгосон хүн гарын үсэг зурна. Зөвшөөрлийг холбооны хэрэгслээр дамжуулан өгсөн бол ажил гүйцэтгэгч нь 4-р баганад зөвшөөрөл өгсөн хүний нэрийг бичнэ.

27. Ажлыг бүрэн дуусгасны дараа ажил гүйцэтгэгч ба ажлын удирдагч нь ажлыг бүрэн дуусгасан он, сар, өдөр, цаг, минутыг харгалзах мөрөнд бичээд энэ тухай мэдэгдэх ба мэдээллийг хүлээн авсан ажилтны ажил, нэрийг бичээд гарын үсэг зурцгаана. Хэрэв ажлын удирдагч томилогдоогүй бол түүний гарын үсэг зурах зайг хоосон үлдээнэ.

Хэрэв ажлыг бүрэн дуусгасан тухай бүртгэн бичих үед шуурхай ажиллагаа эсвэл шуурхай үйлчилгээ-засварын хүмүүсээс томилогдсон ажилд оруулагч буюу жижүүр байхгүй, аль эсвэл ажил гүйцэтгэгч нь ажилд оруулагчийн үүргийг хавсран гүйцэтгэж байгаа тохиолдолд ажил гүйцэтгэгч нь ажлыг бүрэн дуусгасан тухай зөвхөн өөртөө байгаа нарядын хувь дээр бүртгэх ба ажилд оруулагч өөрөө байгаа бол ажил гүйцэтгэгч нь нарядын 2 хувьд ажлыг бүрэн дуусгасан тухай бүртгэн бичээд гарын үсэг зурна.

Хэрэв бригад газардуулга тавиагүй бол “бригадын ажлын байранд тавьсан газардуулгыг авсныг” гэсэн хэсгийг нэг дарж зурна.

Хавсралт 4

НАРЯД БА ШИЙДВЭРЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН БҮРТГЭЛ

Цахилгаан байгууламжид наряд ба шийдвэрээр гүйцэтгэсэн ажлыг дор дурьдсан загварын тусгай журналд бүртгэнэ.

Нарядаар ажил гүйцэтгэх үед эхний удаа ажилд оруулсныг тэмдэглэн бичих ба нарядын дугаар, ажлын байр, ажлын нэр, ажлыг эхлэх ба бүрэн дуусгах (2, 3, 9, 10 дугаар асуултууд) хугацааг бичиж бүртгэх ба шийдвэрээр ажил гүйцэтгэхэд журналын хоёрдугаар баганаас (нарядын дугаар) бусад бүх багануудыг бөглөж бичнэ.

Наряд шийдвэрээр гүйцэтгэсэн ажлыг байгууллагын удирдлагаас тогтоосон өөр арга хэлбэрээр бүртгэх, журналын загварт нэмэлт өөрчлөлт оруулж болно. Тэгэхдээ энэ журналын загварт тусгасан бүртгэвэл зохих мэдээллүүдийг орхигдуулж болохгүй.

Наряд, шийдвэрээр гүйцэтгэсэн ажлыг журналд бүртгэсэн эсэхээс үл хамааран тухайн ажлыг гүйцэтгэхээр ажилд орсон тухай шуурхай ажиллагааны журналд заавал тэмдэглэсэн байх ёстой.

Нарядаар ажил гүйцэтгэх үед шуурхай ажиллагааны журналд эхний удаа болон өдөр тутмын ажилд оруулсан тухай тэмдэглэнэ.

Шийдвэрээр ажил гүйцэтгэх үед бүртгэл журналын наймдугаар баганад тухайлсан зааварчилгааны товч утга агуулгыг бичээд зааварчилгаа авсан ба өгсөн ажилтан гарын үсэг зурна.

Наряд, шийдвэрээр гүйцэтгэсэн ажлын бүртгэл журналын хуудсуудыг дугаарлан үдэж утасны үзүүрийг хавтсанд наагаад байгууллагын тамга дарж битүүмжилсэн байна. Журналыг хамгийн сүүлчийн бүртгэгдсэн ажил бүрэн дууссанаас хойш нэг жил хадгална.

ЖУРНАЛЫН ЗАГВАР

Дэс дугаар	Наряд, шийдвэрийн дугаар	Ажлын байр ба хийх ажлын нэр	Ажил гүйцэтгэгч (хянагч)-ийн овог нэр, аюулгүй ажиллагааны групп	Бригадын гишүүдийн овог нэр, аюулгүй ажиллагааны групп	Наряд олгосон, шийпвэр өгсөн хүний овог нэр, аюулгүй ажиллагааны групп	Аюулгүй ажиллагаа хангах техникийн арга хэмжээ, заавал хийх таслалт, газардуулга тавих газар, хаалт хашилт, плакат, онцгой нөхцөл гэх мэт	Тухайлсан зааварчилгааны утга, зааварчилгаа өгсөн ба авсан ажилтны гарын үсэг	Ажил эхэлсэн он, сар, өдөр, цаг, минут	Ажил бүрэн дууссан он, сар, өдөр, цаг, минут
	1	2	3	4	5	6	7	8	9
1									
2									
3									

Хавсралт № 5

ЦАХИЛГААН БАЙГУУЛАМЖИД АЖИЛЛАХ АЖИЛТНААС АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРМИЙН МЭДЛЭГИЙН ШАЛГАЛТ АВСАН БҮРТГЭЛ

№	Шалгуулагчийн овог, нэр	Албан тушаал	... /Шалгалтын нэр/					
			Шалгалтанд хамрагдсан огноо	Шалгасан шалтгаан	Протоколын дугаар	Мэргэжлийн групп, зэрэг	Дүн	Шалгуулагчийн гарын үсэг
1.								
2.								
3.								

Жич: Шалгасан шалтгаан: - анхны
 - ээлжит
 - ээлжит бус

**ЦАХИЛГААН БАЙГУУЛАМЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД АЖИЛЛАХ
ХҮНЭЭС ТЕХНИК АШИГЛАЛТИЙН ДҮРЭМ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
ДҮРМИЙН МЭДЛЭГИЙН ШАЛГАЛТ АВСАН ПРОТОКОЛ**

20 ... оны ... сарын ... –ны өдөр

Дугаар ...

(Хот, аймаг)

Байгууллагын нэр _____

Хэсэг, нэгжийн нэр _____

Овог нэр _____

Албан тушаал _____

Мэргэжлийн зэрэг, АА-ны групп _____

Энэ албан тушаалаар ажилласан жил _____

Шалгалт авах болсон шалтгаан _____

д/д	Асуултын утга	Дүн
0	1	2

ТАД _____

ААД _____

Ерөнхий дүн _____

Комиссын шийдвэр

.....

.....

Дараагийн шалгалтыг ... оны ... сарын ... –ны өдөр өгөхийг үүрэг болгов.

Шалгалт өгсөн хүний гарын үсэг. /


Комиссын дарга

Гишүүд

.....

.....

ЦАХИЛГААН БАЙГУУЛАМЖУУДЫН СХЕМД
ГАЗАРДУУЛГА ТАВИХ ЖИШЭНҮҮД




Зураг 1. Зураг 2.Зураг 3.

Зураг 1. Цахилгаан хөдөлгүүр дээр ажиллах үед газардуулга тавих жишээ


Зураг 2. Хоёр ороомогтой хүчний трансформатор дээр ажиллах үед газардуулга тавих жишээ

Зураг 3. Секцийн реактор ба түүний таслуур дээр ажиллахад газардуулга тавих жишээ




Зур. 4. “Гүүр” схемтэй дэд станцад 2 дугаартрансформаторын шугамын салгуур ба холболтын таслуур дээр ажиллах үед газардуулга тавих жишээ


Зур.5. Генератор-трансформаторын блок Генератор, блокт трансформатор ба дотоод хэрэгцээний трансформаторт ажиллах үед газардуулга тавих жишээ




Зураг 6.1.35 кВ-ын салбарласан ЦДАШ-д газардуулга тавих (ажлын байран дээр тавих газардуулга зурагдаагүй) жишээ



Зураг 6.2. 35 кВ-ын салбарласан ЦДАШ-д газардуулга тавих (ажлын байран дээр тавих газардуулга зурагдаагүй) жишээ



Зураг 7. Салбарласан 10 кВ-ын ЦДАШ-ын газардуулгын төхөөрөмжтэй тулгуурт газардуулга (ажлын байран дээр тавих газардуулга зурагдаагүй) тавьсан жишээ
1-цахилгаан тэжээлийн эх үүсвэр 2-тулгуур 3-салбар ЦДАШ 4-ажлын байр



Зураг 8. Нөлөөллийн хүчдэлтэй ЦДАШ-ын анкерт

ОСОЛДОГЧИЙГ ЦАХИЛГААН ГҮЙДЛИЙН ҮЙЛЧЛЭЛЭЭС ЧӨЛӨӨЛӨХ

Цахилгаан гүйдлийн үйлчлэх хугацаанаас гэмтлийн хүндрэл хамаардаг учир цахилгаан гүйдэлд нэрвэгдэгчийг гүйдлийн үйлчлэлээс аль болох хурдан чөлөөлөх шаардлагатай байдаг.

Хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулагчид хүрэх үед ихэнх тохиолдолд булчин өөрийн эрхгүй цочирч агших ба амьсгалын болон цусны эргэлтийн үйл ажиллагааг алдагдуулах цаашилбал бүрэн зогсооход хүргэж болох ерөнхий цочрол үүсдэг байна.


Хэрэв нэрвэгдэгч утсыг барьсан байдалтай байвалбулчин, шөрмөс цочирч агшсаны улмаас түүний хуруунууд нь хүчтэй атгагдаж уг утаснаас чөлөөлөх боломжгүй болсон байдаг тултусламж үзүүлэгчийн анхны үйлдэл нь нэрвэгдэгчийн хүрсэн тоног төхөөрөмжийн тэр хэсгийг хүчдэлээс хурдан салгахад оршдог.

Таслалтыг аль ойрхон байгаа таслагч рубильник болон бусад таслах салгах аппаратаар эсвэл холбогдох шуурхай ажиллагааны ажилтандмэдэгдэх замаар гүйцэтгэнэ.

Хэрэв нэрвэгдэгч өндөрт байгаа бөгөөд төхөөрөмжийг тасалж, нэрвэгдэгчийг гүйдлээс чөлөөлөх үед унах аюултай тохиолдолд өндрөөс унахаас урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай.

Харанхуй үед цахилгаан төхөөрөмжийг тасалснаар гэрэлтүүлгүүд унтарч болзошгүй үед өөр эх үүсвэр /байрны тэсрэлт, галын аюултай байдлыг харгалзан аваарийн буюу аккумуляторын гэрэлтүүлэг гэх мэт/-ээс гэрэлтүүлгээр хангах шаардлагатай боловч юуны өмнө төхөөрөмжийг таслах, нэрвэгдэгчид тусламж үзүүлэхийг урьтал болгох ёстой.

Хэрэв төхөөрөмжийг рубильник болон бусад таслах салгах аппаратаар таслах боломжгүй тохиолдолд нэрвэгдэгчийн хүрсэн гүйдэл дамжуулах хэсгээс чөлөөлөх өөр төрлийн арга хэмжээг өөрийн аюулгүй байдлаа хангасаны үндсэн дээр авах шаардлагатай. Энэ тохиолдолд тусламж үзүүлэгч нь өөрийн аюулгүй байдлыг хангаж урьдчилан сэргийлэх зохих арга хэмжээг авалгүйгээр нэрвэгдэгчид хүрэхийг хориглоно.



Зураг 9. Холбогдох шуурхай ажиллагааны ажилтанд мэдэгдэх замаар хүчдэлээс чөлөөлөх

1. 1000В хүртэлх хүчдэлд нэрвэгдэгчийг чөлөөлөх

1000В хүртэл хүчдэлтэй утас эсвэл гүйдэл дамжуулах хэсгээс нэрвэгдэгчийг чөлөөлөхийн тулд хуурай олс, модон саваа, банз мэтийн цахилгаан гүйдэл дамжуулдаггүй зүйлийг ашиглавал зохино.


Хэрэв осолдогчийн хувцас хуурай, биендээ наалдаагүй хөндий байх үед түүний пиджак, пальтоны зах, хормойноос татаж салгах ба энэ үед өөрөө орчины металл зүйлс болон нэрвэгдэгчийн нүцгэн биед хүрэхээс болгоомжлох ёстой.

Хөндийрүүлэх сайн жийрэг хэрэглэхгүйгээр нэрвэгдэгчийн гутал, хувцсанд хүрч, хөлнөөс татаж болохгүй. Учир нь түүний гутал хувцас нь цахилгаан гүйдэл дамжуулахаар чийгтэй байж болно.

Нэрвэгдэгчийн нүцгэн биед зайлшгүй хүрэх шаардлагатай үед тусламж үзүүлэгч нь хөндийрүүлэх бээлий өмсөх, гараа хүзүүний ороолтоор ороох, цэмбэн малгай, пиджак буюу пальтоны ханцуйгаар гараа жийрэглэх, нэрвэгдэгч дээгүүр резинэн дэвсгэр, резин бүхий зүйлс эсвэл хуурай даавуу нөмөргөх замаар өөрийн гараа хөндийрүүлнэ. Мөн хуурай банз, резинэн дэвсгэр бусад цахилгаан гүйдэл дамжуулдаггүй дэвсгэр, эвхэж тавьсан хувцас зэрэг дээр зогсож өөрийгөө хөндийрүүлж болно.

Хэрэв цахилгаан гүйдэл нэрвэгдэгчээр дамжин газар руу урсахад тэр нь гүйдэл дамжуулагч элементыг гараараа атган зуурсан байдаг тул түүнийг газраас хөндийрүүлэн гүйдлийг таслах нь хялбар байдаг.

Гүйдэл дамжуулах хэсгээс нэрвэгдэгчийг чөлөөлөхдөө нэг гараараа ажиллавал зохино. Энэ үед өөрөө ба нэрвэгдэгчийн талаар дээр дурдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг баримтлана. Тэрчлэн хуурай иштэй сүхээр утсыг тас цавчих буюу хөндийрүүлсэн бариултай багажаар тас хазуулж болно. Тэгэхдээ банз модон шат мэтийн зүйл дээр зогсож фаз тус бүрийн утсыг тус тусад нь тас цавчиж, хазуулбал зохино. Мөн хөндийрүүлэгчгүй багажийг хуурай материалаар ороогоод ашиглаж болно.



Зураг 10. Цахилгааныг таслах замаар осолдогчийг гүйдлээс чөлөөлөх



Зураг 11. Хуурай хувцаснаас татах замаар осолдогчийг гүйдлээс чөлөөлөх

2. 1000 В-оос дээш хүчдэлд нэрвэгдэгчийг чөлөөлөх


1000 В-оос дээш хүчдэлтэй гүйдэл дамжуулах хэсгээс нэрвэгдэгчийг чөлөөлөхийн тулд хөндийрүүлэгч бээлий, бот өмсөж уг хүчдэлд тооцсон штанг, эсвэл хөндийрүүлэгч бахийг хэрэглэнэ. /Зураг 12/

Энэ үед гүйдэл дамжуулах хэсэг /утас гэх мэт/ газарт хэвтэж байвал, алхмын хүчдэлд өртөж болзошгүйг санаж ажиллавал зохино. Түүнчлэн нэрвэгдэгчийг гүйдэл дамжуулах хэсгээс чөлөөлсний дараа түүнийг энэхүү аюултай бүсээс гаргах хэрэгтэй.

Цахилгаан дамжуулах шугамыг тэжээлийн цэгээс хурдан таслах боломжгүй тохиолдолд утсан дээгүүр зөөлөн металл утас шидэж богино залгаа хийх замаар таслаж болно. Энэ тохиолдол уг утас нь богино залгааны гүйдэл гүйхэд шатаж тасархааргүй хангалттай хөндлөн огтлолтой байх ёстой.

Утсыг шидэхийн өмнө нэг үзүүрийг төмөр тулгуурын их бие, газардуулагч утас гэх мэтэд холбож газардуулах хэрэгтэй.

Шидэхэд хялбар болгохын тулд утасны үзүүрт ачаа бэхэлбэл зохих ба нэрвэгдэгчдийн тухайн хүрсэн утсыг л газардуулахад хангалттай.



Зураг 12. 1000В-оос дээш хүчдэлээс хамгаалах хэрэгслийн тусламжтайгаар нэрвэгдэгчийг чөлөөлөх

ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН ҮЗЛЭГ, ТУРШИЛТЫН НОРМ

№	Хамгаалах хэрэгсэл ба түүний хэсгийн нэр	Хэрэглэх хэвийн хүчдэл	Туршилтын хүчдэл	Туршилтын хугацаа (минут)	Нэвчих гүйдэл МА-аас багагүй	Ээлжит хугацаа	
						Турших	Үзлэг хийх
1	Хөндийрүүлэх штанг /хэмжүүрийнхээс бусад/	110кВ хүртэл	Шугамын хүчдэлээс 3 дахин их, гэхдээ 40кВ-оос багагүй	5	-	24 сард	12 сард
		110-500кВ	Фазын хүчдэлээс 3 дахин их	5	-	24 сард	12 сард
2	Нум унтраах төхөөрөмжтэй штанг /нум унтраах төхөөрөмжийн авалцаа тасархай үед/	110-220кВ	40кВ	5	-	12 сард	12 сард
3	Хэмжүүрийн штанг	110кВ хүртэл	Шугамын хүчдэлээс 3 дахин их, гэхдээ 40кВ-оос багагүй	5	-	Хэмжилтийн улирал 3 сард 1 удаа	Ашиглахын өмнө
	Хэмжүүрийн штангын толгой	35-500кВ	40кВ	5	-	адил	адил
4	Гулгагч толгойны тууш ба хөндлөн тууз, хэмжүүрийн штангын нийлэг мяндсан хөндийрүүлэх татлага	220-500кВ	1 см-д 2.2кВ	5	-	Хэмжилтийн улирал эхлэхийн өмнө 12 сард	Ашиглахын өмнө
5	Хүчдэлтэй нөхцөлд засвар хийх, ажил гүйцэтгэхэд зориулсан хөндийрүүлэх байгууламжууд ба хэрэгслүүд	110кВ хүртэл	Шугамын хүчдэлээс 3 дахин их, гэхдээ 40кВ-оос багагүй	5	-	6 сард	Ашиглахын өмнө
		110кВ-оос дээш	Фазын хүчдэлээс 3 дахин их	5	-	6сард	Ашиглахын өмнө
6	Хөндийрүүлэх бахь	1000В хүртэл	2кВ	5	-	24 сард	12 сард
		2-35кВ	Шугамын хүчдэлээс 3 дахин их гэхдээ 40кВ-оос багагүй	5	-	24 сард	12 сард
7	Хэмжүүрийн бахь	40В хүртэл	500В	5	-	12 сард	6 сард
		400-600В	2кВ				
		600-1000В	3кВ				
		2-10кВ	40кВ				
8	Гэрэлтэй 1000В-оос дээш хүчдлийн заагуур	2-35кВ	Шугамын хүчдэлээс 3 дахин их, гэхдээ 40кВ-оос багагүй	5	-	12 сард	Ашиглахын өмнө
	Ажлын хэсэг	6-10кВ	40кВ	1	-	12 сард	Адил
		10-35кВ	70кВ	1	-	12 сард	Адил
	Хөндийрүүлэх хэсэг	35-220кВ	Фазын хүчдэлээс 3 дахин их	5	-		
	Гэрэл асах хүчдэлийн доод хэмжээ	6-35кВ	9кВ	-	-		
	Авалцаагүй төрлийн 1000В-оос дээш хүчдэл	6-10кВ	105кВф	5	-	24 сард	Ашиглахын өмнө
9	Заагуур хөндийрүүлэх хэсэг салдаг электрод	6-10кВ	20кВ	1	-	24 сард	Ашиглахын өмнө
	Фаз тохируулахад зориулсан хүчдэл заагуур, хөндийрүүлэх хэсэг ба туслах гуурсууд	6-10кВ	40кВ	5	-	12 сард	6 сард
	Ажлын хэсэг	6кВ	20кВ	1	-		
	Туслах гуурсны гүйдэл	6кВ	6кВ	1	-	2.4	
	Хязгаарлах эсэргүүцэл	10кВ	10кВ	1	-	1.7	
10	Холболтын утас	2-10кВ	20кВ	1	-	20	
	1000 В хүртэл хүчдэл заагуурын гэрэл асах хүчдэлийн доод хэмжээ,	660В хүртэл	90 В	-	-		
	1000 В хүртэл хүчдэл заагуурын их бие, холбох утас	500В хүртэл	1кВ	1	-	12сард	6 сард
11	Хөндийрүүлэг	660В хүртэл	2кВ	1	-		
	Схемийн хэвийн ажиллагааг шалгах нэг туйлт заагуур	500В хүртэл	600В	1	4	12 сард	6 сард
		660В хүртэл	750В	1	0.6	12 сард	6 сард

	Хоёр туйлт заагуур	660В хүртэл	750В	1	4		
12	Хөндийрүүлэх резинэн бээлий	1000В хүртэл	2.5кВ	1	3.0	6 сард	Ашиглахын өмнө
		1000В-оос дээш хүчдэлд	6кВ	1	7.0		
13	Хөндийрүүлэх резинэн бойтог (бот)	1000В хүртэл	3,5 кВ	1	2	12 сард	Ашиглахын өмнө
	Хөндийрүүлэх резинэн шаахай	1000В-оос дээш хүчдэлд	15кВ	1	27.5	36 сард	
14	Хөндийрүүлэх резин дэвсгэр	Бүх хүчдэлд	ГОСТ 4997-68-ын	-	-		
	Хөндийрүүлэх жийрэг хатуу резин	10кВ хүртэл	20кВ	5	-	24 сард	12 сард
		15кВ хүртэл	30кВ	5	-	24 сард	
		1000В хүртэл	5кВ	1	6	36 сард	
15	Хөндийрүүлэх тавцан	10кВ хүртэл	36кВ	1	-	36 сард	Ашиглахын өмнө
16	Хөндийрүүлэгтэй бариултай багажууд	1000В хүртэл	2кВ	1	-	12 сард	Ашиглахын өмнө

Тайлбар: Монтёрын хамгаалах бүс ба бие хамгаалахад хэрэглэх оосор татлагыг 225кг ачаагаар 6 сард 1 удаа 5 минут, монтёрын дөрөөг 135 кг ачаагаар 6 сард 1 удаа 5 мин туршин бөх батыг магадлаж байх ёстой.

Энэхүү хамгаалах хэрэгслийн үзлэг, туршилтын нормыг үйлдвэрлэгчээс тогтоосон туршилтын зааваргүй хамгаалах хэрэгслийг туршихад мөрдөнө. Туршилт, ашиглалтын заавар бүхий хамгаалах хэрэгслийг үйлдвэрлэгчээс нь тогтоосон зааврын дагуу гүйцэтгэнэ.

Хавсралт 10

ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН ХАНГАЛТЫН НОРМ

№	Хамгаалах хэрэгсэл	Тоо ширхэг
0	1	2
А. Байнгын жижүүртэй буюу шуурхай ажиллагааны ажилтан байнга үйлчилдэг 1000В-оос дээш хүчдэлийн хуваарилах байгууламж		
1	Хөндийрүүлэх штанг	Хүчдэл тус бүрт 2ш
2	Хүчдэл заагуур	110кВ хүртэл хүчдэл тус бүрт 2ш
3	Хөндийрүүлэх бахь	Хайламтгай хамгаалууртай хүчдэл тус бүрт (35кВ хүртэл) 1ш
4	Хөндийрүүлэх резинэн бээлий	2 хос
5	Байнгын газардуулгагүй ХБ-д зөөврийн газардуулга	Хүчдэл тус бүрт 2-оос цөөнгүй
6	Байнгын газардуулгагүй ХБ-д зөөврийн газардуулга	Ажлын байрны нөхцөлөөр 1-2ш
7	Зөөврийн хаалт самбар	2-оос цөөнгүй
8	Урьдчилан сэргийлэх плакат	Холболтын тоогоор, иж бүрэн
9	Хашилт хийх олс, мяндсан татлага (10-15м)	ИХБ-д 2-оос цөөнгүй
10	Нүүр хамгаалах хэрэгсэл (нүүрэвч)	2ш
11	Хорт утааны баг	2ш
12	Зүүдэг цоож	Хөшигтэй ячейк, хаалганы тоогоор
13	Резинэн бот	2 хос
14	Резинэн дэвсгэр	2м
15	Хошуувч	2ш
16	Хорт утааны баг	2ш
17	Гар чийдэн	1ш
Б. Шуурхай ажиллагааны ажилтан байнга үйлчилдэггүй буюу байнгын жижүүргүй, төвлөрсөн үйлчилгээтэй 1000В-оос дээш хүчдэлийн хуваарилах байгууламж		
1	Хөндийрүүлэх штанг	Хүчдэл тус бүрт 1ш
2	Хөндийрүүлэх резинэн бот	1 хос
3	Зөөврийн хаалт самбар	2ш-ээс цөөнгүй
4	Урьдчилан сэргийлэх плакат	Холболтын тоогоор
5	Зөөврийн газардуулга	Хүчдэл тус бүрт 2ш-ээс цөөнгүй
6	Нүүр хамгаалах хэрэгсэл (нүүрэвч)	2 хос
В. Шуурхай ажиллагааны хүмүүс байнга үйлчилдэг буюу байнгын жижүүртэй 1000В хүртэл хүчдэлийн хуваарилах байгууламж		
1	Хүчдэл заагуур	1ш
2	Хөндийрүүлэх бахь	1ш

3	Хөндийрүүлэх резинэн шаахай	2 хос
4	Хөндийрүүлэх резинэн бээлий	2 хос
5	Хөндийрүүлэх резинэн дэвсгэр	2м
6	Нүүр хамгаалах хэрэгсэл (Нүүрэвч)	2ш
7	Урьдчилан сэргийлэх плакат	5 бүрдмэл
8	Түр хаалтын самбар, жийргэвч	Тус бүр 2ш
9	Гар чийдэн	1ш
Г. Дэд станцад үйлчилдэг явуулын шуурхай үйлчилгээ-засварын бригад		
1	Шуурхай ажиллагааны штанг	Хүчдэл тус бүр 1ш
2	Хөндийрүүлэх бахь	Хүчдэл тус бүр 1ш
3	110-330кВ-ын шуурхай ажиллагааны штанг	1ш
4	1000В-оос дээш хүчдэлийн заагуур	Хүчдэл тус бүрт 2ш
5	1000В хүртэл хүчдэлийн заагуур	2ш
6	Хөндийрүүлэх резинэн бээлий	Хүчдэл тус бүрт 2ш
7	Нүүр хамгаалах хэрэгсэл (Нүүрэвч)	2ш
8	Монтёрын хамгаалах бүс	2ш
9	Хөндийрүүлэх резин	2хос
10	Хөндийрүүлэх бариултай слесарийн багаж	Иж бүрэн 1ш
11	Плакат санамжууд	Ажлын байрны нөхцөлөөр
12	Зөөврийн газардуулга	Ажлын байрны нөхцөлөөр
13	Хорт утааны баг	2ш
14	Фаз тохируулах багаж	2ш
15	Гар чийдэн	1ш
Д. Агаарын шугамд үйлчилдэг шуурхай үйлчилгээ-засварын бригад		
1	Зөөврийн иж бүрэн газардуулга	Хүчдэл тус бүрт 4ш
2	Нум унтраах төхөөрөмжтэй штанг (фаз тус бүрээр засварлах үед)	1ш
3	Хүчдэл заагуур буюу шуурхай ажиллагааны штанг	1ш
4	Тросыг газардуулахад зориулсан штанг	1ш
5	Шугам хүчдэлтэй нөхцөлд ажилгүйцэтгэхэд зориулсан хамгаалалтын хувцас, багаж хэрэгсэл	Иж бүрнээр 5 хүний
6	Хөндийрүүлэх резинэн бээлий	3хос
7	Нүд хамгаалах хэрэгсэл	2ш
8	Нүүр хамгаалах хэрэгсэл (Нүүрэвч)	2ш
9	Монтёрын хамгаалах бүс	5ш
10	Плакат санамжууд татлага (50м хүртэл)	2ш
11	Хошуувч	2ш
12	Хорт утааны баг	2ш
13	Гар чийдэн	1ш
Е. Хуваарилах цахилгаан шугам сүлжээ, үйлдвэрийн дотоод цахилгаан байгууламжуудыг үйлчилдэгшуурхай ажиллагааны болон шуурхай үйлчилгээ-засварын бригад		
1	Төрөл бүрийн зориулалтын штанг	Хүчдэл тус бүрт 2ш
2	Хөндийрүүлэх бахь	Хүчдэл тус бүрт 1ш
3	1000В-оос дээш хүчдэлийн заагуур	Хүчдэл тус бүрт 2ш
4	1000В хүртэл хүчдэлийн заагуур	2ш
5	Хөндийрүүлэх резинэн бээлий	2 хос (хүчдэл тус бүрт)
6	Хөндийрүүлэх бот	2 хос
7	Хөндийрүүлэх шаахай	2 хос
8	Фаз тохируулах багаж	Ажлын байрны нөхцөлөөр
9	Плакат санамжууд	Ажлын байрны нөхцөлөөр
10	Зөөврийн газардуулга	Ажлын байрны үежлөөр (2-оос доошгүй)
11	Монтёрын бүс	Иж бүрнээр (2-оос цөөнгүй)
12	Нүүр хамгаалах хэрэгсэл (Нүүрэвч)	2ш
13	Гар чийдэн	1ш

Тайлбар: Шуурхай ажиллагааны ажилтан байнга үйлчилдэггүй буюу байнгын жижүүргүй, төвлөрсөн үйлчилгээтэй 1000 В-оос дээш хүчдэлийн хуваарилах байгууламжид хамгаалах хэрэгслийг байнга байрлуулах боломжгүй тохиолдолд тухайн байгууламжид ажил гүйцэтгэх үед ажилтныг хамгаалах хэрэгслээр бүрэн хангах зохион байгуулалтын арга хэмжээг байгууллага нь өөрийн онцлогтоо тохируулан хэрэгжүүлж болно.

ПЛАКАТ

Анхааруулах плакат



1. Дэвсгэрийн хэмжээ 200x160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 10 мм хар хүрээтэй, шар дэвсгэртэй адил талт гурвалжин дотор хар өнгийн сум байна. Доод хэсэгт “Бүү хүр! Аюултай” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ.

1000 В хүртэл хүчдлийн цахилгааны тоолуурын нэгдсэн хайрцаг, тоног төхөөрөмжийн их бие тэдгээрийн хаалтууд дээр байрлуулах байнгын плакат юм.

Анхааруулах плакат



2. Дэвсгэрийн хэмжээ 280x210 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 10 мм хар хүрээтэй, шар дэвсгэртэй адил талт гурвалжин дотор хар өнгийн сум байна. Доод хэсэгт “Өндөр хүчдэл! Аюултай” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ.

Хуваарилах байгууламж, дэд станцын хаалганы болон хашааны гадна талд байнга байлгахаар хадаж бэхлэнэ.

Анхааруулах плакат



3. Дэвсгэрийн хэмжээ 230x160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 10 мм хар хүрээтэй, шар дэвсгэртэй адил талт гурвалжин дотор хар өнгийн сум байна. Доод хэсэгт “Зогс! Өндөр хүчдэл” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ.

Ажлын байртай зэрэгцээ буюу эсрэг харсан ХХБ-ын хаалт, хүн явах зам, зөөврийн хаалт самбар, хөл хорьсон газруудад тавьсан түр хаалт, ИХБ-д болон ажлын байрны эргэн тойронд орших гүйдэл дамжуулах хэсгүүдийг хаасан бүх төрлийн хаалт хашилт дээр тавих зөөврийн тэмдэг юм.

Анхааруулах плакат



4. Дэвсгэрийн хэмжээ 230x160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 10 мм хар хүрээтэй, шар дэвсгэртэй адил талт гурвалжин дотор хар өнгийн сум байна. Доод хэсэгт “Бүү авир! Аюултай” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ.

Ажилтныг өргөхөд зориулсан механизм болон өндөрт байрлалтай ажлын байрны зэргэлдээ оршиж байгаа хийц хэсгүүд нэг бүр дээр нүдэнд харагдахуйц тавьж хэрэглэх зөөврийн тэмдэг юм.

Анхааруулах плакат



5. Дэвсгэрийн хэмжээ 230x160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 10 мм хар хүрээтэй, шар дэвсгэртэй адил талт гурвалжин дотор хар өнгийн сум байна. Доод хэсэгт “Зогс! Аюултай” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ.

1000В хүртэл хүчдэлийн цахилгаан тоног төхөөрөмжийн их бие тэдгээрийн хаалтууд дээр ажлын байрыг хязгаарлахад тавьж хэрэглэх зөөврийн плакат юм.

Анхааруулах плакат



6. Дэвсгэрийн хэмжээ 390x280 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 10 мм хар хүрээтэй, шар дэвсгэртэй адил талт гурвалжин дотор хохимой толгойн зургийг хараар, сумыг улаанаар зурсан байна. Доод хэсэгт “Бүү авир! Үхэл” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ.

1000В-оос дээш хүчдэлийн ЦДАШ-ын тулгуурт газраас 2,5-3 метрийн өндөрт байрлуулах байнгын плакат юм. Төв, суурин газарт тулгуур бүрт байрлуулах ба төв, суурин газрын гадна нэг тулгуур алгасаж байрлуулна. Төмөр ба модон тулгуур дээр хадаж, төмөр бетон тулгуур дээр барлаж болно.

Анхааруулах плакат



7. Дэвсгэрийн хэмжээ 230x160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 10 мм хар хүрээтэй, улбар шар дэвсгэртэй адил талт гурвалжин дотор хар өнгийн “гал”-ны зураг байна. Доод хэсэгт “Галын аюултай! Устөрөгч” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ.

Устөрөгчөөр дүүргэсэн шугам хоолой, тоноглолуудын их бие, хий, тосны системийн төхөөрөмж устөрөгчийн хий хадгалах саван дээр тавьж хэрэглэх плакат юм.

Анхааруулах плакат



8. Дэвсгэрийн хэмжээ 230x160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 10 мм хар хүрээтэй, шар дэвсгэртэй адил талт гурвалжин дотор хар өнгийн сум байна. Доод хэсэгт “Туршилт! Амь насанд аюултай” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ.

Туршиж байгаа тоног төхөөрөмж, туршилтын төхөөрөмж ба тэдгээрийн холболтын утаснуудын эргэн тойронд хашлага ба олсоор хаалт хийж түүн дээр бичигтэй талаар нь гадагш харуулан тавих ба кабель шугам турших үед хэрвээ түүний нөгөө талын үзүүр нь бүрдмэл хуваарилах байгууламжийн түгжээтэй шүүгээ, өрөө буюу байранд байрласан бол түүний хаалга буюу хаалтан дээр тавих плакат юм.

Хориглох плакат



1. Дэвсгэрийн хэмжээ 200x160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 15 мм өргөн улаан дугуй дотор хар өнгийн сумтай, сумыг нь дайруулсан 45° налуу улаан зураастай байна. Доод хэсэгт “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ. Энэхүү плакатыг 80x50 мм хэмжээтэй хийж алсын удирдлагын түлхүүр, залгуур дээр ашиглаж болно.

Ажлын байранд хүчдэл өгч болзошгүй бүх таслах, залгах аппаратуудын залуур, дамжуулга дээр томыг нь, алсын удирдлагын түлхүүр, унтраалга, бариул, товлуур дээр жижгийг нь тавих зөөврийн плакат юм.

Хориглох плакат



2. Дэвсгэрийн хэмжээ 200х160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 15 мм өргөн улаан дугуй дотор хар өнгийн сумтай, сумыг нь дайруулсан 45° налуу улаан зураастай байна. Доод хэсэгт “Бүү нээ! Хүмүүс ажиллаж байна” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ. Энэхүү плакатыг 80х50 мм хэмжээтэй хийж болно.

Технологийн болон удирдлагын хий, шингэний шугам хоолойг хаасан хаалтууд, ажлын байрыг хязгаарласан хаалга, хаалт, хашилт дээр бичигтэй талыг нь ажлын байр руу харуулж байрлуулах ба жижиг хэмжээтэйг нь алсын удирдлагын түлхүүр, унтраалга, бариул, товлуур зэрэг дээр тавих зөөврийн плакат юм.

Хориглох плакат



3. Дэвсгэрийн хэмжээ 200х160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 15 мм өргөн улаан дугуй дотор хар өнгийн сумтай, сумыг нь дайруулсан 45° налуу улаан зураастай байна. Доод хэсэгт “Бүү залга! Шугаман дээр хүнтэй” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ. Энэхүү плакатыг 80х50 мм хэмжээтэй хийж болно.

ЦДАШ, кабель шугам, холбооны агаарын шугам, холбооны кабель шугам болон төрөл бүрийн зориулалттай шугам хоолой дээр ажил гүйцэтгэх үед ажлын байр руу хүчдэл өгч болзошгүй бүх таслах, залгах аппаратуудын залуур, дамжуулга зэргийн бариул дээр томыг нь, алсын удирдлагын түлхүүр, товчлуур, унтраалга, бариул дээр жижгийг нь тавих зөөврийн плакат юм.

Хориглох плакат



4. Дэвсгэрийн хэмжээ 200x160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 15 мм өргөн улаан дугуй дотор 45° налуу улаан зураастай байна. Доод хэсэгт “Бүү онгойлго! Хүмүүс ажиллаж байна” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ. Энэхүү плакатыг 80x50 мм хэмжээтэй хийж болно.

Технологийн болон удирдлагын хий, шингэний шугам хоолойг хаасан хаалт, шибер, вентилүүдийн бариул, залуур дээр бичигтэй талыг нь ажлын байр руу харуулж байрлуулах ба жижиг хэмжээтэйг нь алсын удирдлагын түлхүүр, унтраалга, бариул, товлуур зэрэг дээр тавих зөөврийн плакат юм.

Хориглох плакат



5. Дэвсгэрийн хэмжээ 200х160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 15 мм өргөн улаан дугуй дотор 45° налуу улаан зураастай байна. Доод хэсэгт “Бүү хаа! Хүмүүс ажиллаж байна” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ. Энэхүү плакатыг 80х50 мм хэмжээтэй хийж болно.

Технологийн болон удирдлагын хий, шингэний шугам хоолойг нээсэн хаалт, шибер, вентилүүдийн бариул, залуур болон хаалга, хаалт, хашилт дээр бичигтэй талыг нь ажлын байр руу харуулж байрлуулах ба жижиг хэмжээтэйг нь алсын удирдлагын түлхүүр, унтраалга, бариул, товлуур зэрэг дээр тавих зөөврийн плакат юм.

Зөвшөөрөх плакат



1. Дэвсгэрийн хэмжээ 210x280 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 190x190 мм ногоон өнгийн дэвсгэрдээр цагаан өнгийн сумтай байна. Доод хэсэгт “Энд ажиллаж болно” гэж хараар бичнэ. Энэхүү плакатыг 80x50 мм хэмжээтэй хийж болно.

Ил хуваарилах байгууламж, дэд станцын ажил гүйцэтгэхээр бэлтгэсэн ажлын байр болон үйлдвэрийн доторх цахилгааны хуваарилах самбар, щит, кабель шугам, цахилгаан хөдөлгүүр гэх мэтийн тоног төхөөрөмж дээр ажил гүйцэтгэхээр бэлтгэсэн хэсэгт тавих зөөврийн плакат юм.

Зөвшөөрөх плакат



2. Дэвсгэрийн хэмжээ 210x280 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 190x190 мм ногоон өнгийн дэвсгэрдээр цагаан өнгийн сумтай байна. Доод хэсэгт “Энд авирч болно” гэж хараар бичнэ.

Ил хуваарилах байгууламжид ажил гүйцэтгэхээр бэлтгэсэн байрны зөвхөн дээш авирч болох тоног төхөөрөмж, хийц хэсэг дээр тавих зөөврийн плакат юм.

Заах плакат



1. Дэвсгэрийн хэмжээ 210х280 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 190х190 мм хөх-цэнхэр өнгийн дэвсгэрдээр цагаан өнгийн сумтай байна. Доод хэсэгт “Газардуулсан” гэж хараар бичнэ. Энэхүү плакатыг 80х50 мм хэмжээтэй хийж болно.

Газардуулга тавьсан хэсэг рүү хүчдэл өгч болзошгүй бүх таслуур, залгуур, таслуур, рубильник, автомат зэргийн залуур, дамжуулгын бариул, түлхүүр, товчлуур дээр болон зөөврийн газардуулга тавьсан тавьсан буюу газардуулгын хутга залгасан цэгийн хаалга, хаалт, хашилт дээр тавих зөөврийн плакат юм.